



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

/СУДАЛГААНЫ ТАЙЛАН/

**Улаанбаатар хот
2025 он**

ЗАХИАЛАГЧ:

ГҮЙЦЭТГЭСЭН:

Б.Алтангэрэл

Г.Гантөмөр

Н.Нямдорж

П.Баярбаатар

Я.Батгэрэл

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ
ГАЗАР

Хууль зүйн доктор, профессор

Хууль зүйн доктор, профессор

Нийгмийн ажлын ухааны доктор, дэд профессор

Хууль зүйн ухааны доктор

Хууль зүйн ухааны доктор

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	1
ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	2
УДИРТГАЛ	5
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА	
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1.1. Үнэлгээ хийх шалтгаан	6
1.2. Үнэлгээ хийх хүрээ	6
1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт	7
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр	7
1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох	8
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	8
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	9
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	11
3.1. Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээний эрх зүйн зохицуулалт	22
3.2. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах арга хэмжээний эрх зүйн зохицуулалт	35
3.3. Төлбөрийн чадваргүй иргэн, хуулийн этгээдээс төлбөр гаргуулах арга хэмжээний эрх зүйн зохицуулалт	41
3.4. Эд хөрөнгийн бус шаардлагыг хангах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт	51
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	54
ТАВ. ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	57
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА	
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1.1. Үнэлгээ хийх шалтгаан	59
1.2. Үнэлгээ хийх хүрээ	59
1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт	60
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр	61
1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох	61
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	62
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	62
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	63
3.1. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт	63
3.2. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагын эрх зүйн зохицуулалт	64
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	79
ТАВ. ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	81
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЗӨРЧЛИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА	
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1.1. Үнэлгээ хийх шалтгаан	83
1.2. Үнэлгээ хийх хүрээ	84
1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт	84
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр	85

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох	86
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	87
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	87
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	88
3.1. Баривчлах шийтгэл эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт	88
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	108
ТАВ. ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	109
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЭРҮҮГИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА	
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1.1. Үнэлгээ хийх шалтгаан	110
1.2. Үнэлгээ хийх хүрээ	111
1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт	111
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр	112
1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох	112
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	113
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	114
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	116
3.1. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт	123
3.2. Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт	141
3.3. Албадлагын арга хэмжээний хэрэгжилт	149
3.4. Хуулийн этгээдийг татан буулгах, эрх хасах албадлагын арга хэмжээ	162
авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх	
3.5. Хорих ял эдлүүлэх тогтолцоо /дэглэм, зэрэглэлийн эрх зүйн зохицуулалт/	166
3.6. Хоригдлыг нийгэмшүүлэх ажиллагаа	180
3.7. Хоригдлын ахуйн нөхцөл	189
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	195
ТАВ. ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	198
ТАВДУГААР БҮЛЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН	
АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ	
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1.1. Үнэлгээ хийх шалтгаан	199
1.2. Үнэлгээ хийх хүрээ	199
1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт	200
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр	200
1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох	201
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	202
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	203
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	203
3.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн байдал	203
3.2. Алба хаагчийн эрх зүйн байдал	209
3.3. Шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллын асуудал	217
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	219
ТАВ. ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	220

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШГБ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага
НШШГГ	Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ХЯЭА	Хорих ял эдлүүлэх алба
ШГА	Шийдвэр гүйцэтгэх алба
ХӨТЯЭА	Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба
ШШГТХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ИШГА	Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа
ЗШГА	Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа
ХӨТЯЭА	Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа
ХАДЖ	Хорих ангийн дотоод журам
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ГХ	Гүйцэтгэх хуудас
МД	Мөнгөн дүн

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1	Судалгаанд оролцсон иргэний шийдвэр гүйцэтгэгчийн ажилласан жил, боловсролын зэргийг харьцуулсан үзүүлэлт
Зураг 2	2002 оны ШШГТХ-ийн үйлчлэлийн хүрээнд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гүйцэтгэх хуудасны бодит биелэлтийн судалгаа (2002-2016)
Зураг 3	2002 оны ШШГТХ-ийн үйлчлэлийн хүрээнд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мөнгөн дүнгийн бодит биелэлтийн судалгаа (2002-2016 он)
Зураг 4	2017 оны ШШГТХ-ийн үйлчлэлийн хүрээнд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гүйцэтгэх хуудасны бодит биелэлтийн судалгаа (2017-2024 он)
Зураг 5	2017 оны ШШГТХ-ийн үйлчлэлийн хүрээнд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мөнгөн дүнгийн бодит биелэлтийн судалгаа (2017-2024 он)
Зураг 6	ШШГТХ-ийн иргэн, захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зохицуулалтад өгсөн шийдвэр гүйцэтгэгчдийн үнэлгээ
Зураг 7	“Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ” нь хууль зүйн нэр томьёоны хувьд нийцэж байгаа талаарх асуулгын дүн:
Зураг 8	Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээнд тулгамдаж буй асуудлын талаарх судалгааны дүн
Зураг 9	Шүүхээс үнэлгээтэй холбоотой хэрэг, маргаан шийдвэрлэсэн байдал
Зураг 10	Хөрөнгийн үнэлгээчний тайланг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор талуудад мэдэгдэж, тайланг танилцуулж, санал хүсэлтийг авч тэмдэглэл хөтөлнө” гэсэн зохицуулалтын талаарх асуулгын дүн
Зураг 11	Хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтад өгсөн үнэлгээ
Зураг 12	Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон судалгааны дүн
Зураг 13	Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх санал
Зураг 14	Төлбөрийн чадваргүй хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх талаарх асуулгын дүн
Зураг 15	Эд хөрөнгийн бус шаардлагыг хангах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үнэлгээ
Зураг 16	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл явц
Зураг 17	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж байгаа асуудал
Зураг 18	Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо
Зураг 19	Албадан сургалтын үр нөлөөний талаарх асуулгын үр дүн
Зураг 20	Албадан сургалтын үр дүнг дээшлүүлэх талаарх санал
Зураг 21	Алба хаагчдаас зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд өгсөн үнэлгээ
Зураг 22	Зан үйлд нөлөөлөх сургалтын үр дүнг сайжруулах чиглэлээр гаргасан санал
Зураг 23	Эрүүгийн хуульд тусгасан ялын төрөл эзлэх хувь
Зураг 24	Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх схем
Зураг 25	ШШГТХ-ийн хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж буй зохицуулалтад өгсөн үнэлгээ
Зураг 26	Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдсан асуудал
Зураг 27	Ялтанд хяналтын хувийн хэрэг нээж, цахим бугуйвч зүүх ажиллагаа
Зураг 28	Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдсан асуудал
Зураг 29	Албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад өгсөн үнэлгээ
Зураг 30	Хуулийн этгээдийг татан буулгах, эрх хасах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаарх эрх зүйн зохицуулалтад өгсөн үнэлгээ
Зураг 31	Хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зохицуулалтад өгсөн судалгааны дүн

Зураг 32	Хорих байгууллагын тогтолцооны хөгжлийн талаарх асуулгын дүн
Зураг 33	Хорих ял эдлүүлэх дэглэмийн эрх зүйн зохицуулалтад өгсөн үнэлгээ
Зураг 34	Зэрэглэл хоорондын ялгаанд өгсөн санал
Зураг 35	Нийгэмшүүлэх ажлын үр нөлөөнд өгсөн санал
Зураг 36	Дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдол судалгаа /2019-2023 он тоо, хувиар/
Зураг 37	Дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлын үйлдсэн гэмт хэргийн төрөл:
Зураг 38	Хорих анги дах сургалтын төрөл, хэлбэр
Зураг 39	Нийгэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гаргасан санал
Зураг 40	Хоригдлын ахуй нөхцөлийг сайжруулахтай холбоотой санал
Зураг 41	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо чиг үүрэгт өгсөн үнэлгээ
Зураг 42	Алба хаагчийн эрх зүйн байдлыг дээшлүүлэхэд анхаарах асуудал
Зураг 43	Шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллын талаар
Хүснэгт 1	Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гүйцэтгэх хуудас, мөнгөн дүнгийн биелэлтийн судалгаа (2018-2024 он)
Хүснэгт 2.	Шүүхээс иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдол, маргаан шийдвэрлэсэн байдал
Хүснэгт 3	Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны биелэлт (2018-2024 он)
Хүснэгт 4	Хүүхдийн тэтгэлэг төлөөгүй этгээдэд хариуцлага хүлээлгэсэн байдал
Хүснэгт 5	Төлбөрийн чадваргүй иргэн, хуулийн этгээдтэй холбоотой гүйцэтгэх хуудасны судалгаа
Хүснэгт 6	Төлбөрийн чадваргүй иргэн, хуулийн этгээдтэй холбоотой мөнгөн дүнгийн хуудасны судалгаа (мян, төг)
Хүснэгт 7	Эд хөрөнгийн бус шаардлагыг хангах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны судалгаа
Хүснэгт 8	Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилт (2018-2024)
Хүснэгт 9	Захиргааны шүүхийн шийдвэр биелэгдээгүй шалтгаан
Хүснэгт 10	2017 оны Зөрчлийн хуульд баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчлийн судалгаа
Хүснэгт 11	Монгол Улсын хэмжээнд 2015-2023 оны хооронд баривчлах шийтгэл оногдуулсан судалгаа
Хүснэгт 12	Баривчлагдсан этгээдийн эрх, үүрэг холбогдох хууль, журамд туссан байдал
Хүснэгт 13	Баривчлах байрны ахуй нөхцөл холбогдох хууль, журамд туссан байдал
Хүснэгт 14	ШШГТХ-д зан үйлд нөлөөлөх албадан сургалтын талаар туссан байдал
Хүснэгт 15	ШШГЕГ-ын харьяанд үйл ажиллагаа явуулж буй баривчлах байрны судалгаа
Хүснэгт 16	Гадаадын зарим орны баривчлах шийтгэлийн харьцуулалт
Хүснэгт 17	Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт:
Хүснэгт 18	Нийгэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт:
Хүснэгт 19	Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн хүнд тавьж буй хяналтын судалгаа
Хүснэгт 20	Хоригдлыг хугацаанаас өмнө суллах ажиллагааны үе шат
Хүснэгт 21	Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон хүний судалгаа
Хүснэгт 22	Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хүний судалгаа
Хүснэгт 23	Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний судалгаа:
Хүснэгт 24	Хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээ авагдсан хүний судалгаа
Хүснэгт 25	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний судалгаа
Хүснэгт 26	Хуулийн этгээдийг татан буулгах, эрх хасах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилт
Хүснэгт 27	Шүүхээс хорих ял оногдуулсан байдал
Хүснэгт 28	Хорих ял эдлүүлэх дэглэм, зэрэглэл тус бүрд ял эдлэх хоригдол
Хүснэгт 29	Гадаадын зарим орны хорих байгууллагын тогтолцоо

Хүснэгт 30	Иргэний эдлэх эрх, эрх чөлөөний хоригдолд хамаарах байдал
Хүснэгт 31	Хорих байрны ашиглалтад орсон огноо
Хүснэгт 32	Хорих ангийн багтаамжийн судалгаа

УДИРТГАЛ

Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг батлан, мөн оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш даруй 8 жил өнгөрчээ.

Хэдийгээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, алба хаагчийн эрх зүйн байдал зэрэг олон талт харилцааг зохицуулсан хэдий ч хэрэгжиж эхэлснээс нийгэм, ард иргэдийн дунд шүүхийн шийдвэрийн биелэлт хангалтгүй байдаг гэсэн нийтлэг ойлголттой, практик алба хаагчдаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт нь өнөөгийн нийгмийн эрэлт, хэрэгцээг хангахгүй байгаа зэрэг санал, асуулгын дүн байсаар байна.

ДХИС-ийн судлаачдаас улсын хэмжээнд 2300 иргэн /аймаг тус бүрээс 100, Улаанбаатар хотоос 200/ “та шүүхийн шийдвэрийн биелэлтийг ямар түвшинд хэрэгждэг гэж үздэг вэ?” гэсэн асуултад 785 буюу 34 хувь нь сайн, 951 буюу 41 хувь нь дунд, 406 буюу 18 хувь нь муу, 158 буюу 7 хувь нь огт хэрэгждэггүй¹ буюу 1474 буюу 64 хувь нь хангалтгүй гэж үнэлсэн нь энэ асуудалд анхаарлаа хандуулах цаг болсныг харуулж байна.

Төрийн бодлогын хүрээнд одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй хуулийн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох, шинэчлэл хийх шаардлага байгааг харж Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2.7-д “иргэний хэрэг хянан шийдвэрлэх, **иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл**, компани, шударга өрсөлдөөн, монопол, хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно”, 4.1.1.8-д “хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг баталгаажуулж, шүүхийн шийдвэргүйгээр баривчлах, цагдан хорих, иргэний эрхийг хязгаарлах ажиллагааг зогсоон, хүний эрхийг хамгаалах, процессын шударга ёсыг хангах, мэргэжлийн байлгах чиглэлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай, Таслан сэргийлэх ажиллагааны тухай, Шүүхийн шинжилгээний тухай, **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулиудыг бүрэн процессжуулан хуульчилна**”, 4.1.5.4-д “шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааг олон улсын сайн жишигт хүргэнэ” гэжээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.3 дахь хэсэгт “хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасан боловч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтэд өнөөг хүртэл үр нөлөөний судалгаа хийгдээгүй байгаа нь учир дутагдалтай гэж үзлээ.

Энэхүү үнэлгээг Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ийн дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шатын хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх олон талт ажиллагаанаас иргэний шийдвэр гүйцэтгэл, захиргааны шийдвэр гүйцэтгэл, зөрчлийн шийдвэр гүйцэтгэл, эрүүгийн шийдвэр гүйцэтгэл, алба хаагчийн эрх зүйн байдал гэж багцлан гүйцэтгэлээ.

¹ ДХИС. ИШШГБ-ын үйл ажиллагааны талаарх иргэдийн ойлголт, төсөөлөл. Судалгааны тайлан. Уб., 2020.89 дахь тал.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож, түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэнэ. Энэ үе шатанд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгаан:

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн хамт шийдвэрлэсэн иргэний нэхэмжлэлийн талаарх шүүхийн шийдвэр, хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан гадаад улсын шүүх, олон улсын шүүх, арбитрын шийдвэр, шүүхээр баталгаажуулсан цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, нотариатчийн мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр, шүүхээр баталгаажуулсан гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамжийг тус тус үндэслэн явуулж байна.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Компанийн тухай зэрэг олон хууль тогтоомжоор зохицуулж байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд заасны дагуу хууль тогтоомж нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд үнэлгээний ажлыг эхлэхээс өмнө үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлдог.

Дотоод хэргийн их сургууль, Шийдвэр гүйцэтгэлийн алба хамтран 2020 онд гүйцэтгэсэн “Иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилт” сэдэвт судалгаагаар иргэний шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг хэрэгжүүлж буй байгууллагын бүтэц, тогтолцоотой холбоотой зарим асуудлыг сонгон авч судалсан байдаг. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.3 дахь хэсэгт “энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасны дагуу ШШГТХ-ийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлохыг зорилоо.

1.2. Үнэлгээ хийх хүрээ:

Аливаа хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлахад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.

ШШГТХ-ийн иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийхэд асар их цаг хугацаа шаардагдана. Учир уг хуулийн иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой зүйл, заалт тус хуулийн 34.7 хувь буюу 18-122 дугаар зүйлийг хамарч байдаг.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.4 дэх хэсэгт “хууль тогтоомжийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхдээ хууль тогтоомжид бүхэлд нь, эсхүл түүний зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож болно” гэж заасны дагуу ШШГТХ-ийн иргэний шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд холбогдох зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлсэн болно.

Ингэхдээ захиалагч байгууллага болох ШШГЕГ-ын ирүүлсэн ажлын даалгавар, үнэлгээ хийх болсон шалтгааны харилцан уялдаа, хамааралтай байдлыг харгалзаж, хуулийн хэрэгжилтэд гарч буй эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон зохицуулалтыг сонгосон.

Үүний дүнд ШШГТХ-ийн дараах зохицуулалтыг үнэлгээ хийх хүрээнд хамрууллаа.

д/д	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Зохицуулалтын агуулга
1.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр бүлэг, 44 дүгээр зүйл	Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ
2.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 90 дүгээр зүйл	Хүүхдийн тэтгэлэг гаргуулах арга хэмжээ
3.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 118 дугаар зүйл	Төлбөрийн чадваргүй иргэн, хуулийн этгээдээс төлбөр гаргуулах арга хэмжээ
4.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 9 дүгээр бүлэг, 99 дүгээр зүйл	Эд хөрөнгийн бус шаардлагыг хангах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа

1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт:

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд зааснаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтийн жагсаалтыг гарган, үнэлгээ хийх асуудал тодорхой болсон үед тодорхой 1 шалгуур үзүүлэлтийг сонгон авах бөгөөд зөвхөн 1 шалгуур үзүүлэлтээр тухайн асуудалд бүрэн үнэлэлт өгөх боломжгүй тохиолдолд 2 болон түүнээс дээш шалгуур үзүүлэлтийг сонгох боломжтой гэжээ. Аргачлалд заасны дагуу иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж байгаа байдал гэсэн хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр:

Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтийг олж тодорхойлоход харьцуулах 4 төрлийн хэлбэрээс хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар

судалж тогтооход чиглэгдэнэ. Тодорхой цаг хугацааны дарааллаар нөхцөл байдлын өрнөлийг жагсааж гаргасан судалгааг үнэлгээнд хэрэглэх хэлбэрийг сонгон ашиглалаа.

Энэ хэлбэрийг ашиглахдаа иргэний шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран тоо баримт, олон улсын эх сурвалж, бусад материалд дүн шинжилгээ хийлээ.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох:

Шалгуур үзүүлэлтийг томьёолохдоо шалгуур үзүүлэлт тус бүрээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааны сонгон авсан хэсэгт тохируулан дараах шалгуур үзүүлэлтийг сонгож, асуулт боловсрууллаа.

1. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилтийн түвшин;
2. ШШГТХ-ийн 44 дүгээр зүйл нь шүүхийн шийдвэр бүрэн биелэгдэх зорилгод нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;
3. ШШГТХ-ийн 90 дүгээр зүйл нь шүүхийн шийдвэр бүрэн биелэгдэх зорилгод нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;
4. ШШГТХ-ийн 99 дүгээр зүйл нь шүүхийн шийдвэр бүрэн биелэгдэх зорилгод нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;
5. ШШГТХ-ийн 118 дугаар зүйл нь шүүхийн шийдвэр бүрэн биелэгдэх зорилгод нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох:

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтэд тулгамдсан асуудлыг илрүүлэх зорилгоор баримт бичиг, судалгааны тайлан, илтгэл, өгүүлэл унших, судлах, харьцуулалт хийх, ШШГБ-ын алба хаагчдаас тулгамдаж буй асуудлын талаар судалгаа авах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд аргачлалын 3.7.3-т мэдээлэл цуглуулах дөрвөн аргыг тодорхойлсноос дараах хоёр аргыг сонгон үнэлгээ хийх мэдээллийг цуглуулсан болно.

1. Мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийх;
2. Судалгаа авах.

Мэдээлэл цуглуулах хүрээнд: ШШГТХууль, холбогдох ном, сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, журам, зааврыг цуглуулж, үнэлгээ хийхэд ашиглав.

Судалгаа авах хүрээнд: Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэхийн тулд шийдвэр гүйцэтгэгчтэй ярилцлага хийх, анкетын аргаар судалгаа авч, ШШГЕГ-ын үйл ажиллагааны тайлан, судалгаа, бусад мэдээллийг гаргуулан авч үнэлгээ хийхэд ашигласан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, алба хаагчтай уулзалт-ярилцлага хийх, анкетын судалгаа авч, ярилцлагын аргад тулгуурлаж энэхүү судалгааг гүйцэтгэв.

2.1. Баримт бичгийн судалгаа: ШШГТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээл, илтгэл, өгүүлэл, тайланг ашигласан болно.

2.2. Холбогдох субъектээс авсан судалгаа:


а) ШШГТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, эрх зүйн шинэчлэлтэд шаардлагатай судалгааны материалыг бүрдүүлэх, тулгарч буй хүндрэл бэрхшээлийг судалж дүн шинжилгээ хийх зорилгоор иргэний шийдвэр гүйцэтгэгчээс авсан 19 сэтгэмжтэй асуумжийн 2 нь шийдвэр гүйцэтгэгчийн ерөнхий мэдээлэл, 15 нь иргэн, захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал, 2 нь алба хаагчийн эрх зүйн байдлын талаар хариулахаар тооцож 2 асуумжид нээлттэй байдлаар санал хүсэлт өгөхөөр боловсруулсан.

б) судалгаанд 68 иргэний шийдвэр гүйцэтгэгч хамрагдсан бөгөөд дүнг SPSS 026 программ ашиглан статистик боловсруулалт хийж, судалгааны үр дүнг тооцоходоо дундаж утга, стандарт хазайлт, хамгийн их болон хамгийн бага утга, хамаарлын статистик шинжилгээг хийсэн.

One-Sample Statistics					Test Value = дундаж					
Ажлаас халшрах хам шинж	N	Mean	Std. Deviation	Std. Error Mean	t	df	Sig. (2-tailed)	Mean Difference	95% Confidence Interval of the Difference	
	1168	2.05	0.698	0.084	-2.732	1167	0.007	0.267	Lower	Upper
									-0.29	-0.05

T-статистик нь түүврийн тоо N (1168), хувьсагчийн дундаж утга буюу дундаж нь Mean (2.05), стандарт хазайлт (0.698), стандарт алдааны утга (0.084) харгалзах утга нь (sig=0.007) буюу таамаглал үнэн байна. Дунджийн стандарт алдаа нь түүврийн дунджийн хэлбэлзлийг хэмждэг тул дунджийн стандарт алдаа бага байх тусам бидний түүвэр жинхэнэ дундажтай ойролцоо байх магадлалтай гэж үзсэн.

Зураг 1. Судалгаанд оролцсон иргэний шийдвэр гүйцэтгэгчийн ажилласан жил, боловсролын зэргийг харьцуулсан үзүүлэлт



Судалгаанд оролцогчдын боловсролын түвшнийг үзвэл 51 буюу 75 хувь нь бакалавр, 16 буюу 23.5 хувь нь магистр, 1 буюу 1.5 хувь нь доктор зэрэгтэй байсан бол шийдвэр гүйцэтгэгчээр ажилласан жилээр нь ангилбал 2 буюу 2.9 хувь 1 жил хүртэл, 6 буюу 8.8 хувь нь 1-3 жил, 12 буюу 17.6 хувь нь 3-6 жил, 18 буюу 26.5 хувь нь 6-10 жил, 30 буюу 44.1 хувь нь 10 жилээс дээш жил ажилласан туршлагатай байна. Судалгааны үзүүлэлтээс харахад 88,2 хувь 3 жилээс дээш жил ажилласан туршлагатай шийдвэр гүйцэтгэгч байх тул шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тулгамдсан асуудлыг сайн мэдэх алба хаагчид хамрагдсан гэж үзлээ.

в) ДХИС-ийн судлаачдын өмнө гүйцэтгэсэн шүүхийн шийдвэрийн хэрэгжилтэд өгсөн үнэлгээ болон бусад судалгаа;

2.3. Ярилцлагын арга: ИШГТХ-ийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн бодит байдал, хууль хэрэглээнд тулгамдаж буй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг тодруулахаар ярилцлага хийсэн.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь бусдын эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг зөрчсөн буюу тодорхой үүргээ биелүүлээгүйн улмаас бусдын эдийн засгийн болон бусад эрхэд хор уршиг учруулсан этгээдийн эрхийг зөвхөн хуульд заасан журмаар хязгаарлаж байдаг төрийн албадлагын арга хэмжээний нэг төрөл байдаг. Энэхүү албадлагын арга хэмжээг хэрэгжүүлснээр гэм буруутай этгээдийн үйлдэл, эс үйлдлийн улмаас хохирсон этгээдийн эрх, ашиг сонирхлыг сэргээх, хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах төрийн үндсэн үүргийг хэрэгжүүлэх нэг хэлбэр болно. Өөрөөр хэлбэл, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго нь шүүхээс гарсан шийдвэрийг албадан биелүүлж, бусдын хуулиар хамгаалагдсан эрх ашгийг сэргээхэд оршдог.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зарчимд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах, энэрэнгүй, шуурхай байх зарчим хамаардаг.

- хууль дээдлэх зарчим нь шийдвэр гүйцэтгэгч болон холбогдох албан тушаалтны бүхий л үйл ажиллагаа нь хуульд нийцсэн байх, түүнчлэн эрх, үүргийг тодорхой болгож, хууль зөрчсөн тохиолдолд ноогдуулах хариуцлага гарцаагүй байх;

- хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх зарчим нь төлбөр төлөгч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас төлбөр авагчийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол зөрчигдсөнийг тогтоосон шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг үндэслэн хохиролгүй болгох үйл ажиллагаа явуулах;

- хүний эрх эрх чөлөөг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах зарчим нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө, шаардах эрх, эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгөө төлбөр гаргуулахын тулд эд хөрөнгө, харилцах дансыг битүүмжлэх, барьцаалах, хураан авах, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх замаар захирамжлан гүйцэтгэх ажиллагааг явуулахдаа төлбөр төлөгчийн зарим эрхийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлах;

- энэрэнгүй байх зарчим нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад аливаа этгээдийн эрх, эрх чөлөөг хамгаалах, хүнлэг бус харьцахгүй байх, эрхэд нь хууль бусаар халдах явдлыг гаргахгүй байх;

- шуурхай байх зарчим нь шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахдаа эрх зүйн хэм хэмжээг зөв сонгох, төлбөрийг түргэн шуурхай барагдуулах талаар мэдээллийг шуурхай цуглуулах, зайлшгүй ажиллагааг цаг алдалгүй гүйцэтгэх зорилгыг агуулсан зарчим юм.

ШШГТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасны дагуу иргэний хэргийн талаарх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараах шийдвэрийг үндэслэн явуулдаг. Үүнд:

1. Иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн хамт шийдвэрлэсэн иргэний нэхэмжлэлийн талаарх шүүхийн шийдвэр:

Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гэдэг нь хүн, хуулийн этгээдийн хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялаг, тодорхой төрлийн эрхийг хангах үйл ажиллагаатай холбогдуулан гарсан шүүхийн шийдвэр байдаг. Эрүүгийн хэргийн хамт шийдвэрлэсэн иргэний нэхэмжлэлийн талаарх шүүхийн шийдвэр нь гэмт хэргийн улмаас хүн, хуулийн этгээдэд учирсан эдийн болон эдийн бус эрх, ашиг сонирхлыг сэргээхээр ЭХХША-ны явцад нэгтгэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг ойлгоно. Гэмт хэргийн

улмаас бусдын эд хөрөнгө хийгээд эрүүл мэндэд учирсан хохирол, төлбөрийг иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны арга, журмыг баримтлан нөхөн төлүүлэх ажиллагааг гүйцэтгэдэг.

2. Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж:

Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж гэдэгт зохигчдын эвлэрлийг баталгаажуулж, хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүгчийн захирамжаас гадна хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай ИХШХШТХ-ийн 74², 106 дугаар зүйлд заасан үндэслэлээр хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг ойлгоно.

3. Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын шүүх, олон улсын шүүх, арбитрын шийдвэр:

Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын шүүх, олон улсын шүүх, арбитрын шийдвэр гэдэгт ИХШХШТХ-ийн 190 дүгээр зүйлийн 190.1.5-т “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх арга хэмжээ авсан буюу холбогдох этгээд ийм арга хэмжээ авхуулахаар өргөдөл гаргасан бол” гэж заасны дагуу шүүхэд хүсэлтээ гаргаж, шүүх гүйцэтгэх хуудас олгох тухай захирамж гаргаж шийдвэрлэсэн байхыг ойлгоно. ИХШХШТХ-ийн дээрх заалтын УДШ-ээс “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх арга хэмжээ авхуулахаар өргөдөл гаргасантай холбоотой маргааныг Монгол Улсын харьяалах шүүх шийдвэрлэнэ³ гэж тайлбарлажээ.

4. Шүүхээр баталгаажуулсан цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, нотариатчийн мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр:

Шүүхээр баталгаажуулсан цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал нь шалгалтаар тогтоосон цэргийн алба хаагчийн учруулсан бодит хохирлын хэмжээ нь хохирол учрах үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжид заасан 1 сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээнээс хэтрээгүй бол тухайн цэргийн анги, байгууллагын захирагч шалгалтын дүнг үндэслэн учирсан хохирлыг арилгуулахаар 14 хоногийн дотор эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал гаргасан⁴ тушаалыг баталгаажуулан шүүхээс гүйцэтгэх хуудас олгох үйл ажиллагааг ойлгоно.

Нотариатчийн мэдэгдэх хуудас нь талууд үл маргах журмаар төлбөр төлөх, үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс гаргуулахаар харилцан тохиролцож байгуулсан нотариатаар баталсан гэрээ, төлбөрийг нотолсон баримт бичгийг үндэслэн төлбөр төлөгчөөс мөнгө, эдийн болон эдийн бус хөрөнгийг гаргуулахаар төлбөр авагчийн хүсэлтээр нотариатч үйлдсэн⁵ баримт бичгийг ойлгоно.

Арбитрын шийдвэр нь арбитрын үйл ажиллагаа явуулахаар үндсэн харьяалал тогтоосон, талуудын хооронд гарсан маргааныг арбитрын хэлэлцээр болон Арбитрын тухай

² Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл. эмхэтгэл №8. Уб., 2002.

³ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. Монгол Улсын Дээд шүүх. Уб., 2008. 445 дахь тал.

⁴ Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл №25. Уб., 2002.

⁵ Нотариатын тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл №9. Уб., 2011.

хуульд заасны дагуу үйл ажиллагаа явуулж, хянан хэлэлцэж бичгээр гаргасан эцсийн шийдвэрийг ойлгоно⁶.

5. Шүүхээр баталгаажуулсан гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр:

Шүүхээр баталгаажуулсан гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр Эрүүгийн хуулийн⁷ 10.1 дүгээр зүйл /хүнийг алах/, 11.1 дүгээр зүйл /хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 11.4 дүгээр зүйл /хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах/, 12.1 дүгээр зүйл /хүчиндэх/, 12.3 дугаар зүйл /бэлгийн мөлжлөг/, 13.1 дүгээр зүйл /хүн худалдаалах/, 13.2 дугаар зүйл /хүн хулгайлах/, 13.3 дугаар зүйл /хүн барьцаалах/, 13.4 дүгээр зүйл /хүнийг хүчээр алга болгох/, 15.3 дугаар зүйл /хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах/, 15.5 дугаар зүйл /хууль бусаар үр хөндөх/, 16.1 дүгээр зүйл /хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах/, 16.3 дугаар зүйл /хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх/, 16.6 дугаар зүйл /хүүхэд худалдах/, 16.7 дугаар зүйл /хүүхэдтэй хэрцгий харьцах/, 16.11 дүгээр зүйл /хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх/, 17.2 дугаар зүйл /дээрэмдэх/, 19.3 дугаар зүйл /төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах/, 21.12 дугаар зүйл /эрүү шүүлт тулгах/, 29.1 дүгээр зүйл /түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх/, 29.8 дугаар зүйл /террорист үйлдэл хийх/-д заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан эмчилгээний зардал, оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг төрөөс урьдчилан төлөх тухай “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-гийн зөвлөлийн шийдвэрийг ойлгоно.

6. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамж:

Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамж гэдэгт шүүхээс гарах шийдвэрийг бодитой гүйцэтгэх боломжийг хангахын тулд нэхэмжлэгчийн хүсэлтийг үндэслэн шүүхийн шийдвэр гарахаас өмнө хариуцагчийн эд хөрөнгө буюу мөнгийг тухайн нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр битүүмжлэх, хариуцагчаас эд хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн тодорхой ажиллагаа явуулахыг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр хориглох, хариуцагчийн дансны зарлагын хөдөлгөөнийг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээнд зогсоох, нэхэмжлэлээр шаардсан хэмжээний мөнгийг ШШГБ-ын дансанд урьдчилан оруулах, тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгаж шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг ойлгоно.

Монгол Улсын олон улсын гэрээнд заасан гадаад улсын шүүх, олон улсын шүүх, арбитрын шийдвэр, шүүхээр баталгаажуулсан цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, нотариатчийн мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр, шүүхээр баталгаажуулсан гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох

⁶ Арбитрын тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл №5. Уб., 2017.

⁷ Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл №21. Уб., 2016.

сангийн зөвлөлийн шийдвэр зэргийг албадан гүйцэтгүүлэх талаар шүүх ИХШХШТХ-ийн 184 дүгээр зүйлийн 184.3-т зааснаар шүүгчийн захирамж гаргасан байна⁸.

Судалгааны хүрээнд ШШГЕГ-ын харьяа Шийдвэр гүйцэтгэх албаны хэмжээнд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтийг 2002, 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн үйлчлэлийн хүрээнд судлан үзлээ.

Нэг. 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн үйлчлэлийн хүрээнд:

Төр, эрх зүйн хөгжлийн нийтлэг зүй тогтолд нийцүүлэн шүүхийг шинэчлэн хөгжүүлэх, шударга ёс, хүний эрхийн баталгаа болгон төлөвшүүлэх зорилгоор УИХ-аас 2000 онд “Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”-г баталжээ. Уг төлөвлөгөө нь шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, хараат бус байх, хариуцлага хүлээдэг байх, мэдрэмжтэй байх, шударга байх, хүртээмжтэй байх, бүтээмжтэй байх гэсэн 6 суурь үнэлэхүйг үндэс болгожээ.

Хууль сахиулах байгууллагын зохион байгуулалтыг боловсронгуй болгох, чирэгдэл, дамжлага багатай бүтэц бий болгох, хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбогдуулан хуулийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой хуулиудыг бүхэлд нь өөрчлөх явцад 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Иргэний, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль шинэчлэгдсэн байна.

2002 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдан гарах болсон үндсэн шалтгаан нь Эрүү, Иргэний хууль тогтоомжийн шинэчлэлт болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр нарийвчилсан зохицуулалтыг тухайн үед хийж байжээ.

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 15 жил хүчин төгөлдөр үйлчилсэн ба тухайн үеийн иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтийг судлан үзвэл:

1. 2002 оны жилийн эцсийн байдлаар 61497 гүйцэтгэх баримт бичгийн 63.4 тэрбум төгрөгийг биелүүлэхээс 14767 гүйцэтгэх баримт бичгийн 15.7 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 24.0 хувь;

2. 2003 оны жилийн эцсийн байдлаар 34200 гүйцэтгэх баримт бичгийн 49,0 тэрбум төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 16380 гүйцэтгэх баримт бичгийн 32,1 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, баримт бичгийн бодит биелэлт 47,8 хувь;

3. 2004 оны жилийн эцсийн байдлаар 26769 гүйцэтгэх хуудас бүхий 47,1 тэрбум төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 12489 гүйцэтгэх хуудас бүхий 31,5 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 46,6 хувь;

4. 2005 оны жилийн эцсийн байдлаар 22820 гүйцэтгэх хуудас бүхий 32,0 тэрбум төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 12022 гүйцэтгэх хуудас бүхий 21,5 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 52,6 хувь;

5. 2006 оны жилийн эцсийн байдлаар 19134 гүйцэтгэх хуудас бүхий 38,5 тэрбум төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 11401 гүйцэтгэх хуудас бүхий 28,1 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 59,5 хувь;

⁸ Замбага, Б. Иргэний болон захиргаа зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа. Хичээлийн лекц. 8 дахь тал.

6. 2007 оны жилийн эцсийн байдлаар 19855 гүйцэтгэх хуудас бүхий 35,8 тэрбум төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 12581 гүйцэтгэх хуудас бүхий 26,1 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 63,3 хувь;

7. 2008 оны жилийн эцсийн байдлаар 19864 гүйцэтгэх хуудас бүхий 48,0 тэрбум төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 13574 гүйцэтгэх хуудас бүхий 37,7 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 68,3 хувь;

8. 2009 оны жилийн эцсийн байдлаар 23565 гүйцэтгэх хуудас бүхий 58,2 тэрбум төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 16150 гүйцэтгэх хуудас бүхий 44,6 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 68,5 хувь;

9. 2010 оны жилийн эцсийн байдлаар 25288 гүйцэтгэх хуудас бүхий 193,4 тэрбум төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 15411 гүйцэтгэх хуудас бүхий 83,1 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 60,9 хувь;

10. 2011 оны жилийн эцсийн байдлаар 22155 гүйцэтгэх хуудас бүхий 189,1 тэрбум төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 14292 гүйцэтгэх хуудас бүхий 83,5 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 64,5 хувь;

11. 2012 оны жилийн эцсийн байдлаар 22050 гүйцэтгэх хуудас бүхий 223,7 тэрбум төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 14545 гүйцэтгэх хуудас бүхий 89,8 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 65,9 хувь;

12. 2013 оны жилийн эцсийн байдлаар 23839 гүйцэтгэх хуудас бүхий 823,7 тэрбум төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 16077 гүйцэтгэх хуудас бүхий 507,4 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 67,3 хувь;


13. 2014 оны жилийн эцсийн байдлаар 19507 гүйцэтгэх хуудас бүхий 840,5 тэрбум төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 13068 гүйцэтгэх хуудас бүхий 333,0 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 66,9 хувь;

14. 2015 оны жилийн эцсийн байдлаар 30839 гүйцэтгэх хуудас бүхий 848,9 тэрбум төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 16347 гүйцэтгэх хуудас бүхий 168,2 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 53,0 хувь;

15. 2016 оны жилийн эцсийн байдлаар 35908 гүйцэтгэх хуудас бүхий 1218,6 тэрбум төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 17721 гүйцэтгэх хуудас бүхий 149,6 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 49,3 хувьтай байжээ.


Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтийг өмнөх жилийн үлдэгдэл болон шинээр ирсэн гүйцэтгэх хуудасны тоо, шүүхийн шийдвэрт тусгагдсан мөнгөн дүнгийн тоон илэрхийлэлтэй харьцуулан судлах нь судалгааны үнэн бодит байдлыг илэрхийлэх ач холбогдолтой юм.

Зураг 2. 2002 оны ШШГТХ-ийн үйлчлэлийн хүрээнд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гүйцэтгэх хуудасны бодит биелэлтийн судалгаа (2002-2016)



2002 оны ШШГТХ үйлчилж байсан 15 жилийн хугацаанд шүүхээс ирүүлсэн гүйцэтгэх хуудасны биелэлт 56.9 хувийн дундаж биелэлттэй байжээ. Гүйцэтгэх хуудасны биелэлттэй уялдан шүүхийн шийдвэрт тусгагдсан мөнгөн дүнгийн биелэлтийг судлан үзлээ.

Зураг 3. 2002 оны ШШГТХ-ийн үйлчлэлийн хүрээнд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мөнгөн дүнгийн бодит биелэлтийн судалгаа (2002-2016 он)



2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль үйлчилж байсан 15 жилийн хугацаанд шүүхээс ирүүлсэн мөнгөн дүнгийн дундаж биелэлт 52.3 хувь байх ба 2014-2016 оны хооронд огцом буурсан үзүүлэлттэй байжээ. 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд нийгэм, эдийн засаг, эрх зүйн шинэчлэлт хувьсан өөрчлөгдөж, улмаар олон улсын чиг баримжаа, үндэсний хууль тогтоомжийн шинэтгэлийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн батлах зайлшгүй шаардлага урган гарсан байна.

Хоёр. 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн үйлчлэлийн хүрээнд:

2017 оны ШШГТХ-ийн шинэчилсэн найруулгаар уг хуулийн зорилтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдалтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино гэж тодорхойлжээ.

2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх чиглэлээр шинээр тусгагдсан заалтын онцлогийг дурдвал:

1. Шийдвэр гүйцэтгэгч өөрийн хариуцсан тойргоос бусад газарт аливаа ажиллагаа явуулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гүйцэтгэгчийн даалгавар хүргүүлэн гүйцэтгэх, цаг үеийн шаардлагаас үүдэн нэг төрлийн шийдвэрийг дагнан гүйцэтгэх чиг үүрэг бүхий нэгжээр шийдвэр гүйцэтгүүлэх, гүйцэтгэх шаардлага болон хамрах нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамааран шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шийдвэр гүйцэтгэгчээс бүрдсэн хэсгээр гүйцэтгүүлэх, нэг төлбөр төлөгчид холбогдох хэд хэдэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нэгтгэн гүйцэтгэх боломжийг бий болгосон.

2. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг үүссэн шаардлага, нөхцөлөөс хамааран хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь түдгэлзүүлэх, дуусгавар болгох тухай зохицуулалтыг бий болгон, шийдвэр гаргах эрх бүхий субъектийг тодорхойлж, түдгэлзүүлсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч түдгэлзсэн үндэслэлийг арилсан эсэхэд хяналт тавьж байх тухай зохицуулалтыг тусгасан.

3. Гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох үндэслэлийг тодорхойлохдоо тэжээн тэтгэхтэй холбогдсон шийдвэрийг үүрэг хүлээлгэсэн бүхий л хугацааны туршид гомдол гаргах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломжтой байхаар тусгасан.

4. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд хэрэгжүүлдэг бүхий л арга хэмжээг гүйцэтгэх баримт бичгийн гүйцэтгэлийг баталгаажуулах /хөрөнгө битүүмжлэх, барьцаалах, хураан авах, эд зүйлд үзлэг хийх, нэгжлэг хийх, үнэлгээ тогтоох гэх мэт/ албадлагын арга хэмжээг тодорхойлж, гүйцэтгэх үндэслэл, журмыг тогтоосон.

5. Гүйцэтгэх баримт бичгийн гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг түдгэлзүүлэх, төлбөр төлөгч түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах тухай зохицуулалтыг шинээр тогтоосон.

6. Шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудаст төлбөр гаргуулах хөрөнгө, орлого, эрхийг тодорхой заагаагүйгээс шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн өмчлөх эрхэд өөрийн үзэмжээр халддаг зохицуулалтыг өөрчилж, гүйцэтгэх хуудаст төлбөр гаргуулах хөрөнгө,

орлого, эрхийг заадаг байхаар тусгах, үүнтэй холбоотой холбогдох хуульд өөрчлөлт оруулсан.

7. Шүүхийн шийдвэрийн биелэлтийг бодитой хангахын тулд төлбөр төлөгчийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлж, үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарлахад чиглэсэн зохицуулалтыг тусгасан.

8. Төлбөр төлөгчийн төлбөрт суутгахаар тогтсон хөрөнгийн төрөл, тэдгээрийн онцлогоос хамааран шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулах, үнэлгээ тогтоох онцлог, тэдгээрийг албадан худалдан борлуулах ажиллагааны журмыг тогтоосон.

9. Төлбөр төлөгчийн эрхийг хамгаалах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүнтэй байдлыг хангах зорилгоор төлбөр төлөгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бүхий л шатанд төлбөрт суутган албадан худалдан борлуулахаар тогтсон хөрөнгийг бие даан худалдан борлуулах эрхтэй байхаар тусгасан.

10. Төлбөр төлөгчийн хөрөнгийг албадан борлуулах ажиллагаа, албадан борлуулахаар тогтсон хөрөнгийг санал болгох анхны болон хоёр дахь дуудлага худалдааны үнийг тогтоох журмыг тусгасан. Тухайлбал, дуудлага худалдаа нь анхны үнэд хүрэх санал гараагүй, эсхүл нэг ч этгээд оролцоогүй үндэслэлээр хүчингүй болсон тохиолдолд хоёр дахь дуудлага худалдааны үед үнийг буулгах, харин дуудлага худалдаанд ялсан этгээд төлбөрийг хугацаанд нь шилжүүлээгүйн улмаас хүчингүйд тооцсон бол хоёр дахь дуудлага худалдааны үед үнийг бууруулахгүй байх тухай зохицуулалтыг тусгасан.

11. Худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагчид санал болгох үнийг шинээр тогтоож, хөрөнгийн анхлан тогтоосон үнийг 50 хувиар буюу хоёр дахь дуудлага худалдаанд санал болгосон доод үнэтэй дүйцүүлэн бууруулан тооцож төлбөрт суутган авах тухай зохицуулалт болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудын биедээ биедээ гаргасан ижил төрлийн харилцан шаардлагыг ихээс нь багыг нь суутгаж, төлбөр барагдуулсанд тооцох тухай зохицуулалтыг бий болгосон.

12. Төлбөр төлөгчийн цалин хөлс, бусад орлогоос суутгал хийх, тэжээн тэтгэхтэй холбогдсон төлбөрийг барагдуулах, төлбөр төлөгч-иргэн, төлбөр төлөгч хуулийн этгээдэд холбогдуулан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах журмыг тус тус тодорхойлсон.

Энэхүү хуулийн үйлчилж буй сүүлийн 8 жилийн хугацаанд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтийг судлан үзвэл:

1. 2017 оны жилийн эцсийн байдлаар 39405 гүйцэтгэх хуудас бүхий 1448,3 тэрбум төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 19648 гүйцэтгэх хуудас бүхий 294,9 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 49,8 хувь;

2. 2018 оны жилийн эцсийн байдлаар 38579 гүйцэтгэх хуудас бүхий 1,8 их наяд төгрөгийн төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 20054 гүйцэтгэх хуудас бүхий 504,3 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 51,9 хувь;

3. 2019 оны жилийн эцсийн байдлаар 40999 гүйцэтгэх хуудас бүхий 1,9 их наяд төгрөгийн төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 21191 гүйцэтгэх хуудас бүхий 303,4 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 51,6 хувь;

4. 2020 оны жилийн эцсийн байдлаар 39342 гүйцэтгэх хуудас бүхий 1,7 их наяд төгрөгийн төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 20323 гүйцэтгэх хуудас бүхий 381,2 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 51,7 хувь;

5. 2021 оны жилийн эцсийн байдлаар 36321 гүйцэтгэх хуудас бүхий 1,7 их наяд төгрөгийн төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 19693 гүйцэтгэх хуудас бүхий 339,0 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 54,2 хувь;


6. 2022 оны жилийн эцсийн байдлаар 44731 гүйцэтгэх хуудас бүхий 2,6 их наяд төгрөгийн төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 24406 гүйцэтгэх хуудас бүхий 788,3 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 54,6 хувь;

7. 2023 оны жилийн эцсийн байдлаар 52956 гүйцэтгэх хуудас бүхий 3,0 их наяд төгрөгийн төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 30835 гүйцэтгэх хуудас бүхий 646,6 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 58,2 хувь;

8. 2024 оны жилийн эцсийн байдлаар 56920 гүйцэтгэх хуудас бүхий 3,4 их наяд төгрөгийн төлбөр, тэтгэлэг биелүүлэхээс 30301 гүйцэтгэх хуудас бүхий 1,102,8 тэрбум төгрөгийн төлбөр тэтгэлэг барагдуулж, гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 53,2 хувь байжээ⁹.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтийг өмнөх жилийн үлдэгдэл болон шинээр ирсэн гүйцэтгэх хуудасны тоо, шүүхийн шийдвэрт тусгагдсан мөнгөн дүнгийн тоон илэрхийлэлтэй харьцуулан судлах нь судалгааны үнэн бодит байдлыг илэрхийлэх ач холбогдолтой юм.


Зураг 4. 2017 оны ШШГТХ-ийн үйлчлэлийн хүрээнд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гүйцэтгэх хуудасны бодит биелэлтийн судалгаа (2017-2024 он)



⁹ ШГА-ны судалгаа.

2017 оны ШШГТХ-ийн үйлчлэлийн буюу 2017-2024 оныг хүртэлх хугацаанд шүүхээс ирүүлсэн гүйцэтгэх хуудасны биелэлт 53.1 хувийн дундаж биелэлттэй байна. Энэ хуулийн үйлчилж эхлэх үеэс эхлэн иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шүүхийн шийдвэрт тусгагдсан мөнгөн дүнгийн хэмжээ огцом өсөж их наядаар тооцогдох болсон онцлогтой байна. Өөрөөр хэлбэл мөнгөн дүнгийн хэмжээ огцом өссөн нь нийгэм, эдийн засаг, санхүүгийн хямрал, бусад хямралт байдал /ковид/-тай холбон үзэж болно.

Зураг 5. 2017 оны ШШГТХ-ийн үйлчлэлийн хүрээнд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мөнгөн дүнгийн бодит биелэлтийн судалгаа (2017-2024 он)



Мөнгөн дүнгийн дундаж биелэлт 23.4 хувь буюу хангалттай бус байгаа ба энэ асуудалд өндөр үнийн дүнтэй гүйцэтгэх хуудас, түүний биелэлтийг тухайлан судлах нь зүйтэй гэж үзлээ.


ДХИС-ийн судлаачдаас 21 аймаг тус бүрээс 100 иргэн, Улаанбаатар хотоос 200 иргэн нийт 2300 хүнээс судалгаа авсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас төлбөр, хохирол барагдуулж буй үйл явцыг та хэрхэн үнэлэх вэ” гэсэн асуултад 815 буюу 36 хувь нь сайн, 1180 буюу 51 хувь нь дунд, 305 буюу 13 хувь нь муу гэж хариулжээ.¹⁰ Дээрх хариултаас харахад 1485 буюу 64.5 хувь нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилтэд сэтгэл хангалуун бус байгаад анхаарал хандуулах цаг болжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт муу байгаа нь нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлээс шалтгаалах хэдий ч төлбөр төлөгчийн төлбөрийн чадваргүй байдал, хариуцлагын тогтолцоо сул, эрх зүйн зохицуулалтын хангалтгүй зэргээс нөлөөлж байна.

Иргэний 68 шийдвэр гүйцэтгэгчээс өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй ШШГТХ-д тусгагдсан иргэн, захиргааны шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтад үнэлгээ өгөхтэй холбоотой асуулга авахад дараах дүн гарлаа.

¹⁰ ДХИС. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн ойлголт, төсөөлөл. Судалгааны тайлан. Уб., 2020. 90 дэх тал.

Зураг 6. ШШГТХ-ийн иргэн, захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зохицуулалтад өгсөн шийдвэр гүйцэтгэгчдийн үнэлгээ



Судалгааны түүврийн 15 буюу 22.1 хувь нь шаардлага хангахгүй тул бүрэн шинэчлэх шаардлагатай, 50 буюу 73.5 хувь нь зарим зүйл, заалтыг шинэчлэх шаардлагатай, зөвхөн 3 буюу 4.4 хувь нь шаардлага хангаж байгааг илэрхийлжээ. Зарим зүйл, заалтыг шинэчлэх шаардлагатай гэж үзсэн шийдвэр гүйцэтгэгчийг ажилласан жилээр нь ангилан үзвэл 1 жил хүртэл ажилласан алба хаагч 100 хувь, 3-6 жил ажилласан алба хаагчийн 83 хувь, 6-10 жил ажилласан алба хаагчийн 61.1 хувь, 10-аас дээш жил ажилласан алба хаагчийн 76.6 хувь нь хариулжээ.

Асуулгаас дүгнэж үзэхэд оролцогчдын 95 хувь нь эрх зүйн зохицуулалт өнөөгийн шаардлага хангахгүй байгаа тул шинэчлэх шаардлага байна гэж үзсэн нь иргэн, захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх шаардлага урган гарсан байна гэж үзлээ.

3.1. Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээний эрх зүйн зохицуулалт:

Монгол Улсад шүүх эрх мэдлийг Үндсэн хуулийн дагуу байгуулсан шүүх хэрэгжүүлэх бөгөөд зохион байгуулалтын хувьд бие даасан хараат бус байна. Шүүх нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэг хүлээдэг, өдөр тутам хууль хэрэглэж, хэрэг маргааныг шийдвэрлэдэг онцгой эрхтэй субъект юм. Шүүх шийдвэрээ Монгол Улсын нэрийн өмнөөс гаргана.

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх чиг үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар хэрэгжүүлэн ажиллана. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь төлбөр авагчийн зөрчигдсөн эрхийг сэргээх шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмын хүрээнд явагдана.

Шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмын илэрхийлэл нь Монгол Улсын Шүүхийн тухай хууль¹¹-ийн 23 дугаар зүйлд “Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хүн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй”, “Шүүхийн шийдвэрийг сайн дураараа биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэнэ” гэж зааснаас харагдана. Түүнчлэн Эрүүгийн хууль¹², Иргэний хууль¹³, Зөрчлийн тухай хууль¹⁴, Төрийн албаны тухай хууль¹⁵-д хууль зүйн хариуцлага хүлээлгэх санкцыг тусгайлан хуульчилснаар илэрнэ.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлбөр төлөгч субъектээс хамаарч төлбөр төлөгч-иргэн, төлбөр төлөгч-хуулийн этгээд гэж шийдвэр гүйцэтгэх гүйцэтгэх арга, журмаас нь хамааран мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагаа, эд хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагаа, эд хөрөнгийн бус шаардлага буюу тодорхой үүрэг гүйцэтгэх, гүйцэтгэхгүй байхыг даалгасан шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа, тэжээн тэтгэх үүрэг буюу хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаа гэж хуваан авч үзэж болно.

Шийдвэр гүйцэтгэгч нь гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөрийг төлбөр төлөгчөөс гаргуулан төлбөр авагчийн зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх зорилгоор ШШГТХ-д заасан арга, журмын дагуу төлбөр төлөгчид эд хөрөнгө байгаа эсэх талаар хуульд заасан журмаар мэдээлэл олж авах, төлбөр төлөгчийн мөнгөн хадгаламж болон харилцах данснаас хасалт хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, албадан барьцаалах, эд хөрөнгийг хураах, худалдан борлуулахтай холбогдсон ажиллагааг явуулна.

Шийдвэр гүйцэтгэгч ШШГТХ-р тогтоосон төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө, эсхүл үнэт цаас, түүнчлэн үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, бусад хөрөнгөөс төлбөрийг албадан гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дарааллыг баримтална. Түүнчлэн төлбөр

¹¹ Шүүхийн тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 2021. №05

¹² Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 2016. №07

¹³ Иргэний хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 2002. №7

¹⁴ Зөрчлийн тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 2017. №24

¹⁵ Төрийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 2018. №01

төлөгчийн эдийн бус хөрөнгө¹⁶, гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгө¹⁷, хуваарьт хөрөнгө¹⁸ хэсгээр буюу хамтран өмчлөх төлбөрийн шаардлага хангахуйц хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааг зохион байгуулдаг.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх, төлбөр барагдуулах хамгийн гол арга хэрэгсэл нь баталгаажуулах арга хэмжээ бөгөөд энэ нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтийн үр дүнтэй шууд холбогдоно. 2017 оны ШШГТХ-ийн хүрээнд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг нарийвчлан судлах нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлахад чухал ач холбогдолтой гэж үзлээ.

Хүснэгт 1. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гүйцэтгэх хуудас, мөнгөн дүнгийн биелэлтийн судалгаа (2018-2024 он)

№	Үзүүлэлт		Оны эхний үлдэгдэл	Шинээр	Төлбөр			
					Биелүүлбэл зохих	Биелүүлсэн	Үлдэгдэл	хувь
1.	2018 он	ГХ	19753	21707	38579	20054	18525	52.0
		МД /мян/	1,153,438,552.3	751,409,970.8	1,848,896,314.6	504,376,269.1	1,344,520,045.6	27.3
2.	2019 он	ГХ	18525	22104	40999	21191	19808	51.7
		МД /мян/	1,344,520,045.4	636,517,933.8	1,908,853,931.1	303,480,377.5	1,605,373,553.6	15.9
3.	2020 он	ГХ	19808	25981	39342	20323	19019	51.7
		МД /мян/	1,605,346,793.7	902,524,371.0	1,697,156,314.6	381,292,706.4	1,315,863,608.2	22.5
4.	2021 он	ГХ	19019	21426	36321	19693	16628	54.2
		МД /мян/	1,315,863,593.9	867,917,198.6	1,789,663,574.6	339,059,456.5	1,450,604,118.1	18.9
5.	2022 он	ГХ	16628	35940	44731	24406	20325	54.6
		МД /мян/	1,450,604,118.1	2,213,311,029.6	2,643,470,326.0	788,362,945.4	1,855,107,380.6	29.8
6.	2023 он	ГХ	20325	40473	52956	30835	22121	58.2
		МД /мян/	1,855,107,380.6	2,193,568,301.3	3,021,398,194.3	646,617,641.6	2,374,780,552.7	21.4
7.	2024 он	ГХ	22121	37879	56920	30301	26619	53.2
		МД /мян/	2,374,780,552.7	1,462,268,468.3	3,486,012,933.9	1,102,875,341.9	2,383,137,592.0	31.6

Иргэний шийдвэр гүйцэтгэх баталгаажуулах арга хэмжээ нь төлбөр төлөгч, түүний хөрөнгийн талаар мэдээлэл цуглуулахаас эхлэх бөгөөд ШШГЕГ-ын “Төрийн

¹⁶ Гуравдагч этгээдэд холбогдох бараа, ажил үйлчилгээ нийлүүлсний төлбөрийг шаардах эрх, гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөр төлөгчийн шаардах эрх, оюуны өмчийг эзэмших, ашиглах, өмчлөх болон тэдгээртэй холбоотой шаардах эрх, төлбөр төлөгчийн эдийн бус бусад хөрөнгийг эдийн бус хөрөнгө гэнэ.

¹⁷ Иргэний хуулийн 126 дугаар зүйлд “Гэрлэснээс хойш хамтран амьдарсан хугацаанд бий болсон гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгөөс бусад хөрөнгө нь гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмч мөн” гэж заасан.

¹⁸ Иргэний хуулийн 127 дугаар зүйлд гэр бүлийн хуваарьт хөрөнгийг гэрлэхийн өмнө олж авсан эд хөрөнгө, мөнгөн хуримтлал, эд хөрөнгийн эрх, өв, бэлэглэлийн журмаар шилжүүлэн авсан мөнгөн хуримтлал, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг худалдсан, арилжсаны үр дүнд олж авсан эд хөрөнгө, мөнгө, амин хувийн хэрэгцээг хангахад зориулсан эд хөрөнгө, оюуны өмчлөлийн зүйлийн үнэ буюу зохиогчийн шагнал, хувийн авъяас, чадвар, ололт амжилтыг сайшаан шагнасаны орлого, хуваарьт эд хөрөнгөөрөө олж авсан, мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хөрөнгө, мөнгө хэмээн заасан.

байгууллагуудын лавлагааны нэгдсэн систем”-ээс мэдээллийг хүлээн авах бөгөөд цахим системд холбогдоогүй төрийн болон бусад байгууллагуудад албан бичгээр хүсэлт гарган хариуг авч, хөрөнгө тогтоогдсон даруйд иргэний гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээг¹⁹ хэрэгжүүлнэ. Үүнд:


- иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд /төлөөлөгчид/, бусад хүн, хуулийн этгээдийн төлөөллийг дуудан ирүүлэх;
- иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд /төлөөлөгчид/, бусад хүн, хуулийн этгээдээс гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелүүлэхэд шаардлагатай баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулан авах;
- төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах;
- төлбөр төлөгч болон бусад этгээдээс төлбөр төлөгчийн хөрөнгийн тухай мэдүүлэг гаргуулан авах, түүнийг төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэх;
- төлбөр төлөгчийн үйл ажиллагаанд холбогдох санхүүгийн болон бусад баримт бичигт үзлэг хийх;
- иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд /төлөөлөгчид/, бусад хүн, хуулийн этгээдэд гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангах зорилгоор тодорхой үүрэг хүлээлгэх, энэ тухай мэдэгдэл хүргүүлэх;
- төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эзэмшиж, ашиглаж байгаа этгээдийн орон байрнаас бусад газар, барилга байгууламж, агуулах сав, эзэмшил газарт нэвтрэн орох, үзлэг хийх;
- төлбөр төлөгчийг албадан нүүлгэхээс бусад тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрснөөр төлбөр төлөгч, түүний эд хөрөнгийг эзэмшиж, ашиглаж байгаа этгээдийн орон байранд нэвтрэн орох, үзлэг хийх;
- гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг биелүүлэх зорилгоор төлбөр төлөгчийн бие, бэлэн мөнгө, бусад хөрөнгөд үзлэг хийх, тэдгээрийг битүүмжлэх, барьцаалах, хураан авах, худалдан борлуулах, хураан авсан эд зүйл, хөрөнгийг хадгалуулах, хамгаалуулахаар хүлээлгэн өгөх;
- хуульд заасан үндэслэл, журмын дагуу битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан эд зүйл, хөрөнгийг үнэлэх, уг ажиллагаанд үнэлгээчнийг оролцуулах;
- төлбөр төлөгчийн эд хөрөнгө, түүний эрхийн бүртгэлийн талаар улсын бүртгэлийн байгууллагад хандах, лавлагаа, тодорхойлолт гаргуулах;
- иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогчоос гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх;
- төлбөр төлөгчийн улсын бүртгэлд бүртгэгдсэн эрхийг түдгэлзүүлэх;
- төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх мөнгөн хадгаламж, харилцах данс дахь хөрөнгөөс суутгал хийх, дансны зарлагын гүйлгээг хаах, банк, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, эсхүл эзэмшиж байгаа дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавих;
- хуульд заасны дагуу төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх;
- үл хөдлөх эд хөрөнгийг төлбөр авагчийн удирдлагад шилжүүлэх;

¹⁹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлд “Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ гэж гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг албадан гүйцэтгэх, эсхүл төлбөр төлөгчийг гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг тогтоосон хугацаанд бүрэн гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн шийдвэр гүйцэтгэгчийн хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг ойлгоно” хэмээн заасан.

- худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөрт тооцон суутгаж төлбөр авагчид шилжүүлэх, уг зорилгоор албадан чөлөөлөх.

“Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ” гэсэн нэр томьёо 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд анх тусгагдсан бөгөөд өмнөх 2002 оны хуулийн 34 дүгээр зүйлд шийдвэр гүйцэтгэх нийтлэг ажиллагаа гэсэн байдлаар хуульчлагдаж байжээ.

Зураг 7. “Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ” нь хууль зүйн нэр томьёоны хувьд нийцэж байгаа талаарх асуулгын дүн:



Шийдвэр гүйцэтгэгчдээс авсан судалгааны дүнд 35 буюу 51.5 хувь нь нийцэж байгаа, 24 буюу 35.3 хувь нь нийцэхгүй өөрчлөх нь зүйтэй, 9 буюу 13.2 хувь нь мэдэхгүй гэж хариулсан бөгөөд боловсролын хувьд магистр зэрэгтэй гүйцэтгэгчийн 56.2 хувь, бакалавр зэрэгтэй гүйцэтгэгчийн 50.9 хувь баталгаажуулах гэсэн нэр томьёог хууль нийцсэн гэж үзжээ.

Кейс 1. Би шүүхийн шийдвэрийн дагуу төлбөр авахаар хариуцсан шийдвэр гүйцэтгэгчтэй уулзахад “Шийдвэр гүйцэтгэлийн баталгаажуулах арга хэмжээ хийгдсэн” гэж хэлсэн. Тэгэхэд нь би миний хүнээс өрөө авах асуудал баталгаатай болчихсон юм байна гэж ойлгоод 3 жил боллоо. Шийдвэр гүйцэтгэгчтэй уулзаад нөгөө баталгаажуулсан арга хэмжээ чинь юу болсон бэ гэхэд явагдаж байна гэх юм, энэ баталгаажуулах арга хэмжээ гэдэг чинь төлбөр авагч миний хувьд ойлгомжгүй юм.

Төлбөр авагч Д.О-той хийсэн ярилцлагаас


Судалгааны дүнд үндэслэн “баталгаажуулах арга хэмжээ” гэсэн нэр томьёог өөрчлөх, эсхүл хууль зүйн агуулгын хувьд шинэчлэн тогтоох шаардлага байна гэж үзлээ.

Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээ”-нд тулгамдаж буй асуудлын талаар судалгаа хийхэд дараах дүн гарлаа. Тулгамдаж буй асуудлын талаар 2 буюу 2.9 хувь хөрөнгө мэдүүлэх гаргуулах, 18 буюу 26.5 хувь нь бусдын орон байранд нэвтрэх, үзлэг, нэгжлэг хийхэд, 1 буюу 1.5 хувь нь битүүмжлэх, 9 буюу 13.2 хувь нь хураан авах, 29 буюу 42.6 хувь нь хөрөнгийг үнэлэх, үнэлгээ тогтоох, 9 буюу 13.2 хувь нь худалдан борлуулах гэж хариулжээ. Тэгвэл хамгийн өндөр үзүүлэлттэй буюу хөрөнгийг үнэлэх, үнэлгээ тогтоох гэж хариулсан шийдвэр гүйцэтгэгчийг ажилласан туршлагаар нь ангилан үзвэл 1 жил хүртэл ажилласан алба хаагчийн 50 хувь, 1-3 жил ажилласан алба хаагчийн 66.6

хувь, 3-6 жил ажилласан алба хаагчийн 41.6 хувь, 6-10 жил ажилласан алба хаагчийн 44.4 хувь, 10-аас дээш жил ажилласан алба хаагчийн 36.6 хувь нь хүндрэлтэй гэж хариулжээ. Тухайлбал, нээлттэй санал асуулгад дараах хариултыг дийлэнх хувь нь өгсөн байна.

- шинжээчийн үнэлгээтэй холбоотой гомдол шүүхэд байнга гардаг;
- хөрөнгийн үнэлгээний байгууллагын хөлс өндөр;
- үнэлгээ бодит бус, хугацаа богино байдаг;
- хөрөнгийн үнэлгээ хийх эрх олгогдсон аймаг бүрд салбартай хуулийн этгээдийг оролцуулах шаардлага тулгардаг;
- хөрөнгийн үнэлгээнд маргаан гаргаад хугацаа хожих, ажиллагааг удаашруулах зэрэг асуудлыг дагуулдаг;
- хөндлөнгийн гэрч олддоггүй гэж санал хүсэлтээ илэрхийлж байсан.

Зураг 8. Иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээнд тулгамдаж буй асуудлын талаарх судалгааны дүн



Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад тодорхой эрх, эрх чөлөө нь хуулийн хүрээнд хөндөгдөж, нөгөөтгээгүүр зөрчигдсөн эрхээ сэргээлгэж байдаг субъектүүд нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд болох төлбөр төлөгч²⁰, төлбөр авагч²¹ нар юм. ШШГТХ-д төлбөр төлөгчийн хүлээх үүргийг “төлбөр төлөгч тодорхой үйлдэл хийх, эсхүл түүнээс татгалзах, эд хөрөнгө, мөнгийг шилжүүлэх, оршин суугаа /оршин байгаа/ газрын хаягийг өөрчилсөн бол шийдвэр гүйцэтгэгчид даруй мэдэгдэх болон гүйцэтгэх баримт бичиг, хууль тогтоомжид заасан бусад үүрэг хүлээнэ” гэж ерөнхий байдлаар заасан бол ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлд хэргийн оролцогчдын эрх, үүргийг дараах байдлаар нарийвчлан тусгасан байна. Үүнд:

- шүүхэд хэргийн талаар үнэн зөв тайлбар гаргах;
- шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлага, түүнийг үгүйсгэх, татгалзах үндэслэл, тайлбар түүнтэй холбоотой баримтыг өөрөө нотлох, нотлох баримтыг цуглуулах, гаргаж өгөх;
- шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх;

²⁰ Төлбөр төлөгч гэж төлбөр авагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, үүргээ биелүүлээгүй гэж гүйцэтгэх баримт бичигт заасан хүн, хуулийн этгээдийг хэлнэ.

²¹ Төлбөр авагч гэж эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж түүнийг сэргээх, хамгаалахаар гүйцэтгэх баримт бичигт заасан хүн, хуулийн этгээдийг хэлнэ.

- шүүхийн тавьсан шаардлагыг биелүүлэх;
- хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, шүүх хуралдааны дэгийг сахих;
- шүүхийн шийдвэрийг гардаж авах, биелүүлэх зэргээр хуульчилсан байна.

ШШГТХ-д төлбөр төлөгчийн үүргийг тодорхой зааж өгөөгүй нь төлбөр төлөгч шүүхийн шийдвэрийг үл биелүүлдэг, шийдвэр гүйцэтгэгчийн тавьсан хууль ёсны шаардлагыг үл тоодог, биелүүлдэггүй, дүр эсгэж биелүүлдэг, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд санаатайгаар саад учруулж, удаашруулдаг, шийдвэр гүйцэтгэгчид ажлын ачаалал бий болгох зэрэг сөрөг үр дагаврыг дагуулж байна.

Асуудал 1. ШШГТХ-ийн 33 дугаар зүйлд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тал болох төлбөр төлөгч, төлбөр авагчийн эрх, үүргийг ерөнхий байдлаар зохицуулснаас шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад ялгамжтай хандах нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд ажиллагаа бүрд талуудын эрх, үүргийг тусгасан хэм хэмжээг зохицуулах шаардлага байна. Тухайлбал, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг төлбөр авагч урьдчилан төлөх, төлбөр төлөгчөөс нөхөн төлүүлэх үүргийг 33 дугаар зүйлд тусгаагүй нь учир дутагдалтай байна.

Иймд ШШГТХ-д төлбөр төлөгчийн хүлээх үүргийг дараах байдлаар тодорхойлох нь зүйтэй гэж үзлээ.

- төлбөр төлөгч тодорхой үйлдэл хийх, эсхүл түүнээс татгалзах;
- эд хөрөнгө, мөнгийг шилжүүлж өгөх;
- оршин суугаа /оршин байгаа/ газрын хаягийг өөрчилсөн бол шийдвэр гүйцэтгэгчид даруй мэдэгдэх;
- гүйцэтгэх баримт бичиг, хууль тогтоомжид заасан үүргийг биелүүлэх;
- шийдвэр гүйцэтгэгчийн дуудсанаар хүрэлцэн ирэх;
- шийдвэр гүйцэтгэгчийн тавьсан шаардлагыг биелүүлэх;
- шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг гардаж авах, биелүүлэх.

Төлбөр төлөгчийн үүргийг тодорхой болгосноор хариуцлагыг нэмэгдүүлж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа тасралтгүй, хурдан шуурхай явагдах нөхцөл хангагдана.

Асуудал 2. ШШГТХ-ийн 27 дугаар зүйлд заасан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх зохицуулалтын хүрээнд ШШГБ-ын хэмжээнд байгаа нийт түдгэлзүүлсэн баримт бичгийн зүйл заалтаар нь ангилан авч үзвэл Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан түдгэлзүүлсэн 669 гүйцэтгэх баримт бичиг, шүүхэд болон дээд шатны байгууллагад гомдол, нэхэмжлэл гаргасантай холбогдуулан ахлах шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрээр 84 гүйцэтгэх баримт бичиг, нийт 753 гүйцэтгэх баримт бичиг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан түдгэлзүүлжээ.

Шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргасан үндэслэлээр түдгэлзүүлсэн тохиолдолд 6 сараас 5 жилийн хугацаагаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа түдгэлзэж байна. Тухайлбал, хураасан хөрөнгөтэй холбогдуулан шүүхэд гомдол гаргаад 3 шатны шүүхээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох, шийдвэрлэсэн шийдвэрийг хүлээн авч хөрөнгийн үнэлгээ тогтоох ажиллагаа явуулахад тухайн хөрөнгийн үнэлгээтэй холбогдуулан шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах, хөрөнгийн үнэлгээг 3 шатны шүүхэд гомдол гаргах, дуудлага худалдаа зохион байгуулахад дахин 1, 2 дугаар дуудлага худалдаанд гомдол гаргах, гомдол хянан шийдвэрлэх хугацаанд хөрөнгийн үнэлгээ тогтоох 6 сарын хугацаа өнгөрсөн бол дахин

үнэлгээ тогтоох гэхчлэн нэг гүйцэтгэх баримт бичигт нийт 8 удаа шүүхэд гомдол гаргаж, 14 жилийн хугацаагаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх боломжтой байна.

Хүснэгт 2. Шүүхээс иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдол, маргаан шийдвэрлэсэн байдал

Он	Үнэлгээний талаарх маргаан	Дуудлага худалдааны журам зөрчсөн	Хөдлөх хөрөнгийг худалдсан маргаан	Төлбөр төлөгчийн цалин хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос төлбөр гаргуулсан маргаан	Бусад	Бүгд
2017	206	61	10	98	9	384
2018	182	49	13	2	77	323
2019	203	39	12	7	85	346
2020	314	80	3	1	91	489
2021	283	56	10	0	67	416
2022	246	34	16	2	91	389
2023	229	20	8	1	122	380
Нийт	1663	339	72	111	542	2727

ШШГТХ-ийн 44.4, 55.7, 63.4, 86.7, 90.7, 103.4, 106.1, 122.1 дэх заалтад талууд болон гуравдагч этгээдийн шүүхэд гомдол гаргах эрхийг зааснаар талуудад болон гуравдагч этгээдэд олгосон байна. Тухайлбал, 44.4-д “ахлах шийдвэр гүйцэтгэгч гомдлыг 14 хоногийн дотор шийдвэрлэж, тогтоол гаргана. Тогтоолыг зөвшөөрөөгүй тохиолдолд хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид, ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно”, 63.4-д “иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд хөрөнгийг албадан худалдан борлуулах шийдвэрийн талаар болон хөрөнгийн үнэлгээний талаар энэ хуулийн 55.7-д заасны дагуу шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлсэн бол тухайн асуудлаар хөрөнгө албадан худалдан борлуулах ажиллагааны явцад шүүхэд дахин гомдол гаргах эрхгүй”, 86.7-д “төлбөр авагч нь төлбөр төлөгчид ногдох хөрөнгийн хувь, хэмжээг тогтоолгохоор шүүхэд хандана”, 90.7-д “төлбөр төлөгч хөдөлмөрийн чадваргүй болсон тохиолдолд тухайн хугацааны тэтгэлгийн хэсгийг, эсхүл бүхэлд нь нөхөн төлүүлэхээс чөлөөлүүлэх хүсэлтээ шүүхэд гаргаж болно”, 103.4-д “хуулийн этгээд татан буугдсан, өөрчлөн байгуулагдсаны улмаас шийдвэрийг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч тухайн баримт бичгийг шүүхэд буцаах тухай шийдвэр гаргаж, ахлах шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлнэ” 106.1-д “бие даасан шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дагуу худалдан борлуулсан хөрөнгөөс шаардлагаа хангуулахаар тухайн эд хөрөнгө байгаа газрын шүүхэд гомдол гаргах эрхтэй” гэж тус тус тусгажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зохицуулалтаас үзвэл иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гаргаж буй гомдлыг урьдчилан шийдвэрлэх журам хэрэглэх гомдол, шүүхэд шууд гаргах гомдол гэж 2 хувааж үзнэ.


Урьдчилан шийдвэрлэх журам хэрэглэх гомдолд ШШГТХ-ийн 44 дүгээр зүйлд заасан ажиллагаанд гаргасан гомдлууд хамаарна. Харин шүүхэд шууд гаргаж буй гомдолд материаллаг эрх зүйн шаардах эрхтэй холбоотой гомдлууд хамаарч байна. Энэ талаар ШШГТХ-ийн 55 дугаар зүйлийн 55.7, 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсгийн агуулгаас харж болно. Тухайлбал, 55.7-д “талууд эд хөрөнгийн үнэлгээний талаарх гомдлоо энэ хуулийн

55.3-т заасны дагуу мэдэгдсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор шүүхэд гаргаж болно”, 122.1-т” төлбөр гаргуулахаар хураагдсан хөрөнгийн өмчлөх эрхтэй холбогдсон маргаан үүссэн тохиолдолд холбогдох хүн, хуулийн этгээд тухайн эд хөрөнгийг битүүмжлэх эд хөрөнгийн жагсаалтаас хасуулах, чөлөөлүүлэх тухай нэхэмжлэлээ шүүхэд гаргаж болно” гэж заасан.

Хэдийгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан 753 гүйцэтгэх баримт бичгийг түдгэлзүүлсэн мэт боловч нэг төлбөр төлөгчтэй хэд хэдэн төлбөр авагчид холбогдох баримт бичиг байгаа нөхцөлд ШШГТХ-ийн 28, 112 дугаар зүйлд заасны дагуу нэгтгэн гүйцэтгэж байгаа, дараалалд орсон 7484 гүйцэтгэх баримт бичгийн ажиллагааг түдгэлзүүлсэн байна. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан шүүхэд гаргасан нийт гомдол, нэхэмжлэлийг шүүх хянан үзээд нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн 68 хувь, албадлагын арга хэмжээг хүчингүй болгож шийдвэрлэсэн 7 хувь, нэхэмжлэлийг буцааж шийдвэрлэсэн 25 хувь байна.

Хөрөнгийн үнэлгээ тогтоохдоо ШШГХТ-ийн 55 дугаар зүйлд заасан талууд үнэлгээ тохиролцох, шийдвэр гүйцэтгэгч үнэлгээ тогтоох, үнэлгээчин тогтоох зохицуулалтыг ШШГБ-аас хамааралгүйгээр хөрөнгийн үнэлгээ тогтоох эрх бүхий байгууллага үнэлгээчин, бүрэлдэхүүнтэй үнэлгээчин томилж үнэлдэг байх, бүрэлдэхүүнтэйгээр үнэлсэн нөхцөлд үнэлгээтэй холбогдуулан дахин гомдол эрхгүй байхаар зохицуулах нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулж байгаа, шүүхийн үйл ажиллагаанд зориудаар ачаалал үүсэж байгаа нөхцөл байдлыг арилгах боломжтой байна.

Зураг 9. Шүүхээс үнэлгээтэй холбоотой хэрэг, маргаан шийдвэрлэсэн байдал



Иргэний шийдвэр гүйцэтгэх баталгаажуулах ажиллагаанд хамгийн их маргаан дагуулдаг хөрөнгийн үнэлгээ хийлгэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хоёр өөр ойлголтоор оруулснаас шинжээчид /үнэлгээчин/ хариуцлага хүлээлгэх боломжгүй болсон.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ШШГЕГ-ын даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/167, 2018 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/166, 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/111, 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/170, 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/09 тоот тушаалаар батлагдсан “Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хэрэглэх хэвлэмэл маягтын жагсаалт” бүхий нийт 59 маягтыг ашиглаж байна. Шийдвэр

гүйцэтгэгчийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гаргах шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх ба маягт №16 -д заасан шинжээч томилох тогтоолыг үйлддэг.

ШШГТХ-ийн 42 дугаар зүйлд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шинжээч оролцох эрх зүйн зохицуулалтыг тусгаж өгсөн бөгөөд “иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад мэргэжлийн тусгай мэдлэг шаардсан асуудлаар дүгнэлт гаргуулах зорилгоор шинжилгээ хийж, дүгнэлт гаргах тусгай мэдлэг бүхий, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүнд хувийн ашиг сонирхолгүй этгээдийг шинжээчээр томилон оролцуулна”, 44 дүгээр зүйлийн 44.2.9 дэх хэсэгт “хуульд заасан үндэслэл, журмын дагуу битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан эд зүйл, хөрөнгийг үнэлэх, уг ажиллагаанд үнэлгээчнийг оролцуулах”, 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэгт “дараах хөрөнгийг Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 3.1.1-д заасан үнэлгээчнээр үнэлүүлнэ”, 55.3 дахь хэсэгт “шийдвэр гүйцэтгэгч хөрөнгийн үнэлгээг үнэлгээчнээр тогтоолгосон бол үнэлгээчний тайланг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор талуудад мэдэгдэж, тайланг танилцуулж, санал хүсэлтийг авч тэмдэглэл хөтөлнө” гэж заасан.


Шинжээч болон үнэлгээчин гэх ойлголт нь хоорондоо ялгаатай, тухайлбал, Шүүхийн шинжилгээний тухай хууль²²-д “шинжээч гэж шүүх шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаар хуульд заасан журмын дагуу томилогдсон тусгай мэдлэг бүхий хүнийг”, “шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд гэж мөрдөгч, прокурор, шүүгч, шүүх, арбитр болон зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээдийг” хэлнэ гэж хуульчилсан бөгөөд шинжээчийг зөвхөн дээрх заасан эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр томилно. Эрх зүйн зохицуулалтыг харвал шийдвэр гүйцэтгэгч хөрөнгийн үнэлгээ тогтоох иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ шинжээчийг томилох эрх бүхий этгээд биш байна. Хөрөнгийн үнэлгээний тухай хууль²³-д “үнэлгээчин гэж энэ хуулийн 15.1-д заасан үнэлгээ хийх эрх авсан иргэнийг”, “үнэлгээний хуулийн этгээд гэж хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанийг хэлнэ” гэж заажээ. Хөрөнгийн үнэлгээ хийх гэж тодорхой зорилгод нийцүүлэн хөрөнгийн үнэлгээний зүйлийн үнэ цэнийг тогтоох хараат бус үйл ажиллагааг²⁴ хэлэх тул шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хураагдсан хөрөнгийг гэрээ байгуулан үнэлгээчин томилж үнэлүүлэх ёстой байна.

Зураг 10. “Хөрөнгийн үнэлгээчний тайланг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор талуудад мэдэгдэж, тайланг танилцуулж, санал хүсэлтийг авч тэмдэглэл хөтөлнө” гэсэн зохицуулалтын талаарх асуулгын дүн:

²² Шүүхийн шинжилгээний тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 2023. №05.

²³ Хөрөнгийн үнэлгээний тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 2022. №37.

²⁴ Хөрөнгийн үнэлгээний тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 2022. №37.



Шийдвэр гүйцэтгэгч нараас хөрөнгийн үнэлгээчний тайланг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор талуудад мэдэгдэж, тайланг танилцуулж, санал хүсэлтийг авч тэмдэглэл хөтөлнө” гэсэн зохицуулалтын талаарх асуултад хариулсан үзүүлэлтээс үзэхэд 13 буюу 19.1 хувь нь зөв зохицуулалт, 55 буюу 80.9 хувь нь хугацаа хэт бага тул хугацааг нэмэгдүүлэх шаардлагатай гэжээ. Энэхүү хариултыг шийдвэр гүйцэтгэгчийн боловсролын байдалтай харьцуулан үзвэл бакалавр зэрэгтэй алба хаагчийн 76.4 хувь, магистр зэрэгтэй алба хаагийн 93.7 хувь, доктор 100 хувь хугацаа хэт бага байна гэж үзжээ.

Шинжээч, үнэлгээчин гэх ойлголт нь эрх зүйн зохицуулалтын хувьд тухайн үйл ажиллагаанд ашиглагдах “Хөрөнгийн үнэлгээний тухай хууль”, “Шүүх шинжилгээний тухай хууль”-ийг тус тус удирдлага болгон ажилладаг тусдаа мэргэжил бөгөөд гагцхүү “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуульд эдгээр ойлголтыг зааглаж шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ямар тохиолдолд эдгээр мэргэжилтнийг оролцуулах талаар тодорхой тусгаагүй нь учир дутагдалтай гэж үзлээ.

Төлбөр төлөгч нь хөрөнгөтэй, шүүхийн шийдвэр биелэгдэх боломжтой байхад шүүхэд удаа дараа гомдол, нэхэмжлэл гаргаж, шүүхийн ачааллыг зохиомлоор нэмэгдүүлж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулж байна. Энэ нь ШШГТХ-д талууд болон гуравдагч этгээдээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үед шат бүрд гомдол гаргах эрхийг олгосон нь төлбөр төлөгчийг төлбөр төлөхөөс зайлсхийх, хугацаа хожих, гүйцэтгэх баримт бичгээр тогтоосон төлбөрийн шаардлага биелэгдэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд ШШГТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх заалтыг хасах, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа бүрд шүүхэд гомдол гаргах эрхийг тусгасан ШШГТХ-ийн 55.7, 63.4, 87.7, 106.1 дэх заалтыг өөрчлөх шаардлага байна.

Түүнчлэн Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч, гуравдагч этгээдийн зүгээс урьдчилан шийдвэрлэх журам хэрэглэх гомдол буюу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан ажиллагаанд гомдол гаргасан бол ахлах шийдвэр гүйцэтгэгч гомдлыг сайтар шалгаж үндэслэлтэй бол даруй ажиллагааг хүчингүй болгож дахин явуулах шийдвэр гаргаж сурах шаардлагатай байна. Тухайлбал шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад процессийн алдаа гаргаагүй боловч шийдвэр гүйцэтгэгч гаргасан тогтоол, тэмдэглэлээ алдаатай эсхүл зөрүүтэй үйлдсэн бол ажиллагааг хүчингүй болгоод дахин эхлүүлэх нь гомдол гаргагчийн эрхийг хангах төдийгүй шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шүүхэд гомдол гаргуулахгүй шуурхай явуулах нөхцөл бүрдэх болно.

Асуудал 3. ШШГТХ-ийн 49, 50, 51, 52, 53 дугаар зүйлд хөрөнгө битүүмжлэх, хураах, хадгалах, үнэлгээ тогтоох ажиллагааны талаар тусгасан. Хөрөнгө битүүмжлэх ажиллагааны

зорилго нь төлбөр төлөгчийн хөрөнгө үрэгдэх, бусдад шилжих эрсдэлээс хамгаалах зорилгоор дараалал харгалзахгүй хийгддэг баталгаажуулах арга хэмжээний чухал төрөл байдаг. Энэ ажиллагааг явуулахад хүрээг хууль тогтоогч тодорхойлохдоо ШШГТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт зааснаар зохицуулжээ. Өөрөөр хэлбэл, битүүмжлэх хөрөнгийн хэмжээ нь шийдвэрт заасан мөнгөн хөрөнгийн хэмжээний эзлэх хувийг харгалзан үзэх байдлаар тогтоогдохыг хууль тогтоогч тодорхойлжээ. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад эд хөрөнгө битүүмжлэн хураах ажиллагааг хуулийн дагуу үүсэх барьцаа гэж тайлбарлагддаг бөгөөд үндсэн үүргийн гүйцэтгэлийн хэмжээнээс хэт их давсан барьцаа байж болохгүй талаарх барьцааны эрх зүйд хамаарах зарчмыг хууль тогтоогч шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хязгаарлалт болгож мөн зохицуулсан гэж дүгнэхээр байна.

Битүүмжлэх ажиллагаагаар хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн хэдий ч баталгаажуулах арга хэмжээний дарааллын дагуу тухайн хөрөнгийг тогтоолоор битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, худалдан борлуулах дарааллыг баримталдаг.

Энэ нь захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн хэр нь дахин битүүмжилж хугацаа олгох, олгосон хугацаа дуусах үед хөрөнгийг хураан авах, хураан авснаас хойш 1 сарын хугацаанд талуудыг үнэлгээ тохиролцох, үнэлгээчин томилж үнэлгээ тогтоолгох, тогтоосон үнэлгээнд шүүхэд гомдол гаргах, гомдлыг хянан шийдвэрлэсний дараагаар худалдан борлуулах эсхүл 6 сарын хугацаа өнгөрсөн бол дахин үнэлгээ тогтоож, худалдан борлуулах гэсэн дарааллаар баталгаажуулах арга хэмжээг гүйцэтгэж байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дээрх дарааллыг хөрөнгө бүрд ижил байхаар тогтоосон нь хугацаа алдах, гомдол гаргах үндэслэлийг бүрдүүлж байх тул захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн хөрөнгөд явуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалалд хураан авсан даруйд үнэлгээ тогтоох шийдвэр гаргах дарааллаар тогтоох шаардлагатай байна. Дээр дурдсанчлан иргэний эрх зүйд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад эд хөрөнгө битүүмжлэн хураах ажиллагааг хуулийн дагуу үүсэх барьцаа гэж тайлбарладаг тул ШШГТХ-ийн 49-д заасан “төлбөр төлөгчийн хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах” гэсэн зүйлээс хөрөнгө барьцаалах талаарх зохицуулалтыг хасах нь зүйтэй байна.

Асуудал 4. ШШГТХ-ийн 63-75 дугаар зүйлд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөрт гаргуулсан хөрөнгийг худалдан борлуулах ажиллагааг ШШГТХ-ийн 63-75 дугаар зүйлд хуульчилсан. Худалдан борлуулах ажиллагааны үе шатыг төлбөр төлөгч өөрийн хөрөнгийг худалдан борлуулах, анхны албадан дуудлага худалдаа, хоёр дахь албадан дуудлага худалдаа гэсэн дарааллаар худалдан борлуулахаар хуульчилсан.

Худалдан борлуулах ажиллагааны үе шат бүрд талууд болон өмчлөгч гомдол гаргах зохицуулалтыг тусгасан нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулах үндэслэлийг бүрдүүлж байна. Тухайлбал, үнэлгээ тогтоож худалдан борлуулах нь нэгэнт тодорхой болсон хөрөнгө дээр ШШГТХ-ийн 66 дугаар зүйлийн 66.3 дах заалтад “шийдвэр гүйцэтгэгч дуудлага худалдаа явуулах тухай ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолыг улсын бүртгэлийн байгууллагад болон төлбөр төлөгчид хүргүүлнэ” гэсэн заалтын хүрээнд төлбөр төлөгчид шуудангаар тогтоол очоогүй үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хүчингүйд тооцогдох боломж бүрдэж байна.

Худалдан борлуулах ажиллагаанд үнэлгээ тогтоосон шийдвэрийг танилцуулж, худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдэд шилжүүлж, худалдан борлуулсан

хөрөнгийн үнээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал болон төлбөрийн үнийг төлүүлдэг байх нь зүйтэй байна.

Түүнчлэн ШШГТХ-ийн 41 дүгээр зүйлд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр төлөгчийн орон байр, эд хөрөнгө байгаа газарт нэвтрэх, эд хөрөнгөд үзлэг, нэгжлэг хийх, түүнийг хураан авах ажиллагааг хөндлөнгийн хоёроос доошгүй гэрчийн оролцоотой явуулахаар заасан. Гэвч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хөндлөнгийн гэрч олдохгүй, хөндлөнгийн гэрчийг урьж оролцуулах ажиллагаанд хүндрэл учирдаг. Иймд шүүхийн иргэдийн төлөөлөгч оролцуулдаг зарчмын дагуу хөндлөнгийн гэрчийг оролцуулах эрх зүйн үндэслэлийг бий болгох нь гэрч оролцуулан хийгдэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хүчингүйд тооцогдох эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой байна. Дээрх шийдвэр гүйцэтгэх албадан ажиллагаатай холбоотой зарим нэг зохицуулалтын явцад иргэн, хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны явцад салбарын болон бусад хуулиудын уялдаа холбоо хангалттай зохицуулагдаагүй байна гэж үзлээ.

Асуудал 5. ШШГТХ-ийн 42 дугаар зүйлд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шинжээч оролцох эрх зүйн зохицуулалтыг тусгаж өгсөн бөгөөд “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад мэргэжлийн тусгай мэдлэг шаардсан асуудлаар дүгнэлт гаргуулах зорилгоор шинжилгээ хийж, дүгнэлт гаргах тусгай мэдлэг бүхий, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүнд хувийн ашиг сонирхолгүй этгээдийг шинжээчээр томилон оролцуулна”, 44 дүгээр зүйлийн 44.2.9 дэх хэсэгт “хуульд заасан үндэслэл, журмын дагуу битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан эд зүйл, хөрөнгийг үнэлэх, уг ажиллагаанд үнэлгээчнийг оролцуулах”, 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэгт “дараах хөрөнгийг Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 3.1.1-д заасан үнэлгээчнээр үнэлүүлнэ”, 55.3 дахь хэсэгт “шийдвэр гүйцэтгэгч хөрөнгийн үнэлгээг үнэлгээчнээр тогтоолгосон бол үнэлгээчний тайланг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор талуудад мэдэгдэж, тайланг танилцуулж, санал хүсэлтийг авч тэмдэглэл хөтөлнө” гэж тус тус заасан.

Шинжээч болон үнэлгээчин гэх ойлголт нь хоорондоо ялгаатай юм. Тухайлбал, Шүүхийн шинжилгээний тухай хуульд “шинжээч гэж шүүх шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаар хуульд заасан журмын дагуу томилогдсон тусгай мэдлэг бүхий хүнийг”, “шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд гэж мөрдөгч, прокурор, шүүгч, шүүх, арбитр болон зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээдийг” хэлнэ гэж хуульчилсан бөгөөд шинжээчийг зөвхөн дээрх заасан эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр томилно. Эрх зүйн зохицуулалтыг харвал шийдвэр гүйцэтгэгч хөрөнгийн үнэлгээ тогтоох иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ шинжээчийг томилох эрх бүхий этгээд биш байна. Хөрөнгийн үнэлгээний тухай хууль -д “үнэлгээчин гэж энэ хуулийн 15.1-д заасан үнэлгээ хийх эрх авсан иргэнийг”, “үнэлгээний хуулийн этгээд гэж хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанийг хэлнэ” гэж заажээ. Хөрөнгийн үнэлгээ хийх гэж тодорхой зорилгод нийцүүлэн хөрөнгийн үнэлгээний зүйлийн үнэ цэнийг тогтоох хараат бус үйл ажиллагааг хэлэх тул шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хураагдсан хөрөнгийг гэрээ байгуулан үнэлгээчин томилж үнэлүүлэх ёстой байна.

Шинжээч, үнэлгээчин гэх ойлголт нь эрх зүйн зохицуулалтын хувьд тухайн үйл ажиллагаанд ашиглагдах “Хөрөнгийн үнэлгээний тухай хууль”, “Шүүх шинжилгээний тухай хууль”-ийг удирдлага болгон ажилладаг мэргэжил бөгөөд гагцхүү “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуульд эдгээр ойлголтыг зааглаж шийдвэр гүйцэтгэх

ажиллагааны ямар тохиолдолд эдгээр мэргэжилтнийг оролцуулах талаар тодорхой тусгаагүй.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хамгийн их маргаан дагуулдаг хөрөнгийн үнэлгээ хийлгэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг ШШГТХ-д хуульд хоёр өөр ойлголтоор тусгасан 42 дугаар зүйлийг “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд үнэлгээчин оролцох” өөрчлөх шаардлагатай байна. Түүнчлэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд ШШГЕГ-ын даргын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/167, 2018 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/166, 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/111, 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/170, 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/09 тоот тушаалаар батлагдсан “Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хэрэглэх хэвлэмэл маягтын жагсаалт” бүхий нийт 59 маягтыг ашиглаж байна. Шийдвэр гүйцэтгэгчийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гаргах шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх ба маягт №16 -д заасан шинжээч томилох тогтоолыг үнэлгээчин томилох тогтоол болон залруулах нь зүйтэй.

3.2. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах арга хэмжээний эрх зүйн зохицуулалт:

Хүүхдийг тэжээн тэтгэх үүрэг нь хүүхдийг эрүүл орчинд өсөж хүмүүжихэд шаардлагатай хэрэгцээт наад захын зүйлсийг хангахад чиглэгддэг. Хүүхдийн тэтгэлэг гэж хуульд заасан хэмжээ, хугацаагаар мөнгөн болон эд хөрөнгөөр гаргуулж, тэжээн тэтгүүлэгч хүүхдийн хэрэгцээнд зарцуулах хөрөнгийг хэлнэ. Гэр бүлийн тухай хуулийн 38.1-д зааснаар эцэг, эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй. Энэхүү үүргээ эцэг, эх нь харилцан тохиролцож гэрээ байгуулан шийдвэрлэж болохоор хуульд заасан боловч тэтгэлгийн хэмжээг харилцан тохиролцоогүй, тохиролцоонд хүрч чадаагүй, гэрээ байгуулаагүй тохиолдолд тэтгэлгийн хэмжээг хүүхдийн насны байдлыг харгалзан шүүх тогтоодог.

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааг Гэр бүлийн тухай хууль²⁵, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг үндэслэн явуулж байна. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаа нь хэдийгээр иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэгэн адил явагдах боловч гэр бүлийн хүрээнд явагддаг өвөрмөц ажиллагаа юм.

Хүүхдийн тэтгэлгийг мөнгийг тухайн тэжээн тэтгүүлэгч хүүхдийн оршин суугаа нутаг дэвсгэрт тогтоосон амьжиргааны доод түвшний тодорхой хувь хэмжээгээр тооцон төлбөр төлөгчөөс гаргуулан тэтгэлэг авагчид олгоно. Шүүх хүүхдийн насыг харгалзан сард төлүүлэх тэтгэлгийг хэмжээг 11 хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшний 50 хувиар, 11-16 нас /суралцаж байгаа бол 18 нас/-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшний 100 хувиар тооцдог.

Монгол Улсын “Хүн амын амьжиргааны доод түвшнийг тодорхойлох тухай” хуулийн 3 дугаар зүйлд зааснаар хүн амын амьжиргааны доод түвшин гэж “хэрэглээний доод хэмжээ”-г мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг хэлэх бөгөөд, “хэрэглээний доод хэмжээ” гэж хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэгцээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон тоо, хэмжээг ойлгоно хэмээн заасан. Хүн амын амьжиргааны доод түвшнийг жил бүр тодорхойлно. Ингэхдээ тухайн жилийн бараа, бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөөс хамаарч жилд 1-ээс доошгүй удаа шинэчлэн тодорхойлох бөгөөд дэлхийн улс орнуудад өргөн хэрэглэгддэг хэрэглээний сагс, хэрэглээний үнийн индексийг үндэслэн тооцдог аргыг өөрийн орны онцлог нөхцөлтэй уялдуулан хэрэглэнэ. Хүн амын амьжиргааны доод түвшнийг бүсийн ялгавартайгаар бүсчилсэн хөгжлийн баримт бичигт тусгагдсан бүсээр тодорхойлдог. Үүнд:

1. Баруун бүс: Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд;
2. Хангайн бүс: Архангай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Хөвсгөл, Орхон;
3. Төвийн бүс: Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул;
4. Зүүн бүс: Дорнод, Сүхбаатар, Хэнтий;
5. Улаанбаатар: Улаанбаатар хот хамрагдана.

Хүүхдийн тэтгэлгийг Гэр бүлийн тухай хуульд зааснаар сар, улирал, жилээр болон нэг удаа бөөнд нь мөнгөн хэлбэрээр болон эд хөрөнгөөр олгож болно. Тэтгэлгийг эд

²⁵ Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 1999. №30.

хөрөнгөөр олгохоор талууд харилцан тохиролцсон бол эд хөрөнгийг орон нутгийн зах зээлийн тухайн үеийн ханшаар үнэлнэ.

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаа нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бусад ажиллагаанаас дараах онцлогоор ялгагдана. Үүнд:

- хүүхдийн тэтгэлэг нь сар бүр тодорхой мөнгөн дүнгээр давтамжтайгаар төлөгддөг;
- хүүхдийн тэтгэлэг нь хүүхдийн насны байдлаас хамааран өөр өөрөөр тогтоогддог бөгөөд 11 нас хүрсэн бол төлөх хэмжээ 1 дахин нэмэгдэж байдаг;
- хүүхдийн тэтгэлгийг хэмжээ жил бүр 1 удаа, зарим жилд 2 удаа амьжиргааны доод түвшний хэмжээнээс хамааран өөрчлөгддөг;
- хүүхдийн тэтгэлэг гаргуулах шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явцад тэтгэлэг төлөгч хэд хэдэн төлбөр төлөх үүрэг хүлээсэн бол хүүхдийн тэтгэлгийг дараалал харгалзахгүй тэргүүн ээлжид олгоно;
- хүүхдийн тэтгэлэг гаргуулах шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь хүүхдийг 18 нас хүртэлх хугацааны тэтгэлгийг бүрэн төлж дуусах хүртэл үргэлжилнэ. Тэтгэлэг авагч хүүхэд 18 нас хүрсэн ч тэтгэлгээ бүрэн аваагүй бол тэтгэлэг гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа тэтгэлгийг бүрэн гаргуулах хүртэл үргэлжлэн явагдах ёстой.

ШШГТХ-ийн 110 дугаар зүйлд зааснаар хүүхдийн тэтгэлгийн мөнгийг дараах журмаар олгодог. Үүнд:

1. Төлбөр төлөгчийн цалин хөлс, бусад орлогоос суутгал хийсэн хүн, хуулийн этгээд түүнийг төлбөр авагчид бэлнээр олгох, эсхүл харилцах болон хадгаламжийн дансанд шилжүүлэх;
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд шилжиж орсон тэтгэлгийн мөнгийг банкаар дамжуулан төлбөр авагчид бэлнээр олгох, эсхүл түүний хадгаламжийн дансанд, эсхүл өөрийнх нь заасан дансанд шилжүүлэх;
3. Хүүхдийн тэтгэлгийн мөнгөнд тооцон төлбөр төлөгчөөс гаргуулан авсан эд хөрөнгийг энэ хуульд заасан журмын дагуу худалдан борлуулж, эсхүл шилжүүлэх;
4. Хүүхдийн тэтгэлэг, бусдын амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлын төлбөрийг дараалал харгалзахгүй тэргүүн ээлжид олгох.


Хүүхдийн тэтгэлэг төлөгчийн дийлэнх хувь нь иргэн, тэр дундаа эцэг нь байх бөгөөд цөөн тохиолдолд хуулийн этгээд /хуулийн этгээдийн буруутай үйлдлээс шалтгаалан гэнэтийн осол, аваарт хүүхдийн эцэг, эх нь өртөж нас барсан тохиолдолд тухайн хүүхэд болон гэр бүлийг тэжээн тэтгэх үүргийг тухайн хуулийн этгээд биелүүлж, хүүхдийн тэтгэлэг төлөх/ тэтгэлэг төлөгч байдаг.

ДХИС-ийн судлаачдаас 140 шийдвэр гүйцэтгэгчээс хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг та хэрхэн үнэлдэг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 11 буюу 7,8 хувь нь хангалттай, 20 буюу 14,2 хувь нь хангалтгүй, 109 буюу 77,8 хувь нь сайжруулах шаардлагатай²⁶ гэсэн хариултыг өгсөн нь ШШГТХ-ийн зохицуулалтыг шинэчлэх зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна. Дээрх хариулт нь нийт судалгаанд оролцогчдын 80% нь хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой эрх зүйн

²⁶ ДХИС. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт. Судалгааны тайлан. УБ., 2020. 151 дэх тал.

зохицуулалт нь өнөөгийн нөхцөлд шаардлага хангахгүй шинэчлэн сайжруулах шаардлагатай гэж үзсэн байна.

Зураг 11. Хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтад өгсөн үнэлгээ




Хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой гүйцэтгэх баримт бичгийн тоон үзүүлэлт жил ирэх тусам ихсэж байгаач шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар төлбөрийг барагдуулж буй байдал хангалтгүй байгаа нь ШШГЕГ-ын мэдээ, судалгаанаас харагдаж байна. Хүснэгтээс харахад хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаа 2017 оны ШШГТХ-ийн үйлчлэлийн буюу 2018-2024 оны хооронд гүйцэтгэх хуудас 9.2 хувийн дундаж биелэлттэй, мөнгөн дүн 41.0 хувьтай байгаа нь хангалтгүй түвшинд байна гэж үзлээ.

Хүснэгт 3. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны биелэлт (2018-2024 он)

ҮЗҮҮЛЭЛТ		Оны эхний үлдэгдэл	Шинээр	Төлбөр			
				Биелүүлбэл зохих	Биелүүлсэн	Үлдэгдэл	Хувь
2018 он	гүйцэтгэх хуудас	10677	1604	12255	1243	11012	10.1
	мөнгөн дүн /мян/	5,231,063.6	37,642,718.1	43,921,886.4	14,488,746.0	29,433,140.4	33.0
2019 он	гүйцэтгэх хуудас	11010	1835	12783	1481	11302	11.6
	мөнгөн дүн /мян/	30,509,610.3	11,498,250.7	41,837,039.2	15,833,449.4	26,003,589.8	37.8
2020 он	гүйцэтгэх хуудас	19808	2310	13097	2044	11053	15.6
	мөнгөн дүн /мян/	1,605,346,793.7	25,397,140.6	51,296,952.1	24,274,228.9	27,022,723.2	47.3
2021 он	гүйцэтгэх хуудас	19019	1644	12724	1444	11280	11.3
	мөнгөн дүн /мян/	1,315,863,593.9	43,409,242.5	70,406,769.3	36,428,354.7	33,978,414.6	51.7
2022 он	гүйцэтгэх хуудас	16628	2184	13416	1170	20325	8.7
	мөнгөн дүн /мян/	1,450,604,118.1	13,803,982.8	46,363,522.3	18,026,381.8	1,855,107,380.6	38.9
2023 он	гүйцэтгэх хуудас	20325	2090	14182	1038	22121	7.3
	мөнгөн дүн /мян/	1,855,107,380.6	25,847,674.0	50,566,295.7	20,693,635.3	2,374,780,552.7	40.9
2024 он	гүйцэтгэх хуудас	22121	2140	15435	1327	14108	8.6
	мөнгөн дүн /мян/	2,374,780,552.7	17,511,343.1	48,596,184.7	18,308,909.4	30,287,275.3	37.7

Судалгааны явцад шийдвэр гүйцэтгэгчдээс хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаанд тулгамдаж буй асуудлын талаарх асуулгад 41 буюу 60.3 хувь нь төлбөр төлөгчийн хаяг тодорхойгүй, 20 буюу 29.4 хувь нь төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй, 7 буюу 10.3 хувь нь төлбөр төлөгчид хүлээлгэх хариуцлага сул гэж хариулсан.

Зураг 12. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон судалгааны дүн



ШШГЕГ-ын сүүлийн 3 жилийн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны нэгдсэн судалгаагаар 2021 онд хүүхдийн тэтгэлэг төлөөгүй 13 төлбөр төлөгчид 1.3 сая төгрөгийн торгууль оногдуулж, 30 төлбөр төлөгчид 7-30 хоногийн баривчлах, албадан сургалтад хамруулах шийтгэл оногдуулсан бол 2022 онд 18 тэтгэлэг төлөгчид 1.8 сая төгрөгийн торгох, 36 тэтгэлэг төлөгчид 7-30 хоног баривчлах болон албадан сургалтад хамруулах шийтгэл оногдуулж, 2023 онд хүүхдийн тэтгэлгийн 9 төлөгчид 900.0 мянган төгрөгийн торгох, 19 тэтгэлэг төлөгчид 7-30 хоног баривчлах болон албадан сургалтад хамруулах шийтгэл оногдуулж ажилласан байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас санаатайгаар зайлсхийсэн, хүүхдийн тэтгэлгээ төлөөгүй төлбөр төлөгчид холбогдуулан ШШГБ-аас зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан болох ахлах шийдвэр гүйцэтгэгчээс дараах байдлаар зөрчил шалган шийдвэрлэжээ.

Хүснэгт 4. Хүүхдийн тэтгэлэг төлөөгүй этгээдэд хариуцлага хүлээлгэсэн байдал

Тухайн онд хүүхдийн тэтгэлэг төлөөгүй этгээдэд оногдуулсан хариуцлага					
Огноо	100 нэгжтэй тэнцэх төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан	Албадан сургалтад хамруулсан	7-30 хоног баривчлах шийтгэл оногдуулсан	Зөрчлийн хэрэг үүсгэн шалгахад төлбөрөө бүрэн төлсөн	Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэн төлбөр төлөгч
2021	3	30	30		
2022	19	20	22	9	1067
2023	6	7	8	14	677

Хүүхдийн тэтгэлэг авагч нь хүүхдийн тэтгэлгийн мөнгийг хүүхдийн хэрэгцээнд тэтгэлгийг зарцуулаагүй болон зориулалтын бус зарцуулбал төлбөр төлөгч энэ талаарх гомдлыг шүүхэд гаргаж болно. Шүүх гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл тэтгэлэг төлөгчөөс гаргуулах тэтгэлгийг цуцлах шийдвэр гаргаж болох бөгөөд хүүхдийн асрамжийн асуудлыг ч дахин авч үзэх шаардлага гардаг.

Төлбөр төлөгч нь орлогогүй эсхүл орлого тасалдсан зэрэг тохиолдлуудад тэтгэлэг төлөгчийн орлогыг зөв тодорхойлоход хүндрэл бэрхшээл үүсэж, тэтгэлэг төлөлт тасалдах, цаашлаад тэтгэлэг төлөгдөхгүй байх нөхцөл бололцоог бүрдүүлж байна.

Харин нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар төлдөггүй тохиолдолд хүүхдийн тэтгэлгийн хэмжээг тэтгэлэг төлөгчийн ямар орлоготой нь уялдуулж тогтоох нь ойлгомжгүй байна. Банкин дахь дансанд гүйлгээ хийгдээгүй эсхүл тэтгэлэг төлөгчийн өөрийнх нь мөнгө эсэхийг тодорхойлоход бэрхшээл үүсэж болохоор байна.

Судалгааны явцад шийдвэр гүйцэтгэгчдээс хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр санал авахад 33 буюу 48.5 хувь нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэж үзсэн бол 12 буюу 17.6 хувь нь ажлын байраар ханган цалин хөлснөөс нь тэтгэлэг төлүүлдэг эрх зүйн зохицуулалтыг бий болгох, 23 буюу 33.8 хувь нь тэтгэлэг төлөхгүй байгаа талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх гэж хариулжээ.

Зураг 13. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх санал



Эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэсэн хамгийн өндөр хувьтай саналыг ажилласан жилээр нь харьцуулан үзвэл 1 жил хүртэл ажилласан алба хаагч 100 хувь, 1-3 жил ажилласан алба хаагчийн 33.3 хувь, 3-6 жил ажилласан алба хаагчийн 41.6 хувь, 6-10 жил ажилласан алба хаагчийн 50 хувь, 10-аас дээш жил ажилласан алба хаагчийн мөн 50 хувь нь энэхүү саналыг гаргасан байна.

Хүүхдийн тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй эсхүл шийдвэр гүйцэтгэгчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүй байхыг уриалсан, үйл ажиллагаанд нь саад учруулсан, шийдвэр гүйцэтгэгчийг хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн, эсхүл доромжилсон, түүнчлэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч бус этгээд төлбөр төлөгчийн хөрөнгийн талаарх мэдүүлгийг зориуд худал мэдүүлсэн бол Зөрчлийн тухай хуульд заасны дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ. Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 6.20.6 дахь хэсэгт “Тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна” гэж заасан. Хүүхдийн тэтгэлэг төлөөгүй тэтгэлэг төлөгчид торгох шийтгэл оногдуулах нь үр нөлөө багатай гэж үзэх үндэслэлтэй байна. Түүнчлэн төлбөр төлөх хугацааг 3 сараар тооцож тогтоосон нь төлбөр төлөгчийн эрхийг зөрчсөн зохицуулалт

болсон. тухайлбал, 1 хүүхдийн тэтгэлгийг 3 сар төлөөгүй буюу 1,362,600.0 төлөөгүй төлбөр төлөгчид зөрчлийн хариуцлага тооцож байна. Зөрчлийн тухай хуулийн 15.27 дугаар зүйлд “...эрх хасах ял шийтгүүлсэн этгээд, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч бус этгээд, оролцогч бус иргэн, хуулийн этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үед шийдвэр гүйцэтгэгчийн хүлээлгэсэн үүрэг, хязгаарлалтыг зөрчсөн...” бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж заасан ба төлбөр төлөх үүрэг бүхий этгээд шүүхийн шийдвэр биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо байхгүй байгаа нь тулгамдсан асуудал болж байна.

Асуудал 1. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны албадлагын арга хэмжээг ШШГТХ-д бус Гэр бүлийн тухай хуульд заасан байна. Тухайлбал, Шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлгийг хугацаанд нь төлөөгүй бол хожимдуулсан хоног тутамд тогтоосон тэтгэлгийн үнийн дүнгийн 0.5 хувиар алданги төлөх талаар Гэр бүлийн тухай хуульд заасан байдаг. Гэхдээ алдангийн нийт хэмжээ төлөгдөөгүй тэтгэлгийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна²⁷. Хууль болон гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосон анзыг алданги гэнэ. Тэтгэлэг төлөгч шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас зайлсхийсэн, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй бол тэтгэлэг авагч төлөгдөөгүй хугацааны тэтгэлгийн алдангийг шүүхэд нэхэмжлэл гарган шаардах эрхтэй.

Шийдвэр гүйцэтгэгч шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлгийг төлөгдөөгүй хэсгийг хугацаа харгалзахгүйгээр тэтгэлэг төлөгчөөс нөхөн гаргуулах ба тэтгүүлэгч хүүхэд 18 насанд хүрч, уг үндэслэлээр иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон бол төлөгдөөгүй хугацааны тэтгэлгийг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг шүүхэд тэтгэлэг авагч эсхүл тэтгүүлэгч хүүхэд гаргаж болно. Шийдвэр гүйцэтгэгч хүүхдийн тэтгэлэг төлөлтийн тооцоог бодож төлөөгүй хугацааг тооцон энэ хугацаан дахь тэтгэлгийн хэмжээ тооцож гарган тэтгэлэг төлөгч, тэтгэлэг авагч нарт танилцуулан гарын үсэг зуруулан баталгаажуулна.

Хүүхдийн тэтгэлгийн баримт бичиг нь тэтгүүлэг хүүхэд 18 насанд хүрэх хүртэл буюу маш удаан хугацаанд үргэлжилдэг баримт бичиг байдаг. Тийм ч учраас гүйцэтгэх баримт бичгийн биелэлт бага, мөнгөн дүнгийн биелэлтээр хуримтлал үүсч байгаа эсэхийг тооцон гаргадаг онцлогтой. Тэтгэлэг авагч хүүхэд 18 нас хүрээгүй бол шийдвэр гүйцэтгэгч өөрөө дээрх төлөгдөөгүй тэтгэлгийг нөхөн гаргуулах ажиллагааг явуулах бөгөөд тэтгэлэг авагч хүүхэд 18 насанд хүрсэн бол төлөгдөөгүй тэтгэлгийн талаарх тодорхойлолтыг гарган тэтгэлэг авагчид өгнө. Тэтгэлэг авагч шийдвэр гүйцэтгэгчийн гаргаж өгсөн тодорхойлолтыг нотлох баримт болгон, хүүхдийн тэтгэлгийг алдангийн хамт нөхөн төлүүлэх шийдвэрийг гаргуулахаар шүүхэд хандаж болно.

ШШГТХ-д шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад тэтгэлэг төлхөөс цааргалсан, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан, зайлсхийсэн тэтгэлэг төлөгчид чиглэсэн албадлагын арга хэмжээг хуульчилж өгөх шаардлагатай байна. Тухайлбал: Гэр бүлийн тухай хуульд заасан алдангт төлөх албадлагын арга хэмжээ болон Төрөөс үзүүлж буй халамжийг нь түдгэлзүүлэх, Төрийн үйлчилгээ авах зэрэг зарим эрхийг нь түдгэлзүүлэх албадлагын арга хэмжээг ШШГТХ-д тусгах шаардлагатай.

²⁷ Гэр бүлийн тухай хууль. Уб., 1999. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №30.

3.3. Төлбөрийн чадваргүй иргэн, хуулийн этгээдээс төлбөр гаргуулах арга хэмжээний эрх зүйн зохицуулалт:

Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй” 2019 оны судалгааны 10 гол үзүүлэлтээс Монгол Улс “Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх” үзүүлэлтээр хамгийн бага оноо авсан, бусад улстай харьцуулахад Монгол Улсад зээл, өр төлбөрийн эргэн төлөлтийн хэмжээ хамгийн бага (16.9 хувь) байдаг ба асуудлыг шийдвэрлэхэд хамгийн их хугацаа (4 жил) зарцуулдаг; Одоогийн байдлаар төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх эрх зүйн орчны хөгжлийн түвшин нь нийт 16 онооноос 6.5 оноо авсан²⁸. Энэ нь Монгол Улсад төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль, эрх зүйн орчны шинэчлэл хэрэгтэйг харуулж байна.²⁹

Төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй байх нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд учруулах сөрөг нөлөөллийн хамгийн их нь бол төлбөр төлөхөөс зайлсхийх, төлбөр төлөгчийн оршин суух хаяг тодорхойгүй байдал удаах байрыг эзэлж байна.

Төлбөр төлөгчийн төлбөрийн чадваргүй байдал нь улс орны эдийн засгийн хөгжил, бодлого, хэрэгжилтээс шууд шалтгаалдаг. Улс орны эдийн засгийн харилцаа нь нийгмийн бүхий л харилцааны суурь нь бөгөөд оршин тогтнох үндэс нь билээ.

Төлбөрийн чадваргүй байдал нь дараах шалтгаанаас хамааран гарч байна. Үүнд:

1. Ажилгүйдэл буюу эдийн засгийн хөгжил буурах тусам ажилгүй иргэдийн тоо ихсэж амьжиргааны түвшин буурна. Төлбөр төлөгч иргэн ажил, хөдөлмөр эрхлэхгүй байгаа нь төлбөр төлөх боломж буурах, улмаар төлбөр төлөхгүй байх санаа сэдэл үүсэж, төлбөр төлөхөөс зайлсхийх, саад хийх, оршин суугаа хаягаа өөрчлөх, оргон зугтаах, орлогоо нуун дарагдуулах, эд хөрөнгийн мэдүүлгээ гаргаж өгөхгүй байх, эсхүл худал гаргах зэрэг үйлдэл гаргана. Үүний улмаас шүүхийн шийдвэрт заагдсан төлбөрийг төлөх бодит бололцоо буурч, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учирч, шүүхийн шийдвэрийн биелэлт хангалтгүй болж эхэлдэг.

2. Мөнгөний ханшны уналт нь төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах шүүхийн шийдвэрийн биелэлтэд сөргөөр нөлөөлж байдаг эдийн засгийн үзэгдэл, үйл явц юм. Мөнгөний ханш унах тусам иргэдийн орлого багасаж, тэр хэмжээгээр худалдан авах чадвар доройтон улмаар бусдаас авсан эд зүйл мөнгө, бусдад төлөх ёстой төлбөрийг төлөхгүй байж боломж бололцоог эрэлхийлж эхлэх бөгөөд хөрөнгө орлогоо нуух зэргээр төлбөр төлөхөөс зайлсхийх идэвхтэй үйлдлүүд хийдэг.

3. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ бага байгаа нь иргэдийн ажил хөдөлмөр эрхлэх урам зоригийг мохоож, улмаар ажилгүйдэл, ядуурлын түвшнийг нэмэгдүүлж байгаа ба шүүхийн шийдвэр үл биелүүлэх гэмт хэргийн гаралтыг нэмэгдүүлж, шүүхийн шийдвэрийн биелэлтэд сөргөөр нөлөөлдөг шалтгаан болж байна. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны 12 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 660,000.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

²⁸ Жинчанг Лай, Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх хууль, эрх зүйн орчны шинэчлэл ба хөрөнгө оруулалтын орчин, 2019.

²⁹ Дэлхийн банк улс орнуудын бизнесийн орчны талаарх “Doing Business” /”Бизнес эрхлэхүй”/ тайланг гаргахаа зогсоож, цаашид бизнес, хөрөнгө оруулалтын орчныг үнэлэх шинэ арга барилыг нэвтрүүлж ажиллах болсноо мэдэгдсэн.

Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын тодорхойлсноор “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ” нь цалин хөлсний хуваарилалтын хамгийн доод хэсэгт байгаа ажилчдыг хамгаалах зорилгоор тогтоосон цалингийн бүтцийн суурь давхаргын хамгийн бага хэмжээ юм. Монгол Улсын Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэдэг нь тодорхой боловсрол, тусгай мэргэжил үл шаардах энгийн ажилд хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээгээр ажиллаж байгаа ажиллагчдын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор эрх бүхий этгээдээс тогтоосон цагийн үндсэн цалин /хөлс/-гийн нийтээр дагаж мөрдвөл зохих хамгийн доод хязгаар юм гэж тодорхойлсон байдаг³⁰.

ИШГТХ-ийн үйлчлэлийн хүрээнд төлбөрийн чадваргүй иргэн, хуулийн этгээдтэй холбоотой гүйцэтгэх хуудас, мөнгөн дүнг судлан үзлээ.

Хүснэгт 5. Төлбөрийн чадваргүй иргэн, хуулийн этгээдтэй холбоотой гүйцэтгэх хуудасны судалгаа³¹

Ажиллагааны төрөл	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Иргэний шийдвэр гүйцэтгэл	1660	1702	116	142	103	123	159
Захиргааны шийдвэр гүйцэтгэл	5	1	0	0	0	0	1
Хүүхдийн тэтгэлэг	1660	1702	171	317	349	690	0
Эд хөрөнгийн бус шаардлагын гүйцэтгэл	2	0	0	0	0	0	0

Хүснэгт 6. Төлбөрийн чадваргүй иргэн, хуулийн этгээдтэй холбоотой мөнгөн дүнгийн хуудасны судалгаа (мян, төг)


Ажиллагааны төрөл	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Иргэний шийдвэр гүйцэтгэл	1,669,033,8	2,920,707,6	1,322,336,2	2,016,268,1	2,890,923,0	1,638,014,5	10,338,123,8
Захиргааны шийдвэр гүйцэтгэл	16,715,0	2,000,0	0	0	0	0	129,707,2
Хүүхдийн тэтгэлэг	1,669,033,8	2,920,707,6	1,228,138,4	2,508,663,5	2,772,445,8	3,904,982,2	0

³⁰ info@mlsp.gov.mn

³¹ ИШГА-ын судалгаа.

Шийдвэр гүйцэтгэгчдээс авсан төлбөрийн чадваргүй иргэнээс төлбөр гаргуулах ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх таны санал гэсэн асуултад 98,6 хувь нь ажлын байраар хангаж, цалин хөлснөөс нь төлбөр төлүүлдэг эрх зүйн зохицуулалтыг бий болгох, 1,4 хувь нь нуугдмал эд хөрөнгийг эрэн сурвалжлах тогтолцоог бий болгох гэж хариулсан бол төлбөрийн чадваргүй хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх талаарх асуулгад 21 буюу 30.9 хувь нь хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах гэж үзсэн бол 47 буюу 69.1 хувь нь төлбөр төлөгч хуулийн этгээдийг татан буулгах ажиллагааг эхлүүлэх, харин иргэний хувьд ажлын байраар хангаж, цалин хөлснөөс нь төлбөрийг төлүүлэх нь зүйтэй гэж үзжээ.

Зураг 14. Төлбөрийн чадваргүй хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх талаарх асуулгын дүн



Түүнчлэн ШШГТХ-ийн 93 дугаар зүйлийн 93.2 дахь хэсэгт “Улсын төсвөөс санхүүждэг төлбөр төлөгч-хуулийн этгээдийн дансанд байгаа төлбөр төлөх зориулалт бүхий мөнгөн хөрөнгө нь төлбөрт хүрэлцэхгүй тохиолдолд дараагийн жилийн төсөвт нэмж тусгаж, төлбөрийг барагдуулна”, 132 дугаар зүйлийн 132.3-т “Захиргааны байгууллагын дансанд байгаа мөнгө нь төлбөрт хүрэлцэхгүй тохиолдолд төлбөрийг дараагийн жилийн төсөвт тусгаж, барагдуулна” хэмээн заасан. Төлбөр төлөгч-улсын төсвийн байгууллага, захиргааны байгууллага нь хохирол, төлбөр төлөх зориулалт бүхий төсөвлөсөн мөнгөн хөрөнгөгүйгээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шатанд төлбөр авагч иргэн, хуулийн этгээдээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удаашралттай байгаа талаар гомдол, мэдээлэл цөөнгүй гарч байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байгаа нийт 86534 гүйцэтгэх баримт бичгийн хөрөнгийн мэдээлэл цуглуулах явцад 55-60 орчим хувь нь төлбөрт гаргуулах хөрөнгө орлогогүй, ажил хөдөлмөр эрхэлдэггүй, оршин суух хаяг тодорхойгүй, хорих ял эдэлж байгаа, сар бүрийн цалин хөлс, бусад орлогоос хэсэгчлэн төлдөг, барьцаа хөрөнгийн маргаантай, зэрэг шалтгаантай байна. Үүнээс шалтгаалан ШШГТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.2.7 дахь хэсэгт “төлбөр гаргуулж болох хөрөнгө, орлого байхгүй бөгөөд хуульд заасан аргаар түүний хөрөнгө, орлогыг албадан гаргуулах боломжгүй бол төлбөр төлөгчийг хөрөнгөтэй болох хүртэл” хугацаагаар 1262 гүйцэтгэх баримт бичгийг түдгэлзүүлсэн байна³².

³² Шийдвэр гүйцэтгэх албаны танилцуулга. 2024.

Үндэсний статистикийн хорооны “Ядуурлын хамрах хүрээний судалгаа”-гаар нийт улсын хэмжээнд хийсэн ядуурлын судалгаагаар ядуурлын хамрах хүрээний улсын дундаж үзүүлэлт 27.1 хувьтай, хөдөө орон нутгийн үзүүлэлт 35.6 хувьтай байгаагаас шууд хамааралтай гэж үзэж болохоор байна. Ядуурлын дундаж өндөр байх нь төлбөр төлөгчийн төлбөрийн чадварт шууд нөлөөлж байна.

Асуудал 1. ШШГТХ-ийн 93 дугаар зүйлийн 93.2 дахь хэсэг нь Төсвийн тухай³³ хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад заасан “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” хэсэгтэй нийцэж байгаа боловч Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 23 дугаар зүйл³⁴, ШШГТХ-ийн 9 дүгээр зүйл³⁵-тэй зөрчилдөж, төр, хувийн хэвшилд ялгамжтай хандсан зохицуулалт болжээ.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шатанд дийлэнх төрийн байгууллага нь төлбөрийн нөөц хөрөнгөгүй, ирэх жилийн төсөвт суулгуулахаар холбогдох дээд шатны байгууллага, харьяа яаманд саналаа хүргүүлсэн гэсэн тайлбар ирүүлдэг боловч ирэх жилийн төсөвт суулгадаггүй, суулгасан ч төлбөрийн мөнгийг бүрэн төсөвлөдөггүй, хэсэгчлэн олгодог байдал нь эсрэгээрээ төрд итгэл иргэн-хуулийн этгээд /дотоод, гадаадын хөрөнгө оруулалттай/-ийн итгэлийг бууруулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэр хүнд тодорхой түвшинд үнэгүйдэх, гадаадын хөрөнгө оруулагчдыг үргээх, цаашлаад төлбөр авагч хуулийн этгээдтэй гэрээгээр хамтран ажилласан хувь хүн, аж ахуйн нэгж, ажилчдын эрх ашгийг хохироох давхар сөрөг үр дагаврыг бий болгож байна³⁶.

Иймд төлбөрийн үнийн дүнгээс үл хамааран төлбөр төлөгч иргэн, төлбөр төлөгч-хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчийн гадаадад зорчих эрхийг үнийн дүнгээс үл хамааран түдгэлзүүлэх зохицуулалтыг тусгах нь эрэн сурвалжлагдаж байгаа үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх, удаашрах нөхцөлийг бууруулах боломжтой байна. Дээрх заалттай уялдуулан Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт заасны дагуу төлбөр төлөгч-хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагаас гадна хувьцаа эзэмшигчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх зохицуулалтыг нэмэлтээр тусгах нь зүйтэй байна.

Асуудал 2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.4 дэх хэсэг “төлбөр төлөгчийн нийт хөрөнгө нь гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах эсэх асуудлыг үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгийн хариуцлагын харилцааг зохицуулсан хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлэнэ”, Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг “9.3 дахь заалтад

³³ Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2012. №03

³⁴ Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 23.1. Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хүн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй. 23.2. Шүүхийн шийдвэрийг сайн дураараа биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэнэ. 23.3. Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд зориуд саад учруулсан этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 23.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдсон харилцааг тухайлсан хуулиар зохицуулна гэж заасан.

³⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 9.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хууль ёсны шаардлагыг хүн, хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй. 9.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн, эсхүл хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан хүн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

³⁶ Отгонбаяр, Б. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гарч буй өргөдөл, гомдлын шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс, шийдвэрлэх арга зам илтгэл. “Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийн эмхэтгэл. Уб., 2023. 120 дахь тал.

“Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ” 9.5 дахь хэсэг “Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна” гэж тус тус зохицуулсан.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч-хуулийн этгээд хөрөнгө, орлогогүй, өр төлбөрт орсноос хойш үйл ажиллагаа явуулаагүй, шүүхийн шийдвэрээр төлбөрийн үүрэг хүлээхээс өмнө компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байсан нь татварын тайлан, гаалийн бүрдүүлэлт болон бусад лавлагаа, мэдээллээр тогтоогддог бөгөөд тухайн компани нь өөрийн дүрэмд компанийн болон хувьцаа эзэмшигчийн хөрөнгө, хөрөнгийн эрх зааглагдсан эсэхийг тусгаагүй, тодорхой зааглагдаагүй болохыг тогтоосоны үндсэн дээр хувьцаа эзэмшигчийн хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагаа явуулж байгаа хэдий ч шүүхийн шийдвэрээр төлбөрийн үүрэг хүлээгээгүй, гүйцэтгэх баримт бичигт заагаагүй этгээдээс төлбөр гаргуулах ажиллагаа явуулсан үндэслэлээр шүүхээр ажиллагаа хүчингүйд тооцогдсоор байна.

Төлбөр төлөгч-хуулийн этгээд шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийж, охин болон хараат компани байгуулан үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаад хариуцлага хүлээлгэх, хязгаарлалт тогтоох, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин дутмаг байгаа нь хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагаа удаашрах, шүүхийн шийдвэр биелэгдэх боломжгүй нөхцөлийг үүсгэж байна. Мөн төлбөр төлөгч-хуулийн этгээд шүүхийн шийдвэрээр төлбөрийн үүрэг хүлээхээс өмнө 100-200 сая төгрөгөөр оффис түрээслэн үйл ажиллагаа явуулж байсан ч компанид эд хөрөнгө бүртгэлгүй, харин тухайн компанийг үүсгэн байгуулж, үйл ажиллагаа явуулснаас хойш хувьцаа эзэмшигчийн эзэмшил, өмчлөлд хэд хэдэн хөрөнгө бүртгэгдсэн нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар тогтоогдож, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дээрх хуулиудад заасны дагуу хувьцаа эзэмшигчийн хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагаа явуулсан боловч ажиллагаа шүүхээр хүчингүйд тооцогдож байна.

ШШГТХ-ийн 93 дугаар зүйлийн 93.4 дэх хэсэг болон Компанийн тухай хуулийн 9.3, 9.5 дахь заалтад ямар ч тохиолдолд компанийн ашиг, орлогоос бий болсон бүхий л хөрөнгөөр төлбөрийн үүргийг бүрэн хариуцах илүү нарийвчилсан зохицуулалтыг тусгаж, компанийн хөрөнгөөс өөрийн хөрөнгийг тусгаарлах гэсэн агуулгыг хасах шаардлага байна.

Олон улсад төлбөрийн чадваргүй иргэн буюу хувь хүний дампуурлын тухай асуудал 1980-аад оноос эхлэн эрх зүйгээр зохицуулж эхэлсэн гэж үзэх боловч уг асуудал цоо шинэ ойлголт биш юм. Түүхэн цаг хугацааны хувьд, ерөнхийдөө ХХ дугаар зууны сүүлийн хагаст хувь хүнд олгох зээлийн үйл ажиллагаа эрс нэмэгдэж, улмаар найдваргүй, эргэн төлөгдөх боломжгүй нөхцөл байдал их хэмжээгээр үүссэнтэй холбоотойгоор хувь хүний дампуурлын асуудлыг тусгайлан зохицуулах, орчин үеийн эдийн засаг, санхүүгийн системд тохирсон зохицуулалт бий болгох шаардлага үүссэн байна. Ийнхүү улс орнууд хувь хүнд олгосон эргэн төлөгдөөгүй зээлийг шийдвэрлэх зохицуулалтыг бий болгож эхэлсэн бөгөөд тухайлбал, сүүлийн 30 жилийн хугацаанд Европ тивийн дийлэнх улсад хувь хүний дампуурлыг зохицуулсан хууль тогтоомж баталж хэрэгжүүлжээ. Тухайлбал, 1979 онд АНУ-д Дампуурлын тухай хууль батлагдсанаас хойш, 1986 онд Их Британи, 1989 онд Франц, 1994 онд Герман, 1995 онд Австри, Чех 2008 онд, Польш 2009 онд, Итали 2012 онд, Испани

2013 онд, Унгар 2015 онд тус тус холбогдох зохицуулалтыг хуульчлан баталсан³⁷. Олон улсын зарим эрх зүйн зохицуулалтын онцлогоос судлан үзэхэд тухайлбал:

1. Америкийн Нэгдсэн Улс

АНУ-ын Дампуурлын тухай хуулийн 7 дугаар бүлгийн дагуу, төлбөрийн чадваргүй иргэн өргөдөл гаргахад өртэй этгээд, эсвэл томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч хүлээсэн үүргээ хэсэгчлэн болон бүрэн төлж барагдуулахын тулд хөрөнгийн тодорхой багцаа татан буулгадаг. Татан буугдах хөрөнгийг тухайн мужийн хуулиас хамааран муж бүрд ялгаатай заасан. Ингэхдээ хөрвөх чадвартай хөрөнгийг татан буулгах тохиолдолд зээлдэгч баталгаагүй өрийн ихэнх хэсгээс чөлөөлөгддөг. Үүнд, баталгаагүй өр гэдэгт кредит картын төлбөр, хувь хүнээс авсан зээл, эмнэлгийн төлбөр, байрны хэрэглээний төлбөр зэрэг багтана. Мөн зээлдэгч 7 дугаар бүлгийн дагуу өргөдөл гаргаснаас хойш дахин 6 жилийн дотор өргөдөл гаргах эрхгүй болно (АНУ-ын шүүхийн шийдвэрээр). Энэхүү загвар нь ерөнхийдөө ихэнх улс оронд үйлчилдэг корпорацуудын арилжааны зээлийг татан буулгах загвартай адил бөгөөд “шууд дампуурал” гэсэн ангилалд багтдаг. Харин уг хуулийн 13 дугаар зохицуулалтын хувьд зээлдэгчийн хөрөнгө түүнд хэвээр үлддэг буюу хөрөнгийг нь оролдохгүй боловч зээлдэгч ирээдүйд олох орлогоосоо эргэн төлөх төлөвлөгөөний дагуу зээлээ бүрэн болон хэсэгчлэн төлөх үүрэг хүлээдэг. Эргэн төлөлтийн хуваарийг 3-5 жилийн хугацаатай төлөвлөнө. Хуваарийн дагуу төлж дууссаны дараа бүх өр чөлөөлөгдөнө.

2. Унгар Улс

Унгар улсад хувь хүний төлбөрийн чадваргүйдлийг зохицуулах эрх зүйн шийдэл дэлхийн II дайнаас өмнө байсан боловч социалист дэглэмийн үед арилсан байна. Харин энэ төрлийн эрх зүйн зохицуулалтыг дахин бий болгох санал 2009 оны санхүүгийн хямралын нөлөөгөөр чанаргүй жижиг зээлийн хэмжээ эрс нэмэгдсэн үеэс яригдах болжээ. Мөн хөрш орнуудад нь хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалт бий болж, хэрэгжиж эхэлсэн явдал ч нөлөөлсөн. Ийнхүү Унгарт 2015 онд хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалт бий болсон бөгөөд үндсэн зарчим, зорилго нь Герман, Австри, Ирланд, Испанийн зохицуулалтад тулгуурласан байна.

Тус улсын зохицуулалтын гол онцлог нь зээлдүүлэгчийн ашиг сонирхлыг илүүтэй авч үздэгт орших бөгөөд энэ нь Европын бусад орны чиг хандлагатай ижил юм. Унгар Улсын хувьд хувь хүний дампуурлын эрх зүйн харилцааны үндсэн шалгуурт багтах гол зарчмууд нь харилцан тохиролцох хүсэл эрмэлзэл, эрх бүхий байгууллага, зээлдүүлэгчтэй хамтран ажиллах дур сонирхол, хууль тогтоомжийг хүндэтгэн сахих зэрэг зарчим болно. Мөн өрийн төрөл, бүтэц, үүргийн хэмжээнээс хамааран шалгуур нь хатуу, нарийн ялгамжтай байдлаар зохицуулагдсан.

Хүлээх үүрэг нь хувь зээл, хэрэглэгчийн зээл болон хувийн бизнес эрхлэлтээс үүдэлтэй байх нь харгалзан үзэх гол шалгуур юм. Заавал хангасан байх шалгуурыг нарийвчлан хуульчилсан бөгөөд тухайлбал, хугацаа хэтэрсэн өрийн дээд болон доод хэмжээ (2-20 унгар форинт), зээлдэгчийн нийт хөрөнгөд эзлэх өр төлөх үүргийн хувь (200 хувиас ихгүй), бүтэц (хугацаа хэтэрсэн үүрэг хамгийн багадаа 0.5 сая унгар форинт, ингэхдээ 5-аас илүүгүй хоёрдогч үүрэгтэй байх) зэрэг болно. Одоо үргэлжилж байгаа болон өмнө нь

³⁷ Сүхбаатар С. Хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалт: олон улсын чиг хандлага, зарим улсын туршлага. Судалгааны тайлан. УБ. 2022.38 дахь тал.

байсан хамрагдах боломжгүйд тооцогдох нөхцөл мөн тавигддаг байна (хариуцагчтай холбоотой гэмт хэрэг болон зөрчлийн хувиар шалгагдаж байгаа бусад асуудал г.м).

Ерөнхийдөө тус улсын хуульд заасан хувь хүний дампууралтай холбогдолтой 3 төрлийн процесс буюу боломж байна. Австри Улсын загвартай ижил эхний процесс нь харилцан тохиролцох (эвлэрүүлэн зуучлал) буюу шүүгч, шүүхийн оролцоогүйгээр зээлдэгч, зээлдүүлэгчийн хооронд зээлдэгчийн үүргийг шинэчилсэн тохиролцоонд авч үзэх боломж юм. Шүүхийн процессыг зөвхөн энэхүү харилцан тохиролцоо бүтэлгүйтэх буюу эвлэрлийн журмаар тохиролцсон үүргээ биелүүлээгүй, эсвэл гол томоохон зээлдэгч байхгүй нөхцөлд эхлүүлнэ. Ерөнхийдөө эвлэрүүлэн зуучлалаар харилцан тохиролцох зарчим Европт нийтлэг үйлчилдэг (Англи, Герман, Франц, Австри г.м). Гэхдээ энэ нь төрийн ямар нэгэн институтын оролцоотой болон оролцоогүйгээр янз бүр хэрэгжиж байна.

Хувь хүний дампуурлын зохицуулалтын процесс нь зээлдэгч гол зээлдүүлэгчид мэдэгдсэнээр эхлэх ёстой. Тусгай эрх бүхий байгууллага зээлдэгчийн орлого, хөрөнгийн байдлыг тогтооно. Гол зээлдүүлэгч нь зээлдэгч болон бусад зээлдүүлэгч хоорондын гэрээний харилцаанд зохицуулагчийн үүрэг гүйцэтгэдэг. Байгуулсан гэрээг тусгай байгууллагад бүртгүүлнэ. Ерөнхийдөө зээлдэгчид тавих хяналт нь харьцангуй чанга биш, зээлдэгчийн өдөр тутмын төлбөр, орлогын байдалд хяналт тавих итгэмжлэгдсэн төлөөлөгч томилдоггүй, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулахыг заавал шаарддаггүй боловч харилцан тохиролцсоны дагуу үүссэн эргэн төлөлтийн харилцаанд харин хатуу шаардлага тавьдаг. Зээлдэгч өөрийн бүх хөрөнгө, ирээдүйн орлогоо эргэн төлөлтөд оролцуулах үүрэг хүлээнэ. Зөвхөн тодорхой хэмжээний буюу хувийн үндсэн хэрэгцээг хангах хэмжээгээр орлогын зарим хэсгийг өдөр тутмын амьдралдаа зарцуулж болох бөгөөд шинээр нэмэлт үүрэг, хариуцлага хүлээхийг хориглодог. Захиргааны хураамжаас гадна татвар, даатгал, хэрэглээний зардлаа тогтмол төлөх ёстой бөгөөд сар бүр төлөхөөр заасан доод хэмжээгээр эргэн төлөлтийг заавал хийх ёстой.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон тохиолдолд дараагийн алхам нь шүүхийн ажиллагаа юм. Шүүхийн ажиллагааны эхний үе шат нь “өрийн тохиролцооны журам” байх бөгөөд итгэмжлэгдсэн төлөөлөгч процессыг удирдаж, хүрсэн тохиролцоо нь процесст оролцсон бүх зээлдэгчийн хувьд хүчинтэй байна. Хэлэлцээрийг эцэст нь шүүхээс батлах боловч энэ нь зайлшгүй шаардлага бас биш юм. Энэхүү гэрээнд эргэн төлөлтөд хамаарах бүх нөхцөл, зохицуулалт, барьцаанд тавьсан хөрөнгийг худалдан борлуулах төлөвлөгөө, орлогын ашиглалт, хяналтын төлөвлөлт, аливаа тэтгэмжийн зарцуулалтын талаар тусгах ёстой. Ерөнхийдөө гэрээг хэрэгжүүлэх явцад зээлдэгчийн ахуй амьдрал, орлого, зарлагын байдал нь эрх бүхий байгууллагаас тогтоосон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтад байх бөгөөд тэрээр банкны дансны бүх гүйлгээнд хяналт хийнэ. Үндсэн хэрэгцээ болон тухайн хэрэгцээг хангах зарцуулалтын босго хэмжээг нэг хүнд ногдох байдлаар тооцоолж гаргах бөгөөд түүнд үндэслэн банкны дансны болон бэлэн мөнгөний гүйлгээний хязгаарыг батална. Үл хөдлөх хөрөнгийг заавал худалдан борлуулах шаардлагагүй бөгөөд тухайн хөрөнгийг хэвээр эзэмших болон бага үнийн дүнтэй үл хөдлөх хөрөнгө болгож өөрчлөн эзэмшиж болно. Бүх төрлийн гэнэтийн орлого, шинэ үл хөдлөх хөрөнгийг тайлагнаж, эргэн төлөлт хийхэд зарцуулна. Гэрээнд оролцоогүй зээлдүүлэгчид зээлдэгчээс эргэн төлөлтөд хамаарах аливаа ажиллагааг явуулах эрх байхгүй. Мөн зээлдэгч болон түүний гэр бүлийн амьжиргааны үндсэн хэрэгцээг хангах хэмжээгээр чөлөөлөгдөх орлого, хөрөнгийн жагсаалт гаргана. Өрийн тохиролцооны журмыг шүүхээс зөвшөөрөх

хүртэл эргэн төлөлтийн үүрэг нь өмнө дурдсан эвлэрлийн гэрээнд заасан доод хэмжээтэй тэнцүү байна. Нэмэлт төлбөрийн үүрэг, даатгал, төлбөр, татварын үүрэг мөн хүлээнэ. Үүргээ биелүүлсний хариуд зээлдэгч нь аливаа өр цуглуулах арга хэмжээний эсрэг дампуурлын хамгаалалт эдэлдэг. Харин хариуцагч үүргээ ноцтой зөрчсөн тохиолдолд журмыг хүчингүйд тооцож өмнө явагдаж байсан эргэн төлүүлэх ажиллагаа үргэлжилнэ.

Дээрх өрийн тохиролцооны журмыг хэрэгжүүлэх явцад тохиролцоонд хүрч чадаагүй бол “өр барагдуулах журам”-ын харилцаа эхэлнэ. Өмнөх “өрийн тохиролцооны журам”-ын үед томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн саналд үндэслэн, зээлдэгч болон зээлдүүлэгч нарын хооронд хэлэлцээр хийгдсэний дараа эргэн төлөлтийн төлөвлөгөө гаргаж, шүүх батална. Эргэн төлөлтийн төлөвлөгөөнд орлого болон эд хөрөнгийг бүлэглэн ангилах, хуваах талаар нарийвчлан тусгаж чөлөөлөгдөх орлогын түвшин, худалдах үл хөдлөх эд хөрөнгө, орлогыг зээлдүүлэгчдийн дунд хэрхэн хуваах талаарх журам, эргэн төлөлтийн бүтцээс гадна бусад хамааралтай үүрэг, үйл ажиллагааны талаар мөн тусгадаг. Эргэн төлөлтийн хуваарийг ихэвчлэн 5 жилийн хугацаатай гаргах бөгөөд зээлдүүлэгчид зөвшөөрсөн тохиолдолд 2 жилийн хугацаагаар сунгаж болно. Ингэхдээ, зээлдүүлэгчид насанд хүрээгүй, зээлдэгчийн гэр бүлийн бүртгэлд хүүхдүүд эсвэл 70-аас дээш насны гэр бүлийн гишүүдтэй, эсвэл зээлдэгчийн хүлээсэн үүрэг нь үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн анхны үнэд хүрэхгүй байгаа зэрэг хуульд заасан шалтгаан байгаа тохиолдолд байр, үл хөдлөх хөрөнгийг нь худалдан борлуулахгүйгээр үлдээж болно. Мөн худалдсан тохиолдолд зээлдүүлэгчдийн зөвшөөрлөөр, амьдралын хэрэгцээг хангах хэмжээний жижиг орон сууц болгож өөрчлөн худалдан авч болдог.

Өр төлбөрөө дуусгах үндсэн нөхцөл нь өөр өөр шатлалаар ангилж бүлэглэсэн (ипотек, давуу эрхтэй зээлдэгч, өөр зээлд хамаарах зээл гэхчлэн ангилдаг байна) зээлдүүлэгчдэд эргэн төлөлтийг заасан доод хэмжээгээр хийх шаардлага байна. Гол зээлдэгч нь ерөнхийдөө барьцаа хөрөнгө, бусад төрлийн барьцаагаар баталгаажсан зээл олгогч ипотекийн зээлдэгчид байна. Эргэн төлөлтийн хугацаанд үл хөдлөх хөрөнгө, бусад хөрөнгийн зах зээлийн анхны үнэ нь эргэн төлөлтийн хэмжээнд хүрсэн тохиолдолд төлөлт амжилттай хийгдсэнд тооцно. Ипотект заасан үүрэг, татвар, төлбөр, өмнөх болон одоогийн ажиллагааны зардлыг төлөхөөс өмнө хөрөнгийг худалдан борлуулахад гарсан зардлыг мөн төлөх шаардлагатай. Ангиллын хувьд авч үзвэл “бусад зээл”-д хамаарах нь 38 хувь, “өөр төрлийн зээл”-д хамаарах нь 5 хувь, харин “давуу эрхтэй зээлдэгчийн зээл” нь “бусад зээл” гэсэн ангиллын зээлийн 120 хувьд хүрэх хэмжээнд эргэн төлөлт хийгдэх ёстой. Энэхүү тооцоог гаргахдаа торгуулийн хэмжээ болон хугацаа хэтэрсэн хүүгийн хэмжээг оруулах ёсгүй. Уг ажиллагааны шатанд, амьжиргааны наад захын хэрэгцээг хангах хэмжээнээс бусад төрлийн орлого ерөнхийдөө маш хатуу зохицуулагддаг. Ингэхдээ амьдралын өртгөөс гадна байрны хэрэглээний зардал, даатгалын зардал, засвар үйлчилгээтэй холбоотой баталгаажсан тогтмол зардал, эргэн төлөлтийн орлогоос чөлөөлж болно. Нөгөө талаас зээлдэгчийн орлогын байдалд өөрчлөлт гарсан тохиолдолд (10 хувиас дээш), онцгой төрлийн орлого орсон, шинэ хөрөнгөтэй болсон тохиолдолд шууд мэдэгдэх үүрэгтэй.

Томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч нь зээлдэгчийг тухай бүр шалгаж, хянах боломжтой. Ерөнхийдөө эргэн төлөлтийн хуваарийн биелэлт, зээлдэгчийн хөрөнгийн борлуулалт, эргэн төлөлтийн байдал, бусад холбогдох үйл явцын талаар хагас жил тутам зээлдүүлэгчид тайлагнах ёстой. Хуульд заасны дагуу эргэн төлөлтийн төлөвлөгөөг шүүхээс батлах ёстой учраас эцэст нь эргэн төлөлт бүрэн хийгдсэн эсэх, үүргээс бүрэн чөлөөлөгдөх

эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Төлөлт амжилттай дууссан гэсэн шийдвэр гарсан тохиолдолд эргэн төлөлтийн төлөвлөгөөнд багтаагүй бүх төрлийн үүргээс шууд чөлөөлөгдөнө. Тус ажиллагаанд оролцоогүй зээлдүүлэгчдийн хувьд тохиролцооны журмыг хүчингүйд тооцохгүй ч энэ ажиллагааны үед ямар нэг байдлаар эргэн төлөлт хийлгэхийг хориглоно.

Ерөнхий зарчмын шалгуур буюу төлбөрийн чадваргүйдэлд тооцогдох субъектив шалгуурын хувьд шударга байдал, хамтын ажиллагаа, хууран мэхлэх үйлдэл гаргахгүй байх зэрэг шалгуур тавигдаж байна. Харин объектив шалгуурын хувьд илүү нарийвчилсан хатуу зохицуулалт үйлчилдэг. Өрийг чөлөөлөх эргэн төлөлт хийгдэх шаардлагатай нийт хугацаа нь 1-8 жил бөгөөд гол төлөв 5 жилийн хугацаанд хэрэгждэг байна. Төлөлт хийгдсэнд тооцох доод хэмжээ нь ангиллын хувьд гол зээлдүүлэгч болох ипотекийн зээлдүүлэгчийн хувьд үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн анхны үнээр тооцогдож байна. Энэ нь бусад улс оронд ихэнхдээ үүргийн тодорхой хувиар тооцогддог. Эцэст нь дүгнэж үзэхэд Унгарын зохицуулалтын загвар нь процесс ажиллагаа, нөхцөл, шалгуурын хувьд нэлээн төвөгтэй зохицуулалтад тооцогдож байна.

Ерөнхийдөө Унгарын эрх зүйн зохицуулалт нь Австрийн эхэн үеийн зохицуулалттай төстэй бөгөөд Европын орнуудын загварт багтдаг хатуу зохицуулалтын шинжүүдийг агуулжээ. Эдгээр улс орнууд процессын хувьд ерөнхийдөө адил, тухайлбал процессыг эхлүүлэхээр өргөдөл гаргасны дараа юуны өмнө шүүхийн ажиллагаанаас гадуур шийдвэрлэх, хэрэв амжилтгүй болсон тохиолдолд шүүхээр шийдвэрлэх зарчим баримталж байгаагаараа мөн адил байна.

3. Австри Улс

Австри Улсын 1995 оны Хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалтын загвар 2017 онд Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль (Insolvency law-Insolvenzrechtsänderungsgesetz 2017) баталж, шинэчлэл хийснээр дампуурлын процессын хатуу бүтцээ зөөлрүүлсэн гэж үздэг. Тус улсын дампуурлын эрх зүйн зохицуулалт нь зээлдэгч, зээлдүүлэгч, шүүх/захиргааны байгууллагын шийдвэрээс шалтгаалан процесс хаана, хэрхэн явагдах тухайд шаталсан хувилбарын сонголттой. Ингэхдээ, аль ч процессыг эхлүүлэхэд шударга үзэл агуулсан байх ёстой бөгөөд энэ нь хувь хүний дампуурлын зохицуулалтын үндсэн зарчим болдог.

Австри Улсын зохицуулалтад шууд дампуурлын сонголт байхгүй. Ажиллагааны эхний шат нь шүүхээс гадуурх ажиллагаа байх бөгөөд энэ нь 1995 онд хууль батлагдахаас ч өмнө үйлчилж байсан. Энэ нь үндсэндээ зээлдүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан гэрээнд үндэслэн үүргийн бүтцэд өөрчлөлт оруулах замаар эвлэрлийн журмаар шийдвэрлэх ажиллагаа юм. Эргэн төлөлтийн төлөвлөгөөг зээлдүүлэгчийн шийдвэрээр хамгийн ихдээ 7 жилийн хугацаанд амжилттай биелүүлсэн тохиолдолд төлбөр барагдуулсанд тооцно. Энэ тохиолдолд зээлдэгч өөрийн хөрөнгө, орлого, зардлаа зохицуулах бүрэн эрхээ өөртөө хадгалж, эргэн төлөлтийн төлөвлөгөөг биелүүлэх үүрэг хүлээх бөгөөд өр барагдуулах албан ёсны зөвлөх процессын явцад дэмжлэг үзүүлдэг.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон тохиолдолд шүүхийн процесст шилжихэд мөн ялгаатай сонголт бий. Шүүхийн ажиллагаа эхлүүлэхэд зээлдэгч төлбөрийн чадваргүй болсон, эвлэрэх ажиллагаа амжилтгүй болсон гэдгийг нотлох шаардлагатай. Эхний сонголт бол албадах юм. Зээлдэгч нь дахин сэргэх төлөвлөгөө гаргасны үндсэн дээр төлбөр төлөх үүргийн 20 хувийг 2 жилийн дотор, 5 жилийн дотор 30 хувийг төлөх саналыг

зээлдэгчид тавьдаг. Зөвшөөрөх эсэхийг зээлдэгчийн саналаар шийдэх бөгөөд зээлдэгч бүр өөр өөр босго тавьж болно. Энэ тохиолдолд эд хөрөнгийг албадан худалдахгүй.

Хэрэв энэ ажиллагаа амжилтгүй болбол дараагийн алхам нь эргэн төлөлтийн төлөвлөгөө байна. Энэ ажиллагааны үед зээлдэгчийн хөрөнгө, эд хөрөнгийг бүртгэх бөгөөд үндсэн хэрэгцээг хангах хэмжээний хөрөнгөөс бусад хөрөнгийг худалдан борлуулах боломжтой. Эргэн төлөлтийн төлөвлөгөөнд дээд тал нь 7 жилийн хугацааг заах бөгөөд зээлдэгчийн шийдвэрээр зөвшөөрөл өгнө. Гүйцэтгэлийн явцад зээлдэгч зээлдүүлэгчийн хяналтгүйгээр үйл ажиллагаа явуулах ба төлөвлөгөө амжилттай хэрэгжсэний үндсэн дээр өр төлбөрөөс бүрэн чөлөөлөгдөнө. Хэрэв зээлдүүлэгч төлөвлөгөөнөөс татгалзвал сүүлийн шатны процесс нь оролцох процесс байна. Үүнд, орлогын доод хэмжээг шүүх тогтооно. Тус босгыг давсан орлогын хувьд албан ёсоор томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч төлбөрийг хариуцаж зээлдэгч рүү шууд шилжүүлнэ. Энэ процесс ерөнхийдөө итгэмжлэгдсэн төлөөлөгч, зээлдэгч нарын хяналт дор явагдах бөгөөд амьдралын баталгаажих доод түвшинтэй тэнцэх хэмжээний орлогоор зээлдэгч нь амьдрах болно. Энэхүү процесс 3-7 жил үргэлжлэх бөгөөд үүргийн хэдэн хувийг төлсөн гэдгээс хамаарч гүйцэтгэл эцэслэгдсэн эсэхийг шийднэ. 3 жилийн хугацаагаар тогтоогдсон тохиолдолд төлбөрийн үүргийн 50 хувийг төлж дуусгасан байх ёстой. Харин 7 жилийн хугацаанд баталгаагүй үүргийн 10 хувийг төлж барагдуулаагүй бол төлбөрөөс шууд чөлөөлөгдөхгүй. Гэхдээ энэ нь зөвхөн шүүхийн шийдвэрт үндэслэх бөгөөд шүүхээс эргэн төлөлтийн хугацааг сунгаж болно.

Энэ шатанд гол онцлог нь зээлдэгчдийн зөвшөөрлийг авах хэрэггүй бөгөөд тогтоосон журмын дагуу зохицуулагдаж, уг арга хэмжээнд хамрагдах өргөдөл гаргахад хатуу шаардлага (өмнө нь өргөдөл гаргаж энэ процесст хамрагдаж байсан эсэх, хүчирхийлэл үйлдэж байгаагүй байх, шударга, хариуцлагатай хандсан байх г.м) тавигддаг. Харин 2017 онд хийсэн шинэчлэл нь шинэ эхлэлийг дэмжих хэд хэдэн шинжийг агуулсан байна. Тухайлбал, орлого багатай өргөдөл гаргагч дээр дурдсан ажиллагаануудад хамрагдах боломж хязгаарлагдмал байсныг шинэчилж, орлого багатай өргөдөл гаргагч шууд сүүлийн шатны процесст хамрагдах эрхтэй байхаар хуульчилсан. Үүний зэрэгцээ тухайн процессыг эхлүүлэх шалгуурыг зөөллөсөн байна. Өмнө дурдсанчлан, 7 жилийн хугацаанд баталгаагүй үүргийн 10 хувийг төлж барагдуулсан байх шаардлагыг хасаж, тухайн хугацааг 5 жил болгон богиносгосон. Эдгээрээс гадна захиргааны зардлаас чөлөөлөгдөх боломжийг нэмж тусгажээ. Ингэснээр Австи Улсын зохицуулалт илүү зөөлөн шинжтэй загвар болсон учир дампуурлын процессын дагуу өргөдөл гаргах боломжтой этгээдийн тоо нэмэгдсэн байна³⁸.

³⁸ Сүхбаатар С. Хувь хүний дампуурлын эрх зүйн зохицуулалт: олон улсын чиг хандлага, зарим улсын туршлага. Судалгааны тайлан. УБ. 2022.43-50дахь тал.

3.4. Эд хөрөнгийн бус шаардлагыг хангах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт:

ШШГТХ-ийн 9 дүгээр бүлгийн 99-103 дугаар зүйлд эд хөрөнгийн бус шаардлагыг хангах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар тусгажээ. Хуулийн дээрх зохицуулалтад эд хөрөнгийн бус шаардлагыг хангах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дараах шийдвэрийг хамааруулсан байна.

1. Тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл тодорхой ажиллагаа гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгасан шийдвэрийг гүйцэтгэх;

2. Орон байр, барилгаас нүүлгэн гаргах, байр, агуулах сав, газар чөлөөлөх, барилга байгууламжийг нураах тухай шийдвэрийг гүйцэтгэх;

3. Төлбөр авагчийг байр, барилга байгууламжид нүүлгэн оруулах тухай шийдвэрийг албадан гүйцэтгэх;

4. Хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид шилжүүлэх, тэдгээртэй уулзуулах тухай шүүхийн шийдвэрийг биелүүлэх;

5. Үндэслэлгүйгээр ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн, өөр ажилд шилжүүлсэн ажилтныг эгүүлэн тогтоох тухай шийдвэрийг гүйцэтгэх.

Хүснэгт 7. Эд хөрөнгийн бус шаардлагыг хангах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны судалгаа

ҮЗҮҮЛЭЛТ		Оны эхний үлдэгдэл	Шинээр	Төлбөр			
				Биелүүлбэл зохиx	Биелүүлсэн	Үлдэгдэл	хувь
2018 он	ГХ	125	318	416	288	128	69.2
	МД /мян/	46,067.3	159,437.4	202,794.4	65,770.7	137,023.7	32.4
2019 он	ГХ	120	263	381	234	147	61.4
	МД /мян/	137,023.7	70,344.6	207,453.3	25,930.2	181,523.1	12.5
2020 он	ГХ	188	158	302	158	144	52.3
	МД /мян/	51,518.9	109,494.4	290,683.1	134,988.4	155,694.7	46.4
2021 он	ГХ	144	187	326	188	138	57.7
	МД /мян/	155,694.7	68,610.9	179,692.4	131,874.8	47,817.6	73.4
2022 он	ГХ	138	306	439	251	188	57.2
	МД /мян/	47,817.6	175,247.5	216,948.1	165,429.2	51,518.9	76.3
2023 он	ГХ	188	158	302	158	144	52.3
	МД /мян/	51,518.9	109,494.4	290,683.1	134,988.4	155,694.7	46.4
2024 он	ГХ	232	566	775	471	304	60.8
	МД /мян/	198,532.4	1,131,190.0	1,265,849.3	396,533.4	869,315.9	31.3


Шүүхээс гэр бүл цуцалсан шийдвэрийг гаргахдаа хүүхдийг эцэг, эх болон бүхий этгээдтэй нийтээр амрах болон баяр ёслолын өдрүүд түүнчлэн бусад хугацаанд (хүссэн үед) уулзуулахыг даалгах, долоо хоногт нэгээс доошгүй хоног хамт байлгахыг даалгах зэрэг олон төрлийн шийдвэрийг гаргадаг. Гэтэл энэ төрлийн шийдвэрийг гүйцэтгэхэд заавал шийдвэр гүйцэтгэгч биечлэн уулзуулах шаардлагатай болдог.

Энэ тохиолдолд талуудыг тодорхой үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гэрээ байгуулах замаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах бөгөөд үүрэг хүлээсэн этгээд шүүхээс даалгасан тодорхой үүргийг биелүүлээгүй бол түүний үйлдэл, эс үйлдэхүйд зөрчлийн хариуцлага тооцуулах үндэслэл болдог. Шүүхийн шийдвэрт заасан асран хамгаалагчид хүүхдийг шилжүүлэх явцад тухайн хүүхэд очихоос татгалзсан, уг үндэслэлээр сэтгэл зүйн цочролд орсон бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түр зогсооно.

ШШГБ-д хүүхэд шилжүүлэх эсхүл тодорхой үүрэг гүйцэтгүүлэх шүүхийн шийдвэр харьцангуй бага ирдэг боловч биелүүлэхэд ихээхэн хүндрэл учруулдаг. Шүүхийн шийдвэрт хүүхдийг хууль бус асран хамгаалагчаас (эцэг, эх, эмээ, өвөө) шилжүүлэн шүүхийн шийдвэрт заасан хууль ёсны асран хамгаалагчид (эх, эцэг) хүлээлгэн өгөхөөр шийдвэрлэсэн бол хүүхэд шилжүүлэх үүргийг хангуулах хугацааг төлбөр төлөгч, бусад этгээдэд тогтоож, хүүхдийг асран хамгаалагчид хүлээлгэн өгч, холбогдох үйл явцыг баталгаажуулна. Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахдаа хүүхдийн оршин суух газрын өрхийн эмнэлэгтэй хамтран хүүхдийн биед эрүүл мэндийн үзлэг хийлгэж, ил шарх, сорви, бэртэл, гэмтэл байгаа эсэхийг нягтлан шалгаж, хүүхэд хүлээлцсэн тэмдэглэлд тусгаж, оролцогчоос гаргасан санал, хүсэлтийг шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Нийслэл, орон нутгийн 68 шийдвэр гүйцэтгэгчдээс авсан эд хөрөнгийн бус шаардлагыг хангах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах эрх зүйн зохицуулалтыг хэрхэн үнэлдэг вэ? гэсэн асуултад 6 буюу 8.7 хувь нь шаардлага хангаж байгаа, 44 буюу 63.8 хувь нь зарим зүйл, заалтыг шинэчлэх шаардлагатай, 19 буюу 27.5 хувь нь шаардлага хангахгүй бүрэн шинэчлэх шаардлагатай гэж үзсэн нь дээрх харилцааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх шаардлага байна гэж үзлээ.

Зураг 15. Эд хөрөнгийн бус шаардлагыг хангах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үнэлгээ



Асуудал 1. Иргэний хэргийн шийдвэртэй гүйцэтгэх баримт бичгийн тодорхой хувийг төлбөртэй төрийн байгууллага эзэлдэг бөгөөд Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хэмжээнд төрийн байгууллагад холбогдох нийт 47 тэрбум төгрөгийн 291 гүйцэтгэх баримт бичиг бүртгэлтэй, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шатанд төлбөр авагч иргэн-хуулийн этгээдээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удаашралттай байгаа талаарх гомдол, мэдээлэл цөөнгүй иржээ. Түүнчлэн НШШГГ-т 2023 оны жилийн эцсийн байдлаар ажилд

эгүүлэн томилох төрийн алба хаагчдад холбогдох 145 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан бөгөөд 44 төрийн байгууллага, албан тушаалтан шүүхийн шийдвэрийг биелүүлж 101 төрийн байгууллага албан тушаалтан шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй байна.

Түүнчлэн эд хөрөнгийн бус шаардлагыг хангах “тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл тодорхой ажиллагаа гүйцэтгэхгүй байх, орон байр, барилгаас нүүлгэн гаргах, байр, агуулах сав, газар чөлөөлөх, барилга байгууламжийг нураах, төлбөр авагчийг байр, барилга байгууламжид нүүлгэн оруулах, хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид шилжүүлэх, тэдгээртэй уулзуулах, үндэслэлгүйгээр ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн, өөр ажилд шилжүүлсэн ажилтныг эгүүлэн тогтоох, ажилд эгүүлэн томилох, үйл ажиллагааг зогсоох, хурал хуралдуулах, гэрээний үүргээ биелүүлэх”-ыг даалгасан шийдвэрийг биелүүлэхээс зайсхийсэн төлбөр төлөгчид хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан зохицуулаагүй байна.

Иймд эд хөрөнгийн бус шаардлагыг хангах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх нэгдсэн ойлголтыг иргэний эрх зүйн хүрээнд бий болгож, тухайн шийдвэрийг гүйцэтгээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бий болгох шаардлага байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь бусдын эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг зөрчсөн буюу тодорхой үүргээ биелүүлээгүйн улмаас бусдын эдийн засгийн болон бусад эрхэд хор уршиг учруулсан этгээдийн эрхийг нь зөвхөн хуульд заасан журмаар хязгаарлаж байдаг төрийн албадлагын арга хэмжээний нэг төрөл байдаг. 2017 оны ШШГТХ-ийн үйлчлэлийн буюу 2017-2024 оныг хүртэлх хугацаанд шүүхээс ирүүлсэн гүйцэтгэх хуудасны биелэлт 53.1 хувийн дундаж биелэлттэй байна. Мөнгөн дүнгийн дундаж биелэлт 23.4 хувь буюу хангалттай бус байгаа ба энэ асуудалд өндөр үнийн дүнтэй гүйцэтгэх хуудасны биелэлт хангалттай бус байна гэж үзлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт муу байгаа нь нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлээс шалтгаалах хэдий ч төлбөр төлөгчийн төлбөрийн чадваргүй байдал, хариуцлагын тогтолцоо сул, эрх зүйн зохицуулалтын хангалтгүй зэргээс нөлөөлж байна.

Иргэний 68 шийдвэр гүйцэтгэгчээс өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй ШШГТХ-д тусгагдсан иргэн, захиргааны шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтад үнэлгээ өгөхтэй холбоотой асуулга авахад 15 буюу 22.1 хувь нь шаардлага хангахгүй тул бүрэн шинэчлэх шаардлагатай, 50 буюу 73.5 хувь нь зарим зүйл, заалтыг шинэчлэх шаардлагатай, зөвхөн 3 буюу 4.4 хувь нь шаардлага хангаж байгааг илэрхийлсэн тухайн ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх шаардлага зүй ёсоор урган гарсан байна гэж үзлээ.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсний дүнд дараах дүгнэлт, зөвлөмжид хүрлээ.

1. ШШГТХ-д төлбөр төлөгчийн үүргийг тодорхой зааж өгөөгүй нь төлбөр төлөгч шүүхийн шийдвэрийг үл биелүүлдэг, шийдвэр гүйцэтгэгчийн тавьсан хууль ёсны шаардлагыг үл тоодог, биелүүлдэггүй, дүр эсгэж биелүүлдэг, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд санаатайгаар саад учруулж, удаашруулдаг, шийдвэр гүйцэтгэгчид ажлын ачаалал бий болгох зэрэг сөрөг үр дагаврыг дагуулж байгаа тул тусгайлан хуульчлах шаардлага байна гэж үзлээ. ШШГТХ-ийн 33 дугаар зүйлийн 33.2-д төлбөр төлөгчийн хүлээх үүргийг нарийвчлан тусгах, тухайлбал, гүйцэтгэх баримт бичиг, хууль тогтоомжид заасан үүргийг биелүүлэх, шийдвэр гүйцэтгэгчийн дуудсанаар хүрэлцэн ирэх, шийдвэр гүйцэтгэгчийн тавьсан шаардлагыг биелүүлэх, шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг гардаж авах, биелүүлэх зэргийг тусгах;

2. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтэд шууд нөлөөлж буй хүчин зүйл нь төлбөр төлөгчийн төлбөрийн чадваргүй байдал болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явц дахь тодорхой ажиллагаанд шүүхэд гомдол гаргах явдал гэж үзлээ. Хэдийгээр иргэн Үндсэн хуульд заасан гомдол гаргах эрхтэй хэдий боловч нэгэнт шүүхээр шийдэгдсэн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоосон гэм буруутай үйлдлийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхгүй байхад чиглэгдсэн гомдол гаргах, хугацааг удаашруулах арга хэмжээ авч байна. Иймд ШШГТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх заалтыг хасах, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа бүрд шүүхэд гомдол гаргах эрхийг тусгасан ШШГТХ-ийн 55.7, 63.4, 87.7, 106.1 дэх заалтыг өөрчлөх шаардлага байна;

3. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх, төлбөр барагдуулах хамгийн гол арга хэрэгсэл нь баталгаажуулах арга хэмжээ бөгөөд энэ нь шийдвэр гүйцэтгэх

ажиллагааны биелэлтийн үр дүнтэй шууд холбогдоно. Судалгааны дүнд үндэслэн “баталгаажуулах арга хэмжээ” гэсэн нэр томьёог өөрчлөх, эсхүл хууль зүйн агуулгын хувьд шинэчлэн тогтоох шаардлага байна гэж үзлээ.

4. Иргэний шийдвэр гүйцэтгэх баталгаажуулах ажиллагаанд хамгийн их маргаан дагуулдаг хөрөнгийн үнэлгээ хийлгэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг өнөөгийн шаардлагыг хангахгүй байна. Шинжээч, үнэлгээчин гэх ойлголт нь эрх зүйн зохицуулалтын хувьд тухайн үйл ажиллагаанд ашиглагдах “Хөрөнгийн үнэлгээний тухай хууль”, “Шүүх шинжилгээний тухай хууль”-ийг тус тус удирдлага болгон ажилладаг тусдаа мэргэжил бөгөөд гагцхүү “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуульд эдгээр ойлголтыг зааглаж шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ямар тохиолдолд эдгээр мэргэжилтнийг оролцуулах талаар тодорхой тусгаагүй нь учир дутагдалтай гэж үзлээ. Түүнчлэн ШШГТХ-д шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дээрх дарааллыг хөрөнгө бүрд ижил байхаар тогтоосон нь хугацаа алдах, гомдол гаргах үндэслэлийг бүрдүүлж байх тул захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн хөрөнгөд явуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалалд хураан авсан даруйд үнэлгээ тогтоох шийдвэр гаргах дарааллаар тогтоох шаардлагатай байна;

4. Судалгааны явцад шийдвэр гүйцэтгэгчдээс хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаанд тулгамдаж буй асуудлын талаарх асуулгад 41 буюу 60.3 хувь нь төлбөр төлөгчийн хаяг тодорхойгүй, 20 буюу 29.4 хувь нь төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй, 7 буюу 10.3 хувь нь төлбөр төлөгчид хүлээлгэх хариуцлага сул гэж хариулсан. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд төлбөр төлөгчийг ажлын байраар хангах арга хэмжээг зохион байгуулалтын хувьд авах шаардлага байна;

5. Шийдвэр гүйцэтгэгчдээс авсан төлбөрийн чадваргүй иргэнээс төлбөр гаргуулах ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх таны санал гэсэн асуултад 98,6 хувь нь ажлын байраар хангаж, цалин хөлснөөс нь төлбөр төлүүлдэг эрх зүйн зохицуулалтыг бий болгох, 1,4 хувь нь нуугдмал эд хөрөнгийг эрэн сурвалжлах тогтолцоог бий болгох гэж хариулсан бол төлбөрийн чадваргүй хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх талаарх асуулгад 21 буюу 30.9 хувь нь хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах гэж үзсэн бол 47 буюу 69.1 хувь нь төлбөр төлөгч хуулийн этгээдийг татан буулгах ажиллагааг эхлүүлэх, харин иргэний хувьд ажлын байраар хангаж, цалин хөлснөөс нь төлбөрийг төлүүлэх нь зүйтэй гэж үзжээ;

6. Төлбөрийн үнийн дүнгээс үл хамааран төлбөр төлөгч иргэн, төлбөр төлөгч-хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчийн гадаадад зорчих эрхийг үнийн дүнгээс үл хамааран түдгэлзүүлэх зохицуулалтыг тусгах нь эрэн сурвалжлагдаж байгаа үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх, удаашрах нөхцөлийг бууруулах боломжтой байна. Дээрх заалттай уялдуулан Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт заасны дагуу төлбөр төлөгч-хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагаас гадна хувьцаа эзэмшигчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх зохицуулалтыг нэмэлтээр тусгах нь зүйтэй байна;

7. Эд хөрөнгийн бус шаардлагыг хангах “тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл тодорхой ажиллагаа гүйцэтгэхгүй байх, орон байр, барилгаас нүүлгэн гаргах, байр, агуулах сав, газар чөлөөлөх, барилга байгууламжийг нураах, төлбөр авагчийг байр, барилга байгууламжид нүүлгэн оруулах, хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид шилжүүлэх, тэдгээртэй уулзуулах, үндэслэлгүйгээр ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн, өөр ажилд шилжүүлсэн ажилтныг эгүүлэн тогтоох, ажилд эгүүлэн томилох, үйл ажиллагааг

зогсоох, хурал хуралдуулах, гэрээний үүргээ биелүүлэх”-ыг даалгасан шийдвэрийг биелүүлэхээс зайсхийсэн төлбөр төлөгчид хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан зохицуулаагүй байна. Иймд эд хөрөнгийн бус шаардлагыг хангах иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх нэгдсэн ойлголтыг иргэний эрх зүйн хүрээнд бий болгож, тухайн шийдвэрийг гүйцэтгээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бий болгох шаардлага байна.

ТАВ. ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж:

Монгол Улсын Үндсэн хууль (1992)

Зөрчлийн тухай хууль (2017)

Монгол Улсын Шүүхийн тухай хууль (2021)

Нотариатын тухай хууль(2011)

Хөрөнгийн үнэлгээний тухай хууль (2022)

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017)

Иргэний хууль (2002)

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002)

УИХ, ЗГ-ын тогтоол, бодлогын баримт бичиг:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар (УДШ-ийн тогтоол 2014).

Хүний эрхийн түгээмэл Тунхаглал. (Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейн тогтоол № 2200А ХХI, 1966)

Ном, сурах бичиг, гарын авлага:

Амарсанаа, Ж. нар. Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн товчоон (1911-2008) Куб., 2008.

Амарсайхан, Ц нар. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. Уб., 2008.

Гиймаа, Д. Иргэний эрх зүй. Уб., 2015.

Дашзэвэг, Б. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. Уб., 2013.

Дашзэвэг, Б. Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй-1. Уб. 2003.

Дугармаа, А нар. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй. Уб., 2007.

Лхагваа, А. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. Уб., 2004.

Мөнхжаргал, Т. Монгол улсын иргэний эрх зүй. Уб., 2003.

Нарангэрэл, С. Эрх зүйн эх толь бичиг. Уб., 2007.

Нямсүрэн, Ч. Эрх зүйн ерөнхий онол. Уб., 2010.

Отгонтуяа, О. Иргэний эрх зүй. Уб., 2017.

Сүхбаатар, С нар. Зарим орны шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тогтолцооны талаарх судалгаа. Уб., 2002.

Нэг сэдэвт бүтээл:

Саяболд, Б. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дахь гуравдагч этгээдийн оролцоо, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт. Хууль зүйн магистрын зэрэг горилсон бүтээл. Уб., 2020.

Уранцэцэг, Б. Ажилтны эд хөрөнгийн хариуцлагын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох нь. Докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 1999.

Ууганчимэг, Ж. Иргэний эрх зүйн лекцүүд. Уб., 2016.

ХЗҮХ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны судалгааны тайлан. Уб., 2022.

Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл:

Алтангэрэл, Б. Эрсдэлд суурилсан тогтвортой хөгжил. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл II. Уб., 2023. Эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гүйцэтгэж буй үүрэг илтгэл.

Бадрах, Т. Шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмын детерминизмийн асуудал. Уб., 2002. <https://legaldata.mn/b/1207>.

Батгэрэл, Я. Шийдвэр гүйцэтгэгчийн урамшуулал хэрэгцээ, шаардлага илтгэл. Уб., 2023.

Дугармаа, А. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онол практикийн асуудал. Уб., 2020

Жамъяанпүрэв, Э. Иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн шинэтгэл: илтгэлийн эмхэтгэл “Захиргааны шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх” сэдэвт эрдэм шинжилгээний илтгэл. Уб., 2021.

Зая. А. Эрэн сурвалжлах ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх зарим асуудал., Иргэн захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн шинэчлэл эмхэтгэл. Уб., 2021.

Намсаманд, А. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэл” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт сэдэвт илтгэл. Уб., 2021.

Отгонбаяр, Б. “Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийн эмхэтгэл. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гарч буй өргөдөл, гомдлын шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс, шийдвэрлэх арга зам илтгэл. Уб., 2023.

Шагдарсүрэн, З. “Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийн эмхэтгэл. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны урамшууллын тогтолцоо олон улсын чиг хандлага илтгэл. Уб., 2023.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1. Үнэлгээ хийх шалтгаан:

УИХ-аас 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хуулийг баталж, 2004 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс Захиргааны хэргийн шүүх үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Ингэснээр Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд заасан иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг захиргааны хууль бус үйл ажиллагаанаас хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх хууль зүйн баталгаа захиргааны эрх зүйн төвшинд хэлбэржиж бүрдсэн.

Манай улсад захиргааны хэргийн шүүх байгуулагдсанаас хойш шүүхэд зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар нэхэмжлэл гаргасан иргэн, хуулийн этгээдийн тоо тогтмол өсөж, цаашдаа нэмэгдэх хандлагатай байна. Монгол Улсад анх захиргааны хэргийн шүүх байгуулагдан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж эхэлсэн 2004 онд 145 хэрэг шийдвэрлэгдсэн бол 2023 онд 2371 хэрэг шийдвэрлэгдсэн³⁹ нь үүнийг нотлон харуулж байна.

Гэвч захиргааны хэргийн шүүх байгуулагдсан өнгөрсөн 20 жилийн хугацаанд шүүхийн шийдвэрийн биелэлт хангалтгүй байна. Тухайлбал, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, гүйцэтгэх баримт бичгийг бодит биелэлтийг судлан үзвэл дунджаар 46 орчим хувьтай буюу 2023 оны жилийн эцсийн байдлаар 406 гүйцэтгэх хуудасны 26.247.310.000 (хорин зургаан тэрбум) төгрөгийн шийдвэр биелүүлэхээс 194 гүйцэтгэх хуудасны 19.578.473.100 (арван есөн тэрбум) төгрөг буюу гүйцэтгэх хуудасны 47.8 хувь, мөнгөн дүнгийн 74.9 хувийг гүйцэтгэсэн нь захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт хангалтгүй⁴⁰ байгаа нь харагдаж байна. Дээрхээс харахад захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлтийг нарийвчилсан судалж үзэх, захиргааны шүүхийн шийдвэрийн биелэлт хангалтгүй байгаа шалтгааныг тогтоох, тулгамдсан ямар асуудлууд буйг илрүүлж, шийдвэрлэх арга замыг боловсруулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

ШШГТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.3-д зааснаар захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг ЗХШХШТХ-ийн 12.1-д заасан захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр, захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай хуулийн хүчин төгөлдөр болсон шүүгчийн захирамж, хялбаршуулсан журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, шүүхийн зардал тогтоосон шүүгчийн захирамжийг үндэслэн явуулж байна.

Захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль⁴¹, Төрийн албаны тухай хууль⁴², Монгол Улсын Шүүхийн тухай хууль⁴³ Захиргааны ерөнхий хууль⁴⁴, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль⁴⁵, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль⁴⁶ зэрэг хууль тогтоомжоор зохицуулж байна.

³⁹ МУ-ын Шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ. Уб., 2004, 2023.

⁴⁰ ШГА-ны 2024 оны 5 дугаар сарын 24-ны 9-1/1650 тоот албан бичиг. Уб., 2024.

⁴¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1992. №01.

⁴² Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2018. №01.

⁴³ Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2021. №6.

⁴⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2015. №28.

⁴⁵ Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2016. №09.

⁴⁶ Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. №24.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд заасны дагуу хууль тогтоомж нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд үнэлгээний ажлыг эхлэхээс өмнө үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлно.

Дотоод хэргийн их сургууль, Шийдвэр гүйцэтгэлийн алба хамтран 2020 онд “Иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилт” судалгааг гүйцэтгэсэн бөгөөд тус судалгаагаар захиргааны шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг хэрэгжүүлж буй байгууллагын бүтэц, тогтолцоотой холбоотой зарим асуудлыг сонгон авч судалсан байдаг. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасны дагуу ШШГТХ-ийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлохыг зорилоо.

1.2. Үнэлгээ хийх хүрээ:

Аливаа хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлахад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. ШШГТХ-ийн захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой зүйл, заалт тус хуулийн 4.6 хувь буюу 123-137 дугаар зүйлийг хамарч байдаг. Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.4 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхдээ хууль тогтоомжид бүхэлд нь, эсхүл түүний зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож болно” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн захиргааны шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд холбогдох зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлсэн болно. Ингэхдээ захиалагч байгууллага болох ШШГЕГ-ын ирүүлсэн ажлын даалгавар, үнэлгээ хийх болсон шалтгааны харилцан уялдаа, хамааралтай байдлыг харгалзаж, хуулийн хэрэгжилтэд гарч буй эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон зохицуулалтыг сонгосон.

Үүний дүнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дараах зохицуулалтыг үнэлгээ хийх хүрээнд хамрууллаа.

д/д	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Зохицуулалтын агуулга
1.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 132 дугаар зүйл	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт
2.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 128 дугаар зүйл	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагын эрх зүйн зохицуулалт

1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт:

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд зааснаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтийн жагсаалтыг гарган, үнэлгээ хийх асуудал тодорхой болсон үед тодорхой 1 шалгуур үзүүлэлтийг сонгон авах бөгөөд зөвхөн 1 шалгуур үзүүлэлтээр тухайн асуудалд бүрэн үнэлэлт өгөх боломжгүй тохиолдолд 2 болон түүнээс дээш шалгуур үзүүлэлтийг сонгох боломжтой гэжээ.

Аргачлалд заасны дагуу захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж байгаа байдал гэсэн хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр:

Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтийг олж тодорхойлоход харьцуулах 4 төрлийн хэлбэрээс хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш-хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтооход чиглэгдэнэ. Тодорхой цаг хугацааны дарааллаар нөхцөл байдлын өрнөлийг жагсааж гаргасан судалгааг үнэлгээнд хэрэглэх хэлбэрийг сонгон ашиглалаа. Энэ хэлбэрийг ашиглахдаа захиргааны шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран тоо баримт, олон улсын эх сурвалж, бусад материалд дүн шинжилгээ хийнэ.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох:

Шалгуур үзүүлэлтийг томъёолохдоо шалгуур үзүүлэлт тус бүрээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааны сонгон авсан хэсэгт тохируулан дараах шалгуур үзүүлэлтийг сонгож, асуулт боловсрууллаа.

1. Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилтийн түвшин;
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 132 дугаар зүйл нь шүүхийн шийдвэр бүрэн биелэгдэх зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх ;
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 128 дугаар зүйл нь шүүхийн шийдвэр бүрэн биелэгдэх зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох:

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтэд тулгамдсан асуудлыг илрүүлэх зорилгоор баримт бичиг, судалгааны тайлан, илтгэл, өгүүлэл унших, судлах, харьцуулалт хийх, ШШГБ-ын алба хаагчдаас тулгамдаж буй асуудлын талаар судалгаа авах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд аргачлалын 3.7.3-т мэдээлэл цуглуулах дөрвөн аргыг тодорхойлсноос дараах хоёр аргыг сонгон үнэлгээ хийх мэдээллийг цуглуулсан болно.

1. Мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийх;
2. Судалгаа авах.

Мэдээлэл цуглуулах хүрээнд: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, холбогдох ном, сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, журам, зааврыг цуглуулж, үнэлгээ хийхэд ашиглав.

Судалгаа авах хүрээнд: Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэхийн тулд шийдвэр гүйцэтгэгчтэй ярилцлага хийх, анкетын аргаар судалгаа авсан. Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын үйл ажиллагааны тайлан, судалгаа, бусад мэдээллийг гаргуулан авч үнэлгээ хийхэд ашигласан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, алба хаагчидтай уулзалт-ярилцлага хийх, анкетын судалгаа авч, ярилцлагын аргад тулгуурлаж энэхүү судалгааг гүйцэтгэв.

2.1. Баримт бичгийн судалгаа: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлүүд, илтгэл, өгүүлэл, тайланг ашигласан болно.

2.2. Холбогдох субъектээс авсан судалгаа:

а) захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гардан хэрэгжүүлж буй 68 шийдвэр гүйцэтгэгчээс алба хаагчаас сонгон авсан эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, тулгамдсан асуудлын талаарх санал-асуулга;

2.3. Ярилцлагын арга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн бодит байдал, хууль хэрэглээнд тулгамдаж буй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг тодруулахаар ярилцлага хийсэн.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт

Захиргааны хэргийн шүүх нь эрх тэгш бус субъектүүдийн хоорондын хууль ёсны ашиг сонирхлыг тэнцвэржүүлж, шийдвэрээрээ дамжуулан иргэн хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, нийтийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр үйл ажиллагаанаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хүний эрхийг хангах гол институт юм. Захиргааны хэргийн шүүхийн гол зорилго бол захиргааны байгууллага албан тушаалтны хууль бус үйл ажиллагаанаас зөрчигдсөн хүний эрхийг сэргээн тогтоож, эдлүүлэх үүргээр илэрхийлэгддэг бол шийдвэр гүйцэтгэл нь энэ зорилгыг хангахад оршдог⁴⁷.

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шийдвэр гүйцэтгэгч, төлбөр авагч, төлбөр төлөгчийн хооронд төлбөрийг биелүүлэхтэй холбоотой эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдсан харилцааны нийлбэр байдаг бол Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь нэг талаас төр түүнийг төлөөлсөн захиргааны байгууллага, албан тушаалтан, нөгөө төлөөс эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн хүн, хуулийн этгээд байдгаараа бусад төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас ялгаатай.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгчийг эрх залгамжлагч төлөөлөхдөө өөрийн хүлээн авсан, эрх, эд хөрөнгийн хэмжээгээр шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэг хүлээдэг бол захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хариуцагчийг эрх залгамжлагч төлөөлөхдөө шүүхийн шийдвэрээр тодорхойлсон нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн бүхэлд нь гүйцэтгэх үүрэг хүлээдгээрээ онцлог харилцааг үүсгэдэг.

Захиргааны хэргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэрийг хэргийн оролцогч, түүний эрх залгамжлагч биелүүлэх үүрэгтэй⁴⁸. Захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онцлог нь шийдвэр гаргасан шүүхээс тухайн шийдвэрийг гүйцэтгэх хугацааг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш шийдвэрийн агуулга, хөндөгдөж байгаа эрх, ашиг сонирхлын онцлогоос хамааран тогтоож өгдгөөрөө бусад төрлийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаанаас ялгагддаг.

Захиргааны хэргийн шүүх нь гаргасан шийдвэртээ тухайн шийдвэрийг биелүүлэх арга, журмыг тодорхойлж биелүүлэх хугацааг гаргасан шийдвэр, олгосон мэдэгдэлдээ тусгах бөгөөд шүүхээс тогтоосон хугацаа, үндэслэл, журмын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулна. Захиргааны хэргийн шүүх гаргасан шийдвэрээ биелүүлэх арга, журам, хугацааг зааж өгөөгүй нөхцөлд хэрхэн гүйцэтгэх талаар тодруулах арга хэмжээг шийдвэр гүйцэтгэгч авна⁴⁹.

Захиргааны хэргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэрийг хэргийн оролцогч, түүний эрх залгамжлагч биелүүлэх үүрэгтэй ба хариуцагч захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд нэхэмжлэгч түүнийг албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд хандаж гүйцэтгэх хуудас олгуулна.

⁴⁷ Чимид, Б. Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн, Уб., 2004. 42 дахь тал.


⁴⁸ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24.

⁴⁹ Батгэрэл, Я. нар, дурдсан бүтээл. 123 дахь тал.

Хэргийн оролцогч хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүхэд гаргах ба гүйцэтгэх хуудсыг бичсэний дараа шүүгч шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэх хугацааг 30 хүртэл хоногоор тогтоож, энэ тухай мэдэгдэл гаргаж, хариуцагчид хүргүүлнэ.

Ахлах шийдвэр гүйцэтгэгч нь захиргааны хэргийн шүүхээс хариуцагчид тогтоосон сайн дураар биелүүлэх хугацааг шаардлагатай гэж үзвэл 14 хүртэл хоногоор сунгаж болох ба хугацаа дууссан талаар хариуцагчид мэдэгдэх хуудсаар мэдэгдэнэ.

Зураг 16. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл явц



Захиргааны хэргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэрийг хэргийн оролцогч, түүний эрх залгамжлагч биелүүлэх үүрэгтэй⁵⁰. Захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онцлог нь шийдвэр гаргасан шүүхээс тухайн шийдвэрийг гүйцэтгэх хугацааг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш шийдвэрийн агуулга, хөндөгдөж байгаа эрх, ашиг сонирхлын онцлогоос хамааран тогтоож өгдгөөрөө бусад төрлийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаанаас ялгагддаг.

Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч (хариуцагч)-д шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэх хугацаа тогтоон өгч, тогтоосон хугацаанд сайн дураар биелүүлээгүй бол захиргааны шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэнэ. Хариуцагч шүүхээс тогтоосон буюу шүүхийн мэдэгдэлд заасан хугацаанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй бол ахлах шийдвэр гүйцэтгэгч шүүхийн шийдвэрийг биелүүлэх хугацааг 14 хүртэл хоногоор сунгаж болох бөгөөд сунгасан хугацаанд биелүүлээгүй нөхцөлд хариуцагч этгээд хэн байхаас үл хамааран шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй талаар олон нийтэд мэдээнэ.

Шийдвэр гүйцэтгэгч шүүхийн мэдэгдэлд заасан хугацаа, эсхүл ахлах шийдвэр гүйцэтгэгчийн сунгасан хугацаа дуусмагц шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй захиргааны байгууллага, албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтанд захиргааны шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авахыг даалгасан шийдвэр гүйцэтгэгчийн мэдэгдэл хүргүүлж, шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллаагүй доод шатны албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах, авсан арга хэмжээний талаар эргэж мэдэгдэхийг үүрэг болгоно. Шийдвэр гүйцэтгэгчийн мэдэгдэлд заасан үүргийг хэрэгжүүлээгүй хүн, хуулийн этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэх талаар тодорхой тусгасан байхыг шаарддаг.

⁵⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24.

Захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг биелүүлэх, албадан гүйцэтгэх ажиллагааны онцлог нь захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааг өөрчлөх, хүчингүй болгох, төсвийн зориулалт бүхий мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах чиглэлтэй байдгаараа бусад төрлийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаанаас ялгагддаг. Шийдвэр гүйцэтгэгч нь хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгөөс төлбөр гаргуулах нийтлэг шаардлагын дагуу албадлагын арга хэмжээг хэрэгжүүлдэг ч гэсэн захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад зөвхөн захиргааны байгууллагын дансанд (төрийн сан) байгаа зориулалт бүхий мөнгөн хөрөнгөөс гаргуулдаг.

Захиргааны байгууллагын дансанд шүүхийн шийдвэрийг биелүүлэх зориулалт бүхий мөнгөн хөрөнгө байхгүй нөхцөлд төсвийн тодотголоор нэмэх, эсхүл дараа жилийн төсөвт тусгуулан захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулна. Шийдвэр гүйцэтгэгч захиргааны байгууллагын төсвийн тодотгол, дараа жилийн төсвийн төсөөлөлд шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах, зориулалт бүхий мөнгөн хөрөнгө тусгагдсан эсэх, тусгуулах талаар тодорхой арга хэмжээ авсан эсэхийг тодруулж хэрэв төсөвт тусгаагүй бол энэ талаар эрх бүхий этгээдэд шаардлага хүргүүлэн ажиллах ёстой.

Хэрэв хариуцагч захиргааны байгууллага шүүхийн шийдвэрт заасан төлбөрийг дараагийн жилийн төсөвт тусгаж, барагдуулаагүй бол нэхэмжлэгч шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтан болон төрөөс өөрт учирсан хохирлоо харьяалах шүүхэд хандан нэхэмжлэх эрхтэй⁵¹.

Захиргааны хэргийн шүүх нь гаргасан шийдвэртээ тухайн шийдвэрийг биелүүлэх арга, журмыг тодорхойлж биелүүлэх хугацааг гаргасан шийдвэр, олгосон мэдэгдэлдээ тусгах бөгөөд шүүхээс тогтоосон хугацаа, үндэслэл, журмын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулна. Захиргааны хэргийн шүүх гаргасан шийдвэрээ биелүүлэх арга, журам, хугацааг зааж өгөөгүй нөхцөлд хэрхэн гүйцэтгэх талаар тодруулах арга хэмжээг шийдвэр гүйцэтгэгч авна⁵².

Захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээг хүчингүй болгох тухай, тэдгээрийг илт хууль бус болохыг тогтоосон шийдвэрийг биелүүлэх:

Захиргааны байгууллагаас гаргасан захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээ нь илт хууль бус болохыг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар дараах байдлаар ойлгоно.

1. Захиргааны акт утга агуулгын илэрхий алдаатай;
2. Бичгийн хэлбэрээр гаргасан захиргааны актыг батлан гаргасан байгууллага, албан тушаалтан нь тодорхойгүй;
3. Эрх хэмжээгүй захиргааны байгууллага, албан тушаалтан гаргасан;
4. Актыг гүйцэтгэх субъект тодорхой бус.

Илтэд хууль бус захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээ нь гарсан цаг мөчөөс эхлэн хууль бус байх бөгөөд эрх зүйн харилцаанд орж тодорхой үр дагавар үүсгэсэн байдаг. Шүүхээс захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээг илт хууль бус болохыг нь тогтоосноор тухайн актыг эрх зүйн хэм хэмжээнээс хасаж, эрх зүйн актын үйлчлэлийг зогсооно. Захиргааны акт, захиргааны хэм

⁵¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24

⁵² Батгэрэл, Я. нар, дурдсан бүтээл. 123 дахь тал.

хэмжээний акт, захиргааны гэрээ илт хууль бус болох нь тогтоогдмогц өөр аяндаа биелэгдсэн гэж үзэж болно. Энэ тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч зохих журмын дагуу буюу олгосон зөвшөөрлөө хэрхэн хүчингүй болгож, иргэний зөрчигдсөн эрхийг хэрхэн сэргээж байгаад хяналт тавина.

Шүүхийн шийдвэр нь илт хүчин төгөлдөр бус актын улмаас үүссэн гэм хорыг арилгах, зөрчигдсөн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үр дагаврыг бий болгоно. Иймд шийдвэр гүйцэтгэгч хууль бус актыг үндэс болгон гарсан өөр бусад акт, хийсэн гэрээ, хэлцэл, төлөөлөл нь мөн хүчин төгөлдөр бус болох тул тухайн илт хууль бус актыг хэрэглэсэн байж болох тохиолдлуудыг сайтар судлах шаардлага гарна. Илт хууль бус болохыг тогтоох нэхэмжлэлийн шаардлагыг шүүх хангавал түүнийг шийдвэр гүйцэтгэлийн журмаар биелүүлэх шаардлагагүй юм⁵³.

Захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээг хүчингүй болгох тухай, тэдгээрийг илт хууль бус болохыг тогтоосон тухай шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноор захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээг хүчингүйд тооцох бөгөөд тэдгээрийг дахин хэрэглэхгүй. Захиргааны байгууллага, албан тушаалтан нь захиргааны хууль бус акт нь шүүхийн шийдвэрээр хүчингүйд тооцогдсоноор бусад этгээдийн эрх ашиг, сонирхолд нөлөөлөх бол тухайн захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээг хуульд нийцүүлэн шүүхээс тогтоосон хугацаанд дахин гаргах, байгуулах үүрэгтэй. Хүчингүйд тооцогдсон захиргааны хууль бус актыг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд, тэдгээрийн төлөөлөгч хууль бус болохыг урьдчилан мэдэж байсан, эсхүл түүнийг хүчингүйд тооцсоныг мэдэх боломжтой, мэдэх ёстой байсан боловч хүчингүйд тооцсон захиргааны хууль бус актыг хэрэгжүүлсэн бол хуульд заасан хариуцлага оногдуулна.

Шийдвэр гүйцэтгэгч хүчингүйд тооцсон захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээг хэрэгжүүлэхгүй байх талаар уг захиргааны хууль бус актыг үндэслэн тодорхой үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, эрх олгох эрх бүхий байгууллага, хариуцагч болон гуравдагч этгээдэд мэдэгдэл хүргүүлж, биелэлтийг хангуулан ажиллана.

Захиргааны акт гаргахыг даалгасан, эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоосон шүүхийн шийдвэрийг биелүүлэх:

Захиргааны акт гаргахыг даалгасан, эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоосон шүүхийн шийдвэрийг шүүхээс тогтоосон болон ахлах шийдвэр гүйцэтгэгчээс тогтоосон хугацаанд биелүүлэх үүргийг хариуцагч хүлээнэ.

Захиргааны акт гаргахыг даалгасан шүүхийн шийдвэр гэж тухайн захиргааны байгууллага, албан тушаалтны албан үүргийн хүрээнд эдлэх эрх, хүлээх үүрэгт хамаарах асуудлаар нэхэмжлэлийн шаардлагаар тодорхойлогдсон захиргааны акт гаргахыг даалгасан шүүхийн шийдвэр юм. Харин захиргааны байгууллага, албан тушаалтны эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоосон шүүхийн шийдвэр гэж эрх бүхий этгээдээс албан үүргээ хуульд заасан хугацаанд хэрэгжүүлээгүй эсхүл шийдвэрлээгүй орхигдуулсан эс үйлдэхүйг тогтоож, нэхэмжлэлийн шаардлагаар тодорхойлогдсон үүргийг хэрэгжүүлэх талаар хариуцагчид даалгаж шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг ойлгоно.

⁵³ Батгэрэл, Я. нар. Дурдсан бүтээл. 127 дахь тал.

Захиргааны акт гаргахыг даалгасан, эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоосон шүүхийн шийдвэрийг биелүүлэх гол зорилго бол хариуцагч захиргааны байгууллага албан тушаалтнаар нэхэмжлэлийн шаардлагыг хангуулах, захиргааны акт гаргуулах үйлдэл хийлгэх нь шийдвэр гүйцэтгэгчийн гол зорилго байдаг. Ийнхүү захиргааны байгууллага, албан тушаалтан шүүхийн шийдвэрт заасан захиргааны актыг гаргаснаар шүүхийн шийдвэрийг биелүүлсэнд тооцно.

Төлбөр тогтоосон захиргааны актын төлбөрийн хэмжээг багасган тогтоосон шүүхийн шийдвэрийг биелүүлэх:

Шүүхээс захиргааны байгууллага албан тушаалтны тогтоосон төлбөрийн хэмжээг багасгаж эсхүл хүчингүй болгож шийдвэрлэсэн бол шийдвэр гүйцэтгэгч захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны улмаас нэхэмжлэгч этгээдэд учирсан хохирол, нөхөн төлбөр гаргуулахтай холбогдсон шийдвэрийг иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар хэрэгжүүлнэ.

Төлбөр гэдэгт төрийн өмч /иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц зэрэг/ ашиглуулсны төлөө иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас авч улс, орон нутгийн төсөв, тусгай зориулалтын санд төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг ойлгох талаар заасан байна⁵⁴. Шийдвэр гүйцэтгэгч хариуцагч захиргааны байгууллага, буруутай албан тушаалтнаас төлбөр буюу хохирол гаргуулах шийдвэрийг гүйцэтгэхдээ хуульд заасан дараалал, арга, журмын дагуу бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Хариуцагч захиргааны байгууллагын төлбөр төлөх зориулалт бүхий мөнгөн хөрөнгөөс суутгал хийх тухай мэдэгдлийг хариуцагч этгээдэд хүргүүлэх бөгөөд хариуцагч шийдвэр гүйцэтгэгчийн мэдэгдлийг хүлээн авсан даруйд суутгал хийж 3 хоногийн дотор шийдвэр гүйцэтгэгчийн заасан дансанд шилжүүлэх үүргийг хүлээнэ.

Нэхэмжлэлийн шаардлага хангах хэмжээний мөнгөн хөрөнгө хариуцагч захиргааны байгууллагын дансанд байхгүйн улмаас мэдэгдэлд заасан шаардлагыг хэсэгчлэн биелүүлсэн, эсхүл бүрэн биелүүлэх боломжгүй талаар шийдвэр гүйцэтгэгчид бичгээр мэдээнэ. Энэ тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч тухайн захиргааг санхүүжүүлдэг байгууллагад төлбөрийг гаргуулах мэдэгдлийг хүргүүлэх буюу дараагийн жилийн төсөвт нэмж тусгуулах арга хэмжээг авна. Захиргааны байгууллагын төлбөрт шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын данснаас 3 хоногийн дотор нэхэмжлэгч этгээдийн хүсэлт гаргасан дансанд шилжүүлэх ба нэхэмжлэгчийн данс тодорхойгүй бол мөнгөн хөрөнгийг нийтэд зарласнаас хойш иргэнд олгох бол 3 жилийн, хуулийн этгээдэд холгох бол 1 жилийн хугацаанд хадгална.

Шүүхээс захиргааны байгууллага, албан тушаалтны төлбөр тогтоосон шийдвэрийг өөрчилж тогтоосон бол шүүхээс тогтоосон болон ахлах шийдвэр гүйцэтгэгчээс тогтоосон хугацаанд урьд гаргасан захиргааны актаар тогтоосон төлбөрийн хэмжээг шүүхийн шийдвэрт нийцүүлэн өөрчлөлт оруулна. Мөн шүүхээс тогтоосон төлбөрийн хэмжээг хуульд заасан хэмжээгээр багасгах, дахин нэмэхгүй байх, эсхүл илүү төлсөн төлбөрийн хэмжээг буцаан олгох байдлаар шийдвэрлэсэн байж болно. Шүүхээс өөрчлөн тогтоосон нэхэмжлэгчийн шаардлагыг хэрэгжүүлэхдээ урьд гаргасан захиргааны актаар тогтоосон төлбөрийг нэхэмжлэгч төлж барагдуулсан тохиолдолд шүүхийн шийдвэрээр тогтоосон

⁵⁴ Лхагвасүрэн, Д., Эрдэнэтуяа, Д. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа. Уб., 2016. 55 дахь тал.

зөрүүг захиргааны байгууллагаас буцаан гаргуулж нэхэмжлэгчид олгох ажиллагааг хэрэгжүүлэх ёстой.

Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх:

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор шүүх хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай захирамжийг гаргана. Ингэхдээ захиргааны хэм хэмжээний актын биелэлтийг түдгэлзүүлэх нь бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, хуулийн этгээд, эсхүл нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулахаар бол, хүн, хуулийн этгээдээс албан татвар, төлбөр, хураамж гаргуулах тухай шийдвэр, захиргааны журам зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэсэн бол уг зөрчлийг таслан зогсоох тухай захиргааны хяналтын байгууллага, албан тушаалтны шийдвэр, хуульд заасан тохиолдолд үл маргалдах журмаар биелүүлэх бол шүүх, шүүх бүрэлдэхүүн захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай шийдвэр гаргахгүй.

Дээрх үндэслэлээс бусад захиргааны актын биелэлтийг шүүхийн шийдвэр гарах хүртэлх хугацаанд түдгэлзүүлэх тухай шийдвэрийг шүүх хүлээн авч шийдвэрлэнэ. Шүүгчийн захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн захирамж нь тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл хүчин төгөлдөр байна. Энэ нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 126 дугаар зүйлийн 126.3 дахь хэсэгт заасан “Захиргааны актыг түдгэлзүүлэх тухай” шууд олгох гүйцэтгэх баримт бичигт хамаарах бөгөөд шүүхээс тухайн гүйцэтгэх баримт бичгийг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дууссаны дараагаар буюу шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ирүүлсэн бол хүлээн авах боломжгүй баримт бичигт хамаарах хууль зүйн онцлог зохицуулалттай⁵⁵.

Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай шүүгчийн захирамжийг биелүүлэх ажиллагаа нь захиргааны шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны гол хэсэг юм. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлнэ гэдэг нь уг актын үйлчлэлийг зогсооно гэсэн ойлголт. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх шүүгчийн захирамжаар маргаан бүхий захиргааны актын үндсэн дээр аливаа үйл ажиллагаа явуулахыг хариуцагч болон гуравдагч этгээдэд хориглодог. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх захирамж нь хариуцагчид үүрэг болгосон, гуравдагч этгээдэд үүрэг болгосон захирамж гэсэн төрөлтэй байна.

Шийдвэр гүйцэтгэгч захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх, шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах захирамжийн биелэлтийн агуулга, зорилго, хэрэгжүүлэгч субъект нь өөр өөр байдаг тул шүүгчийн захирамжийг биелүүлэх албадлагын арга хэмжээг шийдвэрийн онцлог, агуулгад нийцүүлэн явуулна. Захиргааны хэргийн шүүхээр хянагдаж байгаа захиргааны акт нь зарим тохиолдолд нэхэмжлэл гаргаж байгаа тухайн иргэн, хуулийн этгээдэд хамаараад зогсохгүй нэхэмжлэл гаргаагүй этгээдэд хамааралтай байдаг тул тэрхүү актын биелэлтийг түдгэлзүүлэх захирамжийг нийтэд мэдэгдэх нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэг хэлбэр болж өгдөг.

Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх гэдгийг хариуцагч захиргааны байгууллага тухайн актыг үйл ажиллагаандаа хэрэглэхгүй байхыг ойлгоно. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн тохиолдолд хариуцагч захиргааны байгууллага, нэхэмжлэгч нар захиргааны актын биелэлтийг хангах боломжгүй юм. Захиргааны актын

⁵⁵ Батгэрэл, Я. нар. Дурдсан бүтээл. 127 дахь тал.

биелэлтийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн түдгэлзүүлж болох бөгөөд хууль зүйн болон бодит байдлын аль ч талаасаа уг захиргааны актыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бүхий л үйл ажиллагаа зөвшөөрөгдөхгүй. Мөн уг маргаантай асуудлаар түдгэлзүүлсэн захиргааны актаас өөр захиргааны акт гарган хэрэгжүүлэхийг хориглоно⁵⁶.

Шийдвэр гүйцэтгэгч хариуцагчид шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэх хугацаа тогтоон өгч, тогтоосон хугацаанд сайн дураар биелүүлээгүй бол захиргааны шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэнэ. Хариуцагч шүүхээс тогтоосон буюу шүүхийн мэдэгдэлд заасан хугацаанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй бол ахлах шийдвэр гүйцэтгэгч шүүхийн шийдвэрийг биелүүлэх хугацааг 14 хүртэл хоногоор сунгаж болох бөгөөд сунгасан хугацаанд биелүүлээгүй нөхцөлд хариуцагч этгээд хэн байхаас үл хамааран шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй талаар олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны төлбөр төлөгч (хариуцагч) нь төрийн байгууллага, албан тушаалтан байдгаас шалтгаалан иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас илүү урт хугацаа шаардагдсан ажиллагаа байсаар ирсэн. Нийтийн эрх, ашгийг хангах, хамгаалах чиг үүргийн хувьд төрийн байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй, зогсолтгүй явах учиртай.

Хүснэгт 8. Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилт (2018-2024)


№	Үзүүлэлт		Шүүхээс шинээр ирсэн	Биелүүлбэл зохих	Биелүүлсэн	Үлдэгдэл	Биелэлтийн хувь
1.	2018 он	ГХ	301	691	426	265	61.6
		МД /мян/	419,677.8	1,587,393.3	883,731.0	703,662.3	55.7
2.	2019 он	ГХ	254	531	297	234	55.9
		МД /мян/	677,192.5	4,882,880.5	1,071,938.6	3,810,941.9	22.0
3.	2020 он	ГХ	253	467	237	230	50.7
		МД /мян/	6,080,627.5	9,824,903.4	1,056,059.4	8,768,844.0	10.7
4.	2021 он	ГХ	229	456	252	204	55.3
		МД /мян/	24,445,101.4	20,908,965.1	999,704.9	19,909,260.2	4.8
5.	2022 он	ГХ	268	467	255	212	54.6
		МД /мян/	822,212.3	20,729,053.9	787,025.1	19,942,028.8	3.8
6.	2023 он	ГХ	196	406	194	212	47.8
		МД /мян/	6,155,399.5	26,124,731.0	19,578,473.1	6,546,257.9	74.9
7.	2024 он	ГХ	206	436	231	205	33.7
		МД /мян/	1,023,668.2	7,586,094.8	903,583.1	6,682,511.7	7.5

69 шийдвэр гүйцэтгэгчээс авсан захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал юу вэ? гэсэн асуултад 17 буюу 25 хувь нь ШШГТХ-д нарийвчилсан зохицуулалтгүй, 26 буюу 38.2 хувь нь шүүхээс шийдвэрийг хэрхэн гүйцэтгэх журмыг зааж өгөөгүй, 25 буюу 36.8 хувь нь албадан гүйцэтгэх эрх зүйн

⁵⁶ Лхагвасүрэн, Д., Эрдэнэтуяа, Д. Дурдсан бүтээл. 55 дахь тал.

зохицуулалт дутмаг гэж хариулсан нь эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх шаардлага байгааг харуулж байна.

Зураг 17. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж байгаа асуудал



Шийдвэр гүйцэтгэгчдээс захиргааны шийдвэр гүйцэтгэх албадан ажиллагаанд тулгамдаж байгаа хүндрэл бэрхшээлийг дараах байдлаар томъёолсон. Үүнд:

1. Захиргааны байгууллага, албан тушаалтан нь шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны тавьсан шаардлагыг биелүүлэхгүй, үл тоодог. Захиргааны байгууллагын албан тушаалтнаас дарамт шахалт ирдэг. Зарим албан тушаалтан нь хууль, эрх зүйн мэдлэг боловсролгүйгээс өөрсдийн эрх ашиг сонирхолдоо хөтлөгддөг.

2. Захиргааны байгууллага, албан тушаалтан шүүхийн шийдвэрийг биелүүлэх тал дээр ач холбогдол өгөхгүй зайлсхийх, дүр эсгэн биелүүлэх, албан тушаалыг бууруулсан, ажлаас халсан зэрэг зөрчил гаргадаг. Тухайн албан тушаалд өөр хүнийг томилсон бөгөөд орон тоо байхгүй гэх зэргээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулах зорилготой.

3. Шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх хариуцлага нь сул байдаг. Хариуцлагыг шууд хэрэгжүүлэх боломжгүйгээс шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийх нөхцөлийг бүрдүүлдэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.2-т “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй хариуцагчийн дээд шатны байгууллага, эрх бүхий албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу хариуцагчид сахилгын шийтгэл оногдуулах болон шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээ авах, хяналт тавих үүргээ биелүүлэх тухай үүрэг хүлээлгэсэн мэдэгдэх хуудсыг шийдвэр гүйцэтгэгч хүргүүлнэ” гэж зааснаар шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа сумын Засаг даргад сахилгын шийтгэл оногдуулах тухай албан бичиг аймгийн Засаг даргад хүргүүлдэг. Аймгийн Засаг дарга Төрийн албаны тухай хуульд зааснаар сумын Засаг дарга улс төрийн албан тушаалтан тул сахилгын шийтгэл оногдуулах боломжгүй гэсэн хариу ирүүлдэг. Энэ нь шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг одоогийн эрх зүйн зохицуулалт шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй захиргааны байгууллага, албан тушаалтанд нөлөөлөхүйц арга хэмжээ болж чадахгүй байна.

4. Иргэний хэргийн шийдвэрээр хуулийн этгээдэд ажилд эргүүлэн томилох, ажлаас үндэслэлгүй халагдсан, чөлөөлөгдсөн, нийгмийн даатгалын шимтгэл төлүүлэх холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад тухайн орон тоо нь бүтэц, зохион байгуулалтын

өөрчлөлтөөр хасагдсан, эргэн томилох боломжгүй, өөрийн гэсэн тогтсон хаяг, байршил, өмч хөрөнгө байхгүй татан буулгах хэмжээний нөхцөл бүрдсэн, татвараас зайлсхийх, нийгмийн даатгалын өр үүсгэж, биелүүлэхэд хүндрэлтэй байдаг.

Түүнчлэн Захиргааны шүүхээс бичигдэж ирсэн гүйцэтгэх хуудсанд заагдсан ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэх, шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэх хугацааг хариуцагч олгох болон биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ болон оногдуулах хариуцлагын талаар тодорхой тусгаагүйгээс шийдвэрийг биелүүлэхэд хүндрэл учирдаг. Гэвч ШШГТХ-ийн 127 дугаар зүйлийн 127.3-т “Шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд гүйцэтгэх арга хэмжээ болон оногдуулах хариуцлагын талаар гүйцэтгэх хуудсанд тодорхой тусгах, Захиргааны ерөнхий хуулийн найм дугаар бүлгийн 85 дугаар зүйлийн 85.1-д зааснаар “Албадлагыг хуульд зааснаар нэн даруй хэрэглэхээс бусад тохиолдолд албадлага хэрэглэх тухай мэдэгдлийг үүрэг хүлээгчид бичгээр өгөх бөгөөд уг мэдэгдэлд үүрэг биелүүлэх хугацааг заана”, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.3. дахь хэсэгт “Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн шүүгчийн захирамж нь тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл хүчин төгөлдөр байна” гэж заасны дагуу баталгаажуулах арга хэмжээг гүйцэтгэсний дараагаар шүүх хэрэг маргааныг хянан шийдвэрлэж дуусах хүртэл ШШГТХ-ийн 29 болон 131 дүгээр зүйлд заасан үндэслэлээр дуусгавар болгох боломжгүй шийдвэр байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3 дахь хэсэгт заасан хэд хэдэн шийдвэр хамаарах бөгөөд эдгээр шийдвэр нь ихэнх тохиолдолд тодорхой үйл явдалтай холбогдох цаг хугацаагаар хэмжигдэж шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гүйцэтгэгддэг. Сонгогчдын нэрсийн жагсаалтаас хасах шийдвэрийг гүйцэтгэх, төсвийн тодотгол хийх, тендер шалгаруулалтыг хүчингүйд тооцох зэрэг шийдвэр нь тодорхой үйл явдлаар хэмжигдэх хугацаанаас хамаарч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удааширдаг буюу хуульд заасан хугацаагаар хяналтыг хэрэгжүүлэх шаардлагатай байдаг зэрэг тулгамдсан асуудал байна.

3.2. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагын эрх зүйн зохицуулалт

Хуулийн хүчин төгөлдөр болсон захиргааны шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогчоос гадна шийдвэрийн биелэлтэд хамааралтай захиргааны байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт заавал биелүүлэх үүрэгтэй. Шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх нь хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг төр, захиргааны байгууллага, албан тушаалтан зэрэг бусад этгээдийн зүгээс өөрчлөх, хүчингүй болгох эрхгүй байх, шүүхийн шийдвэрийг зөрчсөн ямар нэгэн шийдвэр гаргахгүй байх явдлаар тодорхойлогдоно⁵⁷.

Аливаа хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хүн, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй болохыг Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт тогтоосон ба “захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа холбогдох захиргааны байгууллага, хуулийн этгээд, албан тушаалтан, хүн заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд сайн дураар биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэнэ” гэж ЗХШХШТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.2-д заажээ.

Хүснэгт 9. Захиргааны шүүхийн шийдвэр биелэгдээгүй шалтгаан

№	Үзүүлэлт		Төлбөр хийгдээгүй шалтгаан					
			Төлбөрийн чадваргүй	Оршин суугаа хаяг тодорхойгүй	Хорих ял эдэлж байгаа	Эрэн сурвалжлах ажиллагаа явагдаж байгаа	Хэсэгчлэн төлөлттэй	Бусад
1.	2018 он	ГХ	5	4	0	0	2	254
		МД /мян/	16,715.0	2,263.0	0.0	0.0	16,988.3	667,696.0
2.	2019 он	ГХ	1	1	0	0	23	209
		МД /мян/	2,000.0	384.0	0.0	0.0	118,643.6	3,689,914.3
3.	2020 он	ГХ	0	0	0	0	11	219
		МД /мян/	0.0	0.0	0.0	0.0	7,909,756.9	859,087.1
4.	2021 он	ГХ	0	0	0	0	10	194
		МД /мян/	0.0	0.0	0.0	0.0	296,531.7	19,612,728.5
5.	2022 он	ГХ	0	0	0	0	14	198
		МД /мян/	0.0	0.0	0.0	0.0	16,258,027.8	3,684,001.0
6.	2023 он	ГХ	0	0	0	0	4	208
		МД /мян/	0.0	0.0	0.0	0.0	115,966.9	6,430,291.1
7.	2024 он	ГХ	1	0	0	0	0	204
		МД /мян/	129,707.2	0.0	0.0	0.0	0.0	6,552,803.8

⁵⁷ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ., 2014. 55 дахь тал.

Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хариуцагч тогтоосон хугацаанд шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй бол түүнийг захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй үйлдэл, эс үйлдэхгүйг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ⁵⁸.

Шийдвэр гүйцэтгэгч нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэх хугацаа дуусмагц, хариуцагчид шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа явуулахыг мэдэгдэнэ.

68 шийдвэр гүйцэтгэгчээс захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар 9 буюу 13.2 хувь нь захиргааны /зөрчлийн/ хариуцлага хүлээлгэх, 29 буюу 42.6 хувь нь Төрийн албаны хуульд зааснаар сахилгын хариуцлага хүлээлгэх, 30 буюу 44.1 хувь нь эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байх нь зүйтэй гэсэн санал гаргасан.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй хариуцагчийн дээд шатны байгууллага, эрх бүхий албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу хариуцагчид сахилгын шийтгэл оногдуулах болон шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээ авах, хяналт тавих үүргээ биелүүлэх тухай үүрэг хүлээлгэсэн мэдэгдэх хуудсыг шийдвэр гүйцэтгэгч хүргүүлнэ.

Хариуцагчийн дээд шатны байгууллага, албан тушаалтан нь шийдвэр гүйцэтгэгчийн мэдэгдэх хуудсаар хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй тохиолдолд:

1. Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар бүлгийн 15.27 дугаар зүйлд заасны дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч бус хариуцагчийн дээд шатны байгууллага, эрх бүхий албан тушаалтанд зөрчлийн шийтгэл оногдуулах саналыг шийдвэр гүйцэтгэгчээс ахлах шийдвэр гүйцэтгэгчид гаргана.

2. Ахлах шийдвэр гүйцэтгэгч зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр уламжлан захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, Засгийн газраас томилогдож, чөлөөлөгддөг бусад албан тушаалтны асуудлыг Засгийн газарт, УИХ-аас томилогдож, чөлөөлөгддөг албан тушаалтны асуудлыг УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд танилцуулна.


4. Шийдвэр гүйцэтгэгч дээд шатны байгууллага, албан тушаалтнаар уламжлуулан захиргааны хариуцагч эсхүл түүний дээд шатны байгууллага, албан тушаалтанд мэдэгдэл хүргүүлэх шаардлага үүссэн бол холбогдох захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудасны хуулбар, санал уламжлуулах хүсэлтийг Ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид ирүүлэн шийдвэрлүүлнэ.

Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3.9, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 262 дугаар зүйлийн дагуу ШШГЕГ-ын дарга нь тус байгууллагыг төлөөлнө. Харин шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой чиг

⁵⁸ Өнөрцэцэг, Ч. Иргэний, захиргааны, зөрчлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гарын авлага. Уб., 2019. 133 дахь тал.

үүргийг ШГА-ны дарга, ерөнхий шийдвэр гүйцэтгэгч хэрэгжүүлж байна. Үүнээс шалтгаалан захиргааны хэргийн шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хариуцлага тооцуулахтай холбоотой Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.2 дахь заалтын хэрэгжилт хангагдахгүй нөхцөл үүсээд байна.

Зураг 18. Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо⁵⁹



Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр бүрэн гүйцэт биелэгдэж байх нь эрх зүйн соёл, ухамсрын түвшин харилцан адилгүй олон нийтийн зүгээс Захиргааны харгийн шүүхийг хүлээн зөвшөөрөхөд чухал ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрээс шууд хамааралтай байх онцлогтой.

Шийдвэр гүйцэтгэгчийн мэдэгдэлд заасан хугацаанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй бол ахлах шийдвэр гүйцэтгэгч энэ тухай олон нийтэд мэдээлж, шаардлагатай бол биелүүлэх хугацааг 14 хүртэл хоногоор сунгаж болно”, 132.2 дахь хэсэгт “Шийдвэр гүйцэтгэгч шүүхийн мэдэгдэлд заасан хугацаа, эсхүл энэ хуулийн 132.1 дэх хэсэгт заасны дагуу нэмэлт хугацаа тогтоосон бол тухайн хугацаа дуусмагц шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй захиргааны байгууллага, албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авахыг даалгасан мэдэгдэл хүргүүлнэ” гэж шүүхийн шийдвэр биелүүлээгүй захиргааны албан тушаалтанд хүлээлгэх сахилгын хариуцлагыг зааж өгсөн.

ШШГТХ-ийн 128 дугаар зүйлийн 128.1 дэх хэсэгт “Бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газар нь доод шатны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийн биелэлтэд хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд хяналт тавьж, харилцан хамтран ажиллана”, мөн зүйлийн 128.2 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр уламжлан хуульд заасан хугацаанд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, Засгийн газраас томилогдож, чөлөөлөгддөг бусад албан тушаалтны асуудлыг Засгийн газарт, Улсын Их Хурлаас томилогдож, чөлөөлөгддөг албан тушаалтны асуудлыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулна” гэж заасан. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд

⁵⁹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 128.2. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. №24.

иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдийн адил захиргааны хариуцлага хүлээлгэхээс гадна сахилгын болон эрүүгийн, иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалттай.

Сахилгын хариуцлага: ШШГТХ-ийн 132 дугаар зүйлийн 132.2 дахь хэсэгт “Шийдвэр гүйцэтгэгч шүүхийн мэдэгдэлд заасан хугацаа дуусмагц шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй захиргааны байгууллага, албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд ТА-ны тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авахыг даалгасан мэдэгдэл хүргүүлнэ”⁶⁰ гэж сахилгын хариуцлага оногдуулах үндэслэлийг зааж өгчээ.

Иргэний эрх зүйн хариуцлага: Мөн хуулийн 132 дугаар зүйлийн 132.4 дэх хэсэгт “Захиргааны байгууллагын дансанд байгаа мөнгө нь төлбөрт хүрэлцэхгүй тохиолдолд төлбөрийг дараагийн жилийн төсөвт тусгаж, барагдуулах бөгөөд Захиргааны байгууллага төлбөрийг дараагийн жилийн төсөвт тусгаж, барагдуулаагүй бол нэхэмжлэгч шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтан болон төрөөс өөрт учирсан хохирлоо нэхэмжлэх эрхтэй” гэж иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг тогтоосон байна.

Захиргааны хариуцлага: Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 15.2.2 дахь хэсэгт заасан захиргааны хариуцлага хүлээлгэнэ. Хүн, хуулийн этгээд нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг биелүүлэх боломжтой байсан боловч түүнийг биелүүлэх зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол зөрчил үйлдсэнд тооцно. Мөн хуулийн этгээдийг төлөөлөн, түүний ашиг сонирхлын төлөө хуульд заасан зөрчил үйлдсэн бол хуулийн этгээдэд шийтгэл оногдуулна.

Эрүүгийн хариуцлага: Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт “хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй болон энэ хуульд заасан бусад тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан төрийн үйлчилгээний албан хаагчаас бусад албан хаагчид дараах сахилгын шийтгэлийн аль тохирохыг ногдуулна” гэж заасан байдаг.

Төрийн албаны тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.4 дэх хэсэгт “Төрийн албаны төв байгууллагын болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлсэн боловч албан хаагчийг хууль бусаар дахин ажлаас халсан албан тушаалтны шийдвэрийг энэ хуулийн 76.7-д зааснаас бусад тохиолдолд төрийн албаны төв байгууллага хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлнэ”, 76.5 дахь хэсэгт “энэ хуулийн 76.4-д заасан эрх бүхий этгээд нь мэдэгдлийг заавал биелүүлж, авсан арга хэмжээний талаар 7 хоногийн дотор хариу мэдэгдэнэ”, 76.6 дахь хэсэгт “энэ хуулийн 76.4, 76.5-д заасныг зөрчсөн эрх бүхий этгээдийг төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр төрийн албанаас хална” гэж заасан.

42 ахлах шийдвэр гүйцэтгэгчээс авсан “захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд ямар хүндрэл учирч байна вэ?” гэсэн асуулгад 44.3 хувь нь

⁶⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл №24

Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хариуцлага хүлээлгэх хууль эрх зүйн орчин дутагдалтай байдаг гэж хариулсан нь анхаарал татаж байна. Захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэсэн тохиолдол байдаг уу? гэж асуухад хариуцлага хүлээлгэж байгаагүй 16.7 хувь нь сахилгын арга хэмжээ авах санал хүргүүлсэн боловч шийдвэрлээгүй 16.7 хувь нь, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр санал хүргүүлсэн боловч хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн үндэслэлээр буцаасан 2.4 хувь нь, шийдвэрлээгүй 45.2 хувь нь, зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэсэн 7.1 хувь нь, хариуцлага хүлээлгэсэн 11.9 хувь нь байна. Судалгаанд оролцогчдын 84.3 хувь нь хариуцлага тооцуулахаар зохих байгууллагад хандаж 19 хувьд хариуцлага хүлээлгэж байсан бол 81 хувьд хариуцлага хүлээлгэж чадаагүй байна⁶¹.

Асуудал 1. ШШГБ-ын тогтолцоо хаана харьяалагдаж байгаагаас шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөө үзүүлнэ гэх үзэл хандлага сүүлийн үед нэлээдгүй яригдаж байгаа бөгөөд иргэний хэргийн болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувьд Шүүхийн харьяалалд байх нь зүйтэй гэсэн хандлага их байдаг.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг нэмэгдүүлэхэд хамгийн тулгамдсан асуудал бол тухайн ажиллагааг гүйцэтгэж буй байгууллагын тогтолцооны асуудал билээ. Харьцуулсан судалгаанаас авч үзэхэд гадаадын зарим улс орнуудын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь тогтолцооны хувьд өөр өөр байгаа бөгөөд төрийн буюу засгийн газар болон шүүхэд харьяалагддаг, ашгийн төлөө байгууллага буюу хувийн хэвшилд харьяалагддаг, холимог тогтолцоотой буюу засгийн газрын болон хувийн хэвшилд харьяалагддаг бүтэцтэй байна.

Нийслэлийн хэмжээнд ажилд эгүүлэн томилох шүүхийн шийдвэртэй 145 гүйцэтгэх баримт бичиг байгаа ба Засгийн газар хариуцагчаар татагдсан 2 гүйцэтгэх баримт бичигт 2015, 2016 оноос хойш ажиллагаа явагдаж, шүүхийн шийдвэр биелэгдэхгүй өнөөг хүрчээ.

Засгийн газар, яам, харьяа агентлаг, нийслэл дүүргийн Засаг дарга, Засаг даргын тамгын газар, Засаг даргын дэргэдэх агентлаг, нийслэл дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, түүний дарга, Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны харьяа Бүгд найрамдах Солонгос улс дахь Хөдөлмөр, нийгэм хамгааллын үйлчилгээний төв, Нийслэлийн ерөнхий боловсролын зарим дунд сургууль, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл зэрэг байгууллагууд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй байна.

Манай улсын хувьд Засгийн газрын буюу Хууль зүй, дотоод хэргийн яаманд харьяалагдаж байгаа бөгөөд энэ нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг тодруулах зорилгоор асуусан “захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байгаа шалтгааныг тогтолцооноос хамаарч байгаа гэдэгтэй та санал нийлэх үү?” гэсэн асуултад судалгаанд оролцогч ахлах шийдвэр гүйцэтгэгч нарын 88.1 хувь санал нийлнэ гэж, 2.4 хувь санал нийлэхгүй гэж, 9.5 хувь сайн мэдэхгүй байна гэж хариулсан. Энэ нь захиргааны хэргийн хувьд ШШГБ нь Засгийн газрын харьяанд байх нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад бэрхшээлтэй, үр дүн муутай байгааг батлан харуулж байна.

Захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг биелүүлэх харьяалал нь аль байгууллагад байх нь зүйтэй гэж үзэж байна вэ? гэж асуухад судалгаанд оролцогчдын 35,7

⁶¹ Батгэрэл, Я. Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хууль зүйн хариуцлага. Хууль зүйн докторын зэрэг горилсон диссертаци. Уб., 2024.145 дахь тал.

хувь одоогийн тогтолцоо буюу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяанд байх нь зөв гэж үзсэн бол 64.3 хувь өөр байгууллагын харьяанд тухайлбал Шүүх, Төрийн албаны зөвлөл, хувийн хэвшилд байх нь зөв гэж хариулсан.

Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь бусдын хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийг үндэслэн төрийн албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явц юм. Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хүн, хуулийн этгээд заавал биелүүлэх, эд хөрөнгийн болон эдийн бус хохирлыг төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, иргэн, захиргааны шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг хэрэгжүүлэх тогтолцоо, чиг үүргийг зохион байгуулалтыг дэлхийн жишиг хандлага, хөгжлийн бодлогод нийцүүлэн өөрчлөх шаардлага үүсэж байна.

Асуудал 2. Шийдвэр гүйцэтгэгч шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар заавар, зөвлөмж, аргачлалаар хангагдсан эсэх талаар санал асуухад сайн хангагдсан гэж 13.7 хувь, хангагдсан гэж 47.4 хувь, хангагдаагүй гэж 33.7 хувь, мэдэхгүй гэж 5.3 хувь тус тус хариулсан байна. Судалгаанд оролцогчдын 39 хувь нь шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар заавар, зөвлөмж, аргачлалаар хангагдаагүй байна.

Шүүхийн шийдвэр биелүүлэхгүй байгаа төлбөр төлөгчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоо хэр байдаг вэ? гэсэн асуултад хангалттай сайн гэж 1.1 хувь, сайн мэдэхгүй гэж 5.3 хувь, хариуцлага сул гэж 48.4 хувь, сайжруулах шаардлагатай гэж 45.3 хувь нь тус тус үзсэн. Судалгаанд оролцогчдын олонх буюу 93.7 хувь нь шүүхийн шийдвэр биелүүлэхгүй байгаа төлбөр төлөгчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоонд сэтгэл хангалуун биш байгаа бол шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хууль зүйн ямар хариуцлага хүлээлгэвэл илүү үр нөлөөтэй вэ? гэж асуухад 89.5 хувь эрүүгийн хариуцлага илүү үр нөлөөтэй гэж үзсэн бол 51.5 хувь албан тушаалтанд сахилгын хариуцлага хүлээлгэх нь үр дүнтэй гэж, 46.3 хувь захиргааны /зөрчлийн/ хариуцлага нөлөөлнө гэж, 22.1 хувь нь иргэний эрх зүйн хариуцлага үр дүнтэй гэж үзжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагын зохицуулалт нь Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн хууль, Эрүүгийн хуульд байгаа боловч хууль бус шийдвэр гаргасан төрийн албан тушаалтанд хүлээлгэх зохицуулалт өнөөдрийн мөрдөгдөж байгаа хуульд байхгүй байна. ШШГТХ-ийн 128 дугаар зүйлийн 128.1 дэх хэсэгт “Бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газар нь доод шатны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэрийн биелэлтэд хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд хяналт тавьж, харилцан хамтран ажиллана”, мөн зүйлийн 128.2 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр уламжлан хуульд заасан хугацаанд захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, Засгийн газраас томилогдож, чөлөөлөгддөг бусад албан тушаалтны асуудлыг Засгийн газарт, Улсын Их Хурлаас томилогдож, чөлөөлөгддөг албан тушаалтны асуудлыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулна” гэж тус тус заасан. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг

биелүүлээгүй этгээдийн адил захиргааны хариуцлага хүлээлгэхээс гадна сахилгын болон эрүүгийн, иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалттай. Иймд шүүхийн шийдвэрийг биелүүлдэггүй захиргааны байгууллага, албан тушаалтанд ШШГТХ-ийн 132 дугаар зүйлийн 132.2, 132.4 дэх хэсэгт заасны дагуу иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэх, Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 15.2.2 дахь хэсэгт заасан захиргааны хариуцлага хүлээлгэж энэ төрлийн шүүхийн шийдвэрийн биелэлтийг нэмэгдүүлэх боломжтой байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Хуулийн хүчин төгөлдөр болсон захиргааны шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогчоос гадна шийдвэрийн биелэлтэд хамааралтай захиргааны байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт заавал биелүүлэх үүрэгтэй. Шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх нь хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг төр, захиргааны байгууллага, албан тушаалтан зэрэг бусад этгээдийн зүгээс өөрчлөх, хүчингүй болгох эрхгүй байх, шүүхийн шийдвэрийг зөрчсөн ямар нэгэн шийдвэр гаргахгүй байх явдлаар тодорхойлогдоно.

Захиргааны хэргийн шүүх нь гаргасан шийдвэртээ тухайн шийдвэрийг биелүүлэх арга, журмыг тодорхойлж биелүүлэх хугацааг гаргасан шийдвэр, олгосон мэдэгдэлдээ тусгах бөгөөд шүүхээс тогтоосон хугацаа, үндэслэл, журмын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулна. Захиргааны хэргийн шүүх гаргасан шийдвэрээ биелүүлэх арга, журам, хугацааг зааж өгөөгүй нөхцөлд хэрхэн гүйцэтгэх талаар тодруулах арга хэмжээг шийдвэр гүйцэтгэгч авна. 69 шийдвэр гүйцэтгэгчээс авсан захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал юу вэ? гэсэн асуултад 17 буюу 25 хувь нь ШШГТХ-д нарийвчилсан зохицуулалтгүй, 26 буюу 38.2 хувь нь шүүхээс шийдвэрийг хэрхэн гүйцэтгэх журмыг зааж өгөөгүй, 25 буюу 36.8 хувь нь албадан гүйцэтгэх эрх зүйн зохицуулалт дутмаг гэж хариулсан нь эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх шаардлага байгааг харуулж байна.

Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсний дүнд дараах дүгнэлтэд хүрлээ.

1. Захиргааны байгууллага, албан тушаалтан шүүхийн шийдвэрийг биелүүлэх тал дээр ач холбогдол өгөхгүй зайлсхийх, дүр эсгэн биелүүлэх, албан тушаалыг бууруулсан, ажлаас халсан зэрэг зөрчил гаргах тохиолдолд багагүй байгаад анхаарч тодорхой үйлдэл, эс үйлдэхүйд хариуцлага тооцох зохицуулалтыг бий болгох;

2. Шүүхийн шийдвэр биелүүлэхгүй байгаа төлбөр төлөгчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоо хэр байдаг вэ? гэсэн асуултад хангалттай сайн гэж 1.1 хувь, сайн мэдэхгүй гэж 5.3 хувь, хариуцлага сул гэж 48.4 хувь, сайжруулах шаардлагатай гэж 45.3 хувь нь тус тус үзсэн. Судалгаанд оролцогчдын олонх буюу 93.7 хувь нь шүүхийн шийдвэр биелүүлэхгүй байгаа төлбөр төлөгчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоонд сэтгэл хангалуун биш байгаа бол шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хууль зүйн ямар хариуцлага хүлээлгэвэл илүү үр нөлөөтэй вэ? гэж асуухад 89.5 хувь эрүүгийн хариуцлага илүү үр нөлөөтэй гэж үзсэн бол 51.5 хувь албан тушаалтанд сахилгын хариуцлага хүлээлгэх нь үр дүнтэй гэж, 46.3 хувь захиргааны /зөрчлийн/ хариуцлага нөлөөлнө гэж, 22.1 хувь нь иргэний эрх зүйн хариуцлага үр дүнтэй гэж үзсэн нь хариуцлагын тогтолцоог шинэчлэн хуульчлах шаардлага байна гэж үзлээ;

3. Шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх хариуцлага нь сул байдаг. Хариуцлагыг шууд хэрэгжүүлэх боломжгүйгээс шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийх нөхцөлийг бүрдүүлдэг. Захиргааны байгууллага, албан тушаалтны гаргаж буй шийдвэр биелэгдэх боломжгүй гардаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.2-т “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй хариуцагчийн дээд шатны байгууллага, эрх бүхий албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу хариуцагчид сахилгын шийтгэл оногдуулах болон шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээ авах,

хяналт тавих үүргээ биелүүлэх тухай үүрэг хүлээлгэсэн мэдэгдэх хуудсыг шийдвэр гүйцэтгэгч хүргүүлнэ” гэж заасан ба шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа сумын Засаг даргад сахилгын шийтгэл оногдуулах тухай албан бичиг аймгийн Засаг даргад хүргүүлдэг. Аймгийн Засаг дарга Төрийн албаны тухай хуульд зааснаар сумын Засаг дарга улс төрийн албан тушаалтан сахилгын шийтгэл оногдуулах боломжгүй гэсэн хариу ирүүлдэг. Энэ нь шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг одоогийн эрх зүйн зохицуулалт шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй захиргааны байгууллага, албан тушаалтанд нөлөөлөхүйц арга хэмжээ болж чадахгүй байна;

4. Шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэх хугацааг хариуцагч буюу шийдвэрт заасан үйлдлийг гүйцэтгэх талд олгож байгаа ба хуульд шүүхийн шийдвэрийг сайн дураар гүйцэтгэх хугацааг заагаагүй байдаг тул сайн дураар биелүүлэх хугацааг тодорхой тусгаж өгөх;

5. Шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцдог эрх зүйн зохицуулалт дутмаг байна. Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар арга хэмжээ авхуулахаар шүүхэд хандахад “зөрчлийн тэмдэглэл үйлдсэн байх” шаардлагыг тавьдгаас шийдвэр гүйцэтгэгч нар захиргааны арга хэмжээ авхуулж чаддаггүй, эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгагдаж байх явцад шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн үндэслэл тогтоогдохгүй гэж үзэн гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй хэмээн хэргийг хэрэгсэхгүй болгодог. Иймд мэдэгдэл хүргүүлээд биелүүлээгүй тохиолдолд буруутай албан тушаалтанд сахилгын шийтгэл оногдуулах, хугацаатай мэдэгдэл өгөөд биелүүлээгүй тохиолдолд бүрд хариуцлагын арга хэмжээг авах;

6. Төрийн албаны зөвлөлд нэгдсэн санг бүрдүүлж, холбогдох судалгааг гарган хэрэв шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа эрх бүхий этгээдэд мэдэгдэл хүргүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах, Төрийн байгууллагад холбогдох шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа этгээдэд хариуцлага тооцдог тогтолцоотой болох зэрэг болно.

ТАВ. ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль:

- Монгол Улсын Үндсэн хууль (1992)
- Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль (2004)
- Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль (2015)
- Монгол Улсын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002)
- Монгол Улсын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2016)
- Монгол Улсын Зөрчлийн тухай хууль (2017)
- Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (2017)
- Монгол улсын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль (2012)
- Монгол Улсын Шүүхийн тухай хууль (2021)
- Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай (2017)
- Монгол Улсын Төрийн албаны тухай хууль (2017)
- Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль (2020)
- Монгол Улсын Эрүүгийн хууль (2015)

Хоёр. Эрдэм шинжилгээний бүтээл, ном, сурах бичиг:

- Алтангэрэл, Б. Иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилт. УБ., 2020.
- Атарцэцэг, Л., Мөнхтуяа, Д, Сумьяа, Ц. Монголын захиргааны процессын түүхэн хөгжил. УБ.,
- Банзрагч, Г. Захиргааны процессын эрх зүй. УБ., 2019.
- Булган, Д. Захиргааны эрх зүйн УБ., 2012.
- Дашзэвэг, Б. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй (тусгай анги). УБ., 2004.
- Дашзэвэг, Б. Монгол Улсын Эрүү, иргэний хэрэгт холбогдох шүүхийн шийдвэр биелүүлэх хууль тогтоомжийн хөгжилт 1955-2005. УБ., 2005.
- Дамдинцэрэн, Д. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй зарим асуудал. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэл эрдэм шинжилгээний хурал. УБ., 2021.
- Дашцэрэн, Д. Монгол Улсын захиргааны эрх зүй 1. УБ., 2002.
- Долгорсүрэн, Ж. Монгол Улсын Захиргааны эрх зүй. УБ., 2000, Монгол Улсын Захиргааны эрх зүй ба захиргааны процессын ажиллагаа. УБ., 2001, Монгол Улсын Захиргааны эрх зүйн удиртгал. УБ., 2006.
- Дугармаа, А. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онол, практикийн асуудал.
- Лхагва, А. Монгол Улсын Эрүү, иргэний хэрэгт холбогдох шүүхийн шийдвэр биелүүлэх хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 2005, Монгол Улсын Шүүхийн шийдвэр

гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал. УБ., 2008, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. УБ., 2012, Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж. УБ., 2014.

- Лхагвасүрэн, Д., Эрдэнэтуяа, Д. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа. УБ., 2016.

- Мөнх-Эрдэнэ, Т. Нийтийн эрх ашиг сонирхлыг тодорхойлох нь. эрдэм шинжилгээний өгүүлэл. УБ., 2016.

- Сүнжид, Д. Захиргааны ерөнхий хууль: үзэл баримтлал, хэрэглээ. УБ., 2017.

- Цогт, Ц. Захиргааны хэргийн шүүх. УБ., 2019.

- Цэрэнханд, Э., Мөнгөннахиа. Б. Захиргааны хэргийн талаарх шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ. УБ., 2023.

- Одгэрэл, П. Захиргааны эрх зүйн ерөнхий анги. УБ., 2016.

- Оюумаа, Ю., Хажидмаа. М. Шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачаалал судалгаа. УБ., 2020.

- Чимэд, Б. Захиргааны ерөнхий анги. УБ., 1973.

- Сүхбаатар, Ж. Өрнөдийн орнуудын захиргааны эрх зүйн тойм. УБ., 2015.

- Өнөрцэцэг, Ч. Иргэний, захиргааны, зөрчлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа. УБ., 2019.

- Өнөрцэцэг, Ч. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. УБ., 2020.

- Өнөрцэцэг, Ч. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, эрх зүйн зохицуулалт УБ., 2022.

- Эрдэнэцогт, А. Монгол Улсын захиргааны процессын эрх зүй. УБ., 2006.

Гурав. Эрх зүйн баримт бичиг, зөвлөмжийн эмхэтгэл:

- БНМАУ-ын Их, Бага хурлын тогтоол, Үндсэн хууль, тунхаглалууд. УБ., 1956.

- Монгол Улсын хуулиудын эмхэтгэл. УБ., 2004. №6.

Дөрөв. Үйл ажиллагааны тайлан, статистик мэдээлэл:

- МУ-ын шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ. УБ., 2004-2023.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албаны тайлан. УБ., 2002-2022.

- Төрийн албаны зөвлөлийн тайлан. УБ., 2008-2023.

Тав. Эрдэм шинжилгээний сэтгүүл:

- ДХИС. Хууль сахиулахуй.

- ШШГАС. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЗӨРЧЛИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА

1.1. Үнэлгээ хийх шалтгаан:

УИХ-аас 2017 онд баталсан Зөрчлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1-д “Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэнэ” гэж тодорхойлон, “хүн, хуулийн этгээд нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг биелүүлэх боломжтой байсан боловч түүнийг биелүүлэх зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол зөрчил үйлдсэнд тооцно” гэж заасан бөгөөд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд уг хуулийн тусгай ангид заасан шийтгэлийн оногдуулахаар хуульчилсан.

Зөрчил нь эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн байх; нийгэмд хор уршигтай байх; гэм буруутай үйл ажиллагаа байх, хууль тогтоомжид заасан шийтгэл хүлээх үйлдэл, эс үйлдэл гэсэн хууль зүйн шинжийг агуулдаг бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1-д зөрчил гаргасан этгээдэд торгох, тусгайлан олгосон эрх хасах, хууль бусаар олсон орлого, эд зүйл буюу зөрчил гаргахад ашигласан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, байрыг хураах, баривчлах шийтгэл оногдуулахаар заасан бөгөөд торгох, баривчлах шийтгэлийг шийтгэлийн үндсэн хэлбэрээр хэрэглэхээр хуульчилсан.

Баривчлах шийтгэл нь хариуцлагын шинж чанараараа эрүүгийн хариуцлагын хорих ялаас хөнгөн хэдий ч хүний эрх чөлөөг хязгаарлаж, хүний халдашгүй эрхэд халдаж байгаагаараа нийтлэг шинжтэй байдаг. Манай Улсын хууль тогтоомжоор тухайлбал, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулиар баривчлах, цагдан хорих журмыг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар хорих ял эдлүүлэх журмыг нарийвчлан зохицуулсан хэдий ч эдгээртэй адилхан хүний эрх чөлөөг хязгаарлаж байгаа баривчлах шийтгэлийг эдлүүлэх журмыг хуулиар иж бүрэн, нарийвчлан зохицуулаагүй байна.

Баривчлах шийтгэл эдлүүлэх журмыг хуулиар тогтооно⁶² гэж заасан хэдий ч бие даасан хуульгүй, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “Зөрчлийн тухай хуульд заасны дагуу Шүүхийн шийдвэрээр оногдуулсан баривчлах шийтгэлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэнэ” гэж заасны дагуу шүүхийн шийтгэврээр оногдуулсан уг шийтгэлийг нийслэлд Баривчлах төв, байранд, орон нутагт Баривчлах байранд эдлүүлж байгаа нь судлагдахууны хүрээг өргөжүүлж, баривчлах шийтгэл эдлүүлэх журмыг хуулиар иж бүрэн, ойлгомжтой зохицуулах шаардлага зүй ёсоор гарч байгаагийн илрэл бөгөөд улмаар баривчлагдсан этгээдийн эрх зүйн байдлыг тодорхой болгох, шийтгэл эдлэх хугацаандаа сурах, хөдөлмөрлөх зохицуулалтыг боловсронгуй болгож, засрал хүмүүжлийн нөлөөг нэмэгдүүлэх, улмаар зөрчлөөс урьдчилан сэргийлэх, баривчлагдсан этгээдийн хууль ёсны эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс сэргийлэх арга хэмжээ тодорхой зохицуулах шаардлагатай байгаа болно

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд заасны дагуу хууль тогтоомж нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд үнэлгээний ажлыг эхлэхээс өмнө үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлно.

⁶² Зөрчлийн тухай хуулийн 3.7 зүйлийн 4 дэх заалт.

Дотоод хэргийн их сургууль, Баривчлах төвтэй хамтран 2020 онд “Баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ” судалгааг гүйцэтгэсэн бөгөөд судалгаагаар баривчлах байранд явуулж буй зан үйлд нөлөөлөх албадан сургалттай холбоотой зарим асуудлыг сонгон авч судалсан байдаг. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлохыг зорилоо.

1.2. Үнэлгээ хийх хүрээ:

Аливаа хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлахад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.

ШШГТХ-ийн баривчлах шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой зүйл, заалт тус хуулийн 1.6 хувь буюу 144-148 дугаар зүйлийг хамарч байдаг.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.4 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхдээ хууль тогтоомжид бүхэлд нь, эсхүл түүний зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож болно” гэж заасны дагуу ШШГТХ-ийн баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагаанд холбогдох зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлсэн болно. Ингэхдээ захиалагч байгууллага болох ШШГЕГ-ын ирүүлсэн ажлын даалгавар, үнэлгээ хийх болсон шалтгааны харилцан уялдаа, хамааралтай байдлыг харгалзаж, хуулийн хэрэгжилтэд гарч буй эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон зохицуулалтыг сонгосон.

Үүний дүнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дараах зохицуулалтыг үнэлгээ хийх хүрээнд хамрууллаа.

д/д	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Зохицуулалтын агуулга
1.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 144 дугаар зүйл	Баривчлах шийтгэл оногдуулсан шийдвэрийг гүйцэтгэх нийтлэг үндэслэл
2.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 145 дугаар зүйл	Баривчлах байрны дотоод журам
3.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 146 дугаар зүйл	Баривчлагдсан этгээдийн эрх зүйн байдал
4.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 147 дугаар зүйл	Баривчлах шийтгэлийг эдлүүлэх нөхцөл, ахуйн хангамж
5.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 148 дугаар зүйл	Баривчлах байранд байсан хугацааны шууд зардлыг тооцох

1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт:

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд зааснаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтийн жагсаалтыг гарган, үнэлгээ хийх асуудал тодорхой болсон үед тодорхой 1 шалгуур

үзүүлэлтийг сонгон авах бөгөөд зөвхөн 1 шалгуур үзүүлэлтээр тухайн асуудалд бүрэн үнэлэлт өгөх боломжгүй тохиолдолд 2 болон түүнээс дээш шалгуур үзүүлэлтийг сонгох боломжтой гэжээ.

Аргачлалд заасны дагуу баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж байгаа байдал гэсэн хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр:

Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтийг олж тодорхойлоход харьцуулах 4 төрлийн хэлбэрээс хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш-хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтооход чиглэгдэнэ. Тодорхой цаг хугацааны дарааллаар нөхцөл байдлын өрнөлийг жагсааж гаргасан судалгааг үнэлгээнд хэрэглэх хэлбэрийг сонгон ашиглалаа.

Энэ хэлбэрийг ашиглахдаа баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран тоо баримт, олон улсын эх сурвалж, бусад материалд дүн шинжилгээ хийнэ.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох:

Шалгуур үзүүлэлтийг томьёолохдоо шалгуур үзүүлэлт тус бүрээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааны сонгон авсан хэсэгт тохируулан дараах шалгуур үзүүлэлтийг сонгож, асуулт боловсрууллаа.

1. Баривчлах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилтийн түвшин;
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 144 дугаар зүйл нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх ;
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 146 дугаар зүйл нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх.
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 147 дугаар зүйл нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх.
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 148 дугаар зүйл нь зорилгодоо нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох:

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтэд тулгамдсан асуудлыг илрүүлэх зорилгоор баримт бичиг, судалгааны тайлан, илтгэл, өгүүлэл унших, судлах, харьцуулалт хийх, ШШГБ-ын алба хаагчдаас тулгамдаж буй асуудлын талаар судалгаа авах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд аргачлалын 3.7.3-т мэдээлэл цуглуулах дөрвөн аргыг тодорхойлсноос дараах хоёр аргыг сонгон үнэлгээ хийх мэдээллийг цуглуулсан болно.

1. Мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийх;
2. Судалгаа авах.

Мэдээлэл цуглуулах хүрээнд: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, холбогдох ном, сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, журам, зааврыг цуглуулж, үнэлгээ хийхэд ашиглав.

Судалгаа авах хүрээнд: Баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэхийн тулд алба хаагчтай ярилцлага хийх, анкетын аргаар судалгаа авсан. Түүнчлэн ИШШГЕГ-ын үйл ажиллагааны тайлан, судалгаа, бусад мэдээллийг гаргуулан авч үнэлгээ хийхэд ашигласан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, алба хаагчидтай уулзалт-ярилцлага хийх, анкетын судалгаа авч, ярилцлагын аргад тулгуурлаж энэхүү судалгааг гүйцэтгэв.

2.1. Баримт бичгийн судалгаа: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлүүд, илтгэл, өгүүлэл, тайланг ашигласан болно.

2.2. Холбогдох субъектээс авсан судалгаа:

а) баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагааг гардан хэрэгжүүлж буй 61 алба хаагчаас сонгон авсан эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, тулгамдсан асуудлын талаарх санал-асуулга;

б) баривчлах шийтгэл эдэлж буй 452 этгээдээс зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөний талаарх санал-асуулга.

2.3. Ярилцлагын арга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн бодит байдал, хууль хэрэглээнд тулгамдаж буй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг тодруулахаар ярилцлага хийсэн.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1. Баривчлах шийтгэл эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт

УИХ-аас 2017 онд баталсан Зөрчлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1-д “хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчил гэнэ” гэж тодорхойлон, “хүн, хуулийн этгээд нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг биелүүлэх боломжтой байсан боловч түүнийг биелүүлэх зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол зөрчил үйлдсэнд тооцно” гэж заасан бөгөөд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд уг хуулийн тусгай ангид заасан шийтгэлийн оногдуулахаар хуульчилсан.

Баривчлах шийтгэл нь хариуцлагын шинж чанараараа эрүүгийн хариуцлагын хорих ялаас хөнгөн хэдий ч хүний эрх чөлөөг тодорхой хэмжээгээр хязгаарлаж, зорчих эрхэд халдаж байгаагаараа нийтлэг шинжтэй байдаг. Манай Улсын хууль тогтоомжоор тухайлбал, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулиар баривчлах, цагдан хорих журмыг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар хорих ял эдлүүлэх журмыг нарийвчлан зохицуулсан хэдий ч эдгээртэй адилхан хүний эрх чөлөөг хязгаарлаж байгаа баривчлах шийтгэлийг эдлүүлэх журмыг хуулиар иж бүрэн, нарийвчлан зохицуулаагүй байна.

Баривчлах шийтгэл эдлүүлэх журмыг хуулиар тогтооно⁶³ гэж заасан хэдий ч бие даасан хуульгүй, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд “Зөрчлийн тухай хуульд заасны дагуу Шүүхийн шийдвэрээр оногдуулсан баривчлах шийтгэлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэнэ” гэж заасны дагуу шүүхийн шийтгэврээр оногдуулсан уг шийтгэлийг нийслэлд баривчлах төв, байранд, орон нутагт баривчлах байранд эдлүүлж байгаа нь баривчлах шийтгэл эдлүүлэх журмыг хуулиар иж бүрэн, ойлгомжтой зохицуулах шаардлага зүй ёсоор гарч байгаагийн илрэл бөгөөд улмаар баривчлагдсан этгээдийн эрх зүйн байдлыг тодорхой болгох, шийтгэл эдлэх хугацаандаа сурах, хөдөлмөрлөх зохицуулалтыг боловсронгуй болгож, засрал хүмүүжлийн нөлөөг нэмэгдүүлэх, улмаар давтан зөрчлөөс урьдчилан сэргийлэх, баривчлагдсан этгээдийн хууль ёсны эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс сэргийлэх арга хэмжээ тодорхой зохицуулах шаардлагатай байна.

Баривчлах шийтгэл гүйцэтгэхтэй холбоотой Олон улсын баримт бичиг, агуулга:

Дэлхийн улс орнуудын шийтгэлийн бодлого нь нийгэм, олон нийтийн аюулгүй байдлыг хангаж, гэмд явдлыг тогтоон барих, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүнийг дахин хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хууль зөрчихгүй, дагаж мөрддөг байх, нийгмийн эсрэг зан үйлийг өөрчлөх байдлаар шударга ёсны зарчмыг шингээсэн агуулгатайгаар олон оронд хэрэгжиж байгаа бөгөөд зарим улс оронд шийтгэлийн бодлого, философидоо аль болох богино хугацаанд хорих, нийгмээс тусгаарлах, эрхийг хязгаарлах нь шийтгэлийн үндсэн зорилго болох талаар тайлбарласан нь бий. Тиймээс баривчлах шийтгэлд холбогдох НҮБ-аас батлан гаргасан олон улсын гэрээ, конвенц, тунхаглал, бүс нутгийн хэмжээнд хэрэгжих конвенцын холбогдох зүйлийг тоймлон авч үзье.

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал⁶⁴-ийн 3 дугаар зүйлд “хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй”, 5 дугаар зүйлд “хэнд ч эрүү шүүлт тулган

⁶³ Зөрчлийн тухай хуулийн 3.7 зүйлийн 4 дэх заалт.

⁶⁴ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ.

эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй”, 7 дугаар зүйлд “хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчилалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй”, 9 дүгээр зүйл “хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй гэж заажээ.

2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт⁶⁵-ийн 7 дугаар зүйлд “хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно”, 9 дүгээр зүйлд баривчлах ажиллагаатай холбоотой хэд хэдэн зүйлийг тодорхой тусгасан байна. Тухайлбал,

- хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасаж болохгүй.

- баривчлагдсан шалтгааныг хүн бүрд баривчлах үед нь мэдэгдэхийн зэрэгцээ буруутгаж байгаа аливаа үндэслэлийг даруй мэдэгдэнэ.

- баривчлагдаж эсхүл цагдан хоригдож эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр ийнхүү хорьж саатуулсан нь хууль ёсны эсэхийг шүүхээр даруй тогтоолгох, хууль бусаар хорьсон бол суллуулах шийдвэр гаргуулах эрхтэй.

- хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй.

Фактын 10 дугаар зүйлийн 1-д “эрх чөлөөгөө хасуулсан бүх хүнтэй хүнлэг харьцаж, угаас заяасан нэр төрийг нь хүндэтгэнэ”, 2 дугаар зүйлийн (a)-д “онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд буруутнаар татагдсан этгээдийг ял шийтгүүлсэн этгээдээс тусгаарлаж, шийтгэгдээгүй этгээдийн эрх зүйн байдалд тохирсон жич дэглэмд байлгана”, (b)-д “буруутнаар татагдсан насанд хүрээгүй этгээдийг насанд хүрсэн этгээдээс тусгаарлаж хэргийг нь аль болох богино хугацаанд шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлнэ” гэж тус тус заасан нь баривчлах ажиллагаанд баримтлах олон улсын нийтлэг хэм хэмжээ гэж үзэж болохоор байна.

3. НҮБ-ын Ерөнхий Ассамблей⁶⁶ “Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль”-д ... хууль хэрэгжүүлэх албан тушаалтан гэдэгт цагдаагийн бүрэн эрх эдэлдэг, ялангуяа бусдыг баривчлах, хорьж саатуулах эрх бүхий томилдог болон сонгогддог бүх албан тушаалтнууд хамаарна... хэмээн тодорхойлсон байна. Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнууд үүргээ биелүүлэхдээ бүх хүмүүсийн нэр төрийг хүндэтгэж тэдний хүний эрх, эрх ашгийг хамгаалан дэмжинэ гэжээ. Энэ баримт бичигт эрүү шүүлтийг хориглох талаар заахдаа “хууль хэрэгжүүлэх нэг ч албан тушаалтан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр харгис хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх аливаа үйлдлийг хийх, өдөөн хатгах болон эвлэрэнгүй хандаж болохгүй бөгөөд хууль хэрэгжүүлэх нэг ч албан тушаалтан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр харгис хэрцгийгээр, хүнлэг бусаар, нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийг дээд шатны албан тушаалтны захирамж, дайны байдал, дайны аюул, үндэсний аюулгүй байдалд заналхийлэл, дотоодын улс төрийн тогтворгүй байдал болон бусад ямар ч онцгой нөхцөл байдлаар зөвтгөж болохгүй “гэж тодорхойлсон байна.

⁶⁵ Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200A(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

⁶⁶ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 34/169 дүгээр тогтоолоор батлагдсан.

4. НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц” -ийг батлан гаргасан.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц⁶⁷-ийн 2 дугаар зүйлийн 1-д “оролцогч улсууд харьяа нутаг дэвсгэртээ эрүүдэн шүүх аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй хууль тогтоох, захиргааны, шүүхийн болон бусад арга хэмжээг авна”, 10 дугаар зүйлийн 1-д “Оролцогч улсууд аливаа хэлбэрээр баривчлагдсан, саатуулагдсан, хоригдсон этгээдийг харгалзах, байцаах, харьцах, хууль сахиулах, энгийн, цэргийн болон эмнэлгийн бүрэлдэхүүн, төрийн албан тушаалтан, бусад хүмүүсийн сургалтад эрүүдэн шүүхийг хориглох тухай сургалтын материал, мэдээллийг бүрэн тусгана”, 2-д “оролцогч улсууд ийнхүү хориглосон заалтыг аливаа этгээдийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны журам, зааварт тусгана” гэж заасныг улс бүр хэрэгжүүлэх үүргийг хүлээж, үндэсний хууль тогтоомжоо нийцүүлэх ажиллах ёстой. Тунхаглалд эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн аливаа үйлдэл нь хүний нэр төрийг доромжилсон явдал бөгөөд НҮБ-ын дүрмийн зорилгыг зөрчсөн, хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан хүний эрх, үндсэн эрх чөлөөг зөрчсөн явдал мөн тул түүнийг бүх нийтээр буруушааж байх ёстой хэмээн тунхаглажээ.

Үүнээс гадна энэхүү тунхаглалд зааснаар хууль сахиулах байгууллагын ажилтан хорих ял шийтгүүлсэн этгээдтэй харьцах бусад ажилтныг бэлтгэхдээ эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийг хориглосныг бүрэн хэмжээгээр харгалзаж байхаас гадна дээрх ажлыг эрхлэн гүйцэтгэж буй хууль хяналтын байгууллагын ажилтнуудын үүрэг, үйл ажиллагааны дүрэм зааварт шаардлагатай хэмжээгээр тусгаж өгөхөөр зохицуулсан байна.

Конвенцын заалт ёсоор “эрүүдэн шүүх гэж хэн нэгэн хүн буюу гуравдахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ” гэжээ.

Энэхүү тодорхойлолтоос харахад эрүү шүүлт гэдэг нь үйлдсэн буюу сэрдэгдэж буй хэргийн талаар мэдээлэл, мэдүүлэг авах зорилгоор төрийн тусгай эрх бүхий албан тушаалтны зүгээс хийж буй санаатай үйлдэл юм. Тэгэхээр мэдээ сэлт, мэдүүлэг авах эрхийг нь хуулиар баталгаажуулсан эрх бүхий төрийн албан тушаалтны зүгээс хийж буй хууль бус үйлдлийг энэ хүрээнд багтаан ойлгоно. Нөгөө талаас нь эрүү шүүлтийн тодорхойлолтоос үзэхэд эрүү шүүлтэд гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээд, шүүгдэгч, яллагдагчаас гадна эрүүгийн хэргийн бусад оролцогчид, тухайлбал гэрч, хохирогч, шинжээч, орчуулагчид өртөх магадлалтай юм.

Эрүү шүүлтийн гол зорилго нь хэргийн талаар мэдээ баримт гаргуулж авах явдал ба үүнийгээ хууль бус аргаар үйлддэгт түүний гол хор хөнөөл нь оршдог. Гэмт хэрэг, зөрчилд холбогдон сэрдэгдэж буй хүмүүс нь хуулийн тусгай хамгаалалтуудаар хангагдах ёстой

⁶⁷ 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нью-Йорк хотноо баталж, 1987 оны оны 6 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

бөгөөд үүнд шударга шүүхээр шүүлгэх, нотлогдоогүй бол гэм буруугүй байх, аливаа ялын талаар давж заалдах эрх эдлэхээс гадна эрүү шүүлт болон бусад хэрцгий, хүний ёсноос гадуур, эсхүл нэр төрийг нь гутаан доромжилсон харьцаа буюу шийтгэлийг хориглосон хориг, хуулиар адил тэнцүү хамгаалуулах эрх, мөн дур зоргоор баривчлах болон хоригдох явдлаас чөлөөтэй байх эрхүүдээр хангагдан хамгаалагддаг.

Эдгээр эрхүүд нь 1993 оны 1 дүгээр сарын 31-ны байдлаар 113 орон нэгдэн орсон ИУТЭОУП-д тусгагдан батлагдсанаар олон улсын хуулийн хүчин төгөлдөр болсон билээ. Мөн эрүү шүүлт нь тодорхой үндэсний бүлгийн эсрэг үйлдэгддэг. Энэ төрлийн үйлдлийг хэрэглэхийг хориглосон НҮБ-ын “Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц”⁶⁸-д заасан ба...төрийн албан тушаалтан буюу аливаа бүлэг хүмүүс байгууллагын зүгээс хүчирхийлэх, бие махбодод гэмтэл учруулах явдлаас төрөөр хамгаалуулж, хувийн аюулгүй байдлаа хангуулах эрхтэй⁶⁹ бөгөөд хэрвээ ямар нэгэн байдлаар хүчирхийлэлд өртсөн, эрүү шүүлт тулгуулсан бол энэ талаарх гомдлоо “”Арьс үндсээр алагчлах үзлийг устгах хороо”-нд⁷⁰ гарган шийдвэрлүүлэхээр зохицуулан мөрдөж байна. НҮБ-ын “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”⁷¹-д нарийвчилсан зохицуулалтыг оруулалгүйгээр зөвхөн үндсэн зарчмуудыг тусгажээ.

Шүүх, гянданд хорих болон хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжилсон шийтгэлийн төрлийг сахилгын зөрчил гаргасны төлөө хэрэглэхийг хоригловол зохино⁷² гэсэн бол “Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль”-иар⁷³ эрүү шүүлтийг аль байгууллага ямар ч албан тушаалтан хэрэглэхийг хатуу хориглосон байна. Хууль хэрэгжүүлэх нэг ч албан тушаалтан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр харгис хэрцгий, хүнлэг бус хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх аливаа үйлдлийг хийх, өдөөн хатгах болон эвлэрэнгүй хандаж болохгүй бөгөөд хууль хэрэгжүүлэх нэг ч албан тушаалтан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр харгис хэрцгийгээр хүнлэг бусаар нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийг тушаасан дээд шатны албан тушаалтны захирамж, тушаал дайны байдал, дайны аюул, үндэсний аюулгүй байдалд заналхийлэх, дотоодын улс төрийн тогтворгүй байдал болон бусад ямар ч онцгой нөхцөл байдлаар зөвтгөж болохгүй⁷⁴ гэдгийг цохон тэмдэглэжээ.

Үүнийг баривчлах шийтгэл эдлүүлж буй байгууллагын албан тушаалтнууд даган мөрдөх ёстой юм.

5. Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц⁷⁵ /1988 он/-д дараах зарчмыг тусгасан байна.

Үүнд “аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон бүх этгээд өөртэйгөө энэрэнгүй харьцах, хүний хувьд заяасан нэр хүндийг хэрэгжүүлэх эрх эдлэх ёстой хэмээгээд

⁶⁸ Ерөнхий Ассамблейн 2106(XX) тогтоолоор 1965 оны 12 дугаар сарын 21-ний өдөр баталж, 1969 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол улс 1966 оны 5 дугаар сарын 3-нд гарын үсэг зурж, 1969 оны 3 дугаар сарын 31-ний соёрхон баталсан.

⁶⁹ ЭШЭК-ийн 5 дугаар зүйл

⁷⁰ ЭШЭК-ийн 8 дугаар зүйл

⁷¹ Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгсдэд хандах асуудлаар 1955 онд Женевт хуралдсан НҮБ-ын 1 дүгээр хуралдаанаар баталж, Эдийн засгийн болон нийгмийн зөвлөлийн 1957 оны 7 дугаар сарын 31-ний 663 C/XXIY/8, 1977 оны 5 дугаар сарын 13-ны 2076 /LXII/ тогтоолд сайшаав.

⁷² Жишиг дүрмийн 31 дүгээр зүйл

⁷³ Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 34/169 дүгээр тогтоолоор баталсан

⁷⁴ Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль, 5 дугаар зүйл

⁷⁵ Ерөнхий Ассамблейн 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 43/173 дугаар тогтоолоор батлав.

хэрцгий хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх гэдэг нэр томьёог биеийн болон сэтгэл зүйн хүчирхийллээс гадна хоригдож буй байрны нөхцөл нь хүний харах, сонсох болон орон зайг ба цаг хугацааг баримжаагаар төрөлхийн аливаа мэдрэхүйгээс түр буюу бүрмөсөн хагацахаар байх ёсгүй гэсэн өргөн утгаар ойлгоно” гэж заажээ⁷⁶. Энэ баримт бичгийг хэрэгжүүлэхдээ хэрэглэх нэр томьёог субъект бүрээр тайлбарлан гаргаснаас гадна аливаа нэг хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон бүх этгээд өөртэйгөө энэрэнгүй харьцах, хүний хувьд заяасан нэр хүндээ хүндэтгүүлэх эрхтэй болохыг тодорхойлсон.

Саатуулагдсан буюу хоригдсон нэг ч хүнийг эрүүдэн шүүж хүнлэг бус хэрцгийгээр нэр төрийг доромжлон харьцаж шийтгэж болохгүйгээс гадна тэдгээр хүмүүсийн хараа сонсгол, орон зайн буюу цаг хугацааны баримжааг мэдрэх зэрэг байгалиас заяасан аливаа эрхтнээс түр буюу бүрмөсөн хагацаахаар нөхцөлд байлгахаас ямар нэгэн хэлбэрээр хамгаалах явдлыг хангах хэрэгтэй байдаг. Эдгээр хүмүүс болон түүний өмгөөлөгч нар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шат болон саатуулах буюу хорих үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа хуулийн байгууллагуудын зүгээс тухайн хүмүүстэй хэрхэн харьцаж байгаа, эрүүдэн шүүлтийн ямар нэгэн хэлбэрийг хэрэглэж байгаа эсэх талаар саатуулах буюу хорих газрыг удирддаг байгууллагуудад болон гомдлыг хянан үзэх, хамгаалах эрх бүхий байгууллагуудад гомдол хүсэлтийг гаргах эрхээр хангагдах ёстой. Тухайн этгээд ийнхүү гомдол гаргасныхаа төлөө хяхан хавчилтад өртөхгүй чөлөөтэй байх эрхтэй.

Шүүх болон бусад байгууллагад нэн даруй байцаагдах үр нөлөөтэй бололцоо олгохгүйгээр хэнийг ч саатуулж /баривчилж/ болохгүй гэж баримт бичигт тодорхойлжээ. Хэрэв саатуулагдсан буюу хоригдсон этгээд хүссэн хийгээд боломжтой бол түүний байнга оршин суудаг ойр дөт орших саатуулах буюу хорих газарт байлгана⁷⁷ гэж заасан бөгөөд өөр газар шилжүүлэн хорих, тухайн сэжигтэн, яллагдагчийн оршин суудаг газраас өөр аймаг хот, суурин руу хорих зэрэг нь эрүү шүүлт, хүнлэг бус харьцааны нэг тод илрэл болж байдаг

Саатуулагдсан буюу хоригдсон байдлыг далимдуулан хэргийг нь хүлээлгэх, өөрийгөө ямар нэгэн байдлаар илчлэх буюу аливаа бусад хүний эсрэг мэдүүлэг өгүүлэх зорилгоор ашиглахыг хориглоно⁷⁸ хэмээн заасан нь Монгол улсын Үндсэн хуульд заасан өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй гэсэн заалтаар тусгалаа олсон байна.

ШШГТХ-д баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх нийтлэг үндэслэл, баривчлагдсан этгээдийн эрх зүйн байдлын талаар заасан хэдий ч баривчлах шийтгэл эдлүүлэх нөхцөл, журам буюу баривчлагдсан этгээдийг хүлээн авах, байрлуулах, суллах, баривчлах байрны өрөөнд байлгахыг зөвшөөрөх эд зүйл, баривчлагдсан этгээдээс гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх, уулзалт хийх, утсаар яриулах, илгээмж, захидал хүлээн авах, харуул хамгаалалтын ажлын зохион байгуулалт, эрүүл ахуйн шаардлага, баривчлагдсан этгээдийн бие, эд зүйлд үзлэг хийх, тэдгээрийг хураан авах, хадгалах, хүлээлгэн өгөх, захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх ажлыг зохион байгуулах, баривчлагдсан этгээдэд чөлөө олгох, баривчлагдсан этгээдийг хөдөлмөрлүүлэх, баривчлах байрны үйл ажиллагаанд хяналт тавих асуудлыг журмаар зохицуулахаар заасан.

⁷⁶ Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх, УБ., 1996 он, 28 дахь тал

⁷⁷ Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц, 11 дүгээр зарчим

⁷⁸ Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц, 21 дүгээр зарчим

2017 оны Зөрчлийн хуульд баривчлах шийтгэл оногдуулахаар заасан 9 зөрчил байх баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагаа нь дараах онцлогтой. Үүнд:

1. Баривчлах шийтгэлийг шүүгч оногдуулна.

2. Баривчлах шийтгэл эдлүүлэх журмыг хуулиар тогтооно.

3. Шүүх баривчлах шийтгэлийг жирэмсэн эмэгтэй, арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүнд оногдуулахгүй ба энэ тохиолдолд нэг хоногийг арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тооцож торгох шийтгэл оногдуулж болно.

4. Хуульд заасан тохиолдолд баривчлах шийдвэр биелүүлэхийг хойшлуулж болно.

5. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үед саатуулагдсан хугацааг баривчлах шийтгэл эдлүүлэх хугацаанд оруулан тооцно. Хэд хэдэн зөрчилд оногдуулсан баривчлах шийтгэлийн нийт хугацаа гурван сараас хэтрэхгүй байна.

Шүүхээс сүүлийн 15 жилийн байдлаар шийдвэрлэсэн захиргааны зөрчлийг судлан үзвэл жилд дунджаар 10,000-20,000 орчим хэрэг шийдвэрлэдэг байна.

Зөрчлийн тухай хуульд зөрчил үйлдсэн тохиолдолд торгох, баривчлах, эрх хасах гэсэн шийтгэл оногдуулахаар зохицуулсан ба 931 торгох, 9 баривчлах, 16 эрх хасах, мөн торгох, баривчлах үндсэн шийтгэл дээр нэмэгдүүлэн эрх хасах шийтгэлийг оногдуулахаар заажээ. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд зөрчлийн шинжийг харгалзан энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийтгэл оногдуулсан судалгааг харвал:

Баривчлах шийтгэл оногдуулж зөрчил нь халдлагын объектын шинжээрээ нийтийн хэв журмын эсрэг зөрчил буюу олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, танхайрах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, жагсаал, цуглаан зохион байгуулах журам зөрчих зөрчил эзэлж байна.

Хүснэгт 10. 2017 оны Зөрчлийн хуульд баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчлийн судалгаа

№	Зөрчлийн хуулийн холбогдох зүйл, заалтын нэр	Агуулга
1.	5.1 дүгээр зүйл. Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах	3. Мансуурсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
2.	5.2 дугаар зүйл. Танхайрах	1. Олон нийтийн газарт, эсхүл орон байранд: 1.1. хэрүүл маргаан үүсгэж; 1.2. бусдыг өдөөн хатгаж; 1.3. бусдын амгалан тайван байдал алдагдуулж; 1.4. олон нийтийг үл хүндэтгэж; 1.5. үйлчилгээний болон дарааллын журам зөрчиж биеэ авч явах нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг зөрчсөн, эсхүл аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад

		хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
3.	5.4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	4.Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг: 4.1.зодсон; 4.2.хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан; 4.3.бусадтай харилцахыг хязгаарласан; 4.4.хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
4.	5.8 дугаар зүйл.Жагсаал, цуглаан зохион байгуулах журам зөрчих	6.Жагсаал цуглааныг зохион байгуулагч, оролцогч зэвсэг, хорт бодис, тэсэрч дэлбэрэх бодис, орчин тойрон, хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болохуйц аливаа зүйл, амьтан авч явсан бол зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулах, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5.	6.20 дугаар зүйл.Хүүхдийн эрхийг зөрчих	6.Тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
6.	6.26 дугаар зүйл.Бэлгийн дарамт учруулах	1.Бусдад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны үр дагавар үүсгэж бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
7.	8.6 дугаар зүйл. Хулгайлах	1.Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг албадан сургалтад хамруулж долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
8.	8.7 дугаар зүйл.Хөрөнгө завших	1.Бусдын итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг завшсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
9.	14.7 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй	5.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

	байдлын тухай хууль зөрчих	
--	-------------------------------	--

Хүснэгт 11 . Монгол Улсын хэмжээнд 2015-2023 оны хооронд баривчлах шийтгэл оногдуулсан судалгаа⁷⁹

№	Аймаг	2019	2020	2021	2022	2023
1.	Архангай	404	400	403	576	513
2.	Баян-Өлгий	265	287	209	479	512
3.	Баянхонгор	395	467	619	677	651
4.	Булган	277	391	425	451	499
5.	Говь-Алтай	185	245	252	361	371
6.	Говьсүмбэр	131	120	189	218	237
7.	Дархан-Уул	317	258	314	421	526
8.	Дорноговь	284	238	249	512	499
9.	Дорнод	311	440	357	440	467
10.	Дундговь	112	108	136	185	219
11.	Завхан	288	312	314	392	380
12.	Орхон	922	846	633	723	858
13.	Өвөрхангай	1286	1501	1044	1134	1145
14.	Өмнөговь	203	285	348	364	415
15.	Сүхбаатар	160	237	221	284	334
16.	Сэлэнгэ	398	356	433	643	653
17.	Төв	528	521	515	578	496
18.	Увс	251	377	473	442	451
19.	Ховд	374	448	383	474	373
20.	Хөвсгөл	326	426	404	508	529
21.	Хэнтий	487	543	444	589	421
22.	Улаанбаатар	7392	8555	6601	9363	8457
Нийт		15296	17361	14966	19814	19006

Баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэсэн тоон үзүүлэлтээс үзэхэд нийслэлийн хэмжээнд 2021 онд 6601 хүн, 2022 онд 9363 хүн, 2023 онд 8457 хүн, орон нутагт 2021 онд 8365 хүн, 2022 онд 10451 хүн, 2023 онд 10549 хүн баривчлах шийтгэл эдэлж, сүүлийн 3 жилд өссөн үзүүлэлттэй байна. Түүнчлэн баривчлах төвд өдөрт дунджаар 100 гаруй баривчлагдсан этгээд шийтгэл эдэлдэг. 2024 оны 8 дугаар сарын байдлаар Баривчлах төвд шүүгчийн шийтгэврээр шинээр 3069 этгээдийг хүлээн авснаас 137 нь 2 удаа, 23 нь 3 удаа, 4 нь 4 удаа, 1 этгээд 5 удаагийн давтамжтайгаар баривчлах шийтгэлээр шийтгэгдсэн байна. Баривчлагдсан этгээдийн үйлдсэн зөрчлийг ангилж үзвэл 75 орчим хувь нь гэр бүлийн хүчирхийлэл, 15 орчим хувь нь тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодох, 10 хувийг танхайрах, бэлгийн дарамт учруулах, хүүхдийн эрх зөрчих, мансуурах зэрэг зөрчлийг үйлджээ. Эдгээр тоон үзүүлэлт, судалгаанаас үзэхэд баривчлагдсан этгээдийн тоо цаашид жил тутам нэмэгдэх хандлагатай байгааг илтгэнэ⁸⁰.

⁷⁹ ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны, шинжилгээний газрын тайлан.

⁸⁰ 4 дэх тал.

ШШГЕГ-ын харьяа Баривчлах төв, байр нь төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч субъект болохын хувьд холбогдох хууль тогтоомжийн дагуу баривчлах шийтгэлийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх явцдаа зөрчил үйлдэж, баривчлах шийтгэл эдэлж байгаа этгээдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах үүргийг хүлээдэг. Үүнээс үзвэл нэг талаас баривчлах төв, байр нь хүний үндсэн эрхийг хязгаарлаж буй төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч субъект хэдий боловч, нөгөө талаас зөрчил үйлдэгчийн зан үйлийг өөрчлөх, тэдэнд эергээр нөлөөлөх үүргийг хүлээдэг “*сургалтын*” гэж тодорхойлж болохуйц өвөрмөц чиг үүрэг бүхий байгууллага болох нь харагдаж байна.

Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй Зөрчлийн тухай хуулиар баривчлах шийтгэл нь зөрчил үйлдсэн хүнийг долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар тусгай зориулалтын байранд саатуулах хэлбэрээр хэрэгждэг бөгөөд баривчлах шийтгэлийг шүүгч оногдуулахаар хуульчилж, танхайрах, согтуурах, галт зэвсэг болон амьсгал боогдуулах, нулимс асгаруулах бодис хууль бусаар олж авах, авч явах, хадгалах, хүйтэн зэвсэг хууль бусаар авч явах, албан дайчилгаанаас зайлсхийх зөрчил гаргасан иргэнд баривчлах шийтгэлийг сумын Засаг дарга ногдуулж болно гэж заасан онцлогтой юм. Өөрөөр хэлбэл, Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэлийн нэг төрөл нь “*баривчлах шийтгэл*” бөгөөд энэхүү шийтгэлийн агуулга нь зөрчил үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой нөхцөл, журам бүхий байранд саатуулахад оршино. Энэ шийтгэл нь нийгмээс тусгаарлах агуулгатай ч тухайн зөрчил гаргасан этгээдийн зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулж, эерэг нөлөөлөл үзүүлэхэд чиглэгдсэн байдгаараа онцлог учраас онол, практик, эрх зүйн зохицуулалтын онцлогийг шинжлэх ухааны үүднээс судлах шаардлагатай байна.

ШШГТХ-ийн 145 дугаар зүйлд Баривчлах байрны дотоод журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гээд Баривчлах байрны дотоод журамд дараах асуудлыг тусгахаар заасан байна. Үүнд:

- баривчлагдсан этгээдийг хүлээн авах, байрлуулах, суллах;
- баривчлах байранд хөглөх бүртгэл, түүний агуулга;
- баривчлах байрны өрөөнд байлгахыг зөвшөөрөх эд зүйл;
- баривчлагдсан этгээдээс гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх;
- уулзалт хийх, утсаар яриулах, илгээмж, захидал хүлээн авах, хуваарилах, гадаалах;
- харуул хамгаалалтын ажлын зохион байгуулалт, эрүүл ахуйн шаардлага;
- баривчлагдсан этгээдийн бие, эд зүйлд үзлэг хийх, тэдгээрийг хураан авах, хадгалах, хүлээлгэн өгөх;
- баривчлах байранд байсан хугацааны шууд зардлыг тооцох;
- захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх ажлыг зохион байгуулах;
- баривчлагдсан этгээдэд чөлөө олгох;
- баривчлагдсан этгээдийг хөдөлмөрлүүлэх;
- баривчлах байрны үйл ажиллагаанд хяналт тавих асуудлыг тусгахаар заасан байна.

ШШГТХ болон Баривчлах байрны дотоод журамд баривчлагдсан этгээдийн эрх зүйн байдлыг тогтоож өгчээ.

ШШГТХ-ийн 146.1-т “баривчлагдсан этгээд нь баривчлах шийтгэл эдлэх хугацаандаа баривчлах байрны захиргаа, түүний алба хаагчийн хяналтад байх бөгөөд мөн хуулийн 210.1.1, 210.1.2, 210.1.3, 210.1.5, 210.1.9, 210.1.10, 210.1.11, 210.1.12, 210.1.13, 210.1.15-д заасан эрх эдэлж, энэ хуулийн 211 дүгээр зүйлд заасан үүрэг хүлээнэ” гэжээ.

Хүснэгт 12. Баривчлагдсан этгээдийн эрх, үүрэг холбогдох хууль, журамд туссан байдал

д/д	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан байдал	Баривчлах байрны дотоод журамд туссан байдал
<i>Нэг. Баривчлагдсан этгээдийн эрх /хоригдлын эрх/:</i>		
1.	210.1.1.хорих ял эдлэх нөхцөл, журам, эрх, үүрэг, хязгаарлалтын талаар мэдээлэл авах; 210.1.2.хорих ангийн захиргаагаар дамжуулан өөрт холбогдох асуудлаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах; 210.1.3.өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах; 210.1.5.эмнэлгийн тусламж авах; 210.1.9.хорих байгууллагын алба хаагч, эрх бүхий албан тушаалтны зүгээс хүнлэг харьцах, эсхүл хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилж харьцахгүй байхыг шаардах; 210.1.10.хувийн аюулгүй байдлаа хамгаалуулах; 210.1.11.өөрөө зөвшөөрсөн эсэхээс үл хамааран эрүүл мэндэд нь эрсдэл учруулж болзошгүй аливаа туршилтаас ангид байх; 210.1.12.энэ хуульд заасан журмын дагуу зөвшөөрөгдсөн тоо, хэмжээний хоол, хүнсний бүтээгдэхүүн, ахуйн болон нэн тэргүүний бусад зүйл худалдан авах; 210.1.13.шашны зан үйл үйлдэх; 210.1.15.хуваарилагдан очсон хорих ангийн байршил, холбоо барих мэдээллийн талаар гэр бүлийн гишүүнд мэдэгдэх.	Зургаа.Баривчлагдсан хүний эрх, үүрэг 6.1.Баривчлагдсан хүн дараах эрхийг эдэлнэ: 6.1.1.баривчлах төв /байр/-ийн нөхцөл, журам, өөрийн эрх, үүргийн талаар мэдээлэл авах; 6.1.2.хувийн аюулгүй байдлаа хамгаалуулах; 6.1.3.баривчлах төв /байр/-ийн ахуй нөхцөл, бусад асуудлаар гомдол, хүсэлт гаргах; 6.1.4.хууль, эрх зүйн туслалцаа авах; 6.1.5.эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах; 6.1.6.ахуйн хэрэгцээний эд зүйл худалдан авах; 6.1.7.хориглосноос бусад ном, сонин сэтгүүл, хэвлэл ашиглах;
<i>Хоёр.Баривчлагдсан этгээдийн үүрэг /хоригдлын үүрэг/:</i>		
2.	211.1.Хоригдол дараах үүрэг хүлээнэ: 211.1.1.хорих ангид мөрдөх хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн эрх бүхий албан тушаалтнаас баталсан дүрэм, журам, хорих байгууллага, алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг заавал биелүүлэх; 211.1.2.хорих байгууллагаас тогтоосон цагийн хуваарьт үйл ажиллагааг мөрдөх; 211.1.3.хорих байгууллагын алба хаагчаас даалгасан ажлыг заавал гүйцэтгэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журмыг чанд сахих; 211.1.4.тогтоосон журмын дагуу зохион байгуулж байгаа сургалтад хамрагдах; 211.1.5.эрүүл мэндээ хамгаалах, эмчийн зөвлөгөө, шаардлагыг биелүүлэх, хуурамчаар болон санаатайгаар өвчилсөн, эрүүл мэнд, бие эрхтэндээ гэмтэл учруулсан бол холбогдох зардлыг төлөх; 211.1.6.эзэмшиж байгаа эд хөрөнгө, хөдөлмөрийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглах, эвдэж гэмтээхгүй байх;	6.2.Баривчлагдсан хүн дараах үүрэг хүлээнэ: 6.2.1.баривчлах төв /байр/-ийн дотоод журмыг чанд сахин мөрдөх; 6.2.2.албан хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх; 6.2.3. эрүүл ахуй, ариун цэвэр сахих; 6.2.4.өөрт эзэмшүүлсэн эд зүйлсэд ариг гамтай хандах; 6.2.5.зохион байгуулж буй сургалтад тогтмол хамрагдах;

211.1.7.гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд уриалах, өдөөн хатгах, зохион байгуулах идэвхтэй үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх; 211.1.8.хорих байгууллагын алба хаагч, эрх бүхий албан тушаалтан, бусад хоригдол болон хорих байгууллагад байгаа бусад хүнтэй хүндэтгэлтэй харьцах; 211.1.9.эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг сахих. 211.2.Хорих ангид суулт хийх, өлсгөлөн зарлах, хоригдол хөдөлгөөнт утас ашиглах, хадгалах болон бэлэн мөнгө, валют, үнэт зүйл ашиглах, хадгалахыг хориглоно. 211.3.Хоригдол энэ хуульд заасан эрхээ эдлэхдээ энэ хууль, хорих ангийн дотоод журам болон бусад хоригдол, хорих ангийн алба хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх үүрэгтэй. 211.4.Хорих ял эдэлж байгаа гадаадын иргэн энэ зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээхийн зэрэгцээ гадаад хэргийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал хариуцсан нэгжээр дамжуулан өөрийн улсын Дипломат төлөөлөгчийн газрын ажилтантай уулзах, харилцах эрхтэй.	
--	--

Асуудал 1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.1-д ”Баривчлагдсан этгээд нь Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 24.1, 24.4-д заасан ахуйн хангамжаар, энэ хуулийн 231.6-д заасан хэмжээний илчлэгтэй хоол, хүнсний зүйл болон хувцас, хэрэгцээтэй үедээ хэрэглэх ундны усаар хангагдана” гэж заажээ.

Хүснэгт 13. Баривчлах байрны ахуй нөхцөл холбогдох хууль, журамд туссан байдал

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд туссан байдал	Баривчлах байрны дотоод журамд туссан байдал
24.1.Хоригдсон этгээд нь ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөл, унтаж амрах боломжоор хангагдана. 24.5.Хоригдсон этгээд нь аллага, хүчирхийлэл, садар самууныг сурталчилснаас бусад ном, сонин, сэтгүүлийг хорих өрөөндөө байлгаж болно.	2.2.Баривчлах төв /байр/ нь агааржуулах төхөөрөмжтэй байх ба байгалийн болон ердийн гэрэлтүүлэгтэй, салхивчтай байна. 2.3.Баривчлах төв /байр/-д нэг хүнд ноогдох зай талбайн хэмжээ нь 2.5м2-с багагүй байна. Долоо.Баривчлагдсан хүний ахуй хангамж, үйлчилгээ 7.1.Баривчлагдсан хүний бие, өрөөнд дараах эд зүйл байлгахыг зөвшөөрнө: 7.1.1.тухайн улирлын хувцас.дотуур хувцас; 7.1.2.ариун цэврийн хэрэгсэл /оо, сойз, гар нүүрийн болон эдийн саван, алчуур, сахлын машин, жижиг хэмжээтэй 1 үйлдэлтэй хумсны хутга, нүүр, гарын тос, хуурай, нойтон салфетка, ариун цэврийн цаас, эмэгтэй хоригдлын хувьд ариун цэврийн хэрэглэл, гоо сайхны хэрэгсэл/; 7.1.3.хучлага, гудас, ор хөнжлийн даавуу;

	7.1.4.эрүүл ахуйн шаардлага хангасан хоёр килограмм хүртэлх гурилан бүтээгдэхүүн; 7.1.5.эмчийн бичгээр зөвшөөрсөн мансууруулах, тайвшруулахаас бусад эм /тоо, ширхэг, нэрийг дурдсан байна/-ийг сувилагчид хадгалуулан, шаардлагатай үед жорын дагуу авч хэрэглэх; 7.1.6.аллага, хүчирхийлэл, садар самууныг сурталчилснаас бусад сонин, ном, сэтгүүл 5-с дээшгүй, тэмдэглэлийн дэвтэр, хуванцар гадартай тосон бал тус бүр 1 ширхэг; 7.2.Энэ журмын 7.1-д зааснаас бусад эд зүйлсийг баривчлагдсан хүний бие болон өрөөнд байлгахыг хориглоно. 7.3.Баривчлах төв /байр/ нь эрүүл ахуйн шаардлага хангасан нийтийн халуун усны өрөөтэй байна. 7.4.Баривчлагдсан хүнийг долоо хоногт нэг удаа усанд орох боломжоор хангана. 7.5.Халуун усанд ороход шаардагдах ариун цэврийн хэрэгсэл/савангаас бусад/-ийг баривчлагдсан хүн өөрөө хариуцна. 7.6.Баривчлагдсан хүний өөрийнх нь хүсэлтээр буюу ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын дагуу түүний үсийг засна; 7.7.Баривчлагдсан хүнд олгож буй хучлага, гудас, ор дэвсгэрийн хэрэгслийг угааж, ариутгасан байна. 7.8.Энэ журмын 7.1.3-т зааснаас бусад эд зүйлийг баривчлагдсан хүн өөрөө хариуцна.
--	---

Дээрхээс хүснэгтээс харахад баривчлагдсан этгээдийн эрх, үүргийг хоригдолтой адилтгасан нь ойлгомжгүй байх ба Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хоригдлын эрхийг эдлэх боловч дахин Баривчлах байрны дотоод журмаар мөн адил эрх эдлэх нь давхардсан, ойлгомжгүй байдал үүсгэж байна. Иймд баривчлагдсан этгээдийн эрх зүйн байдал, ахуй нөхцөлийг тусгайлан тогтоох нь хүний эрхийг хангахад чиглэгдсэн эрх зүйн зохицуулалт болно гэж үзлээ.

Зан үйлээ засах албадан сургалтыг явуулах эрх зүйн үндэслэл нь дараах хууль тогтоомж, эрх зүйн актын хүрээнд зохицуулагдаж байна. Үүнд:

Нэг.Зөрчлийн тухай хууль /2017 оны 05 дугаар сарын 11-ны өдөр батлагдсан/:

Зөрчлийн тухай хуулийн 4.5 дугаар зүйл. Албадан сургалт

1.Энэ хуулийн тусгай ангид өөрөөр заагаагүй бол шүүх баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно.

2.Албадан сургалтыг баривчлах шийтгэлийг эдэлж байх хугацаанд эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.

3.Албадан сургалт арван цагаас тавин цагийн хугацаатай байна.

4.Албадан сургалттай холбоотой харилцааг хуулиар зохицуулна.

Хоёр. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан/:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйл. Зан үйлд нөлөөлөх сургалт

44.1. Гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэхэд чиглэсэн зан үйлд нөлөөлөх сургалт нь албадан болон сайн дурын хэлбэртэй байна.

44.2. Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг энэ чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага хэрэгжүүлж болно.

44.3. Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөр, журмыг хууль зүйн, нийгмийн хамгааллын, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

44.4. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хорих ял шийтгүүлсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, баривчлах, албадан сургалтад хамруулах шийтгэл хүлээсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллага зохион байгуулна.

44.5. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Гурав. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /2017 оны 06 дугаар сарын 09-ны өдөр батлагдсан/:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зан үйлд нөлөөлөх сургалтыг дараах хэлбэрээр явуулахаар заасан.Үүнд:

Хүснэгт 14. ШШГТХ-д зан үйлд нөлөөлөх албадан сургалтын талаар туссан байдал

Хуулийн зүйл, заалт	Агуулга
189 дүгээр зүйл.Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх	189.1.Шийдвэр гүйцэтгэгч үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, хязгаарлалтыг биелүүлэх хугацаа, хуваарийг нарийвчлан тогтоож, энэ хуулийн Арван есдүгээр бүлэгт заасан журмын дагуу биелэлтэд нь хяналт тавина. 189.2.Зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүнд шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 189.1-д зааснаас гадна зан үйлд нөлөөлөх сургалтын агуулга, хөтөлбөрийг танилцуулна. 189.11.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалт явуулах мэргэжлийн нэгж, сургалтын хөтөлбөртэй байна. 189.12.Сургалт явуулах журмыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга батална. 189.13.Албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалтыг зөвшөөрөл бүхий төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.
222 дугаар зүйл.Хорих анги дахь албадан сургалт	222.1.Хорих анги нь монгол хэлээр уншиж, бичиж чадахгүй Монгол Улсын иргэн-хоригдолд монгол хэл, бичиг үсэг эзэмшүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай хоригдлын зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулна.

Дөрөв. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн А/73 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр”, “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/103 дугаар тушаалаар баталсан “Зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах журам”

Баривчлагдсан этгээдийн дунд явуулах нийгэмшүүлэх ажил нь зан үйлд нөлөөлөх сургалт болон сэтгэл зүйн үйлчилгээ гэсэн үндсэн чиглэлийн хүрээнд явагдана. Зөрчлийн хуулийн тусгай ангид өөрөөр заагаагүй бол шүүх баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно. Албадан сургалтыг баривчлах шийтгэлийг эдэлж байх хугацаанд эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ. Албадан сургалт арван цагаас тавин цагийн хугацаатай байна.


Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 147 дугаар зүйлийн 147.5-т “Баривчлах байр нь баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулна” гэжээ.

Баривчлах байрны дотоод журамд зааснаар баривчлах төв /байр/ нь сургалтын танхимтай байх бөгөөд шүүхийн шийдвэрт заасан хугацаагаар албадан сургалтад хамруулна, сургалт нь баривчлагдсан хүний зан үйлд нөлөөлөх, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх бөгөөд хөтөлбөрийн дагуу явагдана, сургалтыг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болохоор заасан байна.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалт нь сэтгэл зүйн болон эрх зүйн сургалт гэсэн төрөлтэй байна. Баривчлах шийтгэл гүйцэтгэх явцад хийгдэж буй албадан сургалт нь зөрчил үйлдсэн этгээдийн сөрөг зан үйлийг өөрчлөх, улмаар дахин зөрчил үйлдэхгүй байхад чиглэсэн хүмүүжил-нөлөөллийн арга хэмжээ байдаг.

Судалгааны ажлын хүрээнд баривчлах байранд явуулж буй албадан сургалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлыг нээн илрүүлэх зорилго бүхий асуулгыг оролцогчдоос авч нэгтгэн дүгнэхийг зорьсон болно. Судалгаанд хамрагдсан 452 этгээд баривчлах байрнаас зохиож буй албадан сургалтын үр нөлөөг та хэрхэн үнэлж байна вэ? асуултад 123 нь буюу 27.2% нь үр нөлөө сайтай, 202 нь буюу 44.6% нь хангалтгүй, 28% нь ямар ч үр нөлөөгүй гэж хариулжээ.⁸¹


Зураг 19. Албадан сургалтын үр нөлөөний талаарх асуулгын үр дүн



Түүнчлэн албадан сургалтыг хэрхэн явуулах нь зүйтэй гэж үзэж байна вэ? гэсэн асуултад мэргэжлийн багш нараар заалгах гэж 252 буюу 55.7%, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг өөрчлөх гэж 61 буюу 13.4%, одоо явуулж буй сургалтын чанарыг сайжруулах гэж 139 буюу 30.7% нь үзжээ.


⁸¹ ДХИС. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөө. Судалгааны тайлан. УБ., 2020. 64 дэх тал.

Зураг 20. Албадан сургалтын үр дүнг дээшлүүлэх талаарх санал




Судалгааны дүнгээс харахад баривчлагдсан этгээдүүд зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөг хангалтгүй гэж дүгнэсэн байна. Түүнчлэн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулж буй 61 алба хаагчаас зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөг та хэрхэн үнэлэх вэ? гэх асуулгад үр дүн сайтай-18, үр дүнгүй-12, үр дүнг нь тодорхойлох боломжгүй-25, мэдэхгүй-6 хариулсан байна.

Зураг 21. Алба хаагчдаас зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөнд өгсөн үнэлгээ



Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр дүнг сайжруулах хүрээнд ямар ажил чухал вэ? гэх асуулгад сургалтын хөтөлбөр, удирдамж-8, багшлах боловсон хүчин-28, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа-12, төсөв, санхүү, удирдлагын дэмжлэг-13 хүн хариулсан байна.

Зураг 22. Зан үйлд нөлөөлөх сургалтын үр дүнг сайжруулах чиглэлээр гаргасан санал



Баривчлах байрны алба хаагчтай ярилцлагын аргаар тулгамдаж буй асуудлын талаар судалгаа хийхэд дараах нийтлэг хариулт өглөө. Үүнд:

1. Баривчлагдсан этгээдийн тоо өсөх хандлагатай, давтан зөрчил үйлдэл буурахгүй байгаа нь албаны үйл ажиллагаанд хүндрэл учруулах, алба хаагчдын ажлын ачаалал, баривчлах байрны орчин, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

2. Баривчлагдсан этгээдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх асуудал нь тулгамдсан асуудлын нэг юм. Баривчлах төв нь эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх хэсэг /их эмч, бага эмч, сувилагч/-тэй байх ба эмнэлгийн үзлэг хийх, анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх зориулалтын тоног төхөөрөмж, өрөө тасалгаатай байхаар тусгасан байдаг. Баривчлах төв /байр/-д шинээр ирсэн хүнийг хүлээн авч байгаа эмч /сувилагч/ хүн нэг бүрд эрүүл мэндийн үзлэг хийж, карт нээн ажилладаг хэдий ч архины гүн хордлогоос үүдсэн эрсдэл түгээмэл байхын зэрэгцээ халдварт өвчтэй, сэтгэцийн хувьд тулгамдсан асуудалтай зэрэг этгээдүүдэд эрүүл мэндийн эрсдэл үүсэж болзошгүй байгаа нь эрх зүйн зохицуулалтын дутмаг байдалтай холбоотой гэж үзэж болно. Баривчлах төвөөс жилд дунджаар 5600-8800 орчим эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг бол гадна эмнэлэгт 6-20 орчим этгээд хэвтэн эмчлүүлдэг байна. Баривчлагдсан этгээд нас барсан тохиолдлыг Монгол Улсын иргэдийн 1000 хүн тутам дахь дундаж нас баралт 5-5.5 байдаг ба үүнийг Баривчлах төвд /жилд дунджаар 3000-6000 орчим хүн байсан гэж үзвэл/ нас барсан иргэдтэй харьцуулсан судалгаа хийж үзэхэд 0.32-0.37 хувь байгаа хэдий ч эрсдэл бүхий тулгамдсан асуудлын нэг юм.

3. Баривчлагдсан этгээдэд тавих хяналт, хамгаалалтын үйл ажиллагаа нь эрх зүйн зохицуулалтын хувьд дутмаг байна. Баривчлагдсан этгээд нь баривчлах шийтгэл эдлэх хугацаандаа баривчлах байрны захиргаа, түүний алба хаагчийн хяналтад байх ба дээрх хяналтыг хэрэгжүүлэхэд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн болон хуулиар хориглоогүй бусад тоног төхөөрөмжийг ашиглаж болно гэж заасан байдаг. Баривчлах төв, байр нь баривчлах шийтгэлийг эдлүүлэх зориулалтын өрөө, тасалгаа, харуул хамгаалалт бүхий барилга байгууламжтай байх бөгөөд баривчлагдсан этгээдийн байрлах өрөө нь олон улсын стандартад заасан шаардлагыг хангасан байна заасан хэдий ч бүрэн шилжээгүй байна.

Асуудал 2. Өнөөгийн практикт баривчлах байр нь хорих байгууллагын төрөл, бүтцийн нэг хэсэг мөн эсэх тал дээр маргаантай асуулт байна. Энэ нь ШШГТХ-д баривчлагдсан этгээдийн эрх зүйн байдал нь хорих байгууллагын нөхцөл, журамтай адилтгасан байдлаар зохицуулсантай холбоотой юм. Тухайлбал, “баривчлагдсан этгээдийг

энэ хуулийн 208.1, 208.2-т заасны дагуу тус тусад нь байрлуулах бөгөөд баривчлах байрны нөхцөл болон бусдын эрүүл мэндэд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхээс бусад тохиолдолд баривчлагдсан этгээдийг ганцаарчлан хорихыг хориглоно” гэжээ. Харин ШШГТХ-ийн 208 дугаар зүйлийн 208.1-т “хорих ял шийтгүүлсэн өсвөр насны болон эмэгтэй, эрэгтэй хоригдлыг тусад нь ял эдлүүлнэ”, 208.2. “бусдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчтэй хоригдлыг бусад хоригдлоос тусгаарлан ял эдлүүлнэ” гэсэн нь баривчлагдсан этгээдийг гэмт хэрэг үйлдсэн хоригдолтой адил байдлаар зохицуулахыг оролдсон байна.

4. Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д зааснаар “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно”⁸² хэмээн хуульчилсан хэдий ч Прокурорын байгууллагаас зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, тухайлан баривчлах байрны үйл ажиллагаанд шалгалт хийж байна. Тухайлбал, баривчлах төвд хийгдсэн хяналт, шалгалт, түүнд илэрсэн зөрчил, дутагдлын судалгаанаас харахад:

- шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй байгаа этгээдүүдийг нэн даруй олж, баривчлах шийдвэрийг нөхөн эдлүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- баривчлах байранд байрласан хугацааны шууд зардлыг төлөөгүй суллагдсан иргэдийн асуудлыг шүүхээр шуурхай шийдвэрлүүлэх, өөр бусад боломжит арга хэрэгсэл ашиглаж зардлыг төлүүлэхэд анхаарч ажиллах;
- баривчлагдсан этгээдийн ахуй нөхцөл, ялангуяа өрөө бүрийн ариун цэврийн хэрэгслээр хангаж ажиллах;
- харуул хамгаалалтын бүрэлдэхүүнийг бүрэн томилж ажиллуулах;
- эмнэлгийн мэргэжилтнүүд нь Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжид заасан оношилгоо эмчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын стандарт технологи, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд анхаарах.

ШШГТХ-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу орон нутагт Цагдаагийн байгууллагаас баривчлах шийтгэл эдлүүлэх чиг үүргийг шилжүүлэн авах ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна. Тухайлбал,

1. Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/162 дугаар “Эд хөрөнгө шилжүүлэх, хүлээн авах тухай” тушаал, УИХ-аас 2014 онд баталсан “Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн 13 дугаар зүйлд заасны дагуу Баривчлах төвийг Нийслэлийн цагдаагийн газраас Баривчлах төвийг 44 алба хаагчийн тоотойгоор шилжүүлэн авсан.

2. ХЗДХС-ын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/21, ШШГЕГ-ын даргын 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/30 дугаар тушаалаар Баривчлах байрыг 20 албан тушаалын 36 алба хаагчийн бүтэц орон тоотойгоор байгуулсан.

3. ШШГЕГ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/07 дугаар “Хуулийн хэрэгжилтийг хангах тухай” тушаалаар 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баривчлах шийтгэл эдлүүлэх чиг үүргийг Булган, Дорнод, Дундговь, Орхон, Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газруудад Цагдаагийн байгууллагаас 19 хамгаалалтын алба хаагчийн орон тоо, цалингийн сангийн хамт шилжүүлэн авсан.

⁸² Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он.

Хүснэгт 15. ШШГЕГ-ын харьяанд үйл ажиллагаа явуулж буй баривчлах байрны судалгаа

№	Баривчлах шийтгэл эдлүүлэх чиг үүрэг бүхий газар	Үйл ажиллагаа эхэлсэн он	Нийт багтаамж:	Өнөөдрийн байдлаар
1.	Баривчлах байр	2020	256	147
2.	Баривчлах төв	2009 2013	233	115
3.	Булган аймаг дахь ШШГГ	2013	30	12
4.	Дундговь аймаг дахь ШШГГ	2015	36	2
5.	Дорнод аймаг дахь ШШГГ	2015	38	3
6.	Орхон аймаг дахь ШШГГ	2013	28	16
7.	Увс аймаг дахь ШШГГ	2015	36	19

Гадаадын 10 орны баривчлах шийтгэл оногдуулж буй эрх зүйн зохицуулалт, шийтгэл хүлээлгэж буй субъект, хэрэгжүүлж буй байгууллагын онцлогийг харьцуулан үзэхэд тусгалаа. Эндээс харахад гэмт хэргийн шинжтэй үйлдэлд 1-60 хоногийн хугацаатай баривчлах ялыг оногдуулж байгаа нь манай улсын зөрчилд оногдуулсан баривчлах шийтгэлтэй адилтгаж ойлгож болохоор байна. Мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг цэргийн анги нэгтгэл, цагдаагийн байгууллага, олон нийтийн магадлан итгэмжлэгдсэн байгууллага, хорих байгууллагууд хэрэгжүүлж байна.

Хүснэгт 16. Гадаадын зарим орны баривчлах шийтгэлийн харьцуулалт

Улс	Баривчлах шийтгэлийн хугацаа	Шийтгэл оногдуулда г субъект	Хэрэгжүүлэгч байгууллага	Онцлог
<i>Баривчлах шийтгэлийг зохицуулсан бие даасан хуультай орнууд</i>				
ОХУ	1-60 хүртэл хоног	Шүүх	Баривчлах байр эсвэл цэргийн ялтанд зориулсан цэргийн анги нэгтгэл, тэдгээрийн нэгжүүд	Захиргааны эрх зүйн зөрчлийн хуультай. Захиргааны эрх зүйн зөрчилтэй холбоотой хэргийг байгууллага, албан тушаалтны шалгах хугацаа 15 хоног байна. Захиргааны зөрчилд хариуцлага оногдуулах эрх бүхий этгээд нь байцаагч байна.
Казакстан Улс	1-30 хоног	Шүүх	Дотоод Явдлын Яам болон Цэргийн цагдаагийн байгууллага	Захиргааны эрх зүйн зөрчлийн хуультай. Мөн онц байдал зарласан үед 45 хоног хүртэлх хугацаагаар баривчилж болно. Захиргааны баривчилгааг 14 нас хүрээгүй хүүхэдтэй эх, жирэмсэн эмэгтэй, 18 нас хүрээгүй хүүхэд, 1-2 зэрэглэлийн хөгжлийн бэрхшээлтэй хүн, 58 наснаас дээш насны эмэгтэй хүн, 60 настай эрэгтэй хүнд хэрэглэж болохгүй. Захиргааны түр саатуулах хугацааг

				захиргааны баривчилгааны хугацаанд тооцно.
Эстони	1-30 хоног	Шүүх	Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх байгууллага	Misdemeanor /Зөрчил/-т 30 хүртэл хоногоор баривчилж болно.
Унгар	1-60 хоног	Нийслэл, аймгийн Засгийн газрын алба; Цагдаагийн байгууллага; Үндэсний татвар; Гаалийн алба; Шүүх;	Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	Зөрчил, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн бүртгэлийн тогтолцооны тухай хуультай.
Гүрж	1-15 хоног	Шүүх; Дотоод хэргийн байгууллага; Улсын мэргэжлийн хяналтын байгууллага; Нутгийн өөрөө удирдах байгууллага	Шийдвэр гүйцэтгэх алба	Гүрж улс 2014 онд Захиргааны зөрчлийн тухай хуульдаа шинэчлэл хийж олон шинэлэг зохицуулалтыг нэвтрүүлсэн байна. Энэ хүрээнд өмнө зөрчил гаргасан этгээдэд цагдан хорих хугацаа 90 хоног байсныг 15 хоног болгон өөрчилсөн зэрэг олон улсын эрх зүйн зарчимд нийцсэн эерэг хандлагатай хууль болсон гэж үнэлэгдэх болжээ.
<i>Эрүүгийн хуулиар баривчлах ялын зохицуулалттай орнууд</i>				
Турк	Богино хугацаатай хорих ял нь нэг жил ба түүнээс бага хугацаатай байна.	Шүүх	Хорих байгууллага	Богино хугацаатай ялыг яллагдагчийн хувийн байдал, нийгэм эдийн засгийн нөхцөл, хэргийг хянан шийдвэрлэх хугацаанд өөрийн гэм бурууг ухамсарласан байдал, гэмт үйлдлийн шинж чанарыг тус тус харгалзан үзэж өөр төрлийн ялын төрлөөр өөрчлөн шилжүүлж болно.
БНХАУ	Баривчлах ялын доод хэмжээ 1 сараас	Шүүх	Олон нийтийн аюулгүй байдлын байгууллага	Эрүүгийн баривчлах арга нь шийтгэлийн арга учраас хууль зүйн шинж чанар, холбогдох объект, холбогдох эрх мэдэл, холбогдох

	доошгүй байх бөгөөд дээд тал нь 6 сараас дээшгүй (хагас жил) байна.			үндэслэл, холбогдох журам, холбогдох хугацаа зэргээр бусад хоригдох ялаас ялгаатай байдаг. Сард 1-2 удаа гэртээ харьж болно.
<i>Эрх зүйн зөрчилд оногдуулж буй шийтгэлийн бусад төрлүүдийг хуульчилсан орнууд</i>				
АНУ	Эрүүгийн зөрчил (delct) - 15 хоног хүртэл хугацаагаар баривчлах ба хорихоор шийтгэхээр заасан гэмт үйлдэхүй;	Мужийн шүүх, орон нутгийн засаг захиргааны байгууллага	Хорих байгууллага	Америкийн эрүүгийн эрх зүйд гэмт хэрэг үйлдэхүйг гэмт халдлага (criminal offenses)-ын 4 дөрвөн категорид ангилж үздэг.
Англи	Аливаа хүний хяналтад байлгах /a supervision requirement/ (213-р зүйлд зааснаар)	Шүүх	Олон нийтийн магадлагдсан байгууллага	Эрүүгийн төрөлжсөн хуульгүй байдгаас үүдэн олон хууль, хуульчилсан актуудад ял оноох бүрэн эрхийг шүүхүүдэд олгосон байдаг
Франц	Эрүүгийн зөрчлөөс олсон эд зүйлс, ашигласан хэрэгсэл, эд зүйлсийг хураах	Шүүх	Тэнсэн харгалзах байгууллага	Эрүүгийн зөрчил (contraventions). Бага, ялимгүй боловч хорихоос өөр төрлийн ял оноохоор хуульлагдсан гэмт үйлдэхүй (Pety obetse)

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Баривчлах шийтгэл нь төрийн албадлагын арга хэмжээ боловч эрүүгийн ялаас ялгаатай, хууль зүйн хариуцлагын нэг төрөл юм. Мөн уг шийтгэл нь ялаас ялгагдах бие даасан ойлголт хэдий ч зарим улс оронд хэрэгжүүлж буй богино хугацааны ялтай харилцан нөхцөлдсөн, уялдаа холбоо бүхий байна. Баривчлах шийтгэлийн агуулга нь зөрчил үйлдсэн этгээдийг тодорхой нөхцөл, журам бүхий байранд олон нийтээс тусгаарлан саатуулах хэдий ч мөн чанар нь нийтийн эрх ашгийг хамгаалах, дахин зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, тухайн зөрчил гаргасан этгээдийн эрсдэл бүхий зан үйлийг өөрчлөх, эерэг нөлөөлөл үзүүлэх, гэм бурууг ухамсарлуулан ойлгуулахад чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ байна.

Шүүхээс сүүлийн 15 жилийн байдлаар шийдвэрлэсэн захиргааны зөрчлийг судлан үзвэл жилд дунджаар 10000-20000 орчим хэрэг шийдвэрлэдэг ба Монгол Улсын хэмжээнд жилд үйлдэгдэж буй зөрчлийн тоо улам өсөх хандлагатай байгаа нь иргэдийн архидан согтуурах, мансуурах бодисын хэрэглээ өссөн, хөдөлмөр эрхлэлт хангалтгүй, нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөлөл их, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд зөрчил, дутагдал тасрахгүй байгаагай холбож тайлбарлаж болох юм.

Баривчлах шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсний дүнд дараах дүгнэлтэд хүрлээ.

1. Баривчлах шийтгэл эдлүүлэх журмыг хуулиар тогтооно гэж заасан хэдий ч бие даасан хуульгүй, өнөөдрийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Баривчлах байрны дотоод журмаар зохицуулж байгаа нь, эрх зүйн бие даасан зохицуулалт шаардлагатай байгааг харуулж байна.

2. Баривчлах шийтгэл эдэлж буй этгээдийн эрх зүйн байдал, хорих нөхцөл нөхцөл, журмыг хорих ял эдэлж буй хоригдол, цагдан хоригдож буй хоригдогчтой адил хэмжээгээр тусгасан нь эрүү, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ялгааг гаргаагүй зохицуулалт болжээ.

3. ШШГБ-ын хэмжээнд баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагааны бие даасан бүтэц, нэгжийн зохион байгуулалт батлагдсан хэдий ч Нийслэл, аймаг, орон нутаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, нэгжид бие даасан орон тоог бий болгох шаардлагатай байна. Энэ нь баривчлах шийтгэлийг хэрэгжүүлэх нэгдмэл удирдлагын тогтолцоо бий болохын зэрэгцээ шийтгэлийн бодит үр дүн нэмэгдэх боломжийг бүрдүүлнэ гэж дүгнэж байна.

4. Баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагааны явцад хэрэгжиж буй зан үйлд нөлөөлөх албадан сургалтын чанар, үр нөлөөнд анхаарч агуулга, хэлбэрийг өөрчлөх шаардлага урган гарчээ.

5. Баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагааны явцад гарч буй зардлыг төлбөрийн чадваргүй этгээдээр хэрхэн төлүүлэх, албадан хөдөлмөр эрхлүүлэх боломжийг зохицуулсан эрх зүйн зохицуулалтын шаардлага байна гэж дүгнэлээ.

ТАВ. ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он
2. Монгол Улсын Эрүүгийн хууль 2017 он
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он
4. Монгол Улсын Зөрчлийн тухай хууль, 2017

Ном, сурах бичиг, гарын авлага:

1. Гантулга, Н. Хүний эрх ба хорих ял. Уб., 2015.
2. Гантөмөр, Г. Эрүүгийн хариуцлага. Уб., 2006.
3. Дашзэвэг, Б. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй (ерөнхий анги). Уб., 2003.
4. Дашзэвэг, Б. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй (тусгай анги). Уб., 2004.
5. Дашзэвэг, Б. Монгол Улсын Эрүү, иргэний хэрэгт холбогдох шүүхийн шийдвэр биелүүлэх хууль тогтоомжийн хөгжилт 1955-2005. Уб., 2005.
6. Лувсанжав, Н. Баатар, Ч. Хүний эрх, эрх чөлөө ба Үндэсний аюулгүй байдал. Хүний эрх ба Үндэсний аюулгүй байдал-Олон улсын симпозиумын эмхэтгэл. Уб., 1998.
7. Лхагва, А. Шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүй. Уб., 1999
8. Лхагва, А. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. Уб., 2012.
9. Лхагва, А. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж. Уб., 2014.
10. Оюунаа, Ю. Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа. Уб., 2021

Статистик, судалгааны тайлан:

1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн “Шүүн таслах ажиллагааны 2014-2023 оны статистик мэдээ.
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын статистик мэдээ,
3. Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын статистик

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЭРҮҮГИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА

1.1. Үнэлгээ хийх шалтгаан:

Манай улсын хувьд хорих ялаас аль болох татгалзан, үйлдсэн гэмт хэргийн шинж, хувь хүний онцлог байдалд тохирсон ял оногдуулах замаар ялын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор 2015 оны Эрүүгийн хуульд ял, албадлагын арга хэмжээг шинээр хуульчилсан. Тус хуульд нийт 1088 үйлдлийг гэмт хэрэгт тооцож “хорих, торгох, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх болон эрх хасах” ялын төрлийг үндсэн болон нэмэгдэл ялын чанартайгаар ногдуулах тухай заасан байна.⁸³

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хорих, хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэр, эрүүгийн хуульд заасан албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэр, сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих тухай шүүгчийн захирамжийг гүйцэтгэх ажиллагаа багтдаг.

Эрүүгийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т эрүүгийн хариуцлагын зорилго нь “гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оришино” гэж тодорхойлжээ.

Энэхүү зорилгыг хангах үндсэн чиг үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэрэгжүүлж буй “эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа”-ны хүрээнд гүйцэтгэж байна.

Зөвхөн хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад нийт ял эдлэгсдийн 50 орчим хувь нь өмнө гэмт хэрэг үйлдэн ял эдэлж байсан хоригдлууд байгаа нь эрүүгийн хариуцлагын нийгэмшүүлэх зорилго бүрэн хангагдахгүй байгааг харуулж байна. Үүнтэй уялдан нийгэмд гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж буй этгээдийг хугацааны өмнө ямар үндэслэл, шалгуураар сулладаг нь нээлттэй бус, суллагдсан этгээдэд тавих хяналтын үр нөлөө муу зэрэг олон асуудал маргаантай байсаар байна. Түүнчлэн хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилт, бодит нөхцөл байдалд дүн шинжилгээ, судалгаа хийхгүй орхих нь эрүүгийн хариуцлагын зорилго, үр нөлөөг бууруулах нөхцөл байдлыг үүсгэж болзошгүй юм.

Иймд өнөөгийн ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ хийж, тулгамдсан асуудлыг судалгааны үндсэн дээр нээн илрүүлж, ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэгдсэн зөвлөмжийг гаргах шаардлагыг үндэслэсэн болно.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд заасны дагуу хууль тогтоомж нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд үнэлгээний ажлыг эхлэхээс өмнө үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлно. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.3 дахь хэсэгт “энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлохыг зорилоо.

⁸³ Э.Жамбалрагчаа “Монгол Улсын Эрүүгийн хууль дахь ялын хэрэглээнд хийсэн дүн шинжилгээ, чиг хандлага”. ИШПЕГ-ын “Сүлд-Инфо сэтгүүл”. УБ., 2021.53 дахь тал.

1.2. Үнэлгээ хийх хүрээ:

Аливаа хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлахад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.

ШШГТХ-ийн эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой зүйл, заалт тус хуулийн 34,4 хувь буюу 153-256 (хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх 153-194 зүйл буюу 13,9 хувь, хорих ял эдлүүлэх 195-256 зүйл буюу 20,6 хувь) дугаар зүйлийг хамарч байдаг.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.4 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхдээ хууль тогтоомжид бүхэлд нь, эсхүл түүний зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож болно” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагаанд холбогдох зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлсэн болно. Ингэхдээ захиалагч байгууллага болох ШШГЕГ-ын ирүүлсэн ажлын даалгавар, үнэлгээ хийх болсон шалтгааны харилцан уялдаа, хамааралтай байдлыг харгалзаж, хуулийн хэрэгжилтэд гарч буй эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон зохицуулалтыг сонгосон.

Үүний дүнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дараах зохицуулалтыг үнэлгээ хийх хүрээнд хамрууллаа.

д/д	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Зохицуулалтын агуулга
1.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 167-176 дугаар зүйл	Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт
2.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 162-166 дугаар зүйл	Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт
3.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 185-192 дугаар зүйл	Албадлагын арга хэмжээний хэрэгжилт
4.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 193-194 дугаар зүйл	Хуулийн этгээдийг татан буулгах, эрх хасах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх
5.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 195, 198-200 дугаар зүйл	Хорих ял эдлүүлэх тогтолцоо /дэглэм, зэрэглэлийн эрх зүйн зохицуулалт/
6.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 218, 219 дугаар зүйл	Хоригдлыг нийгэмшүүлэх ажиллагаа
7.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 231 дугаар зүйл	Хоригдлын ахуйн нөхцөл

1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт:

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд зааснаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтийн жагсаалтыг гарган, үнэлгээ хийх асуудал тодорхой болсон үед тодорхой 1 шалгуур үзүүлэлтийг сонгон авах бөгөөд зөвхөн 1 шалгуур үзүүлэлтээр тухайн асуудалд бүрэн үнэлэлт өгөх боломжгүй тохиолдолд 2 болон түүнээс дээш шалгуур үзүүлэлтийг сонгох боломжтой гэжээ.

Аргачлалд заасны дагуу эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, үнэлгээний хүрээ,

онцлогоос хамааран зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж байгаа байдал гэсэн хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр:

Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтийг олж тодорхойлоход харьцуулах 4 төрлийн хэлбэрээс хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш-хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтооход чиглэгдэнэ. Тодорхой цаг хугацааны дарааллаар нөхцөл байдлын өрнөлийг жагсааж гаргасан судалгааг үнэлгээнд хэрэглэх хэлбэрийг сонгон ашиглалаа.

Энэ хэлбэрийг ашиглахдаа эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран тоо баримт, олон улсын эх сурвалж, бусад материалд дүн шинжилгээ хийнэ.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох:

Шалгуур үзүүлэлтийг томьёолохдоо шалгуур үзүүлэлт тус бүрээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааны сонгон авсан хэсэгт тохируулан дараах шалгуур үзүүлэлтийг сонгож, асуулт боловсрууллаа.

1. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилтийн түвшин;
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 167-176 дугаар зүйл нь ялын зорилгод нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 162-166 дугаар зүйл нь ялын зорилгод нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 185-192 дугаар зүйл нь ялын зорилгод нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 193-194 дугаар зүйл нь ялын зорилгод нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 195, 198-200 дугаар зүйл нь ялын зорилгод нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;
7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 218, 219 дугаар зүйл нь ялын зорилгод нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;
8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 231 дугаар зүйл нь ялын зорилгод нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох:

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтэд тулгамдсан асуудлыг илрүүлэх зорилгоор баримт бичиг, судалгааны тайлан, илтгэл, өгүүлэл унших, судлах, харьцуулалт хийх, ШШГБ-ын алба хаагчдаас тулгамдаж буй асуудлын талаар судалгаа авах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд аргачлалын 3.7.3-т мэдээлэл цуглуулах дөрвөн аргыг тодорхойлсноос дараах хоёр аргыг сонгон үнэлгээ хийх мэдээллийг цуглуулсан болно.

1. Мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийх;

2. Судалгаа авах.

Мэдээлэл цуглуулах хүрээнд: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, холбогдох ном, сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, журам, зааврыг цуглуулж, үнэлгээ хийхэд ашиглав.

Судалгаа авах хүрээнд: Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэхийн тулд алба хаагчтай ярилцлага хийх, анкетын аргаар судалгаа авсан. Түүнчлэн ШШГЕГ-ын үйл ажиллагааны тайлан, судалгаа, бусад мэдээллийг гаргуулан авч үнэлгээ хийхэд ашигласан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ


Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, алба хаагчидтай уулзалт-ярилцлага хийх, анкетын судалгаа авч, ярилцлагын аргад тулгуурлаж энэхүү судалгааг гүйцэтгэв.

2.1. Баримт бичгийн судалгаа: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлүүд, илтгэл, өгүүлэл, тайланг ашигласан болно.

2.2. Холбогдох субъектээс авсан судалгаа:

а) эрүүгийн 94 шийдвэр гүйцэтгэгчээс шийдвэр гүйцэтгэгчийн ерөнхий мэдээлэл, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, алба хаагчийн эрх зүйн байдлын талаар хариулахаар тооцож нээлттэй байдлаар санал хүсэлт өгөх боломжтойгоор сонгон авсан эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, тулгамдсан асуудлын талаар авсан санал-асуулга;

Судалгаанд оролцсон эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийн боловсролыг ажилласан жилтэй харьцуулсан үзүүлэлт



Зургаас үзэхэд судалгаанд оролцсон эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчийг боловсролоор нь ангилахад бүрэн дунд 1 буюу 1.1 хувь, бакалаврын зэрэгтэй 69 буюу 73.4 хувь, магистрын зэрэгтэй 24 буюу 25.5 хувийг эзэлж байгаа бол ажилласан жилийн хувьд 1 жил хүртэл ажилласан 14 буюу 14.9 хувь, 1-3 жил ажилласан 32 буюу 34 хувь, 3-6 жил ажилласан 19 буюу 20.2 хувь, 6-10 жил ажилласан 9 буюу 9.6 хувь, 10-аас дээш жил ажилласан 20 буюу 21.3 хувийг эзэлж байна

б) хорих байгууллагын 1005 алба хаагчаас хорих ял эдлүүлэх төрөл, дэглэм, зэрэглэл, нийгэмшүүлэх ажлын үр нөлөө зэрэгтэй холбоотой санал-асуулга.

Хорих ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой судалгаанд хамрагдсан хорих байгууллагын 1005 алба хаагчаас 1 жил хүртэл ажилласан 122 буюу 12.1 хувь, 1-3 жил ажилласан 201 буюу 20 хувь, 3-6 жил ажилласан 158 буюу 15.7 хувь, 6-10 жил ажилласан 169 буюу 16.8 хувь, 10-аас жил дээш ажилласан 355 буюу 35.3 хувийг эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан алба хаагчдын ажилладаг алба, нэгжийн тухайд захиргаа 53 буюу 5.3 хувь, гүйцэтгэх алба 124 буюу 12.3 хувь, харуул хамгаалалтын алба 531 буюу 52.8 хувь, нийгэм, сэтгэл зүйн алба 42 буюу 4.2 хувь, санхүүгийн алба 148 буюу 14.7 хувь, тоо бүртгэлийн алба 26 буюу 2.6 хувь, эмнэлгийн алба 81 буюу 8.1 хувийг эзэлж байна. Түүнчлэн 1005 алба хаагчаас 298 буюу 29.7 хувь нь бүрэн дунд, 631 буюу 61 хувь нь бакалавр, 92 буюу 9.2 хувь нь магистр зэрэгтэй байна.


2.3. Ярилцлагын арга: ШШГТХ-ийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн бодит байдал, хууль хэрэглээнд тулгамдаж буй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг тодруулахаар ярилцлага хийсэн.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Эрүүгийн хуульд ялын шинэ төрөл, түүнийг хэрэгжүүлэх, хорих ялыг гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйл, үйлдлийн арга, сэдэл, зохион байгуулалт, оролцооноос хамааран ялгамжтай оногдуулах, түүнчлэн нийгмийн хор аюул бага, болгоомжгүй байдлаар болон анх удаа гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорихоос өөр төрлийн ялаар шийтгэж, тэднийг нийгэмшүүлэх, нийгэм, сэтгэл зүй, гэр бүлийн харилцааны хүрээнд засан хүмүүжүүлэх зорилготойгоор нийтэд тустай ажил хөдөлмөр эрхлүүлэх, шаардлагатай тохиолдолд улс төрийн болон нийгэм, эдийн засгийн эрхэнд хязгаарлалт хийх, зорчих эрхийг хязгаарлах зэргээр эдийн засгийн хувьд чирэгдэл багатай ялыг оногдуулахыг зорьсон байна.⁸⁴

2015 оны Эрүүгийн хуульд нийт 1088 үйлдлийг гэмт хэрэгт тооцож “хорих, торгох, эрх чөлөө хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх болон эрх хасах” ялын төрлийг үндсэн болон нэмэгдэл ялын чанартайгаар ногдуулах тухай заасан байна.⁸⁵

Зураг 23. Эрүүгийн хуульд тусгасан ялын төрөл эзлэх хувь



Манай улсад хэрэглэгдэж буй хорихоос өөр төрлийн ял гэх нэр томьёо нь дэлхийн улс орнуудад:

1. Нийгэм-олон нийтэд тулгуурласан ял нь (community sentence, community based sentence)⁸⁶;
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэж буй сонгох ял (alternative sentence);
3. Хорихоос өөр төрлийн ял (non-custodial sentence)-ын нэгэн адил хэрэглэгдэх нэгдмэл нэршил бүхий ойлголт⁸⁷ юм.

“Нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэл” болон “сонгох хувилбараар оноох ял шийтгэл” гэсэн ойлголт зарчмын хувьд ижил утгыг илэрхийлнэ.

⁸⁴ Б.Нямгомбо. “Хорих болон хорихоос өөр төрлийн ялын үр нөлөө, чиг хандлага”. <http://criminology.mn>

⁸⁵ Э.Жамбалрагчаа, Э.Урангоо. “Монгол Улсын Эрүүгийн хууль дахь ялын хэрэглээнд хийсэн дүн шинжилгээ, гадаад орны зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх ажиллагааны туршлага, өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага”. ШШГЕГ-ын “Сүлд-Инфо сэтгүүл” УБ., 2021.53 дахь тал.

⁸⁶ Зарим судлаачид “нийгэмд үйлчлэх ял”, “нийтийн тусын тулд үйлчлэх ял” зэргээр нэрлэх нь бий.

⁸⁷ <https://www.gov.uk/community-sentences>.

1990 онд НҮБ-аас “Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм” (Токиогийн дүрэм)-ийг батлан гаргасан нь хорих ялаас татгалзах, хорихоос бусад төрлийн ял шийтгэлийг өргөн хэрэглэх нөхцөлийг зарчмын хувьд бүрдүүлсэн чухал зохицуулалт болсон билээ. Токиогийн дүрэм⁸⁸ нь Ерөнхий Ассамблейн 1990 оны 10 сарын 14-ний өдрийн 45/110 дугаар тогтоолоор 7 бүлэг 23 зүйлтэйгээр батлагдсан бөгөөд хорих ялын хэрэглээг багасгах, эрх зүйн зөрчил гаргагчид нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх зорилгыг агуулж, нийгмийн болон хохирогчийн ашиг сонирхлыг хамгаалахыг анхаарч шаардлагатай тохиолдолд хохирогчтой зөвлөлдөж байхыг зөвлөжээ.

Энэхүү дүрмээр хорихоос өөр төрлийн арга хэмжээнд хэрэглэх зарчмыг тусгасан юм. Үүнд:

- хорихоос өөр төрлийн ял хэрэглэж байгаа этгээдийн хувьд наад захын баталгааг агуулах, ЭБША-г хэрэгжүүлэх;
- эрх зүйн зөрчил гаргагч этгээдэд хандахад олон нийтийн идэвхтэй оролцоог хангах;
- эрхийн зөрчил гаргагчид нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- үндэсний эрүүгийн хууль тогтоомжийн бодлого зорилтыг харгалзан хэрэглэх;
- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн аюулгүй байдлын тухайд нийгмийн сонирхол, хохирогчийн эрх, зөрчил гаргагчийн эрхийн хооронд зүй зохистой харьцааг хангах;
- хорих ялыг хэрэглэх явдлыг багасгах замаар бусад боломжийг хангах, нийгмийн шударга ёсны шаардлага, хүний эрхийг хангах зайлшгүй шаардлагыг харгалзан эрүүгийн хууль тогтоомж дахь бодлогыг оновчтой болгох зорилгоор үндэсний хууль тогтоомжийн хүрээнд хорихоос өөр төрлийн арга хэмжээг боловсруулах зорилготой.

Дүрэм нь хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх, түүний зарчмыг тодорхойлох, шийтгүүлсэн этгээдийн хувьд наад захын баталгааг агуулдаг. Энэхүү дүрмийн гол онцлог нь эрх зүйн зөрчил үйлдсэн этгээдийг нийгмийн хэвийн амьдралд эргэж ороход нь туслах, хорих ялаас татгалзах, ялын нөлөөг цээрлүүлэхээс илүүтэй дахин хэрэг үйлдэж давтан гэмт хэрэгтэн болох явдлаас сэргийлж, төрийн эрх бүхий байгууллагын хяналтад авах замаар хүмүүжүүлэхийг илүүд үзжээ. Үүнээс гадна хорихоос өөр төрлийн арга хэмжээ нь үр дүнгээ өгч байгаа тохиолдолд эрх зүйн зөрчил гаргагч этгээдийн хугацаанаас нь өмнө уг арга хэмжээг зогсоох, уучлах, үр дүнд хүрээгүй тохиолдолд шууд хорих ял хэрэглэхээс зайлсхийж дахин хорихоос өөр төрлийн ял шийтгэлээс сонгохыг санал болгож урамшуулах, уучлах, өршөөх, ажил сургалттай нь холбогдуулж чөлөө олгох механизмыг тогтоож өгсөн байна. Дээрх зохицуулалтаас гадна хорихоос өөр төрлийн арга хэмжээ хэрэгжүүлэгч тогтоол гүйцэтгэгчийг нарийн тодорхойлж амьдралын туршлагатай, мэргэжлийн зохих бэлтгэлтэй, хувийн шинж чанараар тохирсон хүн байвал зохино хэмээн тусгайлан тодорхойлсон юм.

НҮБ-ын гишүүн орнууд эрүүгийн хууль тогтоомждоо дээр дурдсан зарчмыг баримталж, хорих ялаас татгалзаж хорихоос өөр төрлийн ялыг сонгон хэрэглэх, уг ялыг хэрэглэхдээ олон нийтийн оролцоог сайжруулж, зөрчил гаргагч этгээдийн нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг нэмэгдүүлж, эргээд нийгэмд хэвийн амьдралд эргэж орох

⁸⁸ Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл. УБ., 2012. 159 дэх тал.

хэрэгцээ, зөрчил гаргагч, хохирогч этгээдийн эрхийн хооронд зүй зохистой харьцааг хангаж, үндэсний хууль тогтоомж, нийгмийн шударга ёсны шаардлагад нийцүүлж хуульчлах шаардлагатайг дурдсан байгаа нь тус ялыг эдлүүлэх ажиллагааны тогтолцоог илэрхийлсэн гэж үзэж болох юм.

Хорихоос өөр төрлийн арга хэмжээнүүдийг сонгох бололцоотой нөхцөлд шүүхийн байгууллага дараах байдлаар шийдвэрлэж болдог байна.

Дүрмийн заалтууд нь мөрдөн байцаалт, шүүхийн хэлэлцүүлэг болон шүүхийн шийдвэр гүйцэтгэл зэрэг байцаан шийтгэх эрүүгийн бүх шатны бүх этгээдэд хэрэглэгдэнэ. Дүрэм нь шашин шүтлэг, арьсны өнгө, нас, хүйс, хэл улс төрийн болон бусад үзэл, нийгмийн гарал үүсэл, эд хөрөнгийн байдал төрсөн газар зэргээр нь ялгаварлан гадуурхахгүйгээр хэрэглэгдэнэ. Хорихоос өөр төрлийн арга хэмжээг оноох шийдвэр нь зөрчил гаргагчийн өргөдлөөр шүүхийн болон бусад хараат бус бүрэн эрхт байгууллагаар хянагдана. Зөрчил гаргагч нь хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэх явцад түүнийг болон түүний хувийн эрхийг хөндсөн асуудлаар шүүхийн болон бусад хараат бус байгууллагад хүсэлт тавих, гомдол гаргах эрхтэй. Хорихоос өөр төрлийн арга хэмжээ нь зөрчил гаргагч дээр эмнэлгийн болон сэтгэл мэдрэлийн туршилт явуулах түүнд бие сэтгэл санааны гэмтэл учруулахыг хориглоно. Дүрэм дараах хэлбэрээр хэрэгжинэ. Үүнд

1. Шүүхийн өмнөх шат:

Тодорхой хэргийг мөрдөн шалгах хийгээд нийгэм, хохирогчийг хамгаалах зорилгоор шүүхийн өмнөх шатанд хорьж саатуулах явдлыг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны онцгой арга хэмжээ болгож хэрэглэх ёстой.

2. Шүүхийн шат ба тогтоол гаргах:

Хорихоос өөр төрлийн арга хэмжээг сонгох бололцоотой нөхцөлд шүүхийн байгууллага шийдвэр гаргахдаа эрх зүйн зөрчил үйлдэгчийг засан хүмүүжүүлэх шаардлага, нийгмийн болон хохирогчийн ашиг сонирхлыг хамгаалах асуудлыг анхааралдаа авбал зохих бөгөөд хохирогч этгээдтэй шаардлагатай тохиолдолд зөвлөлдөж байгууштай.

3. Шийтгэх тогтоол гарсны дараах шат:

Эрх бүхий байгууллага эрх зүйн зөрчил үйлдсэн этгээд нийгэмд хэвийн амьдралд түргэн эргэж ороход нь туслах, хорихоос татгалзах түргэн эргэж ороход нь туслах, хорихоос татгалзах зорилгоор тогтоол гарсны дараа хорихоос өөр төрлийн арга хэмжээг сонгох өргөн боломжтой байна.

Шийтгэх тогтоол гарсны дараа дараах арга хэмжээг авч болно.

- а) хөлөө олгох ба засан хүмүүжүүлэх хагас шоронгийн байгууллагад байлгах;
- б) ажил сургалттай нь холбогдуулж чөлөөлөх;
- в) хугацааг богиносгох;
- г) уучлал үзүүлэх.

Дахин хэрэг зөрчил үйлдэх явдлыг багасгах, архаг болохоос сэргийлэх, түүнийг нийгмийн амьдралд түргэн оруулахад туслах замаар дахин хэрэгт орооцолдох магадлалыг бууруулахад хяналтын зорилго оршино. Хэрэв хорихтой холбоогүй аль нэг арга хэмжээ нь хяналттай байна гэвэл тэр нь хуулиар тодорхойлогдсон тодорхой нөхцөлийн доор эрх бүхий байгууллагаар гүйцэтгэгдэнэ.

Хорихтой холбоогүй тодорхой арга хэмжээний тухайд зөрчил гаргагчид туслахад чиглэсэн хяналтын болон харьцааны илүү үр ашигтай хэлбэрүүдийг тохиолдол бүрт тодорхойлж байвал зохино. Хяналт болон харьцаа хандлагыг үе үе хянан хэлэлцэж шаардлагын хэмжээгээр засаж залруулах хэрэгтэй.

Эрх зүйн зөрчил гаргагчдад хэрэгцээтэй үед нь сэтгэл санааны, нийгмийн эд хөрөнгийн туслалцаа үзүүлэх ёстой ба нийгэмд хэвийн амьдралд эргэж орохыг нь хөнгөвчлөх нийгэмтэй харьцаа холбоогоо бэхжүүлэхэд нь боломж олгох ёстой.

Хэрэв эрх бүхий байгууллага нь зөрчил гаргагчид болзол тогтоосон бол хохирогчийн болон зөрчил гаргагчийн эрх ашиг, нийгмийн сонирхлыг тооцох ёстой. Биелүүлбэл зохих болзол нь бодитой, тодорхой бололцооны хирээр аль болох цөөн байх ёстой бөгөөд эрх зүйн зөрчил үйлдсэн этгээд гэмт хэргийн зам руу буцаж орох магадлалыг багасгах ба түүний засран хүмүүжих нийгэмдээ нэгдэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байхын сацуу хохирогч этгээдийн эрэлт хэрэгцээг бодолцсон байвал зохино. Хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэх эхний үе шатанд эрх зүйн зөрчил үйлдэгч этгээдэд түүний эрх үүргийг оролцуулан тухайн арга хэмжээг хэрэглэх явдлыг зохицуулах болзлын талаар амаар болон бичгээр ойлгуулж тайлбарлана.

Хорихоос өөр төрлийн арга хэмжээг дэмжихэд нь засгийн газрын байгууллагууд, хувийн сектор болон иргэдийг хөхүүлэн дэмжвэл зохино. Хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэх хэрэгт олон нийтийн оролцоо зайлшгүй чухал гэдгийг ухамсарлуулах зорилгоор онол практикийн бага хурал, семинар, симпозиум бусад арга хэмжээг байнга зохион байгуулж байгууштай.

Хорихоос өөр төрлийн арга хэмжээг өргөн хэрэглэх болон эрх зүйн зөрчил үйлдэгсдийг нийгэмд буцаж ороход чиглэгдсэн үйл ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн иргэдийн ажил хэрэгч үзэл хандлага бий болгохын тулд олон нийтийн мэдээллийн бүх төрлийн хэрэгслийг ашиглах ёстой. Олон нийтийн байгууллага нь хорихоос өөр төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг гэдгийг нь олон нийтэд ойлгуулахын тулд бүх хүчээ төвлөрүүлэх ёстой.

Олон улс үндэстэн эрүүгийн эрх зүйд хүний эрхийг хангаж, хүнлэг, энэрэнгүй ёсны хандлагыг хэрэгжүүлж ялын хатуу чанга ял шийтгэлээс татгалзаж, хүмүүжил олгох хорихоос өөр төрлийн нөлөөллийн арга хэмжээг өргөн дэлгэр хэрэглэх чиг хандлагатай байна. Уг байр суурийг ч мөн НҮБ өөрийн олон улсын баримт бичигт тусгах замаар гишүүн орнуудад үүрэг болгожээ.

Тиймдээ ч хорих ялын нийгэмд үзүүлэх үр нөлөө нь төдийлөн өндөр байдаггүйг дэлхий нийт хүлээн зөвшөөрч аль болох хорихоос өөр төрлийн ялыг сонгож, гэмт хэргийн шинж байдлаас нь шалтгаалан ялыг ялгамжтай оногдуулж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэр бүл, нийгэмд нь байлгаж, гэмт хэргийн нийгмийн хор аюулыг ухамсарлуулахад чиглэсэн ялын бодлогыг баримтлах хандлагатай байна.

Жишиг дүрмийн V Хорихтой холбоогүй арга хэмжээг биелүүлэх нь гэсний 10.1-т “дахин хэрэг зөрчил үйлдэх явдлыг багасгах, архаг болохоос сэргийлэх, түүнийг нийгмийн амьдралд түргэн оруулахад туслах замаар түүнийг дахин хэрэгт орооцолдох магадлалыг бууруулахад хяналтын зорилго оршино”, 10.2. “хэрэв хорихтой холбоогүй аль нэг арга хэмжээ нь хяналттай байна гэвэл тэр нь хуулиар тодорхойлогдсон тодорхой нөхцөлийн доор эрх бүхий байгууллагаар гүйцэтгэгдэнэ” гэж заажээ.


Энд шууд цахим гав, цахилгаан буюу электрон хяналтын “төхөөрөмж, согтууруулах ундаа-мансууруулах бодис хэмжигч зэргийг хэрэглэх талаар шууд зааж өгөөгүй боловч дахин хэрэг зөрчил үйлдэх явдлыг багасгахад хяналтын зорилго оршино гэж зааж өгсөн явдал нь дээрх төхөөрөмжүүдийн тусламжтайгаар хяналт тавихтай зорилгын хувьд нийцэж байгаа бөгөөд цахим гав зэрэг төхөөрөмжийг хэрэглэх боломжийг санал болгосон байгаа юм.

Монгол Улсын хувьд энэхүү жишиг дүрэмд нэгдсэн бөгөөд Монгол Улсын Олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөх журамтай учир манай улс аль болох хорихоос өөр төрлийн ял хэрэглэх эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтыг эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчээс ялтан болон эрх бүхий ажилтан, албан тушаалтан, иргэнээс тайлбар, тодорхойлолт, баримт бичиг гаргуулан авах, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг болон түүнд холбогдох баримт бичигтэй танилцах, шалгах, ялтныг биечлэн болон цахимаар шалгах, санал, тогтоол гаргах, ялтантай уулзах, тэмдэглэл үйлдэх, тоо бүртгэл хөтлөх, шаардлагатай байгууллага, албан тушаалтантай хамтран шалгалт хийх хэлбэрээр хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг гүйцэтгэх ажиллагааг ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, нутаг дэвсгэрийн хэмжээнд аймаг, нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлж байна. ХӨТЯЭА нь Хорихоос өөр төрлийн ялын бүртгэл, хяналтын хэлтэс, Албадлагын арга хэмжээ, хяналтын хэлтэс, Цахим хяналт, удирдлагын төв гэсэн бүтэц, зохион байгуулалттай ажиллаж байна. Тус алба нь торгох, зорчих эрхийг хязгаарлах, эрх хасах, нийтэд тустай ажил хийлгэх ял, түүнчлэн үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах болон ял хойшлуулсан, ял тэнссэн, эмнэлгийн чанартай болон хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ зэрэг олон төрлийн шийдвэрийн биелэлтийг ханган ажиллаж байна.

Зураг 24. Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх схем




Монгол Улс дахь ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн байдлаас харахад, хорих ял эдлээд суллагдсан иргэдийн зүгээс давтан гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй, байна. Энэ нь ял эдэлж буй хоригдлыг хорих байгууллагаас суллагдсаны дараа үзүүлэх нийгэмшүүлэх ажлын тогтолцоо байхгүй, хууль сахиулах байгууллагуудын хэмжээнд чиг үүрэг бүрэн тодорхойлогдоогүй, хорихоос өөр төрлийн ялыг олон талт хэлбэрээр хэрэгжүүлэх нэгдсэн тогтолцоогүй нь эрх зүйн зохицуулалтын болон бүтцийн шинэлэг арга хэлбэр шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, ял эдлүүлэх ажиллагааны тогтолцоо, хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын өсөлт, гэмт хэргийн гаралт, нөхцөл байдалтай холбон өөрчлөх, гадаадын бусад орны ижил чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааны туршлагад суурилан, олон улсын чиг хандлага, загварт нийцүүлэн хөгжүүлэх нь зүйтэй гэж дүгнэж болно.

Судалгаанд оролцсон эрүүгийн 94 шийдвэр гүйцэтгэгчээс 10 буюу 10.6 хувь нь шинэчлэх шаардлагатай, 14 буюу 14.9 хувь нь шаардлага хангаж байгаа, 70 буюу 74.5 хувь нь зарим зүйл заалтыг шинэчлэх шаардлагатай гэж үзжээ. Хамгийн өндөр үзүүлэлтэй хариултыг ажилласан жилээр нь үзвэл 1 жил хүртэл ажилласан алба хаагчийн 78.5 хувь, 1-3 жил ажилласан алба хаагчийн 81.2 хувь, 3-6 жил ажилласан алба хаагчийн 57.8 хувь, 6-10

жил ажилласан алба хаагчийн 88.8 хувь, 10-аас дээш жил ажилласан алба хаагчийн 70 хувь нь зарим зүйл заалтыг шинэчлэх шаардлагатай гэж хариулжээ.

Зураг 25. ШШГТХ-ийн хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж буй зохицуулалтад өгсөн үнэлгээ



3.1. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт

XX зууны 2-р хагас буюу 1960-аад оны үеэс АНУ-ын Харвардын Их сургуулийн нийгмийн сэтгэл зүйн салбар электрон хяналтын төхөөрөмж (цахилгаан гав) нь эрүүгийн шүүхийн тогтолцооны чухал хэсэг болох тухай санааг дэвшүүлж байжээ. Тухайн үед Харвардын сэтгэл зүйн салбарт Роберт болон Кирк Габле нар алдартай сэтгэл зүйчид болох Скиннер болон Тимоти Лири нарын удирдлага дор суралцаж байжээ. Тэд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон өсвөр насны хүүхдийн хөдөлгөөнийг хянах тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр судалгаа явуулан, дээрх хүмүүсийн байрлал, байршлыг цаг тухайд нь мэдэх боломжийг эрэлхийлж байжээ. Ингэхдээ хуучны цэргийн төхөөрөмжийг суурь болгон ашиглан, энэхүү төхөөрөмжийг зүүсэн үед өөрийн байршлыг хаанаас ч дамжуулж байлаа.⁸⁹

Хэдийгээр зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэглэх техник, технологийн боломж, үндэс суурь нь 1960-аад оны үед бий болсон боловч уг ялыг шүүхийн практикт хэрэглэх хүртэл дахиад 20 орчим жил болжээ.

Ийнхүү зорчих эрхийг хязгаарлах ял амьдралд хэрэгжих боломж бүрдэж эхэлсэн үе нь 1960-аад он бөгөөд цахим хяналтын гавыг цэргийн технологид хэрэглэж байсан радио долгион дамжуулах төхөөрөмжид уялдуулан бүтээсэн боловч шүүхийн практикт үүнээс бүр хожим 1983 онд АНУ-ын Нью-Мексико мужид хэрэглэсэн байдаг. Үүнээс хойш нэг жилийн дотор АНУ-ын Флорида мужад энэ ялын хэрэглээний талаар томоохон хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. Ингээд 1980-аад оны сүүл хэсэг гэхэд АНУ-ын олон мужад зорчих эрхийн хязгаарлалт, цахим гав, электрон хяналт хэрэглэх олон янзын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлжээ.⁹⁰ Үүний дараа Канад, Австрали, Сингапур, Израйл зэрэг улс санаа авч өөр өөрсдийн онцлогт тохирсон хөтөлбөрийг боловсруулж эхэлсэн байна.⁹¹ Харин Европын улсуудад нэвтрэхэд нэлээд удаашралтай байжээ.

АНУ-ын Нью-Мексико мужын шүүгч Жэк Лов 1983 онд энэхүү ялыг анх удаа хэрэглэн шүүхийн шийдвэр гаргасан юм.⁹² 1987 он гэхэд уг ялаар шийтгүүлэгсдийн тоо 826 болсон⁹³ ба 1997 онд 75.000⁹⁴, 1998 онд энэ тоо ойролцоогоор 95000 болжээ.⁹⁵ 1989 онд Европын улсуудаас анхлан ИБУИНВУ-ад цахим гав, электрон хяналтын хөтөлбөрийг шүүхийн өмнөх шатанд таслан сэргийлэх арга хэмжээний төрөл хэлбэрээр анхлан хэрэглэж, туршиж эхэлсэн байдаг.⁹⁶ Ерээд оны эхэн үеэс Нидерланд, Швед зэрэг улсад шоронд хоригдож буй хоригдлын тоо илэрхий өсөх болсон ажээ.⁹⁷ Шоронд хоригдож буй ихэнх хоригдлууд нь хүч хэрэглэсэн гэмт хэрэг, бэлгэсийн гэмт хэрэг, хар тамхи, мансууруулах бодисын хууль тогтоомж зөрчих зэрэг гэмт хэрэгт холбогдсон хоригдлууд эзэлж байсан ба хорих ял эдэлж буй ялтныг хугацаанаас өмнө суллах орчин нөхцөл хязгаарлагдмал байсан

⁸⁹ Emma Anderson. The Evolution of Electronic Monitoring Devices. <http://www.npr.org/>.

⁹⁰ Jolin/Rogers, Journal of Contemporary Criminal Justice 1989, p. 141; Schmidt, Journal of Contemporary Criminal Justice 1989, p. 138.

⁹¹ RITA HAVERKAMP. Implementing Electronic Monitoring A comparative, empirical study on attitudes towards the measure in Lower Saxony/ Germany and in Sweden. p. 13.

⁹² James Kilgore. Electronic Monitoring Is Not the Answer Critical reflections on a flawed alternative. Urbana-Champaign Independent Media Center A part of the Media Action Grassroots Network (MAG-Net). 2015. p 8.

⁹³ A. K. Schmidt, "Use of Electronic Monitoring by Criminal Justice Agencies" (Washington, DC: Report for National Criminal Justice Research Service, 1988).

⁹⁴ Offender electronic technology. Community Corrections Resource [second edition]. Bureau of Justice Assistance U.S. Department of Justice. 2005. P 16.

⁹⁵ National Law Enforcement and Corrections Technology Center, Online Bulletin, National Institute of Justice (1999).

⁹⁶ G Mair; C Nee. Electronic Monitoring: The Trials and Their Results. 1990. <https://www.ncjrs.gov>.

⁹⁷ Compare the overview of the average prison population of Walmsley 1998.

байна. Ингээд дээрх хоёр орон эрүүгийн эрх зүйд тэр дундаа ялын эрх зүйд томоохон өөрчлөлт оруулж ял шийтгэлийн бодлогыг орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн шинэчлэх алхмыг хийж эхэлсэн юм. Энэ нөхцөлд цахим гав, электрон хяналтын төхөөрөмж нь хорих ялын хамгийн боломжит хэлбэр байж болох талаар үзэл санаа гарч энэхүү ялыг хэрэглэж эхэлсэн байна. Удалгүй энэхүү үзэл санаа нь Баруун Европын бусад улсуудад нэвтэрч эхэлсэн ба тухайлбал, Бельги, Герман, Франц, Итали, Португал, Швейцар зэрэг улсын шүүхээс цахим гав, электрон хяналтыг хэрэглэн хяналт тавих ялыг оногдуулах болжээ.

1990-ээд оноос эхлэн дэлхий нийтийн эрүүгийн эрх зүй, тодруулбал ялын бодлогод зорчих эрхийг электрон хяналтын төхөөрөмж, цахим гавын тусламжтайгаар хязгаарлах ял, арга хэмжээний эзлэх байр суурь өсөн нэмэгдэж, томоохон байр суурийг эзлэх болсон байна.⁹⁸

1990-ээд оны дунд үеэс GPS төхөөрөмжийн тусламжтайгаар ялтанд хяналт тавих боломжтой болсон юм. Энэхүү төхөөрөмжийг хэрэглэх нөхцөл бүрдсэнээр тодорхой бүс нутаг, чиглэлийн хүрээнд хяналт тавих боломжтой болсон гэж үзэж болно.⁹⁹ Мэргэжилтнүүдийн тооцоолж байгаагаар 2014 оны байдлаар АНУ-д 160.000 төхөөрөмж хэрэглэгдэж байгаагаас тал хувийг GPS төхөөрөмж эзэлж байгаа бол үлдсэн хувийг RT төхөөрөмж эзэлж байна.¹⁰⁰ Судлаачдын тооцоолж буйгаар АНУ-д жил бүр 300.000 орчим хүнд энэхүү ялыг хэрэглэж байна.¹⁰¹ Мөн энэхүү тоон дээр 50.000 орчим согтууруулах ундаа, мансууруулах бодис хэмжигч бас нэмэгдэж байна. АНУ-ын агаарын цэргийн хүчин GPS (general positioning system) буюу хиймэл дагуулын тусламжтайгаар байршил тогтоох технологийг бүтээсэн нь 1990-ээд оны үеэс эхлэн иргэний хэрэглээнд нэвтэрч эхэлсэн. Үүнтэй зэрэгцэн зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд GPS технологийг хэрэглэж эхэлжээ. Дэлхийн тойрог замд байгаа хиймэл дагуулын тасралтгүй дохио хүлээн авч дамжуулах технологи дээр суурилан ажилладаг GPS технологийн тусламжтайгаар бүтээгдсэн электрон гавыг зүүсэн хүнийг зөвхөн гэрт нь байрлуулсан төв дамжуулагчийн радиусаар бус, тодорхой замын дагуу бүтэн цагийн хяналт тавих боломж нь энэхүү ялын хэрэглээг шинэ түвшинд гаргасан байна.

Зорчих эрхийг хязгаарлах гэсэн нэр томъёог судлан үзэхэд зорчих гэдэг нь *хүн нэг зүгийг чиглэн зорчих, ийш тийш зорчин явах*, эрхийг хязгаарлах гэдэг нь *эрхийг нь багасгах, хэмжээ тогтоох*¹⁰² гэсэн утгыг илэрхийлж байгаа нь агуулгын хувьд хүний чөлөөтэй зорчих хөдөлгөөнийг хязгаарлах гэж ойлгож болохоор байна.

Энэхүү ялын нэр томъёоны талаар эрх чөлөө хязгаарлах, зорчих эрхийг хасах, гэрийн хорио зэргээр хэд хэдэн нэршлээр томъёологдож байгаа юм. Тухайлбал, Д.Баярсайхан өөрийн бүтээлдээ гэрийн нөхцөлд хорих ял нь 1984 оноос хэрэглэгдэж эхэлсэн бөгөөд шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор тухайн этгээдийн амьдарч буй орон байранд нь хатуу хязгаарлалтын дор хорьж цагдах ял юм¹⁰³ гэж томъёолсон байна. Түүнчлэн англи хэл дээрх electronic monitoring (EM) (цахим хяналт), ankle bracelet (хөлийн гав) radio frequency

⁹⁸ Haverkamp, in: Neue Kriminalpolitik 1999/4, p. 4.

⁹⁹ James Kilgore. Electronic Monitoring Is Not the Answer Critical reflections on a flawed alternative. Urbana-Champaign Independent Media Center A part of the Media Action Grassroots Network (MAG-Net). 2015. p 8.

¹⁰⁰ Interview with George Drake, President of Correct Tech, LLC, September 3, 2014, and July 30, 2015.

¹⁰¹ This includes immigration detention-related uses, juvenile justice, and domestic violence cases that may not involve a parole/probation component.

¹⁰² ШУА. Монгол хэлний их тайлбар толь. 2019.

¹⁰³ Баярсайхан, Д. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2012. 248-249 дэх тал.

(радио долгионы төхөөрөмж) GPS (газар зүйн байршил тодорхойлогч) home confinement (гэрийн хорио) зэрэг олон нэр томьёо өргөн хэрэглэгдэж байгаа юм.

Монгол Улсын хувьд 2015 онд батлагдсан шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ял гэж томьёолж өгсөн. Ялын үндсэн үзэл санаа нь ял шийтгүүлсэн этгээдийг гэрт нь буюу байнга амьдрах газарт нь хөл хорих хэлбэрээр хэрэгжиж байгаа юм. Гэхдээ тухайн ял шийтгүүлсэн ялтан нь цахим гав буюу цахим хяналтын төхөөрөмж бүхий байршлын талаарх дохиог дамжуулах гаднын нөлөөлөлд тэсвэртэй зориулалтын бусаар тайлах, суллах боломжгүй гав (төхөөрөмж)-ыг зүүж байх үүргийг хүлээдэг. Ингээд урьдчилан тогтоосон замаар, тогтоосон цагийн хүрээнд ажил, гэр, сургууль руугаа явах боломжийг олгодог.

Зорчих эрхийг хязгаарлах – электрон хяналтыг хэрэгжүүлж буй байдал:

Электрон хяналтын төхөөрөмж буюу байршил тогтоогч төхөөрөмжийн тусламжтайгаар хяналт тавьж буй орнуудын практикийг судлахад нийтлэг байдлаар хэрэглэж байна. Тухайлбал:

1. Ялын төрөл;
2. Таслан сэргийлэх арга хэмжээний төрөл;
3. Хугацаанаас өмнө буюу тэнсэгдсэн ялтанд хяналт тавих;
4. Хорих ял эдлээд суллагдсан ялтанд хяналт тавих.

Дээрх төрлүүд нь өөр өөрийн онцлогтойгоор шүүхийн болон түүний өмнөх, эсхүл ял эдлүүлэх, үндсэн ялаа эдэлж дууссаны дараах шатыг хамарч хэрэгжиж байгаа боловч нийтлэг талтай байгаа юм. Үүнд:

1. RT болон GPS төхөөрөмжийн тусламжтайгаар хяналтыг хэрэгжүүлдэг;
2. Хяналт нь шүүхийн өмнөх шатны таслан сэргийлэх арга хэмжээ эсхүл зорчих эрхээ хязгаарлуулах ял авсан тодорхой нэг хугацааг хамран хэрэгждэг;
3. Хяналтын нэгдсэн нэг систем, сүлжээнээс хянагддаг;
4. Хяналтын төхөөрөмжийн түрээс, ашиглалтын зардал зэргийг хянагдаж байгаа хүн хариуцдаг зэрэг нийтлэг талууд байгаа юм.

Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлж буй хэлбэр:

Хяналтын төхөөрөмж нь гэрийн хорио гэсэн ойлголттой ямагт хамт хэрэглэгддэг бөгөөд ялтны байршлын талаарх болоод бусад шаардлагатай мэдээллийг илтгэдэг. Уг ялыг сонголтод хэлбэр болгосноор хяналтын төхөөрөмж зүүх, зорчих эрхийг хязгаарлах ял нь илүү өргөн хүрээг хамардаг болсон бөгөөд GPS, дуу хоолойг таних төхөөрөмж, архи согтууруулах ундааг шалгах төхөөрөмж, талбайн хяналтын төхөөрөмж, гар, хөл, бугуйн цахим гав, гэрийн хяналтын төхөөрөмж гэх мэт олон иж бүрдлээс бүрдэж байна.¹⁰⁴

Ерөнхийдөө зорчих эрхийг нь хязгаарласан хүнд цахилгаан хяналтын төхөөрөмжийг ашиглахын тулд тухайн ялтан этгээдэд гаднын нөлөөтэйгөөр тайлагдахгүй, усны болоод тодорхой хамгаалалт бүхий гар, хөлийн цахим гавыг зүүлгэдэг. Уг цахим гав нь тухайн

¹⁰⁴ Gable, Ralph K., and Robert S. Gable. 2005. "Electronic Monitoring: Positive Intervention Strategies." Federal Probation 69(1). Kansas Department of Corrections. 2014. House Arrest—Juvenile Corrections. Olathe, Kan.: Johnson County Department of Corrections.

этгээдийн оршин байгаа газар буюу гэрт нь суурилуулсан хяналтын төхөөрөмжөөр дамжуулж дохиог төв рүү илгээдэг.¹⁰⁵ Гэрийн хяналтын төхөөрөмж нь ялтны гэрийн утасны шугамаар дамжуулан төв компьютер-серверт холбогдсон байдаг ба 24 цагийн турш хяналт тавьж мэдээлэл дамжуулах чадамжтай байдаг.

Идэвхгүй хэлбэрийн хяналт гэдэг нь тухайн ялтанд буюу зорчих эрхээ хязгаарлуулсан хүнд цахим гав хэрэглэхгүйгээр утсаар холбогдож, өөрийн байдлыг тайлагнах, байгаа газар болгоноо илтгэж байхыг шаарддаг. Үүний нөгөө талд идэвхтэй радио долгионы хяналтын асуудал яригддаг. Энэ нь ялтны хөдөлгөөн болоод шилжилт хөдөлгөөн бүрийг цаг тухай бүрд нь дамжуулж үргэлжилсэн мэдээллийг ирүүлж байдаг. Хэрэв тухайн зорчих эрхээ хязгаарлуулсан хүнд зүүсэн гар, хөлийн цахим гаваас ирж буй дохио нь өмнө баталсан зорчих хөтөлбөрөөс гажсан буюу зөвшөөрөгдсөн бүсээс гарсан эсхүл хориглосон газарт зорчсон байвал төв хяналтын системд аюулын дохиог өгдөг. Ингэснээр зохих эрх бүхий байгууллагад нэн даруй зөрчлийн талаар мэдэгдэж, холбогдох хариу арга хэмжээг авдаг. Зорчих эрхийн хязгаарлалт, цахим хяналтын нөхцөлийг зөрчсөн, хяналтын бүсээс гарсан, хориглосон газруудад зорчсон болоод төхөөрөмжийн ашиглалтад санаатайгаар саад хийсэн, салгах, эвдлэхээр оролдсон зэрэг хориотой үйлдэл хийсэн ялтныг зөрчил гаргасан гэж үзэн ял шийтгэл оногдуулдаг¹⁰⁶.

Байрлал тогтоох хяналтын төхөөрөмж буюу GPS төхөөрөмж нь ялтны байрлаж байгаа газрыг харуулсан гурван хэмжээс бүхий дүрс ялгаруулах замаар сансрын хиймэл дагуулын тусламжтай байршлыг тодорхойлдог. Харин идэвхгүй хэлбэрийн GPS төхөөрөмж нь хяналтын төвөөс ирүүлсэн мэдээллийг хадгалж, шилжүүлж байдаг бол идэвхтэй байрлал тогтоох систем нь яг тухайн цаг мөчид ялтан хаана байгаа талаарх мэдээллийг шууд хяналтын төв лүү шилжүүлдэг. Тухайн цаг үеийн байршлын мэдээлэл нь зөрчил гарсан тохиолдолд нэн даруй арга хэмжээ авхуулахаар холбогдох офицер руу нь мэдээлэл өгөх боломжийг олгодог. Мөн уг төхөөрөмж нь ялтан хаана, юу хийсэн, зөвшөөрөөгүй байрлалд байсан талаарх мэдээллээр хангадаг. Энэхүү байрлал тогтоох төхөөрөмжийг ашигласнаар ялтны гэмт хэрэг үйлдэх сэдэл, зан үйл багасаж, хуулийн хэрэгжилтийг сайжруулах замаар эрх чөлөөг (зорчих эрх) хязгаарладаг.¹⁰⁷

Судалгаагаар гэрийн хорионд байх болон хяналтын төхөөрөмж, цахим гавын хяналтад байх хоёрын үр дүн нь адилхан гарсан байна.¹⁰⁸ 300 гаруй насанд хүрээгүй хүмүүсийн дунд явуулсан судалгаагаар гэрийн хорионд байгаа болон хяналтын төхөөрөмжийн хяналтад байгаа хүмүүсийн дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэл, тоо хэмжээ нь адилхан байсан¹⁰⁹ гэсэн байна. 288 насанд хүрээгүй хоригдлоос судалгаа авахад тэдгээрийн

¹⁰⁵ National Law Enforcement and Corrections Technology Center. 1999. Keeping Track of Electronic Monitoring. Washington D.C.: U.S. Department of Justice, National Institute of Justice.

¹⁰⁶ National Law Enforcement and Corrections Technology Center. 1999. Keeping Track of Electronic Monitoring. Washington D.C.: U.S. Department of Justice, National Institute of Justice.

¹⁰⁷ Stephen V., Randy Gaaney, Marcia I. Cohen, Eoin Healy, Martha Yeide, Alan Bekelman, Amanda Bobnis. 2013. Monitoring High-Risk Gang Offenders with GPS Technology: An Evaluation of the California Supervision Program Final Report. Bethesda, MD: Development Services Group.

¹⁰⁸ Bonta, James, Suzanne Wallace-Capretta, and Jennifer Rooney. 2000. "Can Electronic Monitoring Make a Difference? An Evaluation of Three Canadian Programs." *Crime and Delinquency* 46(1):1-75.

¹⁰⁹ Wiebush, Richard G. 1993. "Juvenile Intensive Supervision: The Impact on Felony Offenders Diverted from Institutional Placement." *Crime and Delinquency* 39(1):68-89.

тал хувь нь байнгын хяналтад, үлдсэн тал хувь нь хагас хяналтад байдаг ба хяналтын чанга, сул болон тогтмол, түр зуурын байгаагийн хооронд төдийлөн ялгаа гараагүй ажээ.¹¹⁰

Флорида мужийн Засан сайжруулах газар 1987 оноос эхлэн уг төхөөрөмжийг ашиглаж ирсэн бөгөөд тэдний гаргасан судалгаанд бусад нийгэмшүүлэн засан сайжруулах хөтөлбөрөөс илүүтэйгээр хяналтын төхөөрөмж нь 31 хувиар эрсдэлийг бууруулсан гэсэн дүн гарчээ. GPS төхөөрөмж нь радио долгионы төхөөрөмжөөс илүүтэйгээр үр ашигтай бөгөөд шууд үр дүнг илтгэж, хяналт алдах эрсдэлийг 6 хувиар бууруулсан байна. Хяналтын төхөөрөмж нь биеэ үнэлэх, өмчийн эсрэг, архи согтууруулах удаа хэрэглэсэн зэрэг хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн хүмүүст хэрэглэхэд илүү нөлөө үзүүлдэг байна.¹¹¹

Хяналтын төхөөрөмжийг гэмт этгээдийн эрх чөлөөг хязгаарлах үндсэн ялын төрлөөр ашиглаж болох ба ялтныг ял эдлэх хугацаанд нь гэрийн хорионд ялыг эдлүүлэхдээ ашигладаг. Шүүх хуралдаанаас өмнөх үе шатны хяналтын төхөөрөмжийг хэрэглэх үе шаттай харьцуулахад энэ тохиолдолд шүүхээс тухайн этгээдийн гэм бурууг тогтоож хүртэл оногдуулдаг. Иймд хяналтын төхөөрөмж нь хянахаас илүүгээр хорих шинжтэй байдаг. Хяналтын төхөөрөмж нь ялтныг хохирогчийн эсрэг гэмт үйлдэл хийхээс урьдчилан хянаж, эрх чөлөөнд нь хязгаарлалт тавьж байдаг.

Хяналтын төхөөрөмжийн өөр нэгэн ашиг тус нь байрлал тогтоох төхөөрөмж буюу гар, хөлийн цахим гавыг ашигласнаар гэмт этгээдийн тухайн үед хаана байгаа бодит байрлалыг шууд тогтоох боломжийг олгодог. Ингэж байрлал тогтоосноор урьдчилан төлөвлөж зөвшөөрсөн буюу хөтөлбөрийн дагуух байрлалаар явж байна уу, үгүй юу гэдгийг хянах боломжтой. Мөн тухайн этгээд нь өөрсдийн хийгээгүй гэмт хэргийн төлөө буруутгагдах эрсдэлийг бууруулахаас гадна хохирогч руу халдах, дахин гэмт хэрэг үйлдэх нөхцөл бүрдсэн тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн даруй авах боломжийг бүрдүүлдэг.¹¹² Үүнээс гадна дурдахгүй байж болохгүй нэг нөхцөл байдал нь ялтныг гэр бүлтэйгээ нэгдэх, нийгэмдээ хөл тавьж нийгэмших, нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжих, засрал төлөвшилийг олох боломжийг бий болгодогт оршино.

Цахим хяналтын төхөөрөмж, гавтай байх нь физиологи, сэтгэл санааны сөрөг нөлөөллийг алга болгох, багасгах ашиг тустай хэдий ч цахим хяналтын төхөөрөмжийг өөртөө зүүж авч явах нь сэтгэл зүйн дарамтад оруулах, бусад хүмүүсээс ичих, санаа зовних явдлыг бий болгодог гэж үздэг судлаачид ч байна.

Цахим хяналтын төхөөрөмж буюу GPS төхөөрөмж нь байршлаа мэдээлэх, дохио дамжуулах байдал хязгаарлагдах тохиолдол нь цаг уур, орчны нөхцөл байдал, газар зүйн байршил зэргээс болж дохио сарних, тасалдах, алга болох үзэгдэл өнөөдрийн технологийн үсрэнгүй хөгжилтэй үед ч даван туулж чадаагүй техникийн шинжтэй асуудал хэвээр байгаа юм. Тиймээс хяналтын төхөөрөмж, цахим гав хэрэглэн хяналт тавих, ял шийтгүүлсэн эсхүл цахим хяналтын төхөөрөмжийн хүрээнд батлан даалтад байгаа, ял тэнсэгдсэн ялтны хөдөлгөөнд тогтмол хяналт тавих боломж нь тодорхой хязгаартай гэдгийг хүлээн

¹¹⁰ Development Services Group, Inc. 2014. "Home Confinement and Electronic Monitoring." Literature Review. Washington, DC. Office of Juvenile Justice and Delinquency Prevention. http://www.ojjdp.gov/mpg/litreviews/Home_Confinement_EM.pdf

¹¹¹ Bales, William D., Karen Mann, Thomas G. Blomberg, Gerald G. Gaes, Kelle Barrick, Karla Dhungana, and Brian McManus. 2010. "A Quantitative and Qualitative Assessment of Electronic Monitoring." Tallahassee, Fla.: Florida State University, College of Criminology and Criminal Justice, Center for Criminology and Public Policy Research. <http://www.criminologycenter.fsu.edu/p/pdf/EM%20Evaluation%20Final%20Report%20for%20NIJ.pdf>

¹¹² Sklaver, Stacey L. 2010. "The Pros and Cons of Using Electronic Monitoring Programs in Juvenile Cases." Juvenile Justice Committee Newsletter, No.5. Washington, D.C.: American Bar Association.

зөвшөөрөхөөс өөр аргагүй. Мөн ялтан нь гэрч, хохирогч эсхүл өмнө яллах ажиллагаанд оролцож байсан хүмүүс рүү халдлага хийхэд хамгаалалт хийх, хязгаарлах нөхцөл байдал нь сул байдаг. Зарим тохиолдолд цахим хяналтын төхөөрөмжийг ашигласан нь гэмт хэрэг дахин үйлдэх эрсдэлийг бий болгож байна гэж үздэг судлаачид байгаа юм. Цахим хяналтын төхөөрөмжийн үр нөлөөг сайжруулахын тулд тухайн улсын бүх газрыг хяналтын төхөөрөмж холбогдон ажиллах боломжтой сүлжээтэй (интернэтийн утасгүй сүлжээ болон бусад) болгох, нийгмийн хяналтын сүлжээг сайжруулах шаардлага гардаг.

Эрүүгийн эрх зүй, тэр дундаа ял эдлүүлэх эрх зүйн хүрээнд хяналтын төхөөрөмж, цахим гавыг ашиглах нь ёс зүй, эрх зүйн болон практикт тулгамдсан олон асуудлыг бий болгож байна. Хяналтын төхөөрөмжийн гол ач тус нь тухайн гэмт хэрэг үйлдэн ял шийтгүүлсэн хүнийг засан сайжруулах, засрал хүмүүжлийг олоход нь туслах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой байдаг хэдий ч төхөөрөмж, техник технологиор дамжуулан хязгаарлалт, хараа хяналт тогтоох нь ял шийтгэлтэй адил нөхцөл байдлыг үүсгэдэг хэмээн үздэг судлаачид байна. Ял шийтгэлээс өөр үр нөлөөтэй байсан ч хяналтын төхөөрөмж нь хувь хүний эрх чөлөөнд хязгаарлалтыг тавьдаг.

Зорчих эрхийн хязгаарлалт буюу хяналтын төхөөрөмжийн хяналтад ял эдлээгүй үлдсэн хугацаанд байлгах нь байнгын хяналт, хязгаарлалт багатай орчинд ял эдлүүлж цаашдаа гэр бүл, хамт олны дунд нийгэмдээ дасан зохицох, гэмт хэрэг дахин үйлдэхгүй байх боломжийг нөхцөлдүүлдэг. Жишээлбэл, Шинэ Зеландад явуулсан хяналтын төхөөрөмжийн үнэлгээний талаарх судалгаанд гэрийн хорионд гарсан ялтан нь уг төхөөрөмжид сэтгэл ханамж сайн байгаа бөгөөд шоронд байх үеийн дарамт, шахалт, сүрдүүлгээс хол байх, зайлсхийх боломжийг олгож байна гэжээ.

Аж үйлдвэрлэл, технологийн хөгжил нь хяналтын төхөөрөмжийн хэрэглээний өсөлтөд гол байр суурьтай оролцож байна. Зарим улсад ялтанд хяналтын төхөөрөмжийг суурилуулдаг, хянадаг хувийн хэвшил бий болсон байна. Уг өсөлттэй холбоотойгоор хувийн хэвшилд хяналтын төхөөрөмжийг хэрхэн ашиглах талаар сургалт, үйлчилгээний чанар, тооцоо бүртгэл гэх мэт хяналтын менежментийг сайжруулах үүрэг үүсэж байгааг дурдахгүй байж болохгүй. Мөн уг төхөөрөмжтэй холбоотой санхүүгийн асуудал үүсдэг ба хяналтын төхөөрөмжийг ашиглаж байгаа ялтныг төхөөрөмжийн ашиглалтын болоод хяналтын зардлыг төлөхийг шаарддаг. Энэ нь ихэвчлэн ажиллах тохиромжтой газраа олсон хөдөлмөр эрхэлж байгаа ялтантай холбоотойгоор яригдаж байна. Гэсэн хэдий ч нийгэмшүүлэх хөтөлбөрт хамрагдаж байгаа бүх ялтан засан сайжруулахад гарсан зардлыг төлөх нь зүй ёсны юм. Гэхдээ энэ нь бага орлоготой эсхүл гэр бүлийн орлого багатай хүмүүст хүндээр тусч болзошгүй юм. Өөр нэг асуудал нь хяналтын төхөөрөмж нь үр ашигтай эсэх, шоронд хоригдох хүмүүсийн тоо болон гарах зардлыг бууруулах бодит боломжтой эсэх бөгөөд хяналтын төхөөрөмжийг ашигласнаар шоронд хорихоос илүү зорчих эрхийг хязгаарлах нөхцөлтэйгөөр нийгэмд гаргах нь ялтныг нийгэмшиж, бүгдийг шинээр сайхнаар эхлэхэд дэмжлэг үзүүлж чадаж байгаа юу гэдэг нь гол асуудал болж байгаа юм. Зарим судлаач, хуульч уг төхөөрөмж нь ялтныг нийгэмшүүлж, дахин нийгэмдээ шинээр амьдрах, хөдөлмөр эрхлэхийг дэмжих, өөрийн гэр бүлтэйгээ илүү ойр харилцаатай байх боломж олгож байна. Энэ боломж ялтныг шоронд хорихоос илүүтэйгээр зан авирыг нь өөрчлөхөд илүү дөхөм үзүүлдэг гэсэн байна. Гэсэн хэдий ч үүнд асуудал үүсэж байгаа нь хэрэв гэр бүлийн гишүүд, нийгэмтэй харьцах уг харилцааг хаасан, гэр бүлийн гишүүдтэй уулзах хугацаа тогтоосон бол яах вэ?, дээрх боломж гарах уу? гэдэг дээр асуудал байна гэж харж байгаа хуульчид ч

байгаа юм. Уг асуудлыг хэрхэн зохицуулж, илүү нийгэмших боломжийг олгох талаар цаашид судалгаа шаардлагатай байна.

Эрх зүйн янз бүрийн тогтолцоонд цахилгаан хяналтын төхөөрөмжийн хэрэгжилт өндөр түвшинд амжилттай хэрэгжиж байна. Тухайлбал, Их Британид 80 хувь, Шведэд 90 хувийн гүйцэтгэлтэй, Шинэ Зеландад цахилгаан хяналтын төхөөрөмжийг хэрэглэх гүйцэтгэлийн хувь өндөр байгаа ба дахин гэмт хэрэг үйлдэх хувь буурсан байна.

Үндэсний хууль тогтоомжид зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны талаар туссан байдал:

1. Эрүүгийн хууль:

УИХ-с 1998 онд Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг баталж, хууль тогтоомжийг шинэтгэх ажил эрчимтэй хийгдэн, энэ ажлын хүрээнд анх 2012 онд Хууль зүйн сайдын тушаалаар Эрүүгийн хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдан, хуулийн төсөл УИХ-д 3 удаа өргөн баригдаж, 2 удаа буцаагдсаны эцэст 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр шинэчлэн найруулж, 2017 оны 05 дугаар сарын 11-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулж, 2017 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

Дээрх хуулиар ялын бодлого, тогтолцоонд зарчмын шинжтэй хэд хэдэн өөрчлөлт орсон.

1. Ялын бодлогыг зөөлрүүлэх, ялын олон сонголттой, уян хатан болгох, хорих ялыг эцсийн арга хэмжээ болгон оногдуулах, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ түлхүү оногдуулах зэргээр нийгэм, хамт олон, гэр бүлийн дунд нийгэмшүүлэх;

2. Олон улсын туршлага, зөвлөмж, хөгжингүй зарим улс орны эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг судалсны дүнд зорчих эрхийг хязгаарлах ялын шинэ төрлийг нэмсэн. Ингэснээр хорих ял оногдуулах явдлыг багасгаж, зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр нийгэм, хамт олон, гэр бүлийн дунд нийгэмшүүлэх боломж бүрдэнэ гэж үзсэн.

Зорчих эрхийг хязгаарлах ял нь 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд энэ нэршлээрээ томъёологдсон бөгөөд үүнээс өмнө Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд гэрийн хорио ял, зорчих эрхийг хязгаарлах ял зэрэг нэршлээр орж байжээ.

Эрүүгийн хуульд ялын шинэ төрөл, түүнийг хэрэгжүүлэх, хорих ялыг гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйл, үйлдлийн арга, сэдэл, зохион байгуулалт, оролцооноос хамааран ялгамжтай оногдуулах, түүнчлэн нийгмийн хор аюул бага, болгоомжгүй байдлаар болон анх удаа гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорихоос өөр төрлийн ялаар шийтгэж, тэднийг нийгэмшүүлэх, нийгэм, сэтгэл зүй, гэр бүлийн харилцааны хүрээнд засан хүмүүжүүлэх зорилготойгоор нийтэд тустай ажил хөдөлмөр эрхлүүлэх, шаардлагатай тохиолдолд улс төрийн болон нийгэм, эдийн засгийн эрхэнд хязгаарлалт хийх, зорчих эрхийг хязгаарлах зэргээр эдийн засгийн хувьд чирэгдэл багатай ялыг оногдуулахыг зорьсон байна¹¹³.

Монгол Улсын хувьд шүүхээс хорих ял ихээр оногдуулан, эдлүүлдэг байдлыг өөрчлөх зорилгоор 2015 оны Эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ялыг шинээр

¹¹³ Б.Нямгомбо. “Хорих болон хорихоос өөр төрлийн ялын үр нөлөө, чиг хандлага”. <http://criminology.mn//>.

хуульчилсан бөгөөд ялыг хэрэгжүүлэхэд Цахим хяналт, удирдлагын төв, цахим бугуйвч, түүний техникийн үзүүлэлт, дагалдах тоног төхөөрөмжүүд шаардлагатай байгааг харгалзан бэлтгэл ажлыг хангах үүднээс уг ялыг хэрэгжүүлэх хугацааг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл хойшлуулсан байна.

УИХ-с 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлан 2017 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад “Зорчих эрхийг хязгаарлах ял”-ын талаар дараах байдлаар тусгажээ.

1. Хуулийн 5.5-д “Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг зорчих эрхийг хязгаарлах ял гэнэ” гэж тодорхойлсон байна. Түүнчлэн хуулийн 8.4 дүгээр зүйлд “Шүүх зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж эдлэх ялыг хоёр дахин багасгана” гэжээ.

2. Шүүх тухайн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан ялтныг бусдад аюул учруулах эрсдэлтэй гэж үзвэл тодорхой хүнтэй, бусадтай харилцахыг хориглож болно.

3. Ялтан зорчих эрхийг хязгаарлах ялыг биелүүлээгүй бол ялтны зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацааны нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцож хорих ялаар солино.

4. Шүүхээс гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан дараах байдлаар хорих ялыг хөнгөрүүлж, ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болно:

- хорих ялын дээд хэмжээг гурван жил хүртэл, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол ялаас чөлөөлөх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх;

- хорих ялын дээд хэмжээг таван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол таван жил, түүнээс бага хугацаагаар тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх.

Хорих, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ял эдэлж байх үедээ өөрийн эрүүл мэндэд санаатай хохирол учруулсан хүнийг ялаас чөлөөлөхгүй.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль:

2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр батлагдан мөн оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад “Зорчих эрхийг хязгаарлах ял”-ын талаар дараах байдлаар тусгажээ.

1. Хорих, зорчих эрхийг хязгаарлах ялаас өвчний учир чөлөөлөх:

- эрүүгийн хуулийн 6.13 дугаар зүйлд заасан ял эдлүүлэх боломжгүй байдал үүсвэл прокурор нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын саналыг үндэслэн шинжээчийн дүгнэлт гаргуулна.

- шинжээчийн дүгнэлт, байгууллагын саналд тулгуурласан прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүгч ялтанд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, сэтгэцийн эмгэг судлалын тусгай, эсхүл бусад эмнэлэгт байлгах, эсхүл түүнийг цаашид ял эдлэхээс чөлөөлөх тухай шийдвэр гаргана.

2. Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шийдвэрлэх үндэслэл:

- шүүхийн шийтгэх тогтоол нь түүнийг гаргасан шүүхийн нутаг дэвсгэрийн харьяалалд үл хамаарах өөр орон нутагт биелэгдэж байгаа бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудлыг тогтоол биелүүлж байгаа газрын адил эрхтэй шүүх, хэрэв тийм шүүх байхгүй бол дээд шатны шүүх шийдвэрлэж, шийдвэр гаргасан шүүхэд даруй хүргүүлнэ.

- торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солих, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох, хорих, зорчих эрхийг хязгаарлах ялаас өвчний учир чөлөөлөх асуудлыг уг тогтоолыг ямар шүүх гаргасныг харгалзахгүйгээр тогтоол биелүүлж байгаа газрын шүүх шийдвэрлэнэ.

3. Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шийдвэрлэх журам:

- шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг уг тогтоол гаргасан шүүх тухайн асуудлыг мэдэгдсэнээс хойш 15 хоногийн дотор шийдвэрлэнэ. Ялтан, түүний өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргавал оролцуулна.

- шүүхийн шийдвэрийн хохирол, хор уршиг нөхөн төлүүлэхтэй холбоотой хэсэгт гарсан тодорхой биш асуудлыг шийдвэрлэх шүүх хуралдаанд хохирогчийг оролцуулж болно.

- шүүх ялтанг хорих, зорчих эрхийг хязгаарлах ялаас өвчний учир чөлөөлөх, эмнэлгийн байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ энэ хуулийн Хорин долдугаар бүлэгт заасан журмын дагуу дүгнэлт гаргасан шинжээчийг байлцуулж болно.

- торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солих, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох тухай асуудлыг шийдвэрлэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төлөөлөгчийг оролцуулна.

- хэрэг хэлэлцэх ажиллагааг шүүгчийн мэдээллээр эхлэх бөгөөд шүүх хуралдаанд ирсэн хүмүүсийн хүсэлт, прокурорын дүгнэлтийг сонссоны дараа шүүх шийдвэр гаргана.

- шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл ялтан, түүний өмгөөлөгч давж заалдах гомдол, прокурор эсэргүүцэл бичиж болно.

4. Хорих, зорчих эрхийг хязгаарлах ялаас өвчний учир чөлөөлөх:

- эрүүгийн хуулийн 6.13 дугаар зүйлд заасан ял эдлүүлэх боломжгүй байдал үүсвэл прокурор нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын саналыг үндэслэн энэ хуулийн Хорин долдугаар бүлэгт заасан журмын дагуу шинжээчийн дүгнэлт гаргуулна.

- шинжээчийн дүгнэлт, байгууллагын саналд тулгуурласан прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүгч ялтанд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, сэтгэцийн

эмгэг судлалын тусгай, эсхүл бусад эмнэлэгт байлгах, эсхүл түүнийг цаашид ял эдлэхээс чөлөөлөх тухай шийдвэр гаргана.

- ялаас өвчний учир чөлөөлөх тухай шүүхийн шийдвэр гарсан бол тухайн ялтныг даруй суллана.

- эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэгт заасны дагуу прокурорын дүгнэлтийг үндэслэн ял эдлүүлэх асуудлыг шүүх хянан шийдвэрлэнэ.

- ялаас өвчний учир чөлөөлөх тухай шүүхийн шийдвэр гарсан бол тухайн ялтныг даруй суллана.

- эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэгт заасны дагуу прокурорын дүгнэлтийг үндэслэн ял эдлүүлэх асуудлыг шүүх хянан шийдвэрлэнэ.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль:

2017 оны 6 дугаар сарын 09-ны өдөр батлагдан мөн оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад “Зорчих эрхийг хязгаарлах ял”-ын талаар дараах байдлаар тусгажээ.

1. Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх:

- шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны байнга оршин суугаа болон хөдөлмөр эрхэлж байгаа, эсхүл суралцаж байгаа газрын хаягаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд техникийн болон биечлэн хяналт тавина.

- зорчих эрхийг хязгаарлах ял эдэлсэн хугацааг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болж, ялтанд цахим бугуйвч зүүлгэсэн өдрөөс эхлэн тоолно.

- шийдвэр гүйцэтгэгч ялтанд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журам, хяналтын техник, хэрэгслийг ашиглах, арчлах заавар, журам, ял эдлэх нөхцөл, журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, авах арга хэмжээний талаар тайлбарлаж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна.

2. Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны үүрэг:

- шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлэх;

- шийдвэр гүйцэтгэгч, техникийн ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

- шүүхээс тогтоосон зорчихыг хязгаарласан газарт зорчихгүй байх;

- шийдвэр гүйцэтгэгчид урьдчилан мэдэгдэхгүйгээр оршин суугаа газар, ажлын байраа өөрчлөхгүй байх;

- шийдвэр гүйцэтгэгчийн тогтоосон хугацаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ирэх, ял эдлүүлэхтэй холбогдсон асуудлаар амаар, эсхүл бичгээр, эсхүл цахим хэлбэрээр тайлбар гаргах;

- тогтоосон журмын дагуу зөөврийн хяналтын төхөөрөмжийг биедээ байнга авч явах, бүрэн бүтэн байдлыг нь хангахад шаардлагатай бүх арга хэмжээг авах, хяналтын төхөөрөмжийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

- хувийн бичиг баримтаа биедээ авч явах;

- ял эдэлж дуусмагц хяналтын тоног төхөөрөмжийг шийдвэр гүйцэтгэгчид бүрэн бүтэн хүлээлгэн өгөх.

3. Хяналтын тоног төхөөрөмжийн зардлыг төлөх:

- ялтан гар, хөл болон биеийн бусад хэсэгт зүүж ашиглах хяналтын тоног төхөөрөмжийн зардлыг хариуцан төлөх үүрэгтэй.

4. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлэх журмыг зөрчих, зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солих:

Дараах тохиолдлыг зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журмыг зөрчсөнд тооцно:

- үүргээ биелүүлээгүй;
- техникийн хяналтын тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн, эсхүл тэдгээрийн хэвийн ажиллагааг сарниулсан;
- Зөрчлийн тухай хуульд заасан нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил үйлдэж, шийтгүүлсэн;
- техникийн болон биечилсэн хяналтаас 24 цагаас илүүгүй хугацаагаар санаатайгаар зайлсхийсэн;

Дараах тохиолдлыг зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журмыг ноцтой зөрчсөнд тооцно:

- үүргээ 3 сарын хугацаанд хоёр, түүнээс дээш удаа биелүүлээгүй;
- гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн;
- үүргээ биелүүлээгүй, техникийн хяналтын тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн, эсхүл тэдгээрийн хэвийн ажиллагааг сарниулсан зөрчлийг давтан гаргасан;
- шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, хүч хэрэглэн эсэргүүцсэн, шийдвэр гүйцэтгэгчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан, хохирол учруулахаар заналхийлсэн;
- техникийн, эсхүл биечилсэн хяналтаас 24 цагаас илүү хугацаагаар санаатайгаар зайлсхийсэн.

Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журмыг зөрчсөн ялтанд дахин зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар сануулж, зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэх ярилцлага хийж, тэмдэглэл үйлдэнэ. Ялтан зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх журмыг ноцтой зөрчсөн тохиолдолд зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солино.

5. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмжийг сонгох:

Ахлах шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн шийдвэрийг гүйцэтгэх нөхцөл, тоног төхөөрөмжийг тогтооно. Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг үндэслэн техник хяналт хариуцсан ажилтан суурин болон хөдөлгөөнт хяналтын тоног төхөөрөмжийг ялтны бие, орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл, шаардлагатай бусад газарт суурилуулж, хяналтын тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа болон ялтанд байнгын хяналт тавина.

6. Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд хяналт тавих:

Техникийн хяналтын ажилтан нь мэдээллийн санд ирсэн зөрчлийн дохиог ирсэн даруйд хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэж, хяналтын сангаас зөрчлийн талаарх мэдээллийг хүргүүлнэ. Шийдвэр гүйцэтгэгч техникийн хяналтын ажилтны ирүүлсэн зөрчлийг биечлэн шалгаж, шалтгаан, нөхцөлийг тогтооно. Биечилсэн хяналтыг өдөр, шөнийн аль ч цагт явуулж болно. Шийдвэр гүйцэтгэгч ялтан биечлэн, эсхүл бусдаар

дамжуулан шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн, эсхүл зөрчихийг завдсан талаар хүн, хуулийн этгээдээс мэдээлэл авч болно.

7. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журмыг түр өөрчлөх:

Прокурорын зөвшөөрснөөр ахлах шийдвэр гүйцэтгэгч ялтны зорчих эрхэд тогтоосон хориглолт, хязгаарлалтыг дараах үндэслэлээр 30 хүртэл хоногийн хугацаанд өөрчилж болно:

- ялтны гэр бүлийн гишүүн хүндээр өвчилсөн, нас барсан, гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шаардлагатай тохиолдолд шүүхээс тогтоосон бүсэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжгүй;
- бусдын асрамжид байх шаардлагатай нь эмнэлгийн байгууллагын тодорхойлолт, лавлагаагаар тогтоогдсон ялтнаас өөр асрамжлан хамгаалах хүнгүй гэр бүлийн гишүүнийг асрамжлан хамгаалах шаардлагатай;
- гамшиг, аюулт үзэгдлийн улмаас шүүхээс тогтоосон газар, байршилд байх боломжгүй болсон;
- шүүхээс хориглоогүй тохиолдолд ажилд орох, сургуульд элсэн суралцах шалгалтад шүүхээс тогтоосон газар, байршлаас бусад газарт биечлэн оролцох зайлшгүй шаардлагатай;
- хуулиар тогтоосон төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээнд хамрагдах /тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох/;
- хүндэтгэн үзэх бусад.

Заасан хугацаа дууссан даруйд ялтанд шүүхээс тогтоосон зорчих эрхэд тавьсан хориглолт, хязгаарлалтыг сэргээн тогтоож, ял эдлүүлэх ажиллагааг ердийн журмаар үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. Ялтан шинээр очсон газарт 7 хоногоос дээш хугацаагаар оршин суух шаардлагатай тохиолдолд зорчих эрхийг хязгаарлах ялыг тухайн газарт нь үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

8. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журмыг өөрчлөх:

Прокурор ахлах шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн дараах тохиолдолд ялтны зорчих бүсийг өөрчилж болно:

- ялтны гэр бүлийн байдалд өөрчлөлт орсны улмаас шүүхээс анхлан тогтоосон газарт ял эдлүүлэх боломжгүй болсон;
- ялтны санхүүгийн чадавх, гамшиг, аюулт үзэгдлийн улмаас байнга оршин суугаа газраа өөрчлөх шаардлагатай болсон;
- хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ялтан оршин суух газраа өөрчлөх зорилгоор орон сууц, хашаа байшин худалдан авсан;
- ялтны ял шийтгүүлэх үеийн хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон, эсхүл өөр байгууллага, хуулийн этгээдэд шилжин ажиллах, шилжин суралцах шаардлагатай болсон;
- дээд болон мэргэжлийн боловсролын байгууллагад элсэн суралцах;
- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шаардлагатай тохиолдолд шүүхээс тогтоосон бүсэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжгүй болсон.
- ялтан ял эдлэх бүсээ өөрчлүүлэх тухай үндэслэл бүхий хүсэлтийг бичгээр гаргах бөгөөд ахлах шийдвэр гүйцэтгэгч ялтны хүсэлт, шийдвэр гүйцэтгэгчийн санал, холбогдох материалыг хянаж, 10 хоногийн дотор прокурорт хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

9. Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтныг урамшуулах:

Ялтан ял эдлүүлэх журмыг зөрчөөгүй, өөрийн зан үйл, хувийн байдлаараа ял эдлүүлэх ажиллагаанд саад учруулаагүй бол түүнд 1 сард 5 хүртэл хоногийн шагналын хоног олгож болно.

10. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэхэд ашиглах тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлага:

Ялтан зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэхэд ашиглах тоног төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн, эсхүл хэвийн ажиллагааг нь сарниулсан тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэж, гэм буруутай этгээдээр учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

Дээрх хуулийн зохицуулалтаас дүгнэж үзэхэд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дараах онцлогтой байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 18 дахь хэсэгт зааснаар иргэн " улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно" гэсэн эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож байгаагаар уг ялын цээрлэл нь илэрнэ.

Зорчих эрхийг хязгаарлах ялын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр зүй зохистой, зөв амьдралд ороход туслалцаа үзүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэх зан үйлээс нь татгалзуулах, урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хохирогч, бусад хүнийг хамгаалахад оршино.

Зорчих эрхийг хязгаарлах ял гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэж буй ялын нэг төрөл мөн.

Дээрх тодорхойлолтоос үзэхэд, зорчих эрхийг хязгаарлах ял нь дараах онцлог шинжтэй. Үүнд:

- эрх бүхий байгууллагын хяналтад байх;
- өөрийн оршин суух газраас явахыг хориглох;
- тодорхой газар очихыг хориглох;
- шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих;
- эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих зэрэг болно¹¹⁴.

Эрх бүхий байгууллагын хяналтад байх гэдэг нь ял шийтгүүлсэн ялтны байнга оршин суугаа болон хөдөлмөр эрхэлж байгаа, эсхүл суралцаж байгаа газрын хаягаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага техникийн болон биечлэн хяналт тавих үйл ажиллагааг ойлгоно.

Өөрийн оршин суух газраас явахыг хориглох гэдэг нь өөрийн байнгын оршин суудаг гэж мэдүүлсэн газраас эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй дур мэдэн бүр эсхүл түр хугацаагаар явсан байхыг ойлгоно. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар

¹¹⁴ Г.Гантөмөр, С.Гантулга нар. Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/. УБ., 2020. 380 дахь тал.

зүйлийн 18 дахь хэсэгт "Монгол Улсын иргэн улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй" гэж заасан бөгөөд дээрх эрх чөлөөнд уг ял хориглолтыг тогтоодог онцлогтой.

Тодорхой газар очихыг хориглох гэж шүүх тухайн гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхийн шийтгэх тогтоолд нэрлэн заасан газарт байнга буюу түр хугацаагаар очихыг хязгаарласан ойлголт юм. Тухайлбал, гэмт хэрэг үйлдэгдсэн газар, гэрч, хохирогч, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн эсхүл хэрэг хянан шийдвэрлэхэд оролцсон албан хаагч, хэрэгт хамаарал бүхий бусад хүний байнга буюу түр оршин суудаг орон байр, албан газар, бүс, засаг, захиргааны нэгж зэргийг ойлгоно.

Шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих гэж шүүхийн шийтгэх тогтоолд гэмт хэрэг үйлдсэн хүний зорчиж болохыг зөвшөөрч нэрлэн заасан чиглэлийг ойлгоно. Тухайлбал, ажил хөдөлмөр эрхлэх, сургуульд суралцах, оршин суугаа газар, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх газар зэрэг болно.

Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих гэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 173, 174 дүгээр зүйлд заасан үндэслэл, тохиолдлыг харгалзан зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журмыг түр эсхүл зорчих бүсийг байнга өөрчлөх арга хэмжээг ойлгоно.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан ялтныг бусдад аюул учруулах эрсдэлтэй гэж үзвэл тодорхой хүнтэй, бусадтай харилцахыг хориглож болно" гэж заасан нь уг ялын нэг онцлог гэж үзэж болно. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийг гэр бүлийн гишүүдтэй, хүчиндэх гэмт хэрэг үйлдэгчийг хохирогч, гэрчтэй харилцахыг тодорхой хугацаанд хориглож болно.

Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад баривчлагдсан, цагдан хоригдсон бол баривчлагдсан, хоригдсон нэг хоногийг зорчих эрхийг хязгаарлах ялын нэг хоногоор тооцож уг ялаас хасна.

Шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ялыг 2021 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд дараах 2 хэлбэрээр оногдуулж иржээ. Үүнд:

1. Шүүхээс гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шууд оногдуулах;
2. Хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн солих зэрэг болно.

Нэг. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шууд оногдуулах:

Эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ялыг 240 буюу хөнгөн 121, хүнд 119 гэмт хэрэгт тус тус ногдуулахаар тогтоожээ. Мөн зорчих эрхийг хязгаарлах эсхүл хорих ялын аль нэгийг сонгож хэрэглэхээр хүнд гэмт хэргийн 119, хөнгөн гэмт хэргийн 57 заалтад буюу "Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг", "Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг", "Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг", "Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг" "Авлига, албан тушаалын гэмт хэрэг", "Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг"-т түлхүү ногдуулахаар хуульчилсан байна.¹¹⁵

¹¹⁵ Монгол Улсын Эрүүгийн хууль 2015 он.

Хоёр. Хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн солих:


УИХ-аас 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр батлан, мөн оны 7 дугаар сарын 6-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөж буй Өршөөл үзүүлэх тухай Монгол Улсын хуулийн үйлчлэлийн хүрээнд хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольж иржээ. Хуулийн үйлчлэлд 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 24 цаг 00 минутаас өмнө 2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн, 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 24 цаг 00 минутаас өмнө 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээд хамаарчээ.

Хүснэгт 17. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт:

Он	Гүйцэтгэвэл зохих		Гүйцэтгэсэн		Үлдэгдэл	
	ялтны тоо	хоног	ялтны тоо	хоног	ялтны тоо	хоног
2021	1602	767,211	402	256,811	1200	510,400
2022	3016	1,224,497	1702	744,603	1314	479,894
2023	2834	991,043	1669	592,918	1165	398,125
2024	2787	893,605	1601	523,456	1186	370,149

Эрүүгийн 94 шийдвэр гүйцэтгэгчээс авсан зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдсан асуудлын талаарх асуулгад ял эдлүүлэх нөхцөл, журмыг түр өөрчлөхөд ялтны гэр бүлийн гишүүн гэж заасан нь бусад төрөл саданд нь үйлчилдэггүй гэж 13 буюу 13.8 хувь, ялтан шинээр ажилд орсон тохиолдолд ял эдлүүлэх нөхцөл, журмыг өөрчлөх эрх зүйн зохицуулалт байхгүй гэж 6 буюу 6.4 хувь, шийдвэр гүйцэтгэгч оргон зайлсан ялтныг баривчилсан тохиолдолд саатуулах арга хэмжээ авах эрх зүйн зохицуулалт байхгүй гэж 75 буюу 79.8 хувь хариулжээ.


Зураг 27. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдсан асуудал



Шүүхээс цаашид зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулах байдал ихсэх хандлагатай байгаа нь тухайн ялыг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, хяналтын механизмыг сайжруулах шаардлага урган гарч байгааг харуулж байна. Өнөөдрийн байдлаар

зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтанд хяналт тавихад гар, хөлийн цахим бугуйвч, дагалдах хэрэгсэл /цэнэг хураагч, цэнэглэгч/, бусад хяналтын тоног төхөөрөмж¹¹⁶ гэсэн тоног төхөөрөмжийг ашиглаж байна.

Зураг 28. Ялтанд хяналтын хувийн хэрэг нээж, цахим бугуйвч зүүх ажиллагаа



Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны тоо эрс нэмэгдсэн болон бусад шалтгааны улмаас ялыг хэрэгжүүлэхэд зарим бэрхшээл, хүндрэл үүсэж байна. Үүнд:

1. Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан ялтан нь ял эдлэх хугацаандаа ял эдлүүлэх нөхцөл, журмыг зөрчиж, улмаар дахин гэмт хэрэг үйлдсэн байхад шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ялыг дахин оногдуулж байна.

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд гэр бүл, хамт олныхоо дунд, нийгмээс тусгаарлахгүй ял эдлүүлэх нөхцөл, боломжийг олгож, зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан боловч ялтан ял эдлэхээс оргон зайлах, гэмт хэрэг үйлдсэндээ гэмшиж дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх биш гэмт хэрэг үйлдсэн ч зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулдаг юм байна гэх байдлаар хүлээн авч байна.

¹¹⁶ ХЗХДС-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг А/246 дугаар тушаалаар батлагдсан “Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих тоног төхөөрөмж ашиглах журам ашиглах журам”.

Кейс 1.

“Б” овогтой “П” нь 2021 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 2021/ШЦТ/28 дугаар шийтгэх тогтоолоор ЭХ-ийн 17.12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2, 2.4-д зааснаар 4 сар 26 хоногийн зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлэн ял эдэлж байх хугацаандаа замын хөдөлгөөнд оролцож, Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн холбогдох заалтыг зөрчсөний улмаас зам тээврийн осол гаргаж, хүн дайрч, биед нь хүндэвтэр хохирол учруулсан (ЭХ-ийн 27.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт) гэмт хэрэг үйлдсэн байх тул Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Сум дундын шүүхийн 2022 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 2022/ШЦТ/04 дүгээр шийтгэх тогтоолоор 4 сарын зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж, эдлээгүй үлдсэн 2 сар 23 хоногийн ял дээр тухайн ялыг нэмж, нэгтгэн 6 сар 23 хоногийн зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэжээ.

2. Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан дахин болон өмнө үлдсэн гэмт хэрэгт нь хорих, торгох, нийтэд тустай ажил хийлгэх зэрэг үндсэн ялыг тус тусад нь эдлүүлэхээр шүүх шийдвэрлэсэн тохиолдолд аль ялыг эхэлж эдлүүлэх талаар нэгдсэн ойлголтод хүрэх, шүүхийн шийдвэрт энэ талаар тодорхой заах хэрэгтэй байна.

Кейс 2.

“Я” овогтой “Х” нь Увс аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн 2021/ШЦТ/99 дүгээр шийтгэх тогтоолоор 1 жилийн зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн. Ял эдлэх хугацаандаа Увс аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 2021/ШЦТ/125 дугаар шийтгэх тогтоолоор ЭХ-ийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг үйлдэж, 380 цагийн нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлснийг зэрэгцүүлэн эдлүүлэхээр тогтоосон.

3. Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахдаа хувь хүний зан үйл, ял хэргийн байдал, байнга оршин суух хаяг, төлбөрийн чадвар, хувийн нөхцөл байдал, сүлжээний хамрах хүрээний тархалт зэргийг харгалзан хориглолт хязгаарлалт, бүсийг нарийвчлан тогтоогоогүйгээс ялтанд ялыг эдлүүлэхэд хүндрэл үүсэхээр байна.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчдийн гаргасан санал болон судалгааны дүнд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд дараах тулгамдсан асуудал байна гэж үзлээ.

Асуудал:

1. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг хангахад аймаг, нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсүүдэд ял, албадлагын арга хэмжээ хариуцсан шийдвэр гүйцэтгэгчээс гадна техник, хяналтын ажилтан үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд цаашид бүтэц, орон тооны хувьд бэхжүүлэх шаардлага тулгарч байна.

2. Ялын онцлогоос шалтгаалан шуурхай албаны нэгж, ажилтныг бий болгох шаардлагатай байна. Тус нэгж нь ялтны дундаас дахин гэмт хэрэг үйлдэх, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор биечилсэн хяналтыг тогтмол хугацаанд тавих, байршил хөдөлгөөнд шалгалт хийх, эрэн сурвалжлагдаж байгаа ялтныг эрж хайх, олж тогтоох, баривчлах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа аймаг, нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсүүдэд зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд зориулан улсын төсөвт тусгайлан суулгасан зардал байхгүй байна. Үүнээс үүдэн зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд биечилсэн хяналт тавих, цахим бугуйвч, бусад

техник хэрэгслийг засварлах, шинээр худалдан авах, ялтан болон бусад хамаарал бүхий хүмүүст зориулсан сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах, ялтныг ялаас зайлсхийсэн, завдсан тохиолдолд таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, оргон зайлсан ялтныг эрэн сурвалжилж, олж баривчлах үйл ажиллагаа доголдох магадлалтай байна.

4. Ялтны оршин суух хаягийг олж тогтоон, албадан ирүүлж ялыг хорих ялаар солих асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх хүртэл хугацаанд саатуулах зохицуулалт бий болгох, ял эдлэхээс зайлсхийсэн хугацааг хоногоор нарийвчлан тооцож, ял эдэлсэн хугацаанд тооцохгүй байх, цагдан хоригдож байгаа, баривчлах шийтгэл эдэлж буй ялтны ялыг түдгэлзүүлэх, ял эдлэхээс зайлсхийсэн үйлдлийн үргэлжлэх хугацаа, санаа зорилгыг харгалзан ямар тохиолдолд оргон зайлсанд тооцох, эрүүгийн хариуцлага тооцох эсэхийг тодорхой болгох.

Түүнчлэн зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны хяналтын бүсийг шүүхээс харилцан адилгүй тогтоож байгаа, ял эдлэхээс санаатайгаар зайлсхийсэн ялтныг эрэн сурвалжилж, олж тогтоон баривчилсан тохиолдолд ялыг хорих ялаар солих ажиллагаанд зарим хүндрэл үүсэж байна. Мөн зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл журмыг өөрчлөх, ялтны ялыг хорих ялаар солих асуудлаар прокурорын байгууллагатай нэгдсэн ойлголтод хүрэх шаардлагатай байна.

5. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журмыг өөрчилсөн тохиолдолд сэргээн тогтоох эрх зүйн зохицуулалт тусгагдаагүй байна. Учир нь ШШГТХ-ийн 174-т заасан нөхцөл өөрчлөгдсөн тохиолдолд 174.2-т “ялтан ял эдлэх бүсээ өөрчлүүлэх тухай үндэслэл бүхий хүсэлтийг бичгээр гаргах бөгөөд ахлах шийдвэр гүйцэтгэгч ялтны хүсэлт, шийдвэр гүйцэтгэгчийн санал, холбогдох материалыг хянаж, 10 хоногийн дотор прокурорт хүргүүлэн шийдвэрлүүлнэ” гэсний дагуу аль эрх зүйн зохицуулалтыг баримталж сэргээх талаар хуульд тусгаагүй байна. Практикт 173.2-т заасан “энэ хуулийн 173.1-д заасан хугацаа дууссан даруйд ялтанд шүүхээс тогтоосон зорчих эрхэд тавьсан хориглолт, хязгаарлалтыг сэргээн тогтоож, ял эдлүүлэх ажиллагааг ердийн журмаар үргэлжлүүлэн гүйцэтгэнэ” гэсэн эрх зүйн үндэслэлийг баримтлах боловч энэ зохицуулалт нь өөр агуулгыг илэрхийлж байгаа учир зөрчилд тооцогдох үндэслэл болж байна.

3.2. Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт

Нийтэд тустай ажил хийлгэх ялын зорилго нь ялтны зарим эрх чөлөөг хязгаарлан, бусдыг хүндэтгэх, хууль ёс, дэг журмыг сахин биелүүлдэг болгон хүмүүжүүлэх, амьдралд нь хэрэгтэй ажил хөдөлмөрийн дадлага, туршлага эзэмшүүлэх, ялтныг хөдөлмөрөөр хүмүүжүүлэх замаар дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршдог.

Дэлхий нийтээр хорих ялын нийгэм болон хувь хүнд үлдээх сөрөг үр дагаврыг улам бүр ойлгох болж, гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорих байгууллагад хорихоос өөр байдлаар цээрлүүлэх, засаж хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх арга хэлбэрийг эрэлхийлэх болсны үр дүнд хорихоос өөр төрлийн ялын нэг төрөл болох нийгэмд тустай хөдөлмөр хийлгэх ял буюу албадан ажил, хөдөлмөр хийлгэх ялыг эрүүгийн хариуцлагын хамгийн үр нөлөөтэй арга хэрэгсэлд тооцогдон, ихэнх улс орны эрүүгийн хууль тогтоомжид тусгалаа олж шүүн таслах ажиллагааны практикт өргөн хэрэглэгдэх болсон байна.

Албадан ажил хийлгэх ялыг Европын холбооны 28 улс оронд хэрэглэж байна.¹¹⁷ Албадан ажил хийлгэх ял нь зарим улс орны Эрүүгийн хуульд нийгэмд үйлчлэх ял /community service/ гэсэн нэрээр томьёологдож, хууль тогтоомжид тусгалаа олсон байна.

Уг ялын мөн чанар нь ялтныг хөдөлмөрөөр хүмүүжүүлэхэд оршдог гэж хэлж болно. Албадан ажил хийлгэх ял нь нэр томьёоны хувьд улс орны эрүүгийн хууль тогтоомжид харилцан адилгүйгээр тусгагдан хуульчлагдсан байна. Тухайлбал, Казахстан, Киргизийн Эрүүгийн хуулиудад “нийгмийн ажилд татан оролцуулах”, “нийгэмд үнэ хөлсгүй үйлчлэх”, Гүржийн Эрүүгийн хуульд “нийгэмд ашигтай хөдөлмөр эрхлэх”, Молдавт “нийгмийн тусын тулд үнэ хөлсгүйгээр ажиллах”, Латвид “нийгэм тустай хөдөлмөр хийх”, Францад нийтийн тусын тулд ажиллах”, Канадад “болзолт ял”, ОХУ, Голланд, Украин зэрэг улсад “заавал хийх ял” гэсэн нэрээр тус тус томьёолжээ¹¹⁸.

Хорих ял нь хүнийг нийгэмшүүлэхээсээ илүү улам нийгмээс тусгаарлаж, шоронжих үйл явцыг дэмжин хурдасгаж, гэмт хэрэгтний сэтгэл зүйд нөлөөлж байна гэж үздэг¹¹⁹. Х.И. Албрехт "Шорон бол гэмт хэрэгтнүүдийг бэлтгэдэг их сургууль гэж тэмдэглэсэн байна"¹²⁰. Барууны эрдэмтдийн хийсэн судалгаагаар тухайлбал, Англи Улсад хорих ял эдэлсний дараа болон албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн этгээд дахин гэмт хэрэг үйлдсэн хүний тоо ойролцоо байсан байна гэж тэмдэглэсэн сонирхол татаж байгаа юм¹²¹.

Академич С.Нарангэрэл "Эл ялын агуулга нь ялтнаар үндсэн ажил буюу сургалтаас нь чөлөөт цагт нийгэмд ашигтай ажлыг хөлс цалин олгохгүйгээр хийлгэх явдал юм"¹²² гэж тайлбарласан. Доктор, профессор Д.Баярсайхан “Нийгмийн тустай ажлыг заавал хийлгэх ял нь цаашид боловсронгуй болж хөгжих ялын төрөлд багтдаг бөгөөд орчин үед нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэглээ ач холбогдол, үлэмж дээшилсэн нь энэ ялын хэрэглээ нэмэгдэж,

¹¹⁷Б.Билэгсайхан. Албадан ажил хийлгэх ял бол ял шийтгэлийн өвөрмөц төрөл мөн. УБ 2004. 42 дахь тал; Уголовный кодекс Республики Казахстан СПб., 2001.

¹¹⁸С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол, УБ хот, 2014 он, 181 дэх тал.

¹¹⁹Мөнхбат, Ц. Нийтэд тустай ажил хийлгэх ял. -Уб., 2020. 9 дэх тал

¹²⁰ Дэлхийн ял шийтгэлийн бодлого, чиг хандлага сэдэвт олон улсын эрдэмтдийн уулзалт, хэлэлцүүлгийн материал. Уб., 2015.

¹²¹ Энхнасан, Ж. Албадан ажил хийлгэх ялын асуудал // Шүүх эрх мэдэл. Уб., 2003. 25 дахь тал.

¹²² Нарангэрэл, С. Эрх зүйн толь бичиг. Хоёр дахь хэвлэл. Уб., 2008. 23 дахь тал.

тухайн ялын төрлийн альтернатив нөхцөлийг оновчтой тогтоох явдал зайлшгүй болж, олон улс орны өргөн дэмжлэгийг олж байгаа...”¹²³ гэж тэмдэглэжээ.

Албадан хөдөлмөр эрхлүүлэхтэй холбоотой ял нь Монгол Улсын эрүүгийн эрх зүй, эрүүгийн хууль тогтоомжид уламжлал болон хэрэглэгдэж ирсэн ба харьцангуй үр дүнтэй гэж үнэлэгддэг. Үүний мөн чанар нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан иргэний ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй холбоотой.

Хөдөлмөрийг хүмүүжүүлэх арга хэрэгсэл болгон ашиглах нь хөдөлмөрийн өөрийнх нь нийгмийн мөн чанартай холбоотой гарч ирсэн. Хөдөлмөр гэдэг нь хувь хүнийг төлөвшүүлэх, хөгжүүлэх материаллаг үндэс юм. Хөдөлмөрийн ачаар гэмт хэрэгтэнд нийгэм, хууль ёс, ашиг сонирхолд хүндэтгэлтэй хандах, хөдөлмөрийн ур чадвар эзэмшүүлэх, сахилга хариуцлага, сайн шинж чанаруудыг суулгадаг¹²⁴.

Хууль зүйн доктор, дэд профессор Ц.Мөнхбат нийтэд тустай ажил хийлгэх ял нь зорилго, чиг үүргийн хувьд хүмүүнлэгийн шинжтэй нийгэмшүүлэх агуулга бүхий ял бөгөөд энэ ялыг идэвхтэй хэрэглэж буй улс орнуудын туршлага, эрүүгийн эрх зүйн хандлагаас үзэхэд дор дурдсан онцлог шинжийг өөртөө агуулдаг байна гэж тэмдэглэсэн. Үүнд:

1. Хорихоос өөр төрлийн ялын тогтолцоонд хамгийн түгээмэл хэрэглэгдэхээр хуульчлагдсан ял бөгөөд зорилго нь хүнд биш гэмт хэрэг үйлдсэн этгээдийг засан төлөвшүүлэх нийгэмшүүлэхэд чиглэгдсэн;

2. Энэ ялын нөхцөл, агуулга нь үндсэн ялын төрлөөр сонгох нөхцөлтэй хэрэглэгдэх бөгөөд дотроо олон төрөл байхаар зохицуулагдсан;

3. Нийтэд тустай ажил хийлгэх ял нь тухайн ялтныг нийгэмд ач тустай, нийтийн ашиг сонирхолд нийцэхүйц ажил үүргийг цалин хөлсгүйгээр хөдөлмөрийн тодорхой нөхцөл, дэглэмийн дагуу ногдуулж эдлүүлэхэд чиглэгдсэн;

4. Уг ял нь нийгэм төдийгүй нийтийн ашиг сонирхолд нийцэхүйц үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэхэд чиглэгдсэн байдгаараа харьцангуй үр дүнтэй байдаг;

5. Нийтэд тустай ажил хийлгэх ял нь зарим орнуудад үндсэн ялын чанартайгаар, орлуулах нөхцөлгүйгээр хуульчлагдсан байхад зарим улсад энэ нь онцгой тохиолдолд өөр ялаар орлуулан тооцох нөхцөлтэй байдаг;

6. Энэхүү ялын төрлүүдэд иргэний болон төрийн бус байгууллагуудад хүмүүнлэгийн шинжтэй ажил үүрэг гүйцэтгэх, нийтийн зориулалтын үйлчилгээний болон нийгмийн ажил үүрэг гүйцэтгэх байгууллагуудад ажиллуулах, сургалтын болон мэргэжлийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцох, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газарт ажиллуулах, гал түймэртэй тэмцэх, нийтийг хамарсан гамшгийг арилгах үйлсэд оролцуулах, иргэний болон хүний эрхийн байгууллагатай ажил үүргийн гэрээ хийсний үндсэн дээр тодорхой даалгавар биелүүлж ажиллах, орон нутгийн өөрөө удирдах байгууллагад нийтэд тустай ажил үүрэг гүйцэтгэх г.м олон талт үйл ажиллагаа явуулахад оролцох байдлаар хэрэгждэг;

¹²³ Баярсайхан, Д. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. Уб., 2011. 150 дахь тал.

¹²⁴ Осадчая, Н.Г. Обязательность работы как новый вид наказания в российском уголовном праве : автореф. дис. канд. юрид. наук. Ростов н/д. 1999. С.14.

7. Нийтэд тустай ажил хийлгэх ял нь хугацааны хувьд ихэнхдээ цагаар хэмжигдэх нөхцөлөөр хуульчлагдсан байх ба тухайн ялыг эдлэх явцад хариуцлага болон үр дүнг тусгасан үнэлгээний тодорхой шалгуураар (кредит итгэлцүүрийн нөхцөл, стандарт г.м) ялын дэглэмийг тодорхойлсон байдаг;

8. Уг ялын хэрэглээг шүүхийн төдийгүй нийгмийн бодлогын хэмжээнд судалж, төрийн хүмүүнлэгийн бодлоготой уялдуулж хэрэгжүүлдэг.

Нийтэд тустай ажил хийлгэх ялын эрх зүйн зохицуулалтыг судлан үзвэл Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт нийтэд тустай ажил хийлгэх ялыг үндсэн ялаар хэрэглэнэ гэж заасан байна. Тус хуулийн 5.4 дүгээр зүйлд “гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тусгай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ” гэж тодорхойлсон байна. Тухайн тодорхойлолтоос харахад нийтэд тустай ажил хийлгэх ялын үндсэн шинж нь:

- ажлын хугацааг шүүхээс тогтоодог;
- тухайн ажил нь нийтийн ашиг сонирхлын төлөө байх;
- ажил хийснийх нь төлөө ямар нэгэн ажил хөлс олгодоггүй байхад оршдог байна.

Ялын хугацааны хувьд шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт наймаас дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтоодог.

Эрүүгийн хуулийн 66 заалтад нийтэд тустай ажил хийлгэх ялыг оногдуулахаар заасан байдаг. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 13 бүлгийн 57 зүйлийн 66 заалт буюу 14.7 хувьд нийтэд тустай ажил хийлгэх ял ногдуулж болохоор хуульчилжээ. Нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулахаар заасан гэмт хэргийг зүйл заалтаар нь авч үзвэл: 11.4. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах, 11.5. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах, 13.5. Залилах, 13.6. Бусдын орон байранд хууль бусаар нэвтрэн орох, 13.7. Хууль бусаар нэгжих, хураан авах, битүүмжлэх, 13.8. Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах, 13.9. Хууль бусаар баривчлах, саатуулах, 13.10. Хувь хүний нууцад халдах, 13.11. Хүний хувийн нууцыг задруулах, 13.13. Албадан хөдөлмөрлүүлэх, 14.1. Ялгаварлан гадуурхах, 14.2. Мэдээлэл хайх, хүлээн авахад саад учруулах, 14.3. Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах, 14.4. Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд саад учруулах, 17.3. Залилах, 17.7. Авто тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүй авч явах, 17.8. Эд хөрөнгө устгах, гэмтээх, 20.15. Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах, 21.2. Худал мэдүүлэх зэрэг зүйлд заасан гэмт хэрэгт нийтэд тустай ажил хийлгэх ял ногдуулахаар заасныг онцлох хэрэгтэй. Үүнээс гадна нэлээдгүй зохицуулалт байгааг тэмдэглэх хэрэгтэй. Харин 10 дугаар бүлэг хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 12 дугаар бүлэг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 19 дүгээр бүлэг үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 22 дугаар бүлэг авлигын гэмт хэрэг, 26 дугаар бүлэг цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 28 дугаар бүлэг цэргийн албаны эсрэг гэмт хэрэг, 29 дүгээр бүлэг хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт нийтэд тустай ажил хийлгэх ял ногдуулахгүй онцлогтой байна. Нийтэд тустай ажил хийлгэх ял нь 2017 оноос Монгол Улсын эрүүгийн ялын гүйцэтгэлд хэрэглэгдэж байгаа утга болон агуулгын хувьд албадан ажил хийлгэх ялын боловсронгуй, энэрэнгүй шинжийг агуулсан ялын төрөл юм. Эндээс

харахад шүүх энэ төрлийн ял шийтгэлийг өргөнөөр хэрэглэх хандлагатай байгаа нь харагдаж байна.

Нийтэд тустай ажил хийлгэх ял нь ялтныг олон нийтээс тусгаарлахгүйгээр, гэр орондоо байх боломж олгодог бөгөөд нийтэд тустай ажил хийж, гэм буруугаа цайруулах, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөх боломж олгодог.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд эрүүгийн хуулийг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан Нийтэд тустай ажил хийлгэх ялыг мөн энэ өдрөөс оногдуулж эхэлсэн. Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтийг ял шийтгэл гарцаагүй байх зарчмын хүрээнд бүрэн биелүүлэх шаардлага шийдвэр гүйцэтгэгч төдийгүй ял эдлүүлж байгаа байгууллагад тавигдах болсныг эрх зүйн зохицуулалтаас харж болно.

Эрүүгийн хуульд байгаа тодорхойлолтоос харахад шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр өдөрт бага цагаар удаан хугацааны турш хийлгэх нь гэмт этгээдэд үзүүлж буй ялын цээрлэл мөн юм. Нийтэд тустай ажил хийлгэх ялыг эрүүгийн хуульд “шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт наймаас дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтооно, ялтан нийтэд тустай ажил хийлгэх ялыг биелүүлээгүй бол нийтэд тустай ажил хийлгэх ялын найман цагийн ажлыг нэг хоногоор тооцож хорих ялаар солино, нийтэд тустай ажил хийлгэх ялыг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүнд, биеийн эрүүл мэндэд шууд нөлөөлөхүйц нийтэд тустай ажил хийлгэх ялыг жирэмсэн эмэгтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй хүнд оногдуулахгүй”¹²⁵ гэж заасан байдаг.

Хүснэгт 18. Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт:

Он	Гүйцэтгэвэл зохих		Гүйцэтгэсэн		Үлдэгдэл	
	ялтны тоо	хоног	ялтны тоо	хоног	ялтны тоо	хоног
2020	2114	675,210	1742	156,591	372	419,142
2021	1647	540,117	1364	459,755	283	80,362
2022	1417	488,639	1134	400,525	283	88,114
2023	1420	492,474	1137	406,506	283	85,968
2024	1693	609,014	1145	407,306	548	201,708

Нийтэд тустай ажил хийлгэх ялын хугацааг тоолж эхлэх зохицуулалт нь хорих ял, зорчих эрхийг хязгаарлах ялаас ялгаатай. Жишээ нь, хорих ял эдэлсэн хугацааг шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс, зорчих эрхийг хязгаарлах ял эдэлсэн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болж, ялтанд цахим бугуйвч зүүлгэсэн өдрөөс эхлэн тоолдог бол нийтэд тустай ажил хийлгэх ял эдэлсэн хугацааг ялтан ажил гүйцэтгэж эхэлсэн цагаас эхлэн тооцож, шүүхийн шийдвэрт заасан хугацаа дуусгавар болтол эдлүүлдэг.

Шийдвэр гүйцэтгэгч нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагаанд биечлэн хяналт тавих, ялтны ажлын гүйцэтгэлд хяналт тавих эрх бүхий ажилтан, албан тушаалтнаас тайлбар, тодруулга авах, ажлын цаг ашиглалт, хөдөлмөрийн нөхцөлийг шалгах зэргээр

¹²⁵ Эрүүгийн хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №07.

тогтмол хяналт тавьдаг байна. Ялтныг ажиллуулахаар гэрээ байгуулсан байгууллага шийдвэр гүйцэтгэгчид бүх талын дэмжлэг үзүүлдэг.

Шийдвэр гүйцэтгэгч ялтны ажилласан цагийн бүртгэлийг үндэслэн ялын тооцоог үнэн зөв хийх, ял эдлэхээс зайлсхийсэн нөхцөл байдлыг шалган тогтоох, ялтны хувийн хэргийг хөтлөх үүрэгтэй. Нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг ял шийтгүүлсэн этгээдийг байнга оршин суугаа хаягийн дагуу гүйцэтгэж, тухайн тойргийн шийдвэр гүйцэтгэгч хяналт тавина. Шийдвэр гүйцэтгэгч 7 хоног тутам ялтны ажлыг биечлэн шалгаж, ажлын байрыг шалгасан тэмдэглэлд ялтан болон нийтэд тустай ажлыг хийлгэж байгаа байгууллагын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, баталгаажуулдаг. Нийтэд тустай ажлыг хийлгэж байгаа байгууллага нь ялтны хөдөлмөр эрхлэлт, ажлын цаг, ял эдлэлтийн талаар шийдвэр гүйцэтгэгчид 7 хоног тутам тогтмол мэдээлэх үүрэгтэй.

Асуудал 1. ШШГЕГ-ын даргын 2017 оны 08 дугаар сарын 31- ний өдрийн А/168 дугаар тушаалаар “Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах байгууллагын жагсаалт”-ыг баталсан хэдий ч "нийтэд тустай ажил" гэдэгт ямар ажил, үйлчилгээг хамааруулах, үүнээс алийг нь өсвөр насны хүнээр хийлгэх боломжтой гэдгийг тодорхойлж, нарийвчлан зохицуулаагүй байна.

Улс орнууд нийтэд тустай үйл ажиллагааны төрлүүдийг жагсааж, эсхүл нийтийн тусын тулд чиглэсэн нийтэд тустай үйл ажиллагааг тодорхойлох шалгуурыг гарган хуульчилж байна. Ялангуяа нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгэл хүлээсэн этгээдийн гүйцэтгэх ажил, үйлчилгээ нь хэн нэгэн этгээдийн бизнесийн болон хувийн ашиг сонирхлыг хангахад чиглэвэл уг ялын мөн чанар алдагдахад хүрэх юм. Тиймээс манай улсын хувьд өөрийн хөгжлийн түвшин, үндэсний онцлогт нийцүүлэн нийтэд тустай ажил, үйлчилгээний төрлүүдийг судалж, нийгмийн аль салбар, үйл ажиллагааг хамруулах асуудлыг оновчтой тодорхойлж, зохицуулах нь чухал байна.

Нэг. Аймаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд:

1. Авто замын хөгжлийн газар;
2. Агаарын бохирдлыг бууруулах газар;
3. Архивын газар;
4. Аялал жуулчлалын газар;
5. Байгаль орчны газар;
6. Нийтийн биеийн тамир, спортын хороо;
7. Боловсролын газар;
8. Нийслэлийн Газрын алба;
9. Нийслэлийн хот төлөвлөлтийн, ерөнхий төлөвлөгөөний газар;
10. Гэр хорооллын дэд бүтцийн газар;
11. Дотоод аудитын алба;
12. Залуучуудын хөгжлийн газар;
13. Мал эмнэлгийн газар;

14. Мэдээллийн технологийн газар;
 15. Мэргэжлийн хяналтын газар;
 16. Нийгмийн даатгалын газар;
 17. Нийгмийн халамжийн газар;
 18. Нийтлэг үйлчилгээний газар;
 19. Нийслэлийн бүртгэлийн газар;
 20. Онцгой байдлын газар (нөөцийн албатай);
 21. Өмчийн харилцааны газар;
 22. Статистикийн газар;
 23. Соёл, урлагийн газар;
 24. Татварын газар;
 25. Тээврийн газар;
 26. Хөдөлмөр эрхлэлтийн газар;
 27. Хүнс, хөдөө аж ахуйн газар;
 28. Худалдан авах ажиллагааны газар;
 29. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар;
 30. Улаанбаатар хотын цагдаагийн газар;
 31. Үйлдвэрлэл, инновацийн газар;
 32. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба;
 33. Эрүүл мэндийн газар.
- Хоёр. Сум, дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд:*
1. Боловсролын хэлтэс;
 2. Биеийн тамир, спортын хороо;
 3. Газрын алба;
 4. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс;
 5. Дотоодын аудитын алба;
 6. Замын цагдаагийн хэлтэс;
 7. Мэргэжлийн хяналтын хэлтэс;
 8. Онцгой байдлын хэлтэс;
 9. Статистикийн хэлтэс;
 10. Соёлын ордон;
 11. Татварын хэлтэс;
 12. Улсын бүртгэлийн хэлтэс;

13. Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс;
14. Худалдан авах ажиллагааны алба;
15. Цагдаагийн хэлтэс;
16. Эрүүл мэндийн даатгалын хэлтэс;
17. Эрүүл мэндийн нэгдэл.

Жагсаалтад зарим байгууллагыг ямар үндэслэлээр оруулсан нь ойлгомжгүй байна. Жишээ нь: Статистикийн газар, Мэдээлэл технологийн газар, Худалдан авах ажиллагааны газар, Дотоод аудитын алба гэх мэт.

Мэдээжийн хэрэг эдгээр байгууллагуудад ажиллуулах нь зарим судлаачдын хувьд эргэлзээтэй хэдий ч үндсэн үйл ажиллагаанд оролцуулахгүй, орчны цэвэрлэгээ, тохижилтын ажилд ажиллуулах нь ойлгомжтой юм. Хуульд ялтан ажиллуулах байгууллага бус ялтны хийж гүйцэтгэх ажлын жагсаалтыг батлахаар заасан бол оновчтой байх байсан. Зөвхөн байгууллагуудын жагсаалтыг баталснаар ялтнаар ямар ажил хаана хийлгэх нь тэдгээрийн эрх бүхий албан тушаалтны “эрх мэдэл”-ийн асуудал болохыг үгүйсгэхгүй юм.

ШШГТХ-д "Шүүхийн шийдвэрт тусгайлан заагаагүй тохиолдолд нийтэд тустай ажлын нутгийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагаас баталсан жагсаалтад заасан байгууллагад гүйцэтгэнэ" гэж зааснаас үзэхэд нийтэд тустай ажил хийх байгууллагыг тогтоох эрх хэмжээ нь шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад аль алинд нь хадгалагдаж байна.


Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, хүүхдийн сэтгэцийн хөгжилд харшлахгүй нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулахаар заасан ч өсвөр насны хүний нас, бие, эрүүл мэнд, ёс суртахуун, хүүхдийн сэтгэцийн хөгжилд харшлах эсэхийг тодорхойлох эрх бүхий субъект нь тодорхойгүй байна. Түүнчлэн насанд хүрээгүй этгээдэд шүүхээс оногдуулах нийтэд тустай ажил хийлгэх ял нь насанд хүрсэн этгээдэд оногдуулсантай нэгэн адил хэрэгжих, ялын зохион байгуулалт, үүргийн шинж чанарын хувьд адилхан хэрэгжиж байна. Мөн ял гэдэг утгаараа цээрлүүлэх шинжийг агуулах хэдий ч өсвөр насны хүний хөдөлмөр эрхлэлттэй холбогдсон бусад хууль тогтоомж, хүүхдийн эрхийг хамгаалах хууль, Олон улсын гэрээ конвенцуудын заалтыг харгалзан үзэх зайлшгүй шаардлагатай. Иймээс өсвөр насны хүний нас, бие, эрүүл мэнд, ёс суртахуун, хүүхдийн сэтгэцийн хөгжилд харшлах эсэхийг тодорхойлох эрх бүхий субъектийг тодорхой зааж, тэдгээрийн хийх боломжтой ажлын жагсаалтыг нарийвчлан тогтоон, эдгээр ажлыг сонгож тогтооход эрүүл мэнд, хүүхдийн байгууллагын оролцоог нэмэгдүүлж, зохицуулах нь ач холбогдолтой байна.

Ахлах шийдвэр гүйцэтгэгч ялтны, нийтэд тустай ажил хийлгэх байгууллагыг тогтоох бөгөөд шийдвэр гүйцэтгэгч ажиллуулах байгууллагатай ялтны нэг өдөрт ажиллах цаг, гүйцэтгэх үүрэг, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажлын хувцсаар хангах, ажиллах нөхцөлийг урьдчилан тохиролцож, гэрээ байгуулж шүүхийн шийдвэр, ажил хийлгүүлэх тухай мэдэгдлийн хамт биечлэн хүлээлгэж өгнө.

Эрүүгийн 94 шийдвэр гүйцэтгэгчээс авсан нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдсан асуудлын талаарх судалгаагаар нийтэд тустай ажил гэж ямар ажил байх нь тодорхойгүй, ШШГЕГ-аас нийтэд тустай ажлыг биш, нийтэд тустай ажил хийлгэх байгууллагыг зааж өгсөн гэж 24 буюу 25.5 хувь, ялтан ял эдлэхээс зайлсхийж оргосон

тохиолдолд оргосон үйлдэлд нь шийтгэл оногдуулах эрх зүйн зохицуулалтгүй гэж 18 буюу 19.1 хувь, шийдвэр гүйцэтгэгч оргон зайлсан ялтныг баривчилсан тохиолдолд саатуулах арга хэмжээ авах эрх зүйн зохицуулалт байхгүй гэж 52 буюу 55.3 хувь нь хариулжээ.

Зураг 29. Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдсан асуудал



3.3. Албадлагын арга хэмжээний хэрэгжилт

Нийгмийн хэрэгцээний шалгуур болж эрүүгийн эрх зүйн салбарт хийгдсэн томоохон өөрчлөлтийн илрэл нь Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр шинээр баталсан Эрүүгийн хуулиар ялын тогтолцоонд өөрчлөлт оруулж, шинэ төрлийн ял, албадлагын арга хэмжээг бий болгосон явдал юм.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн долоодугаар бүлэгт “Тэнсэх, албадлагын арга хэмжээ хэрэглэх” гэсэн шинэ бүлгийг хуульчилж өгчээ. Үүнд:

1. Тэнсэх;

2 Албадлагын арга хэмжээний төрөлд:

- Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ;


- Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ;

- Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ;

3. Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах зэргийг энэхүү бүлэгт хамруулан хуульчилсан байна.

Эрүүгийн 94 шийдвэр гүйцэтгэгчээс албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад оролцогчдын 20 буюу 21.3 хувь нь эрх зүйн зохицуулалт шаардлага хангахгүй байгаа тул бүрэн шинэчлэх шаардлагатай гэж үзсэн бол 59 буюу 62.8 хувь нь зарим зүйл заалтыг шинэчлэх шаардлага байна гэжээ. Харин 15 буюу 16 хувь нь одоогийн эрх зүйн зохицуулалт нь шаардлага хангаж байна гэж хариулжээ.

Зураг 30. Албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад өгсөн үнэлгээ:



Нэг. Тэнсэх албадлагын арга хэмжээ:

Олон улсын жишгийг харвал хорих ял оногдуулахаас илүүтэй гэмт хэрэг үйлдсэн хүнтэй хохирол, хор уршиг гэм буруугийн асуудлыг судлан үзсэний үндсэн дээр ялын оронд 20-30 төрлийн албадлага, нөлөөлөх арга хэмжээ авдаг, болохгүй бол хорих ялын асуудал ярьдаг, бусдыг хохироосон бол хохирлыг нь барагдуулж хор уршгийг нь арилгасны дараа оногдуулах ялыг хөнгөрүүлдэг, гэм буруу нь тохирсон ял оногдуулах философи руу

Монголын Эрүүгийн хууль шилжиж байна¹²⁶. Албадлага бол бусдын хүсэл зоригийг үл харгалзан зан үйлд нь гаднаас нөлөөлөх шууд хэрэгсэл билээ¹²⁷.

Тэнсэх, албадлагын арга хэмжээг Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам¹²⁸”, “Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх журам¹²⁹”, “Зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалт явуулах журам¹³⁰”-ыг тус тус үндэслэн хэрэгжүүлнэ.

Хууль тогтоогч тэнсэх арга хэмжээг хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх арга хэмжээг хэрэглэж болохоор Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7 дугаар бүлэг болон 6.7 дугаар зүйлүүдэд заасан байдаг. Тэнсэх, албадлагын арга хэмжээг хэрэглэх тухай Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх талаар дараах байдлаар хуульчилжээ.

Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүн гэмт буруугаа хүлээн зөвшөөрч гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж хор уршгийг арилгасан, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан тухайн зүйл, хэсэг, заалтад заасан хорих ялыг оногдуулахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар тэнсэх юм. Эрүүгийн хуулийн тусгай анги нь 20 бүлэг, 209 төрлийн гэмт хэргийн 424 заалтаас бүрдэж байна. Үүнээс хөнгөн гэмт хэрэгт¹³¹ 289, хүнд гэмт хэрэгт¹³² 135 заалт хамаарна. Хөнгөн гэмт хэрэгт хамаарах 289 заалтаас 84 заалт нь хорих ял оногдуулахаар заагаагүй, хорихоос өөр төрлийн ялтай гэмт хэрэг байх бөгөөд энэхүү 84 заалтаас хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 34 заалт байна. Өөрөөр хэлбэл хорих ял оногдуулахаар заагаагүй 50 хөнгөн гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь хэсэг, мөн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус зааснаар “тэнсэх” албадлагын арга хэмжээг хэрэглэх боломжгүй байна. Учир нь хорих ялтай, хөнгөн гэмт хэргийг л дээр дурдсан үндэслэлээр тэнсэх боломжтой байдлаар зохицуулжээ.

Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүн гэмт буруугаа хүлээн зөвшөөрч гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж хор уршгийг арилгасан, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан тухайн зүйл, хэсэг, заалтад заасан хорих ялыг оногдуулахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар тэнсэж болно. Дурдсан хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, хязгаарлалтыг зөрчсөн бол шүүх тэнссэн шийдвэрийг хүчингүй болгож ял оногдуулахаар хуульчилжээ.

¹²⁶ Г.Оюунболд “Хохирогч хохирч үлддэггүй, хорих ялыг заавал биечлэн эдлүүлдэггүй болно” Itoim. 2016.

¹²⁷ Мөнхбат, Ц. Нийтэд тустай ажил хийлгэх ял. Уб., 2020, 10 дахь тал.

¹²⁸ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн А/240, А/369 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан.

¹²⁹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга нарын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн А/170, А/0138 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан.

¹³⁰ ШШГЕГ-ын даргын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн А/169 дүгээр тушаалаар батлагдсан.

¹³¹ Эрүүгийн хуулийн 2.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг таван жил, түүнээс доош хугацаагаар оногдуулахаар тогтоосон, эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ”.

¹³² Эрүүгийн хуулийн 2.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг хоёр жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар тогтоосон гэмт хэргийг хүнд гэмт хэрэг гэнэ”.

Хүснэгт 19. Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн хүнд тавьж буй хяналтын судалгаа

Он	2020 он	2021он	2022 он	2023 он	2024 он
Нийт	4422	4147	2126	2899	3194
Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	63	20	7	20	14
Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн	55	29	9	22	23

Тэнссэн хугацаанд санаатай гэмт хэрэг үйлдсэн бол шүүх тэнссэн шийдвэрийг хүчингүй болгож Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.8, 6.9 дүгээр зүйлд заасан журмаар ял оногдуулах ба харин болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн бол тухайн гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлсэн байдлыг харгалзан уг албадлагын арга хэмжээг хүчингүй болгох эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

Тэнссэн хугацаанд гэмт хэргийн хохирлыг бүрэн төлж шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж эрхийн хязгаарлалтыг зөрчөөгүй ба цаашил үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагагүй гэж үзвэл прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан хугацааг дуусахаас өмнө ялаас чөлөөлж болно юм. Тэнсэгдсэн хүний гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг төлөх хугацааг шүүх шийдвэрлэнэ гэж хуульчилсан.

Хоёр. Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох:

Эрүүгийн хуулийн 6.12 дугаар зүйлд “хоригдол гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо нөхөн төлж зан байдлаараа нийтэд аюулгүй болсноо нотлон харуулж ял эдлэх хугацаандаа ноцтой зөрчил гаргаагүй, оногдуулсан ялын зохих хувийг эдэлсэн бол прокурорын саналыг харгалзан шүүх хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохоор шийдвэрлэж болно” гэж заасан.

- хохирлоо нөхөн төлсөн гэдэгт хоригдол эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдсэний улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг нөхөн төлсөн байхыг ойлгоно. Хоригдол өөрийн гэм буруугаа ухамсарласан гэмшиж, хохирлоо сайн дураараа албадлага, шахалтгүйгээр төлөх ёстой. Хохирлоо нөхөн төлөх явцад хор уршгийг мөн арилгах үүрэгтэй.

- нийтэд аюулгүй болсноо зан байдлаараа харуулсан гэдэгт гэм буруугаа ухамсарласан, хорих ангийн дотоод журам, албан хаагчийн тавьсан хууль ёсны шаардлага, үүрэг даалгаврыг чандлан биелүүлдэг, сахилгын зөрчил гаргаж байгаагүй, бусад ялтныг хүндэтгэн хүнлэг ёсоор харилцдаг, сургалт, хүмүүжлийн арга хэмжээнд тогтмол оролцдог, мэдлэг, боловсролоо дээшлүүлсэн, эерэг санаачилгатай, ёс суртахууны хэм хэмжээ хэвшиж тогтсон байхыг ойлгоно.

- ноцтой зөрчил гаргаагүй гэдэгт хоригдол хууль тогтоомж, хорих ангид тогтоосон дэглэм, журам, хуулиар хүлээлгэсэн үүргийг зөрчөөгүй, өөрийн болон бусдын эрүүл мэндэд хохирол учруулаагүй, албан хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцээгүй, хорих ангийн хоног, өдрийн цагийн хуваарь зөрчөөгүй, аюулгүйн зурвасыг (албан хаагчийн аюулгүй байдлын хангах үүднээс тогтоосон тодорхой зай) 3-аас дээш удаа даваагүй зэрэг зөрчил

гаргаагүй байхыг ойлгоно.

- ялын тодорхой хувийг биеэр эдэлсэн Эрүүгийн хуульд зааснаар хорих ялаас хугацаанаас өмнө суллах нэг нөхцөл нь шүүхээс оногдуулсан хорих ялын тодорхой хувийг биеэр эдэлсэн байх ёстой. Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтооход шүүхээс оногдуулсан ялын дор дурдсан хувийг эдэлсэн тохиолдолд, дээр дурдсан бусад нөхцөлийг харгалзан хугацаанаас өмнө тэнсэн суллагдах эрх үүснэ. Тухайлбал,

- таван жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын хоёрны нэгээс доошгүй хувийг биеэр эдэлсэн;

- таван жилээс дээш арван хоёр жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын гуравны хоёроос доошгүй хувийг биеэр эдэлсэн;

- арван хоёр жилээс дээш хорин жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын дөрөвний гурваас доошгүй хувийг биеэр эдэлсэн бол хугацаанаас өмнө тэнсэн суллаж, хяналт тогтоож болно.

Хүснэгт 20. Хоригдлыг хугацаанаас өмнө суллах ажиллагааны үе шат

Үе шат	Хийгдэх ажиллагаа	Хэрэгжүүлэх субъект
Хүсэлт гаргах	Хугацаанаас өмнө суллагдах болзол шаардлага хангасан хоригдлын ялын тооцоог гаргана	Хүний тоо бүртгэлийн байцаагч
	Хугацааны өмнө суллагдах болзол шаардлага хангасан гэж үзвэл нийгмийн ажилтнаар уламжлуулан ангийн арга зүйн зөвлөлд хугацаанаас өмнө суллагдах талаар хүсэлт гаргана.	Хоригдол
	Хүсэлтийг хүлээн авч ангийн арга зүйн зөвлөлийн даргад хоригдлын ялын тооцоо, суллагдан гараад оршин суух хаягийн тодорхойлолт, суллагдан гараад ажиллах ажлын байрны тодорхойлолт зэргийг танилцуулна.	Нийгмийн ажилтан
Арга зүйн зөвлөлөөр хэлэлцэх	ангийн арга зүйн зөвлөлийн хэлэлцэх асуудлыг төлөвлөж хуралдааны товыг гарган арга зүйн хуралдааныг зохион байгуулна .	Нийгмийн ажилтан
	Арга зүйн зөвлөлийн хурлаар хоригдол суллагдах нөхцөл, шаардлагыг хангасан тухай шийдвэр гарсан тохиолдолд ажлын 3 өдрийн дотор прокурорт дараах материалыг хүргүүлнэ. Үүнд: Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих прокурорт: -хоригдлын өөрийн хүсэлт; -ялын тооцоо; -хоригдлын засрал хүмүүжлийн тодорхойлолт; -сургалтад хамрагдсан тодорхойлолт; -сэтгэл зүйн тодорхойлолт; -арга зүйн хурлын тэмдэглэл; -суллагдан гараад оршин суух хаягийн тодорхойлолт; -суллагдан гараад хийх ажлын байрны тодорхойлолт; -хоригдлын үндсэн хувийн хэрэг.	Арга зүйн зөвлөлийн дарга
Прокурорын хяналт	Тухайн материалыг ажлын 10 хоногийн дотор хянан үзэж суллах үндэслэлтэй гэж үзвэл хугацаанаас өмнө суллагдах хоригдлын материалыг прокурорын дүгнэлтийн хамт шүүхэд	Прокурор

	хүргүүлнэ.	
Шүүхээр шийдвэрлэх	Шүүх ажлын 3 хоногийн дотор материалтай танилцан шүүх хурлаар хэлэлцүүлэн суллах үндэслэлтэй гэж үзвэл хугацааны өмнө суллана.	Шүүгч

Хорих анги нь Эрүүгийн хуульд заасан үндэслэлээр хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох хурлыг 30 хоног тутамд зохион байгуулна. Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоолгох тухай прокурорын дүгнэлтийг шүүх шийдвэрлээгүй бол уг асуудлыг 6 сарын дотор дахин авч хэлэлцэхгүй зохицуулалттай.

Хүснэгт 21. Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон хүний судалгаа

Он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Нийт	2512	2743	1956	2157	2263
Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	9	2	8	12	8
Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн	37	34	39	25	19

Хорих ялаас хугацаанаас нь өмнө суллахдаа эдлээгүй үлдсэн ялын хугацаатай тэнцүү хяналтын хугацаа тогтооно. Суллагдсан хүн хяналтын хугацаанд түүнд хүлээлгэсэн үүргийг зөрчсөн бол прокурорын саналыг харгалзан шүүх хяналт тогтоосон шийдвэрийг хүчингүй болгож, эдлээгүй үлдсэн ялыг эдлүүлэхээр шийдвэрлэнэ.

Хугацаанаас өмнө суллагдсан хүн хяналтын хугацаанд санаатай гэмт хэрэг үйлдсэн бол шүүх эдлээгүй үлдсэн ял дээр шинээр үйлдсэн гэмт хэрэгт оногдуулсан ялыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.9 дүгээр зүйлд заасан хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах үндэслэл, журмаар нэмж нэгтгэн биеэр эдлэх ялын хугацааг тогтооно. Харин хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан хүн хяналтын хугацаанд болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн бол хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах үндэслэл, журмыг хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэдэг.

Асуудал 1. Практикт хорих ялаас хугацааны өмнө суллагдсан этгээдэд тавих хяналт сул, тэдэнд үзүүлэх нийгэмшүүлэх болон халамжийн үйлчилгээний зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт оновчтой бус, хүний нөөцийн хүртээмжгүй байдал тулгамдаж байна.

Олон улсад энэхүү тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хүрээнд хорих ял эдлээд суллагдсан этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх, хяналт тавих үйл ажиллагааг Пробацын алба гүйцэтгэдэг туршлага байна.

Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд “ял шийтгэгдсэн хүнийг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх, нийгмээс тусгаарлахгүйгээр ялын бодлогыг хангах зорилгоор “Цахим хяналтын төв”-ийг байгуулж, “Пробацын тогтолцоог хөгжүүлнэ”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар батлагдсан “ХЗДХС-ын эрхлэх асуудлын хүрээний 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-ний 3 дугаар зүйлийн 1.5 дахь хэсэгт “Пробацын тогтолцоог хөгжүүлэхтэй холбогдсон суурь болон хавсарга судалгаа хийх” зэргээр пробацын тогтолцоог бий болгох чиглэлээрх эрх зүйн

үндсийг бүрдүүлжээ. Иймд олон улсад хэрэглэгдэж буй пробацын үйл ажиллагааны сайн туршлагыг өөрийн орны нийгэм, эдийн засаг, эрх зүйн хөгжил, ял эдлүүлэх, хяналт тавих байгууллагын чиг үүргийг харгалзан оновчтой байдлаар нутагшуулах шаардлага үүссэн гэж үзлээ.

Гурав. Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах:

Анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болохоор хуульчилсан байна. Ялтан хүүхдээ асарч хүмүүжүүлэхээс зайлсхийсэн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шүүгч захирамж гаргаж шийдвэрлэх юм.

Харин дээрх хугацаанд ялтан санаатай гэмт хэрэг шинээр үйлдвэр шүүх хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах журмыг баримтлан ял оногдуулах бөгөөд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон, хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлөх асуудлыг тус тус шийдвэрлэнэ.

Шийдвэр гүйцэтгэгч тогтоолын биелэлтийг хойшлуулсан шийдвэрийг хүлээн авч тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдэд хяналт тавих нөхцөл, журам, эрх, үүргийг нь тайлбарлаж, гарын үсэг зуруулан, хувийн бичиг баримт, онцлог содон тэмдэг, ялтны хувийн байдлын талаарх бусад мэдээллийг хувийн хэрэгт тэмдэглэж, ял эдлэлтийн байдалтай холбоотой бусад баримт бичгийг хавсарган, сахилга, засрал хүмүүжил, шүүхээс даалгасан үүргийн биелэлтийн талаар хяналтын хувийн хэрэгт 30 хоног тутам тэмдэглэл хийж, тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дуусмагц энэ тухай прокурор, цагдаагийн байгууллага болон ял шийтгүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэн ажиллана.

Мөн тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, түүнчлэн ялтныг хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэнийг дуудан ирүүлж, эрх, үүргийг нь танилцуулах, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх талаар шаардлага тавьж, биелэлтийг хангуулах ажиллагааг явуулна.

Хүснэгт 22. Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хүний судалгаа:

Он	2020 он	2021он	2022 он	2023 он	2024 он
Нийт	433	269	157	181	176
Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	1	1	1	-	2
Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн	11	15	3	5	5

Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан болон хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон ялтны бүртгэлийг түүний оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн шүүхийн шийдвэр

гүйцэтгэх алба, нэгдсэн тоо бүртгэлийг хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба хариуцан хөтөлнө¹³³.

Дөрөв. Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ:

Гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, шинж онцлогийг харгалзан тухайн хүнд тодорхой үүрэг хүлээлгэж улмаар хувийн болон бусад эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож буй эрх албадлагын арга хэмжээний төрөл үүрэг хүлээлгэх, хязгаарлах албадлагын арга хэмжээ гэнэ.

Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан хэд хэдэн үүрэг хүлээлгэж, эрхийн хязгаарлалтыг тогтоох юм.

Хүлээлгэх үүрэг нь:

- гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах;
- зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах;
- тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх;
- оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж буй эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх.

Хязгаарлалт нь:

- тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах;
- галт зэвсэг өмчлөх, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох;
- тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглох зэрэг болно.

Дээрх үүрэг болон хязгаарлалтыг шүүх шийтгэх тогтоолоор хүлээлгэх ба зөрчсөн тохиолдолд ял оногдуулах юм.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх уг шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулна” гэж заасныг дээрх байдлаар ойлгож болох бөгөөд энэхүү албадлагын арга хэмжээг дангаар хэрэглэх боломжгүй, Эрүүгийн хуулийн ерөнхий ангид зааж тодорхойлсон ялын төрлүүдтэй хамтатгаж эсхүл тэнсэгдсэн, ял хойшлуулсан хүнд тус тус хэрэглэхтэй холбогдоно. Түүнээс бус тусгайлсан ямар нэг ял оногдуулах асуудал биш юм.

Үүрэг хүлээлгэх, хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан хугацаанд санаатай гэмт хэрэг үйлдсэн бол шүүх уг албадлагын арга хэмжээ авагдсан шийдвэрийг хүчингүй болгож, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.1 дүгээр зүйлд заасан журмаар ял оногдуулахаар Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.3 дугаар зүйлийн 5-д заажээ. Хуулийн дээрх ойлголтыг юуны өмнө Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлд зааснаар хорих ялыг оногдуулахгүйгээр 5 жил хүртэл хугацаагаар тэнсэгдсэн хүнд мөн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг удирдлага болон ял оногдуулна. Нэгэнт шүүх хорих ялыг оногдуулахгүй учраас Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.3 дугаар зүйлийн 5 дахь зааснаар уг албадлагын арга хэмжээ авагдсан хүний санаатай үйлдсэн гэмт хэрэг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.1 дэх хэсэгт зааснаар ял оногдуулж харин хорих ял оногдуулахгүйгээр тэнсэн хэрэгт хорих ялыг нь оноож улмаар Эрүүгийн хуулийн ерөнхий

¹³³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Уб., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24.

ангийн 6.9 дүгээр зүйлийг удирдлага болгон хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял шийтгэх тогтоолоор ял оногдуулах асуудлыг шийдвэрлэх юм.

Харин үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан хугацаанд болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн бол тухайн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан уг албадлагын арга хэмжээг хүчингүй болгох эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Уг албадлагын арга хэмжээний хууль зүйн үр дагавар нь юуны өмнө ямар хугацаагаар хүлээлгэхийг хууль тогтоогч тусгайлан хуульчлагдаагүй ч хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн тохиолдолд тэнсэнтэй байх хугацаа хүртэл, бусад ялтай хамтатган хэрэглэсэн тохиолдолд тухайн ял дуусах хүртэл хугацаанд үргэлжилнэ гэж ойлгож болох юм.

Хууль тогтоогч дээрхийг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

1. Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан гэмт хэргийн хохирлыг бүрэн төлж шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж эрхийн хязгаарлалтыг зөрчөөгүй ба цаашид үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагагүй гэж үзвэл прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх уг хугацаанаас өмнө ялаас чөлөөлж болохоор заасан.

2. Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан хугацаа дууссаны дараа тухайн хүнд ял оногдуулах эсэхийг прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэхээр зааснаас харахад ял оногдуулалгүй тэнсэгдсэн хүнд ял оноох эсэх нь нээлттэй үлдсэн бөгөөд хуулийн энэхүү заалтаас харахад ял оногдуулж ч болох ажээ.

Шүүх ялын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсхүл оногдуулсан ял дээр нэмж албадлагын арга хэмжээг хэрэглэж болно. Албадлагын арга хэмжээг субъектийн хувьд хүнд оногдуулах, хуулийн этгээдэд оногдуулах гэж хэлбэрийн хувьд үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ гэж ангилна.

Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ гэдэг нь Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах, зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах, тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх, оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх талаар үүрэг хүлээлгэж, тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах, галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох, тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглох зэрэг эрхийн хязгаарлалтыг тогтоосон байхыг ойлгоно.

Шийдвэр гүйцэтгэгч албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийг хүлээн авч хувийн хэрэг нээн түүнд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, хязгаарлалтыг биелүүлэх хугацаа, хуваарийг нарийвчлан тогтоож, биелэлтэд нь хяналт тавин ажиллана. Зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүнд шийдвэр гүйцэтгэгч зан үйлд нөлөөлөх сургалтын агуулга, хөтөлбөрийг танилцуулж сургалтыг зохион байгуулна. Албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалтыг тусгай зөвшөөрөл бүхий магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагаар гэрээний

үндсэн дээр гүйцэтгүүлж болно. Шийдвэр гүйцэтгэгч албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд техникийн болон биечилсэн хяналт тавина.

Албадлагын арга хэмжээ авагдсан этгээд дуудсан цагт хүрэлцэн ирэх, шийдвэр гүйцэтгэгчээс тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх, оршин суух газар, ажил, албан тушаал өөрчлөгдсөн тухай болон шаардлагатай бусад мэдээллийг тухай бүр танилцуулах үүрэг хүлээнэ. Сум, дүүргийн Засаг дарга, Цагдаагийн байгууллага албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд шүүхээс даалгасан үүрэг, хязгаарлалтыг биелүүлэх талаар зохих туслалцаа үзүүлж сахилга, засрал хүмүүжлийн байдалд хяналт тавин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай мэдээлэл солилцож хамтран ажиллана. Шийдвэр гүйцэтгэгч албадлагын арга хэмжээ авагдсан этгээд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн талаар хуульд заасан журмын дагуу мэдээллийг авах эрхтэй.

Шийдвэр гүйцэтгэгч хугацаа, хуваарь, шүүхээс хүлээлгэсэн үүргийг зөрчсөн этгээдийн албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгуулж, ял оногдуулах тухай саналыг прокурорт гарган шүүхээр шийдвэрлүүлнэ.

Тав.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ:

Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан, гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг хариуцах чадваргүй болсон нөхцөлд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэнэ. Хэрэг хариуцах чадваргүй байдлыг Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйлд “сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдолын улмаас өөрийн үйлдлийг бодит шинж чанар, аюулгүй байдлыг ухамсарлах, удирдан жолоодох чадваргүй болсныг хэрэг хариуцах чадваргүйд тооцно” хэмээн хуульчилсан бөгөөд эмнэлгийн чанартай арга хэмжээг зөвхөн хэрэг хариуцах чадваргүй хүнд хэрэглэх юм.

Харин сэтгэцийн байдал нь өөртөө, бусдад аюул учруулахааргүй бол шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхгүйгээр сэтгэцийн эрүүл мэндийн холбогдох байгууллагад эмчлүүлэх, асран хамгаалагчид халамжлуулахаар шилжүүлж болохоор заасан. Эдгээрээс үзвэл уг арга хэмжээг эмнэлэгт эмчлүүлэх эсхүл ар гэрийнхний хяналтад шилжүүлэх гэсэн 2 аргыг хэрэглэж болно гэсэн үг.

Хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан дараах тохиолдолд албадлагын арга хэмжээг хэрхэхийг авч үзвэл:

- гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсны улмаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан бол шүүхээс уг албадлагын арга хэмжээг зогсоох тухай шийдвэр гаргана.

- гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай байсан боловч хэрэг шалган шийдвэрлэх үед хэрэг хариуцах чадваргүй болсны улмаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан бол шүүхээс уг албадлагын арга хэмжээг зогсоож ял оногдуулна.

- эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүн хөөн хэлэлцэх хугацаанд эмчлэгдсэн, хэрэг хариуцах чадваргүй байдал нь арилсан бол шүүхээс түүнд оногдуулсан ялаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг авагдсан нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцон хасаж үлдсэн ялыг эдлүүлнэ.

Хэрэг хариуцах чадвартай байхдаа ял шийтгүүлсэн ялтны сэтгэцийн эмгэгийг эмчлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд шүүх амбулаторийн албадан хяналтад эсхүл сэтгэцийн эмгэг судлаачдаар эмчлүүлэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж болно.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг сунгах, өөрчлөх, зогсоох эсэхийг тус тус шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх шийдвэрлэхээр хуульд заажээ. Зөвхөн хэрэг хариуцах чадваргүй хүнд бус хэрэг хариуцах чадвартай хүний хувьд эл арга хэмжээг хэрэглэж болох бөгөөд энэ тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан сэтгэл заслын, донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болох юм.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, хяналт тавихад Эрүүгийн хууль¹³⁴, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль¹³⁵, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль¹³⁶, Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам¹³⁷ бусад холбогдох хууль тогтоомж, энэ журмыг мөрдлөг болгоно. Шүүхээс “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ¹³⁸” хэрэглэх шүүхийн шийдвэр гармагц уг этгээдийг шүүхийн шийтгэх тогтоол, сэтгэцийн эмгэг судлалын шинжилгээний дүгнэлт, бусад холбогдох баримт бичгийн хамт албадан эмчлэх эмнэлэгт хүлээлгэн өгөх үүргийг ШШГБ гүйцэтгэнэ.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх этгээдийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв шүүхийн шийдвэр, сэтгэцийн эмгэг судлалын шинжилгээний дүгнэлт, магадалгааны актын хуулбар, иргэний болон бусад холбогдох бичиг баримтыг үндэслэн хүлээн авч бүртгэл хөтөлж, өвчний түүх нээн эмчилгээг эхлүүлнэ. Эмнэлгийн байгууллага дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

1. Албадан эмчлүүлж байгаа этгээдэд зайлшгүй шаардлагатай шинжилгээ, эмчилгээг цаг тухайд нь хийх;
2. Эмчилгээний явц, үр дүнг үнэн зөв, тодорхой тусгах;
3. Эмчилгээний үр дүн, өвчний шинж байдлыг харгалзан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг сунгах, өөрчлөх, зогсоох эсэх талаар шинжээчийн дүгнэлт гаргуулах;
4. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг цаашид хэрэгжүүлэх шаардлагагүй, эсхүл хугацааг сунгах шаардлагатай тохиолдолд энэ тухай прокурорт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад даруй мэдэгдэх.

Хүснэгт 23. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний судалгаа:

Он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Оны эхэнд	44	37	36	44	38
Нэмэгдсэн	27	16	29	19	18

¹³⁴ Мөн тэнд

¹³⁵ Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017.№24.

¹³⁶ Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2013.№03.

¹³⁷ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн дугаар А-240/А369 дугаар хамтарсан тушаалын хавсралт.

¹³⁸ Эрүүгийн хууль. УБ., 2015. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №07.

Хасагдсан	34	17	21	25	18
-----------	----	----	----	----	----

Албадан эмчлүүлж буй этгээдийн харьяалах нутаг дэвсгэрийн тойргийн шийдвэр гүйцэтгэгч тухайн этгээдийн сэтгэц засралын байдлын талаар сар тутам эмчилж буй байгууллагаас тодорхойлолт авч, хяналтын хувийн хэрэгт хавсаргаж ажиллана.

Зургаа. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ:

Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого¹³⁹-ыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна¹⁴⁰. Шүүх хөрөнгө, орлого хураан авахдаа хураан авах хөрөнгө, орлогыг шийдвэртээ нэг бүрчлэн заана.

Гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн өмчлөлд, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл байсан нь тогтоогдсон бол түүнийг хураан авч хадгалах, устгах, гэмт хэргийн хохирол нөхөн төлөхөд зарцуулна. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого хууль ёсны дагуу хийгдсэн хэлцлийн үндсэн дээр бусдын өмчлөлд шилжсэн бол шүүх тухайн эд зүйлийг үнэлж гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох, хураан авахыг хуулиар хориглоогүй хөрөнгө, орлогоос албадан гаргуулж хохирлыг төлүүлнэ. Тухайн хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдэж олсон болохыг мэдсээр байж авсан болох нь тогтоогдвол шүүх уг эд зүйл, хөрөнгө, орлогыг бусдын өмчлөлд шилжүүлсэн хэлцлийг хүчингүйд тооцож, хөрөнгө, орлогыг хураан авч хохирлыг нөхөн төлүүлнэ.

Шийдвэр гүйцэтгэгч хөрөнгө, орлогыг хураах шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг иргэний шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны журмаар гүйцэтгэх бөгөөд шүүхийн шийдвэрт заасан эд зүйл, хөрөнгийг хариу төлбөргүйгээр албадан хураан авах, улсын орлого болгох зорилгоор төрийн холбогдох байгууллагад шилжүүлэх, худалдан борлуулж олсон орлогыг улсын төсөвт оруулах арга хэмжээнээс бүрдэнэ. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын хэмжээ нь хохирлоос илүү гарсан тохиолдолд улсын төсөвт шилжүүлнэ.

Хүснэгт 24. Хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээ авагдсан хүний судалгаа

Он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Гүйцэтгэвэл зохих	961	1316	1640	1951	2418
Гүйцэтгэсэн	641	808	1161	1067	1367

¹³⁹ “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж Монгол Улсад бол Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан, гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж шууд, шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгслийг ойлгоно.

¹⁴⁰ Эрүүгийн хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №07.

Одоо хяналтад байгаа	320	508	479	884	1051
----------------------	-----	-----	-----	-----	------

Зургаа. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ:

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорихгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэн засаж хүмүүжүүлэх эрх зүйн зохицуулалтыг анх 1961 оны эрүүгийн хуульд тогтоосноос хойш уламжлагдан хадгалагдаж байна. Эдүгээ үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн 8.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хөнгөн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай өсвөр насны хүн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахгүйгээр тэнсэж, нэгээс гурван жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэнэ гэж заасан.

Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулахгүйгээр тэнсээд түүний гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлийн 7.3.2-т заасан гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах, гэмт зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах, тодорхой ажил үүрэг гүйцэтгэх, оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэхийг үүрэг болгосон албадлагын арга хэмжээг хэрэглэж болно. Эдгээр үүргийн заримыг болон бүгдийг биелүүлэхийг шүүх шийтгэх тогтоолоороо даалгаж болно.

Шүүхээс гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутайд тооцсон өсвөр насны хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, дээр дурдсан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн нөхцөлд хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавьж хэрэгжүүлнэ.

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хянан хүмүүжүүлэх хугацаанд хараа хяналтаа байлгаж хүмүүжүүлэх үүргийг:

- тодорхой хамт олон;
- төрийн бус байгууллага;
- эцэг, эх эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн аль нэгний;
- сурган хүмүүжүүлэгч;
- ойрын төрөл садны хүн;
- тодорхой иргэний хүсэлт, зөвшөөрснөөр даалгаж болно.

Хүснэгт 25. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний судалгаа

Он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Нийт	368	318	249	409	452
Шийдвэрийг хүчингүй болгож, ял оногдуулсан	-	1	-	1	1
Дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн	6	5	3	6	8

Хэрвээ хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд засрал олохгүй, шүүхээс даалгасан үүргийг удаа дараа зөрчиж, дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй бол хяналт тавьж байгаа байгууллагын саналыг үндэслэн шүүх сургалт хүмүүжлийн хорих байгууллагад шилжүүлэн ялыг сэргээн эдлүүлж болно.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд үнэхээр засарч хүмүүжсэнээ харуулбал хугацааны өмнө зогсоох асуудлыг хяналт тавьж байгаа байгууллагын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэж болно.

Шүүх хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэм буруутайг тогтоож, ял оногдуулахгүйгээр тэнсэж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэдэг эрх зүйн зохицуулалт тэднийг эрх чөлөөт амьдрал, дассан орчноос нь хөндийрүүлэлгүйгээр нийгэм, хамт олон, гэр бүлийнхний нөлөөлөл, өөрийн ухамсраар засран хүмүүжих итгэл найдвар хүлээлгэж, сурч хөдөлмөрлөх боломж олгож, нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн ялтнуудын муу нөлөөллөөс ангид байлгах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ихээхэн ач холбогдолтой.

3.4. Хуулийн этгээдийг татан буулгах, эрх хасах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх

Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 2.1-д зааснаар “хуулийн этгээд гэж өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдэл”-ийг хэлдэг.

2015 онд батлагдсан эрүүгийн хуульд манай улс удаа хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн хэм хэмжээг тогтоосон. Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1-д “хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл”-ийг эрүүгийн хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэргийн шинжийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа эсхүл хамтран (төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнээр) шийдвэр гаргаж хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл, эс үйлдэхүйгээр бүрэн бүрдүүлсэн байхыг ойлгохоор хуульчилсан.

Хуулийн этгээдийг төлөөлөх эрхтэй дээрх хоёр субъект:

- а) хуулийн этгээдийн нэрийн өмнөөс;
- б) хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргаж, зөвшөөрөл өгч хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэргийг бусдаар үйлдүүлсэн;
- в) хуулийн этгээдэд хуулиар хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй эс үйлдэхүй, заавал биелүүлэх ёстой үүргийг биелүүлэхээс зайлсхийсэн үйлдлээр гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Дээрх үндэслэл, журмын дагуу хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээх тохиолдолд түүний нэрийн өмнөөс, ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргаж, зөвшөөрөл өгсөн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөхгүй. Манай улсын нутаг дэвсгэрт хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэмт хэргийг гадаад улсын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар үйлдсэн бол нэгэн адил хариуцлага хүлээлгэнэ.

Эрх хасах албадлагын арга хэмжээ:

Нэг жилээс найман жил хүртэл хугацаагаар хуулийн этгээдэд нэг, эсхүл хэд хэдэн төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлах, эсхүл эрх хасах албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

Эрх хасах албадлагын арга хэмжээг хуулийн этгээдэд хэрэглэх тохиолдолд түүний аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн дагуу олгогдсон эрхийг шүүхийн шийтгэх тогтоолоор хүчингүй болгон хэрэгжүүлдэг. Эрх хасах албадлагын арга хэмжээ нь эрх хасах ялаас ялгаатай. Эрх хасах албадлагын арга хэмжээг эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн этгээдэд хэрэглэдэг бол эрх хасах ялыг гэм буруутай тодорхой хүнд зөвхөн нэмэгдэл ялын чанартай хэрэглэдэг. Гэмт хэрэг үйлдсэн хүний эзэмшсэн мэргэжлийн дагуу үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг шүүхийн шийтгэх тогтоолоор тодорхой хугацаанд хориглон хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдсэн хүн мэргэжлээрээ ажиллах эрхээ шүүхийн шийтгэх тогтоолд заасан хугацаанд эдлэх боломжгүй болно.

Эрх хасах ялаар шийтгүүлсэн хүний, мөн эрх хасах албадлагын арга хэмжээ хэрэглэсэн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хяналт тавьж хэрэгжүүлнэ. Эрх хасах албадлагын арга хэмжээг шүүх нэмэгдлээр хэрэглэх болсон үндэслэл нь гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлын хувьд хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн түүний эрхэлж байгаа аж ахуйн үйл ажиллагаатай шууд холбоотой, уг гэмт хэргийг үйлдэхэд хүргэсэн шалтгаан, нөхцөл болсон байна. Эрх хасах албадлагын арга хэмжээний хугацаа 1 жилээс найман жил хүртэл байна. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн этгээд хэд хэдэн төрлийн үйл ажиллагаа явуулдаг тохиолдолд түүний нэг буюу хэдэн эрхийг хязгаарлах, эсхүл эрх хасах албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

Хүснэгт 26. Хуулийн этгээдийг татан буулгах, эрх хасах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилт

Он	Гүйцэтгэвэл зохих		Гүйцэтгэсэн		Үлдэгдэл	
	Эрх хасах	Татан буулгах	Эрх хасах	Татан буулгах	Эрх хасах	Татан буулгах
2020	3	-	1	-	2	-
2021	4	-	2	-	2	-
2022	8	-	1	-	7	-
2023	11	-	6	-	5	-
2024	15	-	6	-	9	-

Татан буулгах албадлагын арга хэмжээ:

Татан буулгах гэдгийг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг шүүхийн шийдвэрээр бүр мөсөн зогсоож, улсын бүртгэлээс хасах утгаар ойлгоно. Эрүүгийн хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд ял оногдуулах гэмт хэргийг үйлдсэн хуулийн этгээдэд шүүхийн шийтгэх тогтоолоор татан буулгах албадлагын арга хэмжээ хэрэглэсэн тохиолдолд түүний хөрөнгө, орлогыг хураан авч гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхөд зарцуулж, илүү гарвал улсын төсөвт шилжүүлэхээр шийдвэрлэнэ. Олон охин компани, салбар, төлөөлөгчийн газартай хуулийн этгээдийн аль нэгэн гэмт хэрэг үйлдсэн бол зөвхөн тухайн охин компани, салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгана.

Хуулийн этгээдийг татан буулгасан шүүхийн шийдвэр гарч, хүчин төгөлдөр болсон үеэс Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23-25 дугаар зүйлд заасан журмын дагуу хуулийн этгээдийг татан буулгасныг улсын бүртгэлд бүртгүүлнэ. Улсын бүртгэлийн байгууллага нь татан буугдсан хуулийн этгээдийн мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулснаар хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хассанд тооцно. Татан буулгасан шүүхийн шийдвэрийг эс биелүүлсэн нөхцөлд хэрэгжилтийг ШШГБ хангана.


Хуулийн этгээдийг татан буулгах албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ хөрөнгө, орлогыг хураан авч гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхөд зарцуулж, үлдсэн хөрөнгийг улсын төсөвт шилжүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар нь гэмт хэрэг үйлдсэн бол салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгаж болно.

Хуулийн этгээдийг татан буулгах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг тухайн хуулийн этгээдийг албадан татан буулгаж, улсын бүртгэлээс хассанаар биелэгдсэнд тооцно. Татан буулгах ажлыг албадлагын арга хэмжээ авагдсан хуулийн

этгээдийн төлөөлөл, ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч, бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөллөөс бүрдсэн дөрвөөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй комисс¹⁴¹ зохион байгуулна. Комисс нь уг хуулийн этгээдийг татан буулгах ажлыг Иргэний хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу зохион байгуулж, хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасуулах мэдэгдлийг улсын бүртгэлийн асуудал хариуцсан байгууллагад, аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох мэдэгдлийг уг зөвшөөрлийг олгосон этгээдэд хүргүүлнэ.

Улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах шийдвэрийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль тогтоомжид заасны дагуу гаргаж, нийтэд мэдээлнэ. Татан буугдаж байгаа хуулийн этгээдээс шаардах эрхтэй этгээдийн өргөдлийг хүлээн авах хугацаа нь хуулийн этгээдийг татан буугдсан тухай нийтэд мэдээлснээс хойш 2 сараас багагүй, 6 сараас ихгүй байна. Комисс татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагыг гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, шүүхийн шийдвэрийн дагуу гаргуулах төлбөр, хөдөлмөрийн гэрээний дагуу ажилтанд төлөх хөдөлмөрийн хөлс, хууль тогтоомжид заасны дагуу бусад этгээдтэй хийх тооцоо гэсэн дарааллаар хангана. Хуулийн этгээдэд байгаа мөнгөн хөрөнгө нь шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд Комисс түүний бусад эд хөрөнгийг хуульд заасан журмын дагуу худалдан борлуулж, төлбөрийг барагдуулна.

Зураг 31. Хуулийн этгээдийг татан буулгах, эрх хасах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаарх эрх зүйн зохицуулалтад өгсөн үнэлгээ



Эрүүгийн 94 шийдвэр гүйцэтгэгчээс авсан хуулийн этгээдийг татан буулгах, эрх хасах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаарх эрх зүйн зохицуулалтад оролцогчдын 21 буюу 22.3 хувь нь шаардлага хангахгүй тул бүрэн шинэчлэх шаардлагатай, 24 буюу 25.5 хувь нь шаардлага хангаж байгаа, 49 буюу 52.1 хувь нь зарим зүйл заалтыг шинэчлэх шаардлагатай байгаа талаар илэрхийлсэн байна.

Хуулийн этгээдийн хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ:

Гэмт арга, үйлдлээр хөрөнгө, орлоготой болсон хуулийн этгээдээс бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор шүүхийн шийдвэрээр хөрөнгө, орлогыг албадан

¹⁴¹ Иргэний хуулийн 32.2-т заасны дагуу байгуулагдсан татан буулгах комисс гүйцэтгэнэ.

гаргуулан хэрэгжүүлдэг. Гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдээс албадан гаргуулах хөрөнгө, орлогын хэмжээ бусдад учруулсан хохиролтой тэнцэхүйц байна. Ахлах шийдвэр гүйцэтгэгч албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн хамт хүлээн авч бүртгэлд оруулан албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд хяналтын хувийн хэрэг нээж, ажлын 3 өдрийн дотор тойрог хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид хуваариалан, энэ тухай прокурорт мэдэгдэнэ.

Татан буулгах арга хэмжээнд Улсын бүртгэлийн байгууллагад шүүхийн шийдвэрийг хүргүүлснээр дуусгавар болгох харилцаа байхаар зохицуулах шаардлага байна.


3.5. Хорих ял эдлүүлэх тогтолцоо /дэглэм, зэрэглэлийн эрх зүйн зохицуулалт/

Хорих ял нь иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн зарим эрхийг хуульд зааснаар хязгаарлах хэлбэрээр цээрлэл үзүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг гаргуулахгүй байх, нийгмийн дотор байгаа гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүст урьдчилан сэргийлэх нөлөө үзүүлдэг өргөн хэрэглэгддэг төрийн албадлагын онцгой төрөл юм.

Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь ялын бодлого, зорилгыг хангахад чиглэх ба ялын бодлого нь тухайн улс орны нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүйн хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн дэг журмыг хангах, хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалах чиг үүрэг хэрэгжүүлэхэд төрөөс баримталж буй чиглэл бөгөөд төр, эрүүгийн ялын бодлогоо хариуцлагын оновчтой төрөл, тогтолцоог бий болгох, оногдуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох, түүгээр дамжуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлж байдаг.

Хорих байгууллагын 1005 алба хаагчаас авсан Таны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгагдсан хорих ял эдлүүлэх ажиллагааны зохицуулалтад өгөх үнэлгээ? асуултад 401 буюу 39.9 хувь нь шаардлага хангаж байгаа, 404 буюу 40.2 хувь нь зарим зүйл, заалтыг шинэчлэх шаардлагатай, 132 буюу 13.1 хувь нь журам, зааврын хүрээнд нарийвчлан зохицуулах шаардлагатай, 68 буюу 6.8 хувь шаардлага хангахгүй байгаа тул бүрэн шинэчлэх шаардлагатай гэсэн байна.

Зураг 32. Хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зохицуулалтад өгсөн судалгааны дүн



Өнөөгийн мөрдөж буй Эрүүгийн хуулиар хорих ялыг гэмт хэрэг үйлдсэн хүний эрх чөлөөг 6 сараас 20 жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хязгаарлаж нээлттэй, эсхүл хаалттай хорих байгууллагад эдлүүлнэ гэж заасан. Хэдийгээр хорих ялыг аль болох бага оногдуулах эрх зүйн орчин, үзэл баримтлал буй хэдий ч хоригдлын тоо 4000-аас төдийлөн буурахгүй байна.


Шүүхээс 2021 онд 2336, 2022 онд 2919, 2023 онд 2594 гэмт хэрэг үйлдсэн хүнд хорих ял оногдуулжээ.

д/д	Төрөл, дэглэм	2021		2022		2023	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1.	Нээлттэй	2067	87.5	2635	89.9	2594	92.7
2.	Хаалттай	247	11.5	230	8.2	155	5.5
3.	Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага	19	0.9	46	1.6	46	1.6
4.	Бүх насаар хорих ял	3	0.1	8	0.3	3	0.1
Нийт хорих ял оногдуулсан хүн		2336	100	2919	100	2798	100

Хорих ял эдлүүлэх тогтолцоо нь нээлттэй (энгийн, тусгай зэрэглэл), хаалттай хорих анги (энгийн, тусгай зэрэглэл, тусгай нэгж), сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, цагдан хорих төв, байр, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөс бүрдэж байна.

Хорих байгууллагын 1005 алба хаагчаас авсан Та хорих байгууллагын тогтолцоог хэрхэн хөгжүүлбэл зүйтэй гэж үздэг вэ? гэсэн асуултад бүсийн хэмжээнд 1 хорих анги байх нь зөв гэж 248 буюу 27.7 хувь, аймаг бүр хорих ангитай байх нь зөв 301 буюу 30 хувь, одоогийн тогтолцоо нь зөв 437 буюу 43.5 хувь, хорих анги нүүдлийн хэлбэртэй байх нь зөв гэж 19 буюу 1.9 хувь нь хариулсан.

Зураг 33. Хорих байгууллагын тогтолцооны хөгжлийн талаарх асуулгын дүн



ШШГТХ-ийн 195 дугаар зүйлийн 195.1 дэх хэсэгт “Хорих байгууллага нь нээлттэй, хаалттай хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, цагдан хорих төв, байр, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг /цаашид “хорих анги” гэх/, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөс бүрдэнэ” гэж заасны дагуу манай улсад одоогоор 24 хорих анги, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг, 1 цагдан хорих төв, 18 цагдан хорих байр, 1 сургалт хүмүүжлийн тусгай байгууллага нийт 42 хорих байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 28. Хорих ял эдлүүлэх дэглэм, зэрэглэл тус бүрд ял эдлэх хоригдол

Дэглэм	Зэрэглэл	Ял эдлэх хоригдол
Нээлттэй	Энгийн	- анх удаа гэмт хэрэг үйлдэж 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн; - болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн.
	Тусгай	- 2 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн;


			- хаалттай хорих ангиас болон нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлээс хуульд заасан журмын дагуу нээлттэй хорих ангид үргэлжлүүлэн ял эдлүүлэхээр шилжүүлсэн, урьд өмнө гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан.
Хаалттай	Энгийн		-санаатай гэмт хэрэг анх удаа үйлдэж 4-6 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн; -урьд өмнө хөнгөн гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан 4 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг.
	Тусгай		-6 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн; -урьд өмнө хүнд гэмт хэрэг санаатай үйлдэж хорих ял шийтгүүлж байсан.
		Тусгай нэгж	-бүх насаар хорих ял шийтгүүлсэн.

Хорих ангийн нээлттэй, хаалттай дэглэмийн гол агуулга нь хоригдлыг байнгын ажлын байраар хангах, ял эдлүүлэх орчин нөхцөлийг хүний эрхийг хангахад чиглүүлэн зохион байгуулах зэрэг асуудлыг цогц хэлбэрээр шийдвэрлэх, хоригдлыг нийгэмшүүлэхэд чиглэгддэг. Хорих ангийг тусгаарлагдсан нэгээс илүү зэрэглэлд хувааж, өөр өөр зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол бие биетэйгээ харилцах боломжгүй байдлаар зохион байгуулж болно.

Өнөөгийн хорих ял эдлүүлэх ажиллагааны нэг онцлог нь 100 орчим жил үйлчилж ирсэн жир, чанга, онцгой, гяндан зэрэг хорих байгууллагын төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай болон энгийн, тусгай зэрэглэл гэж нэршлийн хувьд өөрчилсөн явдал байна.

Хорих байгууллагын 1005 алба хаагчаас авсан Та хорих ял эдлүүлэх төрөл, дэглэмийн эрх зүйн зохицуулалтыг хэрхэн үнэлдэг бэ? гэсэн асуултад нээлттэй, хаалттай дэглэм, энгийн, тусгай зэрэглэл нь төдийлөн ялгаагүй байна 367 буюу 36.5 хувь өмнөх хуулийн зохицуулалтаар /жир, чанга, онцгой, гяндан/ байх нь үр дүнтэй гэж 205 буюу 20.4 хувь, хуулийн зохицуулалт нь ойлгомжгүй гэж 76 буюу 7.6 хувь, 357 буюу 35.5 хувь нь сайн зохицуулагдсан гэж хариулсан.

Зураг 33. Хорих ял эдлүүлэх дэглэмийн эрх зүйн зохицуулалтад өгсөн үнэлгээ



Нээлттэй хорих анги:

Нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол 30 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж болох бөгөөд түр хугацааны уулзалт хийх, захидал илгээх, илгээмж авах, утсаар ярих тоог хязгаарлахгүй ба тусгай зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол 7 хоногт нэг удаа түр, 45 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 7 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болох бөгөөд захидал илгээх тоог хязгаарлахгүй. Тус дэглэмд ял эдэлж буй хоригдол нь бусад дэглэмийн хоригдлоос ялгагдах нэг онцлог нь хорих байгууллага өөрийн болон өөрийн хувь нийлүүлсэн, хамтарсан хуулийн этгээдэд, эсхүл бусад хуулийн этгээдтэй гэрээ байгуулан зохих хяналттайгаар хөдөлмөрлүүлэх эсхүл хоригдлыг хүсэлтийг нь үндэслэн хаалттай хорих анги, цагдан хорих байр, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, хорих эмнэлгийн аж ахуйн үйлчилгээнд хөдөлмөрлүүлж болдог. Харин хоригдлын ажил, амралтын цагийг хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу зохицуулах ба Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд зааснаар долоо хоногийн ердийн ажлын цаг 40-өөс илүүгүй, ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8-аас илүүгүй байхаар тогтоожээ.

Нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа хорих ялын 50-иас дээш хувийг эдэлсэн хоригдлыг харуул хамгаалалтгүй ажиллуулж болох ба энэ тохиолдолд 5.4х8.6 см хэмжээтэй үнэмлэх олгох ба түүнд хоригдлын овог нэр, зураг, хорих ангийн дугаар, хаана, ямар газар ажиллах болон хугацааг зааж, хорих ангийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. Харин харуул хамгаалалтгүй ажиллаж байгаа хоригдол тогтоосон журмыг зөрчвөл хорих ангид татан байрлуулж, үнэмлэхийг хураан, зөрчлийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ. Харуул хамгаалалтгүй ажиллаж буй хоригдол хууль, журам зөрчихгүй байх, зөвшөөрөгдсөн газар, хугацаанд ажиллаж, тогтоосон хугацаанд анги, байрлалд ирэх, хариуцуулсан ажлыг чанар, үр дүнтэй гүйцэтгэн, эд хөрөнгийг бүрэн бүтэн байлгах үүрэг хүлээдэг. Түүнчлэн 50-иас доош хувийг эдэлсэн хоригдлыг хорих ангийн өөрийн үйлдвэрлэл болон хорих ангиас гадуур прокурорын зөвшөөрлөөр гэрээний үндсэн дээр харуул хамгаалалттай хөдөлмөрлүүлэх ба харуул хамгаалалтын зохих шаардлага хангагдаагүй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журам биелэгдээгүй, эсхүл энэ талаар зааварчилга өгөгдөөгүй, эмч болон сэтгэл зүйч хоригдлын биеийн эрүүл мэндийн байдал дордсон, сэтгэл санаа тогтворгүй байгаа тухай тодорхойлолт гаргасан тохиолдолд хөдөлмөрлүүлэхийг хориглоно.

Нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа хоригдлын бусад дэглэмд ял эдэлж буй хоригдлоос эрх зүйн байдлын хувьд ялгагдах зарим онцлогтой байна. Үүнд:

1. Хорих ялын 50-иас доошгүй хувийг эдэлсэн, сахилгын зөрчил гаргаж байгаагүй бөгөөд их, дээд сургууль, коллежийн эчнээ сургалтад суралцах хүсэлт гаргасан бол хорих ангийн даргын саналыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга шийдвэрлэдэг. Энэ тохиолдолд түүний ар гэр, эсвэл өмгөөлөгч нь сургуулийн захиргаатай урьдчилан тохиролцож, сургалтын хорих ангийн байрлалд явуулахыг зөвшөөрөн гэрээ байгуулах ба элсэлтийн болон төгсөлтийн шалгалт өгөх үеийн харуул хамгаалалтыг хорих анги зохион байгуулдаг.

2. Хоригдлын төрөл, садны (эхнэр, нөхөр, хүүхэд, төрсөн болон хадам эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, өвөг эцэг, эмэг эх, нэг ам бүлд хамт амьдардаг ач, зээ) хүн хүндээр өвчилсөн, эсхүл нас барсан, гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсоны улмаас ар гэрт нь үлэмж хор хөнөөл учирсан бол тухайн хоригдлын зан байдал, засрал хүмүүжлийг харгалзан хорих ангийн дарга зам хоногийг оролцуулан 7 хүртэл хоногийн чөлөө олгоно. Чөлөөг олгохдоо

хорих ангийн дарга холбогдох баримт бичгийн бүрдлийг нягталж, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарын гаргасан тодорхойлолтыг үндэслэн тушаал гаргах ба хоригдлын хүчин төгөлдөр гадаад паспортыг хураан авах ба хоригдол чөлөөгөөр явахдаа орон нутаг дахь хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст бүртгүүлэх үүрэг хүлээдэг.

Асуудал 1. Нээлттэй хорих ангийн тухайд хаалттай дэглэмтэй хорих ангиас уулзалт, хөдөлмөрлөх, чөлөө авах эрх зэргээрээ ялгаатай байгаа нь учир дутагдалтай гэж үзэн дэглэм, зэрэглэлийн ялгаатай байдлыг улам тодруулах шаардлага байна гэж үзлээ.

Хаалттай хорих анги:

Хаалттай хорих анги нь энгийн болон тусгай зэрэглэлтэй байна. Тусгай зэрэглэл нь бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ганцаарчлан ял эдлүүлэх тусгай нэгжтэй байна. Хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд санаатай гэмт хэрэг анх удаа үйлдэж 4-6 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн, эсхүл урьд өмнө хөнгөн гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан 4 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг, тусгай зэрэглэлд 6 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн, эсхүл урьд өмнө хүнд гэмт хэрэг санаатай үйлдэж хорих ял шийтгүүлж байсан хоригдлыг ял эдлүүлнэ.

Хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол нь 60 хоногт нэг удаа түр, 90 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 30 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болно.

Хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол 90 хоногт нэг удаа түр, 120 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 60 хоногт нэг удаа илгээмж авч, нэг удаа утсаар ярьж болно.

Хаалттай хорих ангид ял эдэлж байгаа хоригдлыг зөвхөн хорих байгууллагын үйлдвэрлэлд хөдөлмөрлүүлдэг. Нээлттэй хорих ангид ял эдэлж буй хоригдол 1 жилийн хугацаанд хоёр, түүнээс дээш удаа сахилгын зөрчил гаргасан, эсхүл сахилгын ноцтой зөрчил гаргасан тохиолдолд зөвлөл нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлээс тусгай зэрэглэлд, хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлээс тусгай зэрэглэлд, тусгай зэрэглэлээс тусгай нэгжид зэрэглэл хүндрүүлэн шилжүүлэх саналаа прокурорт гаргаж, прокурор 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

Сургалт-хүмүүжлийн байгууллага:

Гэмт хэрэг үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх ба арван дөрвөөс арван зургаа хүртэл насны хүн Эрүүгийн хуулийн тусгай ангийн хүнийг алах-10.1, хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах-11.1, хүчиндэх-12.1, хулгайлах-17.1, дээрэмдэх-17.2, эд хөрөнгө устгах, гэмтээх-17.8, мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах-20.7, олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах-20.16, цахим мэдээлэлд хууль бусаар халдах-26.1, цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах-26.2, хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах-26.3, террор үйлдэх-29.8-т гэсэн гэмт хэрэг үйлдсэн бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Шүүх дээрх хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хорих ял оногдуулж эдлэх ялыг хоёр дахин багасгах ба арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн хүнд бүх насаар хорих ял оногдуулахгүй.

Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хоригдлын ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлэх ба сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын нөхцөлийг хуулиар тогтоодог. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь өсвөр насны эмэгтэй хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх тусгай нэгжтэй байна.

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа өсвөр насны хүнд ерөнхий, мэргэжлийн боловсрол, хөдөлмөрлөх, амьдрах ухааны дадал олгох сургалт зохион байгуулна. Хорих ял эдэлж байгаа өсвөр насны хүнээр хөдөлмөр эрхлүүлэхгүй.

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял эдэлж байсан өсвөр насны хүн арван найман насанд хүрсэн бол түүний эдлээгүй үлдсэн хорих ялыг хорин нэгэн нас хүртэл сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад үргэлжлүүлэн эдлүүлэх, эсхүл насанд хүрэгчдийн хорих байгууллагад шилжүүлэн эдлүүлэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

Ингэхдээ өсвөр насны хоригдол арван найман насанд хүрсэн тохиолдолд ялыг нь хорих ангид шилжүүлэн эдлүүлэх эсэх асуудлаар хоригдлыг арван найман насанд хүрэхээс 3 сарын өмнө сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дарга прокурорт санал гаргах бөгөөд прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

Шүүх хоригдлын эдлээгүй үлдсэн ялын хугацаа 2 жилээс илүүгүй тохиолдолд түүний хувийн байдал, төлөвшлийг харгалзан сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын даргын санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн хорих ялын хугацааг дуусах хүртэл сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад үргэлжлүүлэн ял эдлүүлж болно.

Эмэгтэйчүүдийн хорих анги:

Хорих ял шийтгүүлсэн арван найман насанд хүрсэн эмэгтэй хоригдлын ялыг эмэгтэйчүүдийн нээлттэй, хаалттай хорих ангид эдлүүлнэ. Эмэгтэйчүүдийн хаалттай хорих анги нь энгийн болон тусгай зэрэглэлтэй байна. Үүнд:

- нээлттэй хорих ангид анх удаа гэмт хэрэг үйлдэж 5 жил хүртэл хугацаагаар ял шийтгүүлсэн, эсхүл болгоомжгүй гэмт хэрэг үйлдэж 5 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн эмэгтэй хоригдлыг ял эдлүүлнэ.

- хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд 5 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн, эсхүл урьд өмнө хорих ял шийтгүүлж байсан хоригдлыг ял эдлүүлнэ.

- хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд 10 жил, түүнээс дээш хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгүүлсэн, эсхүл урьд өмнө хүнд гэмт хэрэг хоёр, түүнээс дээш удаа үйлдэж хорих ял шийтгүүлж байсан эмэгтэй хоригдлыг ял эдлүүлнэ.

Эмэгтэйчүүдийн хорих ангийн тухайд ял эдлэх нөхцөл, журмыг хөнгөрүүлсэн нөхцөлөөр тогтоохыг зорьсон бөгөөд нээлттэй хорих ангид ял эдэлж буй хоригдлын илгээмж авах тоог хязгаарлахгүй бөгөөд 7 хоногт нэг удаа түр, 30 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 7 хоногт нэг удаа илгээмж явуулж, утсаар ярих, хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд ял эдэлж буй хоригдол 30 хоногт нэг удаа түр, 60 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 30 хоногт нэг удаа утсаар ярьж, 15 хоногт нэг удаа илгээмж авах, хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдэлж буй эмэгтэй хоригдол 45 хоногт нэг удаа түр, 90 хоногт нэг удаа удаан хугацааны уулзалт хийж, 30 хоногт нэг удаа илгээмж авч, 60 хоногт нэг удаа утсаар ярьж болох эрх зүйн зохицуулалттай.

Харин ял эдэлж байх хугацаандаа хүүхэд төрүүлсэн хоригдлыг хүүхдийг нь хоёр нас хүртэл хамт байлгах ба энэ тохиолдолд илгээмжийн тоонд тавих хязгаарлалт хамаарахгүй

бөгөөд хүүхэд нь хоёр нас хүрсэн боловч эмэгтэй хоригдлын ял эдлэх үлдэгдэл хугацаа 1 жилээс илүүгүй тохиолдолд хорих ял эдлэх хугацааг дуусах хүртэл хүүхдийг үргэлжлүүлэн хамт байлгасан бол хорих анги нь эхийн хамт байгаа хоёр хүртэлх насны хүүхдийг эрүүл өсөж бойжих, аюулгүй орчныг бүрдүүлсэн тусгай байр, нөхцөлөөр хангана.

Хаалттай хорих ангийн тусгай нэгж:

Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжоос харахад бүх насаар хорих ялыг оногдуулах, эдлүүлэх ажиллагаа нь дараах онцлогтой байна. Үүнд:

Нэг. Бүх насаар хорих ялыг эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдсэн хүнд шүүхээс оногдуулна.

Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй 2015 оны эрүүгийн хуульд бүх насаар хорих ял оногдуулах нийт 15 гэмт хэргийг хуульчлан өгчээ. Үүнд: хүнийг алах (ЭХ-ийн 10.1.2), хүчиндэх (ЭХ-ийн 12.1. 4), бэлгийн мөлжлөг, (ЭХ-ийн 12.3.4), хүн худалдаалах (ЭХ-ийн 13.1.3), эх орноосоо урвах (ЭХ-ийн 19.1), төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах (ЭХ-ийн 19.3.2) гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах, (ЭХ-ийн 19.4.2), зэвсэгт үймээн дэгдээх (ЭХ-ийн 19.5), хорлон сүйтгэх (ЭХ-ийн 19.6.2), мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах (ЭХ-ийн 20.7.4), түрэмгийлэл, эсхүл дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх (ЭХ-ийн 29.1), дайны үед хориглосон арга, хэрэгсэл хэрэглэх (ЭХ-ийн 29.4.2), төрлөөр устгах, (ЭХ-ийн 29.5), олон улсын хамгаалалтад байдаг хүнд халдах (ЭХ-ийн 29.7.2), террорист үйлдэл хийх (ЭХ-ийн 29.8) гэмт хэргүүд хамаарч байна.

Хууль тогтоогчоос дээрх гэмт хэргүүд нь нийгмийн хор аюул, хор уршгийн хувьд бусад гэмт хэрэгтэй харьцуулахад асар их байгаад анхаарч бүх насаар хорих ял оногдуулахаар хуульчилсан байна.

2. Бүх насаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй.

Хууль тогтоогч гэмт хэрэг үйлдсэнээс хойш бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй гэж заасан нь эрүүгийн хуульд заасан 14 төрлийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдлыг хассан байна.

3. Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн хүнд бүх насаар хорих ял оногдуулахгүй байхаар тусгасан.

Эрүүгийн хуульд зааснаар гэмт хэрэг үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх ба арван дөрвөөс арван зургаа хүртэлх насны хүн энэ хуулийн тусгай ангийн 10.1 /хүнийг алах/, 11.1 /хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 12.1 /хүчиндэх/, 17.1 /Хулгайлах/, 17.2 /дээрэмдэх/, 17.8 /эд хөрөнгө устгах, гэмтээх/, 20.7 /мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/, 20.16 /олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах/, 26.1 /цахим мэдээлэлд хууль бусаар халдах/, 26.2 /цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах/, 26.3 /хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах/, 29.8 /террор үйлдэх/-т заасан гэмт хэрэг үйлдсэн бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 3.1-д “хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг нь хангахад энэ хууль үйлчилнэ” гэж заасан нь арван найман нас хүрээгүй хүнийг

хүүхэд гэж тооцдогтой холбоотой бөгөөд энэ нь хүмүүнлэг ёсны зарчимтай холбоотой юм.

4. Бүх насаар хорих ялыг хаалттай хорих ангийн тусгай нэгжид ганцаарчлан ял эдлүүлнэ.

Хаалттай хорих ангийн тусгай нэгжид ял эдэлж байгаа хоригдлыг ганцаарчилсан тасалгаанд хорих бөгөөд шаардлагатай гэж үзвэл хорих ангийн дарга прокурортой зөвшилцөн хоригдлыг хоёроор нь хорьж болно. Шаардлагатай гэдэг үндэслэл нь тухайн хоригдолд эрүүл мэндийн туслалцаа хэрэгцээтэй тохиолдолд өөр хоригдолтой цуг байлгах асуудлыг хорих ангийн захиргаа прокурортой зөвшилцөхийг ойлгодог байна.

5. Хоригдлыг тусгай тоноглогдсон газарт, зохих хяналт хамгаалалтад өдөрт 1 цагаас доошгүй хугацаагаар гадаалуулна.

Хоригдлыг гадаалуулах хугацаанд бусад хөдөлгөөнийг түр зогсоож, хорих ангийн төлөөлөгч, ерөнхий жижүүр биечлэн хяналт тавих ба хоригдол гадаалуулах хугацаанд зөрчил гаргавал даруй зогсоодог. Түүнчлэн гадаалуулахын өмнө болон дараа хоригдлын бие, хорих өрөө, тусгай төхөөрөмжлөгдсөн газарт үзлэг, нэгжлэг хийнэ.

6. Хоригдлыг зөвхөн хорих ангийн байранд хөдөлмөрлүүлж болно.

Бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлын хувьд бусад нээлттэй, хаалттай дэглэмд ял эдэлж буй хоригдлын хөдөлмөрөөс ялгадаг онцлог нь зөвхөн хорих өрөө, байрандаа хөдөлмөрлөх боломжтой байдагт оршино.

7. Хоригдол 180 хоногт хоёр удаа түр уулзалт хийж, 30 хоногт нэг удаа захидал явуулж, 90 хоногт нэг удаа илгээмж авч болно.

Хоригдлыг түр хугацааны уулзалт хийх үед түр уулзалтын өрөөнд, шалтай бэхлэгдсэн гавыг хөлд зүүсний дараа, гарыг урд нь гавлаж, харуул хамгаалалтын ажилтны хяналтад уулзуулна.

8. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд 10 жил ял эдэлсэн тохиолдолд хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлж болно.

Дээрх зохицуулалтаас дүгнэхэд, бүх насаар хорих ял гэдгийг хорин таван жилийн хугацаагаар тодорхойлох бөгөөд үүний 10 жилийг хаалттай хорих ангийн (тусгай нэгж) ганцаарчлан эдэлж, үлдсэн хугацааг хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд бусад хоригдлын нэгэн адил хөдөлмөр эрхлэх, эргэлт уулзалтыг ердийн журмаар авах, хугацаанаас өмнө тэнссэн суллагдах эрхээр хангагдах боломжтой байгаа нь НҮБ-аас гаргасан Бүх насаар хорих ялын талаарх зөвлөмжтэй нийцэж байна. ХЭҮК бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлын хувийн хэргээс 6 шүүхийн шийтгэх тогтоолыг түүвэрлэн дүн шинжилгээ хийхэд тогтоох хэсэгт гэм буруутайд тооцож, “бүх насаар хорьсугай” гэж шууд утгаар дурдсан байх бөгөөд хоригдлыг суллах, зэрэглэл бууруулах талаарх хуулийн зохицуулалт, уучлал хүсэх эрхийн талаар тайлбарлаагүй байна¹⁴².

9. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хүн хорин таван жил хоригдсоны дараа шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, ялтны хувийн байдлыг харгалзан суллах эсэхийг шийдвэрлэх ба ялтныг суллаагүй бол хоёр жил тутам энэ

¹⁴² ХЭҮК. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл. Бүх насаар хорих болон ганцаарчлан хорих ял эдлүүлж буй байдал. 2023. 83 дахь тал.


талаар дахин хэлэлцдэг.

Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлд “бүх насаар хорих ял шийтгүүлсэн хүнийг хорин таван жилийн хугацаанд хаалттай хорих байгууллагад тусгаарлан хорих ба тус хугацаа дууссаны дараа шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, ялтны хувийн байдлыг харгалзан суллах эсэхийг шийдвэрлэнэ” гэж, мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 206 дугаар зүйлийн 206.5 дахь хэсэгт “Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд 10 жил ял эдэлсэн тохиолдолд хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлж болно” гэж заажээ. Дээрх зохицуулалтаас дүгнэхэд, бүх насаар хорих ял гэдгийг хорин таван жилийн хугацаагаар тодорхойлох бөгөөд үүний 10 жилийг хаалттай хорих ангийн (тусгай нэгж) ганцаарчлан эдэлж, үлдсэн хугацааг хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд бусад хоригдлын нэгэн адил хөдөлмөр эрхлэх, эргэлт уулзалтыг ердийн журмаар авах, хугацаанаас өмнө тэнссэн суллагдах эрхээр хангагдах боломжтой байгаа нь НҮБ-аас гаргасан бүх насаар хорих ялын талаарх зөвлөмжтэй нийцэж байна¹⁴³.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.9 дүгээр зүйлд зааснаар хорих байгууллага бүх насаар хорих ял шийтгүүлсэн этгээдийг суллуулах саналыг Эрүүгийн хуульд заасан хугацаанаас 1 сарын өмнө прокурорт хүргүүлнэ. Прокурор саналыг хүлээн авч судлан, суллах эсхүл суллахаас татгалзсан талаарх дүгнэлтийг хорих байгууллагын оршин байгаа газрын шүүхэд хүргүүлнэ. Шүүх бүх насаар хорих ял шийтгүүлсэн этгээдийг суллах шийдвэр гаргахдаа ялтны эдлээгүй үлдсэн ялын хугацаатай тэнцүү хяналтын хугацаа тогтооно.

Хорих байгууллагын 1005 алба хаагчаас авсан Та энгийн, тусгай зэрэглэлийн хоорондын ялгааг хэрхэн зохицуулбал зүйтэй гэж үздэг вэ? гэсэн асуултад хорих орчин нөхцөл өөр байх гэж 377 буюу 37.5 хувь, хоригдлын эрх зүйн байдал нь өөр байх гэж 330 буюу 32.8 хувь, хорих ангийн харуул хамгаалалт нь өөр байх 144 буюу 14.3 хувь, хоригдлын хөдөлмөрлөх нөхцөл нь өөр байх гэж 154 буюу 15.3 хувь нь хариулсан.

Зураг 34. Зэрэглэл хоорондын ялгаанд өгсөн санал



Хорих байгууллагын 1005 алба хаагчаас авсан та нэг хорих анги нээлттэй, хаалттай дэглэмтэй байх нь хэрэгтэй гэж үздэг үү? гэсэн асуултад хорих ангийн барилга

¹⁴³ ХЭҮК. Мөн тэнд. 83 дахь тал.

байгууламжийн хүрэлцээ, зориулалт, багтаамжаас шалтгаалан боломжгүй гэж 109 буюу 10.8 хувь нь, хорих анги нэг л дэглэмтэй байх нь зүйтэй гэж 283 буюу 28.2 хувь, шаардлагагүй гэж 84 буюу 8.4 хувь, шаардлагатай гэж 529 буюу 52.6 хувь нь үзсэн.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх үндсэн гол арга нь хорих ял эдлүүлэх дэглэмийн оновчтой тогтолцоо, түүнд тохирсон нөхцөл журмыг зохицуулсан эрх зүйн зохицуулалт байдаг ба Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дэглэм нь төдийлөн ялгаагүй, ялын зорилгыг бүрэн хангахад чиглэхгүй байна. Өөрөөр хэлбэл, дэглэм нь ял эдлэх нөхцөлийн ялгаатай байдал гэж үзвэл хорих орчин нөхцөл, хамгаалалт, нийгэмшүүлэх ажилд хамрагдах байдал, эргэлт уулзалт, эрхийн хязгаарлалт, хөдөлмөрийн нөхцөл зэрэг олон зүйлээр ялгагдаж байх ёстой байна. Хэдийгээр нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжсэн нь дэвшилттэй зохицуулалт болсон боловч тухайн дэглэм, зэрэглэл тус бүрийн ялгааг нарийвчлан тодруулаагүй дутагдалтай тал байна гэж үзлээ.

Европ, Ази, Африк, Австрали, Америк тивийн орнуудын эрүүгийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн эх сурвалжид “хамгаалалтын зэрэглэл” гэсэн нэр томъёог ашигласан байх бөгөөд энэхүү зэрэглэлээр нь нээлттэй, хагас нээлттэй, хаалттай, хагас хаалттай гэх зэргээр хувааж тэдгээрийн агуулгад хоригдолд тавих хяналт, хорих байгууллагын хамгаалалт, хоригдлын эрхийн хязгаарлалт, сайшаал-урамшуулал, албадлага хэрэглэх асуудлууд нэгэн адил хамаардаг байна.

Хорих ялыг хоригдлын амьдарч байсан засаг захиргааны нэгжийн буюу гэр бүлийн гишүүдийнх нь ойролцоо эдлүүлэх нийтлэг зарчимд тулгуурлан гадаад улсуудад хорих ял эдлүүлэх байгууллагын зохион байгуулалтын бүтцийг гибрид буюу хэд хэдэн дэглэм, харуул хамгаалалтын зэрэглэл нэг дор оршин үйлчилж байна. Социалист, постсоциалист улсуудын эрүүгийн болон ял эдлүүлэх хууль тогтоомжид “хорих ял эдлүүлэх дэглэм” гэсэн нэр томъёог хэрэглэж ирсэн бөгөөд түүний нэг зорилгыг өнөөдрийг хүртэл “засан хүмүүжүүлэх” хэмээн тодорхойлж байгаа бол дэлхийн бусад улсад “correction” /засах, эвдэрсэн буруу зан үйлийг өөрчлөх/ болон “rehabilitation” /нийгэмд нь буцаан оруулах бэлтгэл хангах/ хамаарах арга хэмжээг хорих ял эдлүүлэх байгууллага авч хэрэгжүүлж байна.

Олон улсад дэглэмийн ангилал нь дараах хүчин зүйлсээс хамаарч байна. Үүнд:

- хоригдлын үйлдсэн гэмт хэрэг;
- хоригдлын үйлдсэн гэмт хэргийн давтамж;
- хоригдлын өмнө оргож байсан талаарх судалгаа;
- ял эдлэх хугацаа;
- хугацаанаасаа өмнө суллагдах таамаглал;
- өмнө сахилгын шийтгэл хүлээсэн байдал;
- эрсдэлтэй (анхаарал татсан) бүлэгт багтах эсэх;
- тогтвортой байдлын хүчин зүйлс (хөдөлмөрлөх чадвар, оршин сууж байсан газар, гэр бүлийн талаарх мэдээлэл);
- архи ба мансууруулах бодисын хамааралтай эсэх;
- нас.

Хүснэгт 29. Гадаадын зарим орны хорих байгууллагын тогтолцоо¹⁴⁴:

<i>Англи Улс:</i>	<i>Холбооны Бүгд Найрамдах</i>	<i>Бүгд Найрамдах Польш Улс:</i>	<i>Америкийн Нэгдсэн Улс:</i>	<i>Оросын Холбооны Улс:</i>
-------------------	--------------------------------	----------------------------------	-------------------------------	-----------------------------

¹⁴⁴ Алтан-Очир, М. Хорих ял эдлүүлэх дэглэм. Уб., 2020 он.

	Герман Улс:			
Хорих байгууллага нь төвийн ба орон нутгийн хорих байгууллагаас бүрдэнэ. Орон нутгийн ял эдлүүлэх байгууллагад гол төлөв хэрэг нь шүүхэд шилжихийн өмнөх болон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болохыг хүлээж байгаа хүмүүс хоригддог. Хэдийгээр төвлөрсөн ял эдлүүлэх байгууллагыг дээрх байдлаар ангилдаг ч үндсэнд нь нээлттэй ба хаалттай гэж хуваадаг.	Хорих ял эдлүүлэх ажиллагааг дэглэмийн төрлийн хувьд нээлттэй ба хаалттай гэсэн хоёр хэлбэрээр эдлүүлдэг байна. Нээлттэй хорих байгууллагад 6 сар хүртэл богино хугацаагаар хорих ял шийтгүүлэгчид, эсхүл үйлдсэн гэмт хэргийн хор аюул нь бага хоригдлын ялыг эдлүүлнэ. Хаалттай хорих байгууллага нь ял эдлүүлэх байгууллагын үндсэн төрөл бөгөөд тооны хувьд ч олон байдаг ажээ.	Хорих байгууллага нь хаалттай, хагас хаалттай, нээлттэй гэсэн 3 дэглэмтэй байдаг ба гэмт хэрэг үйлдсэн байдал зэргээс нь шалтгаалан эдгээр дэглэмд ял эдлэгчдийг хуваарилдаг байна. Нээлттэй дэглэмийн хоригдол тусгай хамгаалалттайгаар тухайн шоронгийнхоо ахуйн үйлчилгээний болон гадуур аж ахуйн байгууллагад гэрээгээр ажилладаг ба хагас хаалттай дэглэмийн хорих ангийн хоригдол тухайн хорих ангийнхаа барилгын материал, машины эд анги, засвар, гэр ахуйн барааны сэлбэг зэрэг үйлдвэрт ажилладаг. Хаалттай хорих ангид ихэвчлэн онц аюултай гэмт хэрэгтэн ял эдэлдэг тул тэд ажил хийдэггүй. Хорих ангийн нэг онцлог нь хоригдогч болон нээлттэй, хагас нээлттэй, хаалттай дэглэмийн ялтныг байршлын хувьд тусгаарлалттайгаар нэг хорих ангид хорьдог.	Хорих байгууллагын бүтэц нь нээлттэй, хаалттай гэсэн үндсэн хоёр хэсэг тэдгээрийн дунд завсрын, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнийг хорьж ялыг нь эдлүүлэх онцгой байгууллагаас бүрдэнэ. Тус улсад үйлдсэн гэмт хэргийг онцлогтой уялдуулан А, В, С, D гэх зэргээр мөн ангилан хуваарилдаг байна.	а) энгийн дэглэмтэй хорих ангид анх удаа болон болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн, мөн хөнгөн болон хөнгөвтөр төрлийн гэмт хэрэг санаатай үйлдсэн, түүнчлэн шүүхээс гэмт хэрэгтэн засрах боломжтой гэж үзсэн тохиолдолд 2 сараас 5 жил хүртэл хорих ял шийтгэгдсэн этгээдийн ялыг; б) жирийн дэглэмтэй хорих ангид анх удаа хүнд гэмт хэрэг үйлдсэн, мөн давтан гэмт хэрэг үйлдсэн буюу өмнө нь ял эдэлж байсан этгээд болон 5-20 жил хүртэл хорих ял шийтгэгдсэн этгээдийн ялыг; в) чанга дэглэмтэй хорих ангид анх удаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн эсвэл давтан гэмт хэрэг үйлдсэн, өмнө нь ял эдэлж байсан этгээд болон 20-35 жил хүртэл хорих ял шийтгэгдсэн этгээдийн ялыг; г) онцгой

				дэглэмийн хорих ангид онц хүнд давтан гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй хүнд оногдуулах ба цаазаар авах ял эсвэл 25 жил буюу бүх насаар хорих ял шийтгэгдсэн этгээдийн ялыг эдлүүлнэ.
--	--	--	--	--

Гадаадын зарим орны ял эдлүүлэх тухай хууль тогтоомжийг судлахад ихэнх орон нь хорих ял эдлүүлэх нээлттэй, хаалттай тогтолцоотой хэдий ч ямар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг, ямар нөхцөл, журмаар хорих нь өөр өөрийн онцлогтой байна. Тухайлбал, нээлттэй хорих ангид ял эдэлж буй хоригдол хорих ангиас гарч хөдөлмөрлөх, суралцах эрх эдлэх зэрэг илүү хөнгөрүүлсэн буюу нөхцөлөөр хоригдох боломжтой байдаг байна.

Хорих ял эдлүүлэх тогтолцоо, дэглэм, зэрэглэлийн эрх зүйн зохицуулалттай холбоотой дараах тулгамдсан асуудал байна гэж үзлээ. Үүнд:

Асуудал:

1. ШШГТХ-ийн 195 дугаар зүйлд хорих ангийн дэглэмийн тухай дурдаагүй боловч 206 дугаар зүйлд “Хорих ял эдлүүлэх хорих ангийн дэглэм, зэрэглэлийг өөрчлөх” гэсэн зохицуулалт орсон. Цаашид хорих ангийн дэглэмийг тодорхойлох шаардлагатай.

2. ШШГТХ-ийн 206 дугаар зүйлийн 206.7-д “сүүлийн 1 жилийн хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй, сахилга, засрал хүмүүжлийн байдлаараа эерэг үнэлгээ авсан нээлттэй хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдлыг хорих ялын хугацаа дуусахаас 1 жилийн өмнө нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлнэ” гэсэн заалтад тийнхүү ял эдлүүлэх хоригдлын саналыг Арга зүйн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж Прокурор шийдвэрлэх, эсвэл шууд тухайн зэрэглэлд шилжүүлэх эсэх нь тодорхойгүй.

3. ШШГТХ-ийн 226 дугаар зүйлийн 226.1-д “сахилгын зөрчил гаргаж байгаагүй, хөдөлмөрлөх үүргээ биелүүлж урамшуулал авч, хорих анги дахь сургалт, нийгэмшүүлэх ажилд идэвхтэй оролцож байсан хоригдол Эрүүгийн хуулийн 6.12 дугаар зүйлд заасан хугацаанаас 1 жилийн өмнө нээлттэй хорих ангид ял эдлүүлэх саналыг энэ хуулийн 224.2-т заасан зөвлөлөөр хэлэлцэж, саналаа прокурорт, прокурор үндэслэлтэй гэж үзвэл шүүхэд хүргүүлэн шийдвэрлүүлнэ” гэж заасан нь 206 дугаар зүйлийн 206.10 -д “Хоригдлыг 1 жилийн дотор нэгээс илүү удаа зэрэглэл хөнгөрүүлэн шилжүүлэхгүй.” гэж заасантай зөрчилдсөн.

4. ШШГТХ-ийн 199 дүгээр зүйлийн 199.3-д “хаалттай хорих ангийн тусгай нэгжид бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ял эдлүүлнэ.” гэж заасны дагуу тусгай нэгжид зөвхөн бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлын ял эдлэх зохицуулалттай боловч 206 дугаар зүйлийн 206.8-д “Хоригдол 1 жилийн хугацаанд хоёр, түүнээс дээш удаа сахилгын зөрчил гаргасан, эсхүл сахилгын ноцтой зөрчил гаргасан тохиолдолд зөвлөл ... хаалттай хорих ангийн ..., тусгай зэрэглэлээс тусгай нэгжид зэрэглэл хүндрүүлэн шилжүүлэх саналаа

прокурорт гаргаж, прокурор 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.” гэж заасан нь хоорондоо зөрчилдсөн.

5. ШШГТХ-ийн 195 дугаар зүйлийн 195.1-д “хорих байгууллага нь нээлттэй, хаалттай хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, цагдан хорих төв, байр, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг /цаашид “хорих анги” гэх/, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөс бүрдэнэ.”, 195.3-д “Хорих ангийг тусгаарлагдсан нэгээс илүү зэрэглэлд хувааж, өөр өөр зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол бие биетэйгээ харилцах боломжгүй байдлаар зохион байгуулж болно.” гэж заасан боловч дэглэм, зэрэглэлийн ялгаа нь зөвхөн хоригдлын эргэлт, уулзалт, утсаар ярих тоогоор хязгаарлагдаж байна.

6. ШШГТХ-ийн 199 дүгээр зүйлийн 199.3-д “хаалттай хорих ангийн тусгай нэгжид бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ял эдлүүлнэ.” гэж заасны дагуу тусгай нэгжид зөвхөн бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлын ял эдлэх зохицуулалтай боловч 206 дугаар зүйлийн 206.5-д “Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд 10 жил ял эдэлсэн тохиолдолд хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлж болно”, 206.8-д “Хоригдол 1 жилийн хугацаанд хоёр, түүнээс дээш удаа сахилгын зөрчил гаргасан, эсхүл сахилгын ноцтой зөрчил гаргасан тохиолдолд зөвлөл ... хаалттай хорих ангийн ..., тусгай зэрэглэлээс тусгай нэгжид зэрэглэл хүндрүүлэн шилжүүлэх саналаа прокурорт гаргаж, прокурор 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.” гэж заасан нь хоорондоо зөрчилдсөн.

7. ШШГТХ-ийн 199 дүгээр зүйлийн 199.5-д “хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол 90 хоногт нэг удаа түр, ... болно” 200 дугаар зүйлийн 200.4-д “Хоригдол 180 хоногт хоёр удаа түр уулзалт хийж, ... болно” гэж тус тус заасан нь хаалттай хорих ангийн тусгай зэрэглэл болон тусгай нэгжид ял эдэлж байгаа хоригдол ижил хугацаанд уулзалт хийж болохоор заасан. Улмаар тусгай нэгжид ял эдэлж байгаа хоригдол нь өдөр дараалан уулзалт хийх боломжтой байхаар байна.

8. 15 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэгдсэн, ШШГТХ-ийн 206.8-д заасны дагуу 1 жилийн хугацаанд хоёр, түүнээс дээш удаа сахилгын зөрчил гаргасан, эсхүл сахилгын ноцтой зөрчил гаргасан хоригдлын ялыг тусад нь ял эдлүүлэх хаалттай хорих ангийн онцгой зэрэглэлийг шинээр хуульчлах шаардлага байна.

9. ШШГТХ-ийн 228 дугаар зүйлийн 228.2-д “Хорих ангийн дотоод журмыг ноцтой зөрчсөн дараахь тохиолдолд сахилгын байранд хорих сахилгын шийтгэл оногдуулна” гэж заасан боловч 206 дугаар зүйлийн 206.8-д “..., эсхүл сахилгын ноцтой зөрчил гаргасан тохиолдолд зөвлөл нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлээс тусгай зэрэглэлд, хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлээс тусгай зэрэглэлд, тусгай зэрэглэлээс тусгай нэгжид зэрэглэл хүндрүүлэн шилжүүлэх саналаа прокурорт гаргаж, прокурор 10 хоногийн дотор шийдвэрлэнэ” гэж заасан нь зөрчилдсөн, 1 удаа ноцтой зөрчил үйлдсэн тохиолдолд сахилгын хорих байранд хорих, мөн зэрэглэл дээшлүүлэх боломжтой;

10. ШШГТХ-ийн 208 дугаар зүйлийн 208.3-д “...мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, ... тусад нь ял эдлүүлнэ” гэж заасан байх боловч 2024 оны жилийн эцсийн байдлаар 151 хоригдол тухайн төрлийн гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж байгаа нь дээр заалтыг хэрэгжүүлэх практик боломжгүй.

11. Сүүлийн жилүүдэд 409, 413, 415, 427, 423, 457 дугаар хорих ангиудыг нээлттэй, хаалттай дэглэмтэй байхаар зохион байгуулсан нь ШШГТХ-ийн 195 дугаар зүйлийн 195.3-д “хорих ангийг тусгаарлагдсан нэгээс илүү зэрэглэлд хувааж, өөр өөр зэрэглэлд ял эдэлж байгаа хоригдол бие биетэйгээ харилцах боломжгүй байдлаар зохион байгуулж болно” гэж заасныг зөрчиж, нэг хорих ангийг тусгаарлагдсан нэгээс илүү зэрэглэлд бус нэгээс илүү дэглэмд хуваасан.

12. ШШГТХ 206 дугаар зүйлийн 206.5 дахь заалт “Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд 10 жил ял эдэлсэн тохиолдолд хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлж болно” гэсэн нь тус хуулийн бусад зохицуулалттай зөрчилдөж байна. Учир нь 199 дүгээр зүйлийн 199.1 “Тусгай зэрэглэл нь бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ганцаарчлан ял эдлүүлэх тусгай нэгжтэй байна”, 199 дүгээр зүйлийн 199.3 дахь заалт “Хаалттай хорих ангийн тусгай нэгжид бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ял эдлүүлнэ” гэсэн заалттай агуулгын хувьд зөрчилдөж байна. Дээрх 206 дугаар зүйлийн 206.5 дахь зохицуулалтыг дүгнэн үзэхэд бүх насаар хорих ялаар шийтгүүлсэн хоригдлын тусгай зэрэглэлээс энгийн зэрэглэлд шилжүүлэх асуудлыг зохицуулсан боловч харин тусгай нэгжээс тусгай зэрэглэлд шилжүүлэх асуудлыг орхигдуулсан байна.

13. ШШГТХ 236 дугаар зүйлийн 236.1 дэх заалт “Нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа хоригдол хорих ялын 50-иас доошгүй хувийг эдэлсэн, сахилгын зөрчил гаргаж байгаагүй бөгөөд их, дээд сургууль, коллежийн эчнээ сургалтад суралцах хүсэлт гаргасан бол хорих ангийн даргын саналыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга шийдвэрлэнэ” гэсэн нь тус хуулийн бусад зохицуулалттай зөрчилдөж байна. Учир нь 210 дугаар зүйл хоригдлын эрх 210.1.4 дэх заалт өөрийн зардлаар их, дээд сургууль, коллежийн эчнээ сургалтад хамрагдах эрхтэй гэж нийт хоригдлын эрхийг тогтоосон боловч 236.1 дэх заалтаар зөвхөн нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа гэж хоригдлын эрхээр хязгаарласан зөрчилдөөнтэй заалт болсон байна. Өөрөөр хэлбэл дээрх 236 дугаар зүйлийн 236.1 дэх зохицуулалтыг дүгнэн үзэхэд ШШГТХ-ийн 210.4-тэй зөрчилдөөд зогсохгүй Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.7-д заасан иргэний үндсэн эрх, эрх чөлөөгөө буюу сурч боловсрох эрх, 14 дүгээр зүйлийн 14.2 “.. хүнийг ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэсэн заалттай зөрчилдөж байна гэж үзлээ.

3.6. Хоригдлыг нийгэмшүүлэх ажиллагаа

Хорих ангийн “нийгмийн ажил” гэсэн нэр томьёо, ойлголт бий болоод 20-оод жил болсон цаг хугацаанд нийгмийн ажилтны албан тушаалын тодорхойлолт, нийгмийн ажлын заавар, нийгэмшүүлэх хөтөлбөр зэрэг эрх зүйн бичиг баримт боловсрогдон гарч хэрэгжиж байгаа билээ.

Хорих байгууллага дахь нийгэмшүүлэх ажил нь хорих ялаар шийтгэгдсэн хүнийг нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцох төлөвшлийг бий болгоход чиглэсэн сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, сургах, иргэд, бусад нийгмийн байгууллагатай зөв харилцаа үүсгэх, хөдөлмөрийн дадал, хүмүүжил олгох, хууль, дэг журмыг хэвшүүлэх нөлөөллийн цогц үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, хоригдлыг нийгэмшүүлэх асуудал нь хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад болон ял эдлээд суллагдсаны дараа гэмт хэрэг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, гэмт зуршлаас нь татгалзуулах, хуулиа сахидаг (law binding) иргэншсэн бие хүн болон төлөвшүүлэх, нийгмийн амьдралд буцаан нэгтгэхэд чиглэсэн сэтгэл зүй, нийгмийн ажил, эрх зүй, менежментийн цогц арга хэмжээ¹⁴⁵ гэж ойлгож болно.

Хорих байгууллагад явуулах нийгмийн ажлын үйлчилгээ нь хорих байгууллагын зүгээс хоригдолд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг үе шаттай, үр дүнтэй явуулснаар тэднийг нийгэмшүүлэх буюу нийгэмд нь эргэн нэгтгэх (resocialization, reintegration into society), суллагдахаас өмнө эрх чөлөөт амьдралд нь бэлтгэх, суллагдаж гараад дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдэн явагддаг. Үүнд тусгайлан боловсруулсан хөтөлбөр, сургалтын дагуу тухайн хоригдлын зан байдал, хувийн онцлог, нас хүйс зэрэг онцлогийг харгалзан ялгамжтай явуулдаг нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээгээр дамжин хэрэгжиж үр дүн нь гардаг байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас батлан гаргасан “Иргэний болон улсын төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ийн 10.3 дахь хэсэгт “Хорих байгууллагын дэглэмийн нэн чухал зорилго нь хоригдлыг засан хүмүүжүүлж, нийгмийн хэвийн гишүүн болгох явдал байна. Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүйчүүдийг насанд хүрэгсдээс тусгаарлаж, тэдний нас, эрх зүйн байдалд нийцсэн дэглэмд байлгана¹⁴⁶ гэж заасан нь олон улсын түвшинд хорих ял эдлүүлэх ажиллагааны зорилгыг тодорхойлсон явдал юм. Дээрх заалтыг дэлхийн улс орнууд хорих ял эдлүүлэх ажиллагаандаа хэрэгжүүлэн, хорих ял шийтгэгдсэн хүнийг нийгэмшүүлэн, дахин гэмт хэрэг үйлдэх явдлаас урьдчилан сэргийлэхийг үндсэн зорилгоо болгож байна.

Хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг 2015 онд батлагдсан Эрүүгийн хуульд тусгагдсан эрүүгийн хариуцлагын зорилгыг “гэмт хэрэг үйлдсэн хүнийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх”¹⁴⁷ гэж тусгаснаар ШШГТХ-ийн 218-222 дугаар зүйлд хоригдлыг нийгэмшүүлэх ажил, түүний хэлбэр, зохион байгуулалт, хийгдэх ажил, хорих анги дахь сургалтын талаар хуульчилсан. Энэ зохицуулалт нь хоригдлын хувийн байдлыг харгалзан

¹⁴⁵ Г.Баттулга. “Хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлж буй олон улсын туршлага” “Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2016 он, 8 дахь тал.

¹⁴⁶ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.


¹⁴⁷ Төрийн мэдээлэл. Эрүүгийн хууль. 2016. №07.

ял эдлэх бүхий л хугацааг хамарсан боловсрол, ёс зүй, сэтгэл зүйн нөлөөллийн үйл ажиллагаагаар дамжуулан нийгэмшүүлэх эрх зүйн үндэс тавигдсан.

ШШГТХ-ийн дээрх эрх зүйн зохицуулалтаас өмнө хоригдолд сургалт, хүмүүжлийн ажил явуулах, хөдөлмөрлүүлэх замаар нөлөөллийн ажлыг зохион байгуулж байсан уламжлалтай билээ. ШШГБ нь 2004 онд анх удаа нийгмийн ажилтныг томилон ажиллуулан хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх зорилгоор 2008 онд “Ялтныг нийгэмшүүлэх ажлын хөтөлбөр”, 2010 онд “Ялтны дунд явуулах сургалт, хүмүүжлийн ажлын заавар”, 2018 оноос “Нийгмийн ажлын аргачилсан заавар”-ыг батлан хэрэгжүүлж ирсэн. Гэсэн хэдий ч Хорих ял эдлүүлэх албаны 2023 оны жилийн эцсийн тоо мэдээнээс харахад дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдол нийт хорих ял эдлэгсдийн 55.2 хувийг эзэлж, үүнээс 2 удаа гэмт хэрэг үйлдсэн хоригдол 958 буюу 38.4 хувь, 3 удаа гэмт хэрэг үйлдсэн хоригдол 544 буюу 21.8 хувь, 4-10 удаа гэмт хэрэг үйлдсэн хоригдол 637 буюу дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлын 25.5 хувийг эзэлж байгаа тул хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх шаардлага урган гарч байна. 2019-2023 оны статистик мэдээнээс харахад хорих ял эдлэгсдийн дунд дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлын тоо буурахгүй байгаа нь хорих байгууллагын үйл ажиллагаанд нийгэмшүүлэх ажил хангалтгүй, судалгаанд суурилсан нийгэмшүүлэх ажил явагддаггүй, хоригдлыг нийгэмшүүлэх тогтолцоо бүрэлдэн тогтоогүй гэж үзлээ.

Хорих байгууллагын 1005 алба хаагчаас авсан Та хоригдлыг нийгэмшүүлэх ажлын үр дүнг дээшлүүлэхэд юун дээр анхаарвал зүйтэй гэж үздэг бэ? гэсэн асуултад 270 буюу 26.9 хувь хоригдолд мэргэжил олгох сургалт сайжруулах, 114 буюу 11.3 хувь нь суллахад бэлтгэх үйл явцад анхаарах, 224 буюу 22.3 хувь нь суллагдсаны дараа хүлээн авах орчин, ажлын байрыг бий болгох, 229 буюу 22.8 хувь нь нийгэмшүүлэх ажлыг хэрэгжүүлж буй хүний нөөцөд анхаарах, 168 буюу 16.7 хувь нь хоригдлын хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах гэж хариулсан.

Зураг 35. Нийгэмшүүлэх ажлын үр нөлөөнд өгсөн санал



Хоригдлыг нийгэмшүүлэхтэй холбоотой харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийг хангах тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний

эрхийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хүрээнд зохицуулж байна. Тухайлбал:

- Эрүүгийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д зааснаар “эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино”;

- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, 12.2 дахь хэсэгт “хорих болон засан хүмүүжүүлэх байгууллагад хоригдож байгаа залуучуудад зориулсан сэтгэл заслын үйлчилгээ, соёл, спорт, хүмүүжлийн арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор залуучуудын болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх”;

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 15.1.2-т “хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг үйлдвэрлэл дээрээ дадлагажуулан үндсэн ажилтнаар нэг жилээс доошгүй хугацаагаар үргэлжлүүлэн ажиллуулж байгаа ажил олгогчид дадлагын хугацааны сургалтын зардлыг нөхөн олгож, нэг жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний санхүүгийн дэмжлэгийг ажилтан, ажил олгогч тус бүрд нь нэг удаа олгох”, 15.1.5-т “хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг ажлын байраар хангаж, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх талаар тодорхой санаачилга гаргаж, үр дүнд хүрсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл шалгаруулж, урамшуулах”;

- Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5-т “онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн, дор дурдсан өрх, иргэнд олгох”;

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын 44.4-т “зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хорих ял шийтгүүлсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, баривчлах, албадан сургалтад хамруулах шийтгэл хүлээсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллага зохион байгуулах”;

- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9.2.2-т “гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлж суллагдсан хүнд хяналт тавих”, 9.2.3-т “гэмт хэрэг үйлдэж болзошгүй нөхцөлд байгаа болон хорих ял шийтгүүлж, суллагдсан этгээдэд нийгэмд дасан зохицох, нийгмийн амьдралд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх”, 9.2.5-д “гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийн зан байдалд нөлөөлөх, хуулийг чандлан сахих дадал төлөвшүүлэх, хорих байгууллагад байх хугацаанд боловсрол, ажил хөдөлмөр эрхлэх дадал, туршлага олгох, суллагдсаны дараа нийгэмд дасан зохицох шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох”;


- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 218.1-д “хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ”, 219.1-д “хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл,

сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна” гэж хуульчилсан байна.

Хорих ангид хоригдлыг нийгэмшүүлэх үйл ажиллагаа ШШГЕГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/269 дугаар тушаалаар батлагдсан “Нийгмийн ажлын заавар”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 30 өдрийн А/167, А/233 тоот хамтарсан тушаалаар баталсан “Хоригдлыг суллахад бэлтгэх нийгэмшүүлэх хөтөлбөр”-ын хүрээнд явагдаж байна.

Хорих ял эдлүүлэх албаны 2023 оны жилийн эцсийн тоо мэдээнээс харахад дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдол нийт хорих ял эдлэгсдийн 55.2 хувийг эзэлж, үүнээс 2 удаа гэмт хэрэг үйлдсэн хоригдол 958 буюу 38.4 хувь, 3 удаа гэмт хэрэг үйлдсэн хоригдол 544 буюу 21.8 хувь, 4 дээш 10 удаа гэмт хэрэг үйлдсэн хоригдол 637 буюу дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлын 25.5 хувьтай байгаа нь энэхүү асуудалд задлан шинжилгээ хийх хэрэгцээ байгааг илэрхийлдэг. Хорих ял эдлэгсдийн талаас илүү хувь нь дахин гэмт хэрэг үйлдэж хорих ангид эргэн ирж байгаа нь хоригдлыг нийгэмшүүлэх ажилтай шууд холбоотой төдийгүй анхаарал хандуулах болсныг илтгэж байна.

Зураг 36. Дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдол судалгаа¹⁴⁸ /2019-2023 он тоо, хувиар/:



Тоон үзүүлэлтээс харахад хамгийн өндөр хувь буюу 44.7 хувийг эзэлж буй өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үүний дотор хулгайлах, дээрэмдэх, мал хулгайлах гэмт хэргийг суллагдсаны дараа 1 жилийн дотор үйлдсэн тохиолдол 33.9 хувь хамгийн өндөр үзүүлэлтэй байгаа бол суллагдсанаас хойш 5 жилийн дараа үйлдсэн тохиолдол 25.8 хувь, 2-4 жилийн дотор үйлдсэн тохиолдол дунджаар 9.5-20.1 хувьтай байсан.


Хүнийг алах гэмт хэргийг дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлын 23.8 хувь буюу 342 хоригдол байна. Дахин гэмт хэрэг үйлдэхдээ хүнийг алах гэмт хэрэг үйлдсэн хоригдлын хувьд хорих ангиас суллагдсаны дараа 1-4 жилийн дотор үйлдэж буй тохиолдол 7-11.7 хувьтай тэнцэж байгаа бол суллагдаад 5 жилийн дараа хүнийг алсан тохиолдол дангаараа 62.6 хувьтай тэнцэж байна.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлын 10.4 хувь буюу 149 хоригдол байх бөгөөд 1 жилийн дотор үйлдсэн тохиолдол 23.5 хувь, 2-4 жилийн дотор үйлдсэн тохиолдол 6.7-15.4 хувьтай байгаа бол 5 жилээс дээш жил өнгөрсний дараа энэхүү гэмт хэрэг үйлдсэн тохиолдол 44.3 хувьтай байна.

¹⁴⁸ ХЗДХЯ. Гэмт хэргийн цагаан ном. 2016-2023 он.

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг тэр дундаа хүчиндэх гэмт хэргийн дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлын 15.6 хувь үйлдсэн байх бөгөөд хорих ангиас суллагдаад 1 жилийн дотор үйлдсэн тохиолдол 11.6 хувь, 2-4 жилийн дотор үйлдсэн тохиолдол 6.7-13.4 хувь, 5 жилээс дээш жил өнгөрсний дараа хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн тохиолдол 59.8 хувьтай тэнцэж байна.

Зураг 37. Дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлын үйлдсэн гэмт хэргийн төрөл:




Хэдийгээр суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэж буй шалтгаан, нөхцөл нь ажилгүйдэл, ядуурал, архидалт зэрэг нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлтэй холбоотой хэдий ч санаатай гэмт хэрэг үйлдэх нь тухайн хүний сэтгэл зүйн байдал, харилцааны ур чадвар, нийгэмшлийн түвшинтэй шууд холбоотой хэмээн үзэх үндэслэлтэй байдаг.

Хэдийгээр өргөн утгаараа нийгмийн ажил нь нэг талаас хүний эрхийг хангаж буй боловч хоригдлын хувьд нийгэмшүүлэх ажлын утга, агуулгыг бүрэн ойлгоогүй байна. Судалгааны явцад 1293 хоригдлоос “та хорих ангид явуулж буй нийгэмшүүлэх ажлыг хэрхэн ойлгодог вэ” гэсэн асуултад 514 буюу 40% нь хүний эрхийг хангахад чиглэсэн үйлчилгээ, 189 буюу 14% нь ахуй нөхцөлийг сайжруулахад чиглэсэн үйлчилгээ, 359 буюу 28% нь сургалтын үйл ажиллагаа, 231 буюу 18% нь сайн мэдэхгүй гэж хариулсан байна.

Хоригдлыг нийгэмшүүлэхэд сургалт чухал үүрэг гүйцэтгэх ба ШШГТХ-ийн 220 дугаар зүйлд хорих анги дахь сургалт, 221 дүгээр зүйлд хорих анги дахь сургалтын хэлбэр, 222 дугаар зүйлд хорих анги дахь албадан сургалтын зохицуулалтыг заасан байна.

ХЯЭА-ны Сургалт, нийгэм, сэтгэл зүйн хэлтсийн сүүлийн 5 жилийн тайланд шинжилгээ хийн үзвэл 60 гаран нийгмийн ажилтны орон тоотойгоор 30 гаран салбар нэгжид жилд дунджаар 4000 гаран хоригдолд хорих ял эдлэх хугацаанд нь бүртгэл, судалгаа хийх, зан байдлыг тодорхойлох, яриа таниулга хийх, ганцаарчилсан болон бүлгийн уулзалт зөвлөгөө өгөх, нийгмийн халамж, туслалцаанд хамруулах, хөдөлмөрт хуваарилах, урамшуулах, бичиг баримтжуулах, сургах үйл ажиллагаа буюу бичиг үсэг, суурь боловсрол, мэргэжлийн боловсрол олгох, амьдрах ухааны сургалт зохион байгуулжээ.

Зураг 38. Хорих анги дахь сургалтын төрөл, хэлбэр



Хоригдлын суллахад бэлтгэх чиглэлээр хөтөлбөрт хамруулах, гэр бүлд чиглэсэн мэдээлэл, зөвлөгөө өгөх, төрийн болон төрийн бус байгууллагад холбон зуучилж үйлчилгээ үзүүлэх зэрэг 14 багц ажлын хүрээнд нийгэмшүүлэх ажил зохион байгуулагдсан байгаа нь төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын нэг хэсэг болох ялын гүйцэтгэх үүргийн илрэл байх учиртай юм. Гэсэн хэдий ч хорих ял эдлүүлэх ажиллагаа тэр дундаа нийгэмшүүлэх ажлын үр дүнг тооцох чухал үзүүлэлт нь суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэн ял эдэлж буй хоригдлын тоо байдаг.

Хоригдолд чиглэгдсэн энэхүү үйл ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль¹⁴⁹-ийн 218.1-д “хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ”, 219.1-д “хоригдлыг хууль зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна” гэж хуульчилсны хүрээнд нийгмийн ажлын зааврыг батлан хэрэгжүүлж байна.

ШШГЕГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/269 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн ажлын заавар”-т шинжилгээ хийж үзвэл “хорих байгууллагын нийгэмшүүлэх ажил гэж хоригдол нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход нь дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ”, “нийгэмшүүлэх ажлын үе шат гэж хорих байгууллагын нийгмийн ажилтан хоригдолтой ажиллах үйл ажиллагааны чиглэл, арга зүйг тодорхойлж, хоригдолтой харилцаа холбоо тогтоох, нөхцөл байдлын үнэлгээ хийх, нийгэмшүүлэх үйлчилгээг төлөвлөх, хүргэх, үнэлэх, дуусгах үе шат бүхий үйл явцыг хэлнэ

¹⁴⁹ Төрийн мэдээлэл. эмхэтгэл. 2017. №24.

гэж заасан боловч зааврын гурав дугаар зүйлд нийгмийн ажлын үйлчилгээ, үе шат гэж хоригдолтой холбоотой анхан шатны мэдээлэл цуглуулах, санал хүсэлтийг авах зорилготой ярилцлага хийж, шинээр ирсэн хоригдлоос анхан шатны мэдээлэл, санал хүсэлт авсан тэмдэглэлийг хөтөлнө, хорих ял эдлэх хугацаанд мөрдөх хууль, журам, дүрэм, зааврыг танилцуулах сургалтад хамруулж, харилцаа холбоо тогтооно, нөхцөл байдлын үнэлгээг 14 хоногийн дотор хийх ба нийгмийн ажлын үйлчилгээг шаардлагатай эсэхийг тодорхойлж нөхцөл байдлын үнэлгээний тайланд тусгана гэх зэрэг байдлаар 9 үйл ажиллагааг тусгаж өгсөн учир дутагдалтай юм. Гэтэл үе шат гэдэг нь нийгмийн хөгжилд хүрсэн хугацааг хэлэх бөгөөд хоригдлыг хүлээн үеийн нийгэмшүүлэх ажил, ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил буюу хөгжүүлэх, нөхөн сэргээх, суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил буюу нийгэмд бэлтгэх” хэмээн үзэх нь зохимжтой хэмээн судлаачийн зүгээс үзсэн.

Энэхүү зохицуулалтын хүрээнд хоригдолд сургалт, зан үйлийн нөлөөллийн арга хэмжээ, мэргэжлийн боловсрол, хөдөлмөрийн ур чадвар олгох зэрэг байдлаар хорих анги бие даан болон төрийн бус байгууллагын оролцоо, хамтын ажиллагааны хүрээнд танхимаар, цахимаар зохион байгуулж байгаа хэдий ч тодорхой үр дүн нэмэгдэхгүй байгаа нь бодит үнэн юм. Гэвч нийгэмшүүлэх ажлын үр дүнг хэмжих гол үзүүлэлт болсон гэмт хэрэг дахин үйлдэх явдал манай орны хувьд харьцангуй өндөр байгаа ба үүнд объектив, субъектив олон хүчин зүйлс нөлөөлж буй нь дамжиггүй боловч хуулийн зохицуулалтын хийдэл, механизмын үр нөлөө дутмаг байдал онцгой анхаарал татдаг¹⁵⁰ гэж үзсэнтэй санал нийлсэн. Өөрөөр хэлбэл, нийгмийн ажилтны өдөр тутамдаа мөрдөгдөж буй нийгмийн ажлын зааварт хоригдлыг нийгэмшүүлэх ажлын үе шат бүрд хийгдэх ажил, тухайлан нийгэмшүүлэх хөтөлбөрийн талаар зохицуулалт тусгагдаагүйгээс нийтлэг төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байгаа ба нийгэмшүүлэх ажлын үр дүнг тооцох байдал учир дутагдалтайг харуулж байна.

Үүнээс үзэхэд оновчтой нийгэмшүүлэх ажлын үндсэн суурь нь нийгмийн ажилтны хэрэгжүүлж буй хөтөлбөр, мэргэжлийн үйл ажиллагаагаар дамжин илэрдэг. Энэхүү үйл ажиллагааг үнэлэх зорилгоор дахин гэмт хэрэг үйлдсэн 1416 хоригдлоос нийгмийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаанд үнэлгээ авахад, судалгааны түүврийн 2.5 хувь нь маш муу, 11.7 хувь нь муу, 37.5 хувь нь дунд гэж хариулсан бөгөөд нийт хоригдлын 51.7 хувь нь хангалтгүй гэсэн үнэлгээ өгсөн бол 48.3 хувь нь нийгмийн ажилтны үйл ажиллагаанд сайн, маш сайн гэсэн үнэлгээ өгчээ.

Тэгвэл нийгмийн ажилтны хэрэгжүүлэх хөтөлбөр, үндсэн үйл ажиллагаанд үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн зүгээс доогуур үнэлгээ өгч байгаа нь нэг талаас мэргэжлийн үйл ажиллагаанд мэргэжлийн бус алба хаагч ажиллаж байгаатай шууд холбоотой гэж үзэх үндэслэлтэй юм. Учир нь бид хорих байгууллагад сүүлийн 3 жилийн хугацаанд нийгмийн ажилтан мэргэжлийн албан тушаалд¹⁵¹ ажиллаж буй алба хаагчийн эзэмшсэн мэргэжил, туршлагад шинжилгээ хийлээ.


Хорих байгууллагын 1005 алба хаагчаас авсан Та хоригдлыг нийгэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд юун дээр анхаарвал зүйтэй гэж үздэг бэ? гэсэн асуултад 496 буюу 49.4 хувь нь үйлдсэн гэмт хэрэг, хувийн онцлогт нь тохирсон тусгайлсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх, 218 буюу 21.7 хувь нь нийгэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагагүй,

¹⁵⁰ Галбадрах, Б. “Хорих байгууллагаас суллагдсан эмэгтэйчүүдийг нийгэмд дасан зохицоход туслах, дэмжлэг үзүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, практикт хийх дүн шинжилгээ”. Уб., 2021.

¹⁵¹ ХЯЭА-ны Сургалт, нийгэм, сэтгэл зүйн хэлтсийн 2021, 2022, 2023 оны тайлан.

113 буюу 11.2 хувь нь хүлээн авах үеийн, ял эдлэх үеийн, суллагдахад бэлтгэх гэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, 178 буюу 17.7 хувь нь гэр бүлд холбон зуучлах, нийгэмд дасан зохицуулах ажлыг эрчимжүүлэх гэж хариулсан.

Зураг 39. Нийгэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гаргасан санал:



Гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн нэгтгэх, нийгэмшүүлэх зорилтыг биелүүлэх үүднээс олон улсад үндсэн 3 хөтөлбөрийг иж бүрэн хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үздэг. Үүнд:

1. Хорих ангид хоригдлыг нийгэмшүүлэх хөтөлбөр;
2. Гэмт хэрэгтнийг хорихоос суллагдсаны дараагаар эргэн нэгтгэх, халамжлах хөтөлбөр;
3. Гэмт хэрэгтэнд хорихоос өөр төрлийн ял оногдуулах буюу нийгэмд суурилсан хөтөлбөр юм.

Хоригдлын тухайд ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, урт хугацаанд хэрэгжих, үр дүнг тооцож болохуйц хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх ба сулласны дараа хүлээн авах орчин, халамжийн үйлчилгээ нэн чухал байна.

Судалгааны хүрээнд хоригдлыг нийгэмшүүлэх үндсэн 5 хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжтой гэж үзлээ. Үүнд:

1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;
2. Сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх;
3. Согтуурах, мансуурах дон, хорт зуршлаас татгалзуулах;
4. Боловсрол, мэргэжлийн сургалтад хамруулах;
5. Хөдөлмөрт хамруулах хөтөлбөр зэрэг болно.

Түүнчлэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/146 дугаар “Хичээл сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох тухай” тушаалаар хичээл сургалтын үйл ажиллагааг түр зогсоосон хугацаанд сургалтын хөтөлбөрийг тасалдуулалгүй теле болон цахим хичээл хэлбэрээр зохион байгуулах арга хэмжээ авч ажиллах талаар үүрэг өгсний дагуу бүх их, дээд сургууль, коллежийн хичээл цахим хэлбэртэй болсон. Мөн судалгаанд хамрагдсан хорих байгууллагын алба хаагчдын 70 орчим хувь нь хоригдлыг цахим сургалтад хамруулах боломжтой гэж дүгнэсэн. Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 236 дугаар зүйлийн 236.2-д “Сургалтыг хорих ангийн байранд явуулна” гэснийг

“Сургалтыг хорих ангийн байранд танхимын болон цахим хэлбэрээр явуулна” гэж шинэчлэн найруулах саналтай байна.

ШШГТХ-д хоригдлыг нийгэмшүүлэх хэлбэрийг тогтоохдоо хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна гэж заасан боловч хоригдолд үзүүлсэн нийгэмшүүлэх үйлчилгээний үр дүнг тооцох асуудлаар тусгаагүй нь учир дутагдалтай төдийгүй хоригдлыг урамшуулах, хорих ялаас хугацааны өмнө суллаж, хяналт тогтоох тухай санал гаргахтай холбоотой олон эргэлзээтэй асуудлыг дагуулж байдаг.

Эрүүгийн хуульд заасан хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохоор үндэслэлийн дараах нөхцөлийг тодорхойлох буюу хэмжих боломжтой боловч нийгэмшсэн эсэх асуудлыг тодорхойлох талаар нарийвчлан зааж өгөөгүй нь харагдаж байна. Тухайлбал, хорих ял эдэлж буй хоригдлын нийгэмшлийн асуудал буюу нийтэд аюулгүй болсноо нотлон харуулсан байх шаардлага хэмжихэд хүндрэлтэй байдаг. Учир нь нийтэд аюулгүй болсноо нотлон харуулах нь нэг талаас хорих байгууллагад зохион байгуулж буй нийгэмшүүлэх ажлын зөвхөн нэг хэсэг ойлголт, нөгөө талаасаа хэн, яаж, хэрхэн үнэлэх нь холбогдох хууль, журамд тусгагдаагүй нь эргэлзээтэй буюу албан тушаалтны үзэмжээр шийдвэрлэгдэх асуудлын нэг болжээ.

Өнөөгийн мөрдөгдөж буй нийгмийн ажлын заавар нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд заасан хорих анги дахь нийгэмшүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтаас хэрхэн санхүүжүүлэх, нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулахад хорих анги, алба хаагч, бусад байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд ямар туслалцаа авах зэргийг тусгаагүй нь хоригдлыг нийгэмшүүлэх олон нийтийн оролцоо, салбар дундын хамтын ажиллагааг зохицуулаагүй орхигдуулсан. Тус зааварт нийгэмшүүлэх ажлын мэргэжлийн удирдлага¹⁵²-аар хангах, мэргэжлийн хувьд чиглүүлэх ажлын чиглэлээр нарийвчлан тусгагдаагүй цаашлаад хоригдлыг нийгэмшүүлэх эхний алхам буюу хэрэгцээг тодорхойлох, тохирох хөтөлбөр хэрэгжүүлэх, үр дүн өөрчлөлтийг үнэлэх талаар заагаагүй орхигдуулсан зэргийг харгалзан нийгмийн ажлын зааврыг шинэчлэн боловсруулах шаардлага байна гэж үзсэн.

¹⁵² Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага (MNS 6949:2021). 4.10-т нийгмийн ажлын мэргэжлийн удирдлага гэдэг нь нийгмийн ажилтны арга зүйн чадамж, практикийг дэмжих, сайн сайхан байдлыг хангах, үйлчлүүлэгчид мэргэжлийн үр өгөөжтэй үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдэж, нийгмийн ажилтныг удирдан чиглүүлэх, дэмжих, хөгжүүлэх зорилготой үйл ажиллагаа гэжээ.

3.7. Хоригдлын ахуйн нөхцөл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хоригдлын эдлэх эрхийг нэмсэн, нийгэмшүүлэх ажиллагааг хуульчилсан зэрэг өмнөх хууль тогтоомжоос харьцангуй ололттой зохицуулалтыг тусгаж өгсөн. Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлэгт хүний эрх, эрх чөлөө, үүргийг талаар хуульчилсан бөгөөд хорих ял эдэлж буй хоригдолд хэрхэн хамаарч буй талаар судаллаа.

Хүснэгт 30. Иргэний эдлэх эрх, эрх чөлөөний хоригдолд хамаарах байдал:

д/д	Иргэний эдлэх эрх, эрх чөлөө	Хоригдлын эрх зүйн байдал
1.	Амьд явах эрхтэй.	Шүүхийн шийдвэрээр ямарваа нэгэн ял, шийтгэл эдэлж буй албадлагын арга хэмжээ авагдсан этгээд амьд явах эрхээ бүрэн эдлэх учиртай.
2.	Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;	Хорих болон баривчлагдсан этгээдийг хорьж буй орчин нөхцөл нь хүний наад захын хэрэгцээ, шаардлагыг хангахуйц байхаар тоноглогдсон байна. Хорихоос өөр төрлийн ял эдэлж буй ялтны тухайд ял эдлэх орчин нөхцөл нь эрүүл, аюулгүй байх ёстой.
3.	Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй.	Хоригдол итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан эд хөрөнгийн шинжтэй харилцаанд оролцох эрхтэй.
4.	Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;	Хоригдол хорих байгууллагын алба хаагчаас даалгасан ажлыг заавал гүйцэтгэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журмыг чанд сахих үүрэгтэй ба хөдөлмөр хамгааллын тусгай зориулалтын хувцас, хамгаалах хэрэгсэл, шаардлагатай тохиолдолд хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг үнэ төлбөргүй олгож, хийсэн хөдөлмөрт нь тооцож хөлс олгодог.
5.	Өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;	Хоригдол урьд тогтоолгосон тэтгэвэр, тэтгэмжээ үргэлжлүүлэн авах, хуульд заасан болзол шаардлагыг хангасан тохиолдолд хуулиар тогтоосон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох эрхтэй.
6.	Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй;	Хоригдол эмнэлгийн тусламж авах эрхтэй ба эрүүл мэндээ хамгаалах, эмчийн зөвлөгөө, шаардлагыг биелүүлэх, хуурамчаар болон санаатайгаар өвчилсөн, эрүүл мэнд, бие эрхтэндээ гэмтэл учруулсан бол холбогдох зардлыг төлөх үүрэгтэй.
7.	Сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно.	Хоригдол өөрийн зардлаар их, дээд сургууль, коллежийн эчнээ сургалтад хамрагдах эрхтэй. Өсвөр насны хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулна.
8.	Соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй;	Хоригдол, холбогдох зардлаа өөрөө хариуцаж хорих байгууллагаас тогтоосон газарт шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих эрхтэй.
9.	Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг	<i>Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд:</i>


	удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй;	1. Хорих ял эдэлж байгаа иргэн сонгуульд оролцох эрх эдлэхгүй. <i>Улсын их хурлын сонгуулийн тухай хуульд:</i> 1. Хорих ял эдэлж байгаа Монгол Улсын иргэн сонгуульд оролцох эрх эдлэхгүй. <i>Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд:</i> 1. Гэмт хэрэг үйлдэж, шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор ял эдэлж байгаа хүн нэр дэвшихийг хориглоно.
10.	Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй;	Улс төрийн намын тухай хуульд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн сайн дурын үндсэн дээр нам байгуулах, намд элсэх, намаас гарах, хууль болон тухайн намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нийцүүлэн улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхтэй гэж заасан байдаг хоригдол нь сонгуулийн эрхгүй тул энэхүү эрхийг эдлэх боломжгүй байдаг.
11.	Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй;	Хоригдол гэрлэх болон гэр бүлийн харилцаанд оролцох эрхтэй.
12.	Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй;	Хоригдол хорих ангийн захиргаагаар дамжуулан өөрт холбогдох асуудлаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрхтэй.
13.	Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй.	Хоригдол хорих байгууллагын алба хаагч, эрх бүхий албан тушаалтны зүгээс хүнлэг харьцах, эсхүл хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилж харьцахгүй байхыг шаардах эрхтэй.
14.	Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй;	Хоригдол өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах эрхтэй.
15.	Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй;	Хоригдол хорих ангийн дотоод журам, цагийн хуваарьт нийцүүлэн шашны зан үйл үйлдэх эрхтэй.
16.	Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй;	Хоригдол хорих ял эдлэх нөхцөл, журам, эрх, үүрэг, хязгаарлалтын талаар мэдээлэл авах эрхтэй ба харин хорих ангид суулт хийх, өлсгөлөн зарлахыг хориглоно.
17.	Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй;	Хоригдол өөрт холбогдох асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.

18.	Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй.	Хоригдлын хувьд хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад энэхүү эрх бүрэн хязгаарлагдана.
-----	---	--

Хүснэгтээс харахад хоригдлын сонгох, сонгогдох, чөлөөтэй зорчих, жагсаал, цуглаан хийх зэрэг эрхийг бүрэн хязгаарлаж бусад эрхээ ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомж, хорих ангийн дотоод журамд нийцүүлэн эдэлж байна.

НҮБ-аас батлан гаргасан олон улсын баримт бичиг болох “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”¹⁵³, “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”¹⁵⁴, “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”¹⁵⁵, зэрэг түгээмэл баримт бичиг, түүнчлэн “Хоригдолтой харьцах үндсэн зарчим”¹⁵⁶, “Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм”¹⁵⁷, “Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүстэй холбогдуулан НҮБ-аас гаргасан журам”¹⁵⁸, зэргийг хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрхийг хангах хүрээнд үйлчилж байна.

Зураг 40. Хоригдлын ахуй нөхцөлийг сайжруулахтай холбоотой санал



Хоригдлын ахуй нөхцөлийг сайжруулахын тулд хорих ангийн барилга байгууламжийг шинэчлэх гэж 323 буюу 32.1 хувь, хоригдлын ахуй нөхцөлийг тогтоосон стандартыг баталж, хэрэгжүүлэх гэж 148 буюу 14.7 хувь, одоогийн нөхцөл байдал нь хангалттай байгаа гэж 234 буюу 23.3 хувь, дэглэм, зэрэглэл бүрд тохирсон стандарт баталж, хэрэгжүүлэх гэж 300 буюу 29.9 хувь нь үзжээ. Хамгийн өндөр үзүүлэлтэй хариулт буюу хорих ангийн барилга байгууламжийг шинэчлэх асуудал гэж үзсэн алба хаагчийг ажиллаж буй албаар нь ангилбал захиргааны алба хаагчийн 33.9 хувь, гүйцэтгэх алба хаагчийн 37

¹⁵³ НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217/А/III/ тогтоолоор баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ.

¹⁵⁴ НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200 А/XXI/ тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

¹⁵⁵ 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нью-Йорк хотноо баталж, 1987 оны 6 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

¹⁵⁶ НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1990 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 45/111 тогтоолоор баталсан.

¹⁵⁷ Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ба эрх зүйн зорчил үйлдэгсдэд хандах асуудлаар 1955 онд Женевт хуралдсан НҮБ-ын нэгдүгээр их хурлаар баталж, эдийн засгийн болон нийгмийн зөвлөлийн 1957 оны 7 дугаар сарын 31-ний 663 С/XXIY/, 1977 оны 5 дугаар сарын 13-ны 2076 /LXII/ тогтоолоор сайшаасан.

¹⁵⁸ НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1990 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 68 дугаар хуралдаанаар баталсан.

хувь, харуул хамгаалалтын алба хаагчийн 30.6 хувь, нийгэм, сэтгэл зүйн алба хаагчийн 30.9 хувь, санхүүгийн алба хаагчийн 35.8 хувь, тоо бүртгэлийн алба хаагчийн 30.7 хувь, эмнэлгийн алба хаагчийн 27.1 хувь нь үзжээ.

Хоригдлын ахуй нөхцөлийн хүрээнд хорих байрны асуудал чухлаар тавигддаг. ШШГЕГ-ын харьяа нийт 46 хорих анги, байгууллага хот, суурин газарт-38, хот, суурин газраас алслагдсан-8, 2000 оноос өмнө баригдсан-9, 2000 оноос хойш баригдсан-37 барилга байна.

Хүснэгт 31. Хорих байрны ашиглалтад орсон огноо

д/д	Хорих анги, байгууллагын нэршил	Хоригдлын байрны ашиглалтад орсон он
1	401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг	2015 онд
2	405 дугаар хаалттай хорих анги	1988 онд
3	407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги	Нээлттэй байр 2008 онд Хаалттай байр 1981 онд
4	409 дүгээр нээлттэй, хаалттай хорих анги	2017 онд
5	Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага	1970 онд
6	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих анги	2008 онд
7	415 дугаар нээлттэй, хаалттай хорих анги	Нээлттэй байр нь 2012 онд, хаалттай байр 2007 онд
8	417 дугаар нээлттэй хорих анги	2001 онд
9	Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих анги	2005 онд
10	421 дүгээр нээлттэй хорих анги	1978 онд
11	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги	2012 онд
12	Говьсүмбэр аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-425 дугаар нээлттэй хорих анги	2007 онд
13	427 дугаар нээлттэй, хаалттай хорих анги	2008 онд
14	429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	2007 онд
15	433 дугаар хаалттай хорих анги	2012 онд
16	435 дугаар хаалттай хорих анги	1972 онд
17	Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих анги	2013 онд
18	439 дүгээр хаалттай хорих анги	2012 онд
19	441 дугаар нээлттэй хорих анги	2003 онд
20	Дархан-Уул аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй хорих анги	1963 онд

21	Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги	1987 онд
----	---	----------

Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хорих байгууллагуудын хүчин чадлыг хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн зохицуулалтад тусгагдсан нэг хоригдолд 2.5 мк талбай ногдох стандартын хүрээнд авч үзвэл 5498 хоригдол байх боломжтой хэдий ч хорих ангийн байршил, тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдэж буй гэмт хэргийн тооноос хамаарч багтаамж давж байна. Тухайлбал, 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн ШШГЕГ-ын албан ёсны тоо баримтад шинжилгээ хийж үзвэл 7 хорих ангид ял эдлэгсдийн тоо, багтаамжаасаа 2-60 хүнээр давсан байна.

Хүснэгт 32. Хорих ангийн багтаамжийн судалгаа¹⁵⁹:

д/д	Нэр	Хорих байрны багтаамж	Хоригдлын тоо	Илүү
1.	401 дүгээр хорих анги	164	91	
2.	405 дугаар хорих анги	115	57	
3.	407 дүгээр хорих анги	288	271	
4.	409 дүгээр хорих анги	960	363	
5.	413 дугаар хорих анги	360	350	
6.	415 дугаар хорих анги	476	376	
7.	417 дугаар хорих анги	156	166	+10
8.	419 дүгээр хорих анги	229	257	+28
9.	421 дүгээр хорих анги	216	218	+2
10.	423 дугаар хорих анги	376	368	
11.	425 дугаар хорих анги	208	245	+37
12.	427 дугаар хорих анги	400	380	
13.	429 дүгээр хорих анги	140	79	
14.	433 дугаар хорих анги	342	196	
15.	435 дугаар хорих анги	216	167	
16.	437 дугаар хорих анги	144	205	+61
17.	439 дүгээр хорих анги	300	141	
18.	441 дүгээр хорих анги	80	71	
19.	445 дугаар хорих анги	172	207	+35
20.	457 дугаар хорих анги	104	126	+22
21.	Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага	52	51	
Нийт		5498	4259	

ШШГТХ-ийн 217 дугаар зүйлийн 217.1-д “Нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа хорих ялын 50-иас дээш хувийг эдэлсэн хоригдлыг харуул хамгаалалтгүй, 50-иас доош хувийг эдэлсэн хоригдлыг хорих ангийн өөрийн үйлдвэрлэл болон хорих ангиас гадуур прокурорын зөвшөөрлөөр гэрээний үндсэн дээр харуул хамгаалалттай хөдөлмөрлүүлж болно” гэж заасан нь Прокурорын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Прокурор ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавихдаа холбогдох хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 23.1.17-д “харуул хамгаалалтгүй ажиллах хоригдлын материалыг хянаж зөвшөөрөл олгох, гэрээгээр ажиллах хоригдлын талаарх саналтай танилцах” гэж заасантай зөрчилдсөн, цаашид Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх бүхий нэгжээс зөвшөөрөл авч, прокурорт танилцуулах хэлбэрээр зохицуулах боломжтой. ШШГТХ-ийн 241 дүгээр зүйлийн 241.1-т зааснаар хорих ангийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь биечилсэн болон техникийн хамгаалалттай байхаар заасан боловч 243 дугаар

¹⁵⁹ШШГБ-ын нөхцөл байдлын шуурхай мэдээ.2024.03.13.

зүйлд хорих өрөө, хорих анги дотор хоригдол зорчих бусад хэсгийг хамарсан болон хамгаалалтын бүсэд дуу-дүрсний, хамгаалалтын хашааны гадна талд дүрсний бичлэгийн хяналтыг хийхээр зохицуулсан нь шаардлага хангахгүй байна. Иймд хорих ангийн байршлаас гадуур гарч ажил хийж буй хоригдолд биечилсэн болон техникийн хамгаалалттай байхаар зохион байгуулахдаа телехяналт тавих зориулалт бүхий нисгэгчгүй нисэх төхөөрөмж /дрон/, байршил тогтоох цахим төхөөрөмж /цахим гав, цахим чип/ зэрэг технологийг нэвтрүүлэн хяналт тавьснаар хорих ял эдлүүлэх дэглэм, зэрэглэл харгалзахгүйгээр, хорих ангийн хамгаалалтын бүсээс гадуур хоригдлыг хөдөлмөрт хамруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Нэг. Хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэл:

1. Эрүүгийн хуулийн 5.4 дүгээр зүйлийн 5.4.1-д “Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ” гэж тодорхойлсон бөгөөд 2017 онд шинэчлэн батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 163 дугаар зүйлийн 163.3-д “Шүүх ялтны мэргэжил, ур чадварыг харгалзан ялтанд тодорхой нийтэд тустай ажлыг хийхээр даалгасан тохиолдолд ялыг шүүхийн шийдвэрт заасан журмын дагуу гүйцэтгэнэ” гэсэн боловч өнөөдрийн байдлаар шүүхээс нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтныг ажиллуулах нийтийн ашиг сонирхолд нийцсэн ажлыг шүүхийн шийдвэрт тогтоон ирүүлэхгүй байна. Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 163 дугаар зүйлийн 163.1-д “Шүүхийн шийдвэрт тусгайлан заагаагүй тохиолдолд нийтэд тустай ажлыг нутгийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагаас баталсан жагсаалтад заасан байгууллагад гүйцэтгэнэ”, 163.2-д “Нийтэд тустай ажил хийлгэх байгууллагыг сонгохдоо ялтны эрүүл мэндийн байдал, эзэмшсэн мэргэжил, ур чадварыг харгалзан ахлах шийдвэр гүйцэтгэгч ажиллуулах байгууллагыг тогтооно ” гэж нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтийг хэрхэн хангах талаар тусгагдсан.

Одоогийн мөрдөгдөж буй хуулиар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь ажлын байраар хангах боломжтой аймаг, нийслэл, сум, дүүргийн харьяа тохижилт үйлчилгээний орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудад нийтийн эзэмшлийн гудамж, талбайн цэвэрлэгээ, ногоон байгууламж арчлах, хайс, хашлага засвар, байгууллага, дүүргийн гадна талбайн тээврийн хэрэгслийн зохицуулагч, хог ачих, буулгах зэрэг ажлуудыг хийлгэн ялыг эдлүүлж байна.

2. Эрүүгийн хуульд нийтэд тустай ажил хийлгэх ялын доод болон дээд хэмжээ нэмэгдэж 240-720 цаг, өдөрт ажиллах цагийг 4-өөс дээшгүй, ялтан хүсвэл 8 цагаас ихгүй байхаар хуульчилсан нь ялтнууд суралцах болон ажлаа хийхийн зэрэгцээ нийтэд тустай ажил хийлгэх ялыг эдлэхэд ялын үргэлжлэх хугацаа урт болсон. Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтнууд нь нийгэм, гэр бүл, хамт олныхоо дунд, үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэхийн зэрэгцээ нийтэд тустай ажлыг өөрийн биеэр хийж, гэмт хэргийн хор уршгийг ухамсарлан ялыг эдэлж байгаа тул цаашид торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, эрх хасах ялыг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, сайжруулах шаардлага урган гарч байна. Өмнө нь мөрдөгдөж байсан эрүүгийн хуулийг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрүүгийн хуультай харьцуулахад шинээр батлагдсан эрүүгийн хууль гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд хорих бус хорихоос өөр төрлийн ялыг түлхүү хэрэглэхээр хуульчилсан нь манай орны эрүүгийн ялын бодлого энэрэнгүй /гуманизация уголовной политики/ ёсны зарчимд суурилсан буюу ялын уян хатан, зөөлөн /гибкость/ бодлогыг баримталж буйг илтгэн харуулж байна.

3. Хуулийн 299 дүгээр зүйлийн 299.5-д “Энэ хуулийн 169.1-д зааснаас бусад тохиолдолд захиргааны, зөрчлийн, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.” гэж заасан боловч эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг аймаг, нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн төсөвт тусгайлан суулгадаггүй, албан хаагчдын цалингийн сан, захиргааны болон бичиг хэргийн зардал гэх мэтээр ерөнхийлөн тусгадаг. Уг захиргааны зардлаас салгаж хорихоос

өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг газар, хэлтсийн төсөвт тусгаж, олгохгүй байгаа нь ял, албадлагын арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль шинэчлэн батлагдсанаар Цагдаагийн байгууллагын гүйцэтгэж байсан зарим чиг үүрэг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжин ирсэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, тогтоолын биелэлтийг хойшлуулсан болон албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд хяналт тавих, Зөрчлийн хуулиар шийтгүүлсэн этгээдэд холбогдох шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шийдвэр гүйцэтгэгч хариуцан ажиллаж байна. Улсын хэмжээнд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан ахлах шийдвэр гүйцэтгэгч 16, шийдвэр гүйцэтгэгч 53 ажиллаж байгаа хэдий ч нийслэл болон ачаалал ихтэй зарим орон нутагт нэг шийдвэр гүйцэтгэгч 162-400 ялтан, этгээдэд хяналт тавин ажиллаж байгаа нь батлагдсан жишиг, нормативаас 42-280 ялтан, этгээдээр илүү байсаар байна.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 167 дугаар зүйлийн 167.1-т “Шийдвэр гүйцэтгэгч нь зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны байнга оршин суугаа болон хөдөлмөр эрхэлж байгаа, эсхүл суралцаж байгаа газрын хаягаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд техникийн хяналтын болон биечлэн хяналт тавина.”, мөн зүйлийн 167.2-т “Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлсэн хугацааг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тоолно”, мөн зүйлийн 167.3-т “ Шийдвэр гүйцэтгэгч ялтанд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журам, хяналтын техник, хэрэгслийг ашиглах, арчлах заавар, журам, эдлэх нөхцөл, журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, авах арга хэмжээний талаар тайлбарлаж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна” гэж зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг хэрхэн хангах талаар тус тус тусгагдсан байна. Эндээс харахад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан үндэслэлээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа газар, хэлтсийн хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгч нар “зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт”-ийг биечлэн болон техникийн хяналтыг хангуулахаар зохицуулсан ч ялын биелэлтийг хангахад дараах хүндрэлтэй асуудлууд тулгарч байна. Үүнд: Шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан үндэслэлийн дагуу “Шийдвэр гүйцэтгэгч нь ялтны оршин суугаа болон хөдөлмөр эрхэлж байгаа газрын хаягаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд техникийн болон биечлэн хяналт тавина” гэж заасан ч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа нэгжгүй нутаг дэвсгэрт зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд хэрхэн хяналт тавих талаар “хууль, эрх зүйн зохицуулалт” байхгүй, Зорчих эрх хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан төвөөс алс сум, багт ажиллаж амьдардаг тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч тухай бүр нь тогтоосон хугацаанд биечлэн хяналт тавих боломжгүй, Шийдвэр гүйцэтгэгч нь алсгагдсан орон нутагт ял эдэлж буй ялтанд биечлэн хяналт тавихад зардал ихээс гадна ялтан хуульд заасан зөрчил гаргасан, оргосон тохиолдолд тухайн бүсэд шуурхай хүрч ажиллах боломжгүй, ялтныг хяналтаас алдах эрсдэлтэй байна.

5. Шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 167.2-т “Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлсэн хугацааг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тоолно” гэж заасан ч хэрэгжүүлэхэд дараах асуудлууд тулгарч байна. Хорихоос өөр төрлийн ялын онцлогоос хамаарч хугацааг тоолох талаар 2 өөр зохицуулалтыг оруулсан байдаг.

6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 160 дугаар зүйлийн 160.1-д “Ялтан торгох ял оногдуулсан шийдвэрт өөрөөр заагаагүй бол тухайн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 90 хоногийн дотор, хэрэв хэсэгчлэн төлөхөөр тогтоосон бол тогтоосон хугацаанд биелүүлэх үүрэгтэй” мөн хуулийн 164 дүгээр зүйлийн 164.2 -т “Нийтэд тустай ажил хийлгэх ял эдэлсэн хугацааг ялтан ажил гүйцэтгэж эхэлсэн цагаас эхлэн тооцож, шүүхийн шийдвэрт заасан хугацаа дуусгавар болтол эдлүүлнэ.” мөн хуулийн 167 дугаар зүйлийн 167.2-т “Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлсэн хугацааг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тоолно.” мөн хуулийн 180 дугаар зүйлийн 180.2-т “Эрх хасах ял эдэлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан хугацааг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тоолно.” гэж тус тус заасан. Торгох, зорчих эрхийг хязгаарлах, эрх хасах ял гүйцэтгэх хуудас хүчин төгөлдөр болсон өдрөөс, нийтэд тустай ажил хийлгэх ялыг ялтан ажил хийсэн өдрөөс эхлэн тоолохоор зохицуулалт хийгдсэн. Шүүхээс гүйцэтгэх хуудсанд хүчин төгөлдөр болсон өдрийг тусгаагүй, хугацаа алдаж хүргүүлдгээс зорчих эрхийг хязгаарлах ял, эрх хасах ял шийтгүүлсэн ялтан хяналтад ороогүй байхад хугацаа тоологдон ял завших нөхцөл боломжийг бүрдүүлэх, шүүхээс тогтоосон торгох ялыг биелүүлэх хугацаа дууссан үед ирүүлж хяналт тавих боломжгүй байдал үүсэж байна.

Хоёр. Хорих ялын гүйцэтгэл:

1. Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар хорих ял эдлүүлэх тогтолцоог нээлттэй, хаалттай болон энгийн, тусгай гэсэн зэрэглэлтэй байхаар зохицуулсан нь цаг үеэ олсон чухал заалт болжээ. Гэвч нээлттэй, хаалттай гэх зохицуулалт нь дэглэм мөн эсэх, зэрэглэл хоорондын ялгаатай байдлыг нарийвчлан зохицуулаагүй байх нь судалгааны үндсэн дээр харагдаж байна. Түүнчлэн хуучин хуульд байсан 15 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэгдсэн, эсхүл онц аюултай гэмт хэрэгтнийг аль төрөлд хорих асуудлыг хуульчлан тогтоогүйгээс анх удаа гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудтай цуг хорих нөхцөл бүрдэж байна.

2. Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн эрх зүйн зохицуулалт нь хэт их шат дамжлага дамжсан зөвшөөрлийн хүрээнд явагдаж буй нь тулгамдаж буй асуудал гэж үзлээ.

3. Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажилд хоригдлын үйлдсэн гэмт хэрэг, хувийн онцлогт нь тохирсон хөтөлбөр ашиглах явдал учир дутагдалтай байна.

4. Европ, Ази, Африк, Австрали, Америк тивийн орнуудын эрүүгийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн эх сурвалжид “хамгаалалтын зэрэглэл” гэсэн нэр томъёог ашигласан байх бөгөөд энэхүү зэрэглэлээр нь нээлттэй, хагас нээлттэй, хаалттай, хагас хаалттай гэх зэргээр хувааж тэдгээрийн агуулгад хоригдолд тавих хяналт, хорих байгууллагын хамгаалалт, хоригдлын эрхийн хязгаарлалт, сайшаал-урамшуулал, албадлага хэрэглэх асуудлууд нэгэн адил хамаардаг байна. Хорих ялыг хоригдлын амьдарч байсан засаг захиргааны нэгжийн буюу гэр бүлийн гишүүдийнх нь ойролцоо эдлүүлэх нийтлэг зарчимд тулгуурлан гадаад улсуудад хорих ял эдлүүлэх байгууллагын зохион байгуулалтын бүтцийг гибрид буюу хэд хэдэн дэглэм, харуул хамгаалалтын зэрэглэл нэг дор оршин үйлчилж байна.

ТАВ. ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль, тогтоомж:

1. Үндсэн хууль. 1992 он
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /шинэчилсэн найруулга/. 2017 он
3. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. 2015 он
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он
5. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай 1999 он
6. Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/. 2017 он
7. Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/. 2017 он
8. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. 2017 он
9. Иргэний хууль. 2002 он
10. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2002 он

Хоёр. Ном, сурах бичиг, гарын авлага, судалгааны тайлан:

1. Б.Алтангэрэл. “Хорих ял эдлүүлэх ажиллагаа” сурах бичиг. УБ., 2018 он
2. Б.Алтангэрэл. “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа” сурах бичиг. УБ., 2019 он
3. М.Алтан-Очир. Хорих ял эдлүүлэх дэглэм. УБ., 2020 он
4. ДХИС. “ШШГБ-ын үйл ажиллагааны талаарх иргэдийн ойлголт, төсөөлөл” судалгааны тайлан. УБ., 2020 он
5. ДХИС. Иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа судалгааны тайлан. 2020 он
6. Б.Алтангэрэл “Эрүүгийн ялын гүйцэтгэлийн үр нөлөөнд хийсэн дүн шинжилгээ” судалгааны тайлан. УБ., 2018 он

ТАВДУГААР БҮЛЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

1.1. Үнэлгээ хийх шалтгаан:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийн хүчин төгөлдөр эрүү, иргэн, захиргааны шүүхээс гаргасан шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэдэг, төрийн албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй төрийн цэргийн байгууллага юм.

Шүүхийн шийдвэр бүрэн биелснээр төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, эрх зүйн зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулсан хариуцлагыг бүрэн эдлүүлэх зэргээр нийгэмд шударга ёс тогтоох, иргэдийн төрд итгэх итгэл дээшлүүлэх, улмаар ардчиллын үндсэн зарчим бэхжүүлэх үйл явцад чухал байр суурь эзэлдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуульд тодорхойлсон тусгайлсан чиг үүрэг гэх ойлголтыг нэг мөр болгох, хамаарах асуудлыг нарийвчлан судлах, үндэсний аюулгүй байдлыг хангахад нөлөөлөх эсэх талаар судалгааны ажлын шаардлагыг үндэслэн энэхүү сэдвийг сонгох үндэслэл болсон. Түүнчлэн тус байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдалд үнэлгээ хийж, тулгамдсан асуудлыг судалгааны үндсэн дээр нээн илрүүлж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэгдсэн зөвлөмжийг гаргах шаардлагыг үндэслэсэн болно.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд заасны дагуу хууль тогтоомж нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд үнэлгээний ажлыг эхлэхээс өмнө үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлно. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлохыг зорилоо.

1.2. Үнэлгээ хийх хүрээ:

Аливаа хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлахад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүтэц, тогтолцоо, чиг үүрэг, алба хаагчтай холбоотой зүйл, заалт тус хуулийн 15,2 хувь буюу 257-302 дугаар зүйлийг хамарч байдаг.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.4 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхдээ хууль тогтоомжид бүхэлд нь, эсхүл түүний зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож болно” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн баривчлах шийтгэл гүйцэтгэх ажиллагаанд холбогдох зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлсэн болно. Ингэхдээ захиалагч байгууллага болох ШШГЕГ-ын ирүүлсэн ажлын даалгавар, үнэлгээ хийх болсон шалтгааны харилцан уялдаа, хамааралтай байдлыг

харгалзаж, хуулийн хэрэгжилтэд гарч буй эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон зохицуулалтыг сонгосон.

Үүний дүнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дараах зохицуулалтыг үнэлгээ хийх хүрээнд хамрууллаа.

д/д	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Зохицуулалтын агуулга
1.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 257, 263-269 дугаар зүйл	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн байдал
2.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 283-288 дугаар зүйл	Алба хаагчийн эрх зүйн байдал
3.		Шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллын асуудал

1.3. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт:

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд зааснаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтийн жагсаалтыг гарган, үнэлгээ хийх асуудал тодорхой болсон үед тодорхой 1 шалгуур үзүүлэлтийг сонгон авах бөгөөд зөвхөн 1 шалгуур үзүүлэлтээр тухайн асуудалд бүрэн үнэлэлт өгөх боломжгүй тохиолдолд 2 болон түүнээс дээш шалгуур үзүүлэлтийг сонгох боломжтой гэжээ.

Аргачлалд заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын болон алба хаагчийн эрх зүйн байдлын хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж байгаа байдал гэсэн хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр:

Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтийг олж тодорхойлоход харьцуулах 4 төрлийн хэлбэрээс хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш-хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтооход чиглэгдэнэ. Тодорхой цаг хугацааны дарааллаар нөхцөл байдлын өрнөлийг жагсааж гаргасан судалгааг үнэлгээнд хэрэглэх хэлбэрийг сонгон ашиглалаа.

Энэ хэлбэрийг ашиглахдаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын болон алба хаагчийн эрх зүйн байдалтай холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран тоо баримт, олон улсын эх сурвалж, бусад материалд дүн шинжилгээ хийнэ.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох:

Шалгуур үзүүлэлтийг томъёолохдоо шалгуур үзүүлэлт тус бүрээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааны сонгон авсан хэсэгт тохируулан дараах шалгуур үзүүлэлтийг сонгож, асуулт боловсрууллаа.

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилт;

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 257, 263-269 дугаар зүйл нь зорилгод нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 283-288 дугаар зүйл зорилгод нийцэж байгаа эсэх, практикт хүндрэл, бэрхшээл учруулж байгаа эсэх;

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох:

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтэд тулгамдсан асуудлыг илрүүлэх зорилгоор баримт бичиг, судалгааны тайлан, илтгэл, өгүүлэл унших, судлах, харьцуулалт хийх, ШШГБ-ын алба хаагчдаас тулгамдаж буй асуудлын талаар судалгаа авах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд аргачлалын 3.7.3-т мэдээлэл цуглуулах дөрвөн аргыг тодорхойлсноос дараах хоёр аргыг сонгон үнэлгээ хийх мэдээллийг цуглуулсан болно.

1. Мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийх;

2. Судалгаа авах.

Мэдээлэл цуглуулах хүрээнд: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, холбогдох ном, сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, журам, зааврыг цуглуулж, үнэлгээ хийхэд ашиглав.

Судалгаа авах хүрээнд: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын болон алба хаагчийн эрх зүйн байдалтай холбоотой тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлэхийн тулд алба хаагчтай ярилцлага хийх, анкетын аргаар судалгаа авсан. Түүнчлэн ШШГЕГ-ын үйл ажиллагааны тайлан, судалгаа, бусад мэдээллийг гаргуулан авч үнэлгээ хийхэд ашигласан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, алба хаагчидтай уулзалт-ярилцлага хийх, анкетын судалгаа авч, ярилцлагын аргад тулгуурлаж энэхүү судалгааг гүйцэтгэв.

2.1. Баримт бичгийн судалгаа: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлүүд, илтгэл, өгүүлэл, тайланг ашигласан болно.

2.2. Холбогдох субъектээс авсан судалгаа:

а) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын болон алба хаагчийн эрх зүйн байдалтай холбоотой 1168 алба хаагчаас сонгон авсан эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, тулгамдсан асуудлын талаарх санал-асуулга;

2.3. Ярилцлагын арга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн бодит байдал, хууль хэрэглээнд тулгамдаж буй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг тодруулахаар ярилцлага хийсэн.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн байдал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийн хүчин төгөлдөр эрүү, иргэн, захиргааны шүүхээс гаргасан шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэдэг, төрийн албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй төрийн цэргийн байгууллага юм. Шүүхийн шийдвэр бүрэн биелснээр төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, эрх зүйн зөрчил үйлдсэн этгээдэд оногдуулсан хариуцлагыг бүрэн эдлүүлэх зэргээр нийгэмд шударга ёс тогтоох, иргэдийн төрд итгэх итгэл дээшлүүлэх, улмаар ардчиллын үндсэн зарчим бэхжүүлэх үйл явцад чухал байр суурь эзэлдэг.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Үндэсний аюулгүй байдлыг хангах үүргийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газар, хууль сахиулах болон тусгай чиг үүрэгтэй байгууллагууд, төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд гүйцэтгэнэ” гэж тодорхойлон, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд: “Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газар, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон холбогдох албан тушаалтнаас бүрдэнэ” хэмээн зааж өгчээ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй дараах байгууллагууд байна. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах алба;
- Гаалийн алба;
- Дипломат алба;
- Гамшгаас хамгаалах алба;
- Зэвсэгт хүчин, бусад цэрэг;
- Татварын алба;
- Тусгай алба;
- Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба;
- Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхлэх алба;
- Цагдаагийн алба багтаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулиар хүлээсэн эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх явцад дээрх тогтолцоог бүрэлдүүлж буй тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай харилцан хамтран ажиллаж байдаг.

Өнөөдрийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд нийт 200 гаруй эрх зүйн акт (дүрэм, журам, заавар, стандарт) хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Дээрх дүрэм, журам зааврын 50-60 хувь нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх тэр дундаа иргэн, нийгмийн аюулгүй байдлыг хангах, хорих анги, байгууллага бүхий онцгой объектыг цэргийн сахилга бат, зохион байгуулалтын хүрээнд хамгаалах, харуул манааны үүргийг журамлахад чиглэгдэж, “Цэргийн нийтлэг дүрмүүд”-ийг мөрдлөг болгон ажиллаж Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан “Цэргийн цол олгох журам”-ыг баримтлан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад цэргийн цол олгодог. Тус зарлигийн нийтлэг үндэслэлийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэгт цэргийн цол олгох харицааг зохицуулахаар зааж өгсөн ба

энэ нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч цэргийн цол хэрэглэх нэг үндсэн эрх зүйн үндэслэл болдог. Мөн нийт алба хаагчийн бие бялдрын бэлтгэлжилтийг хангах, түүнийг зохион байгуулах, түвшинг тогтоох, шалгах, үнэлэхэд Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/505 дугаар тушаалаар батлагдсан “Цэргийн бие тамирын бэлтгэлийн стандарт”-ыг баримталж байгаа бөгөөд энэ нь Батлан хамгаалах тухай хуульд заасан цэргийн байгууллагын тодорхойлолтод нийцэж байна.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “галт зэвсэг хэрэглэх эрхтэй” гэх зохицуулалтыг үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 285 дугаар зүйлийн 285.5 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч хуульд заасан үндэслэл, журмын дагуу нэг бүрийн тусгай хэрэгсэл, биеийн хүч, галт зэвсэг хэрэглэх эрхтэй” гэж заасны дагуу хорих анги, цагдан хорих, баривчлах байр болон бусад онцгой объектын аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж буй алба хаагч, цэргийн алба хаагчтай нэгэн адил галт зэвсэг хэрэглэх эрхийг хуулиар олгогджээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч хоорондын харилцаандаа “Цэргийн албаны дотоод дүрэм”, онцгой объектын харуул хамгаалалтын үйл ажиллагаа, хамгаалалтын ажилтны ээлж хүлээлцэхэд “Цэргийн хүрээний ба харуулын албаны дүрэм”, алба хаагчийн жагсаалын ажиллагаа, хөдөлгөөн, жагсаалын үзлэг явуулахад “Цэргийн жагсаалын дүрэм”, сахилга, ёс зүйн зөрчил болон албаны хариуцлага, дэг журмыг сахин биелүүлэхтэй холбогдсон харилцааг “Цэргийн сахилгын дүрэм”-ийг баримтлан шийдвэрлэж байгаа нь цэргийн байгууллагуудтай нэгдмэл байгааг харуулж байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1 дүгээр зүйлийн 1.1.5 дахь хэсэгт “Монгол Улсын төр, нийгэм, иргэний аюулгүй байдал харилцан, уялдаатай хангагдсанаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдал баталгаажна”, 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн” гэж тус тус заасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага Монгол Улсын хэмжээнд үйлдэгдэж буй бүх төрлийн гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч, гэмт буруутай нь шүүхээс тогтоогдож хорих ял шийтгүүлсэн этгээд болон зөрчлийн хэрэгт шийтгэгдсэн хүнийг холбогдох хуулийн хүрээнд нийгмээс тусгаарлах чиг үүргийг хэрэгжүүлж, дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх замаар Монгол Улсын дотоод аюулгүй байдлыг хангах тогтолцоонд чухал байр суурийг эзэлдэг. Өөрөөр хэлбэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь иргэн, нийгмийн аюулгүй байдлыг хангах, гэмт халдлага, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, хор уршгийг бууруулах тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд энэхүү чиг үүргийг цэргийн албаны сахилга бат, зохион байгуулалтад тулгуурлан хэрэгжүүлдэг нь тус байгууллагыг “Төрийн цэргийн байгуулал”-д хамаарч буй нь зүй ёсны болохыг илэрхийлж байна.


Дэлхийн зарим улс орны нөхцөл байдлыг судлан үзвэл эрүү, иргэний шүүхийн шийдвэрийг төрийн нэрийн өмнөөс албадан хэрэгжүүлдэг байгууллагын 80 гаруй хувь нь цэргийн албаны статустайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай төстэй чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагыг

сонгон авч тухайн байгууллагын хэрэглэдэг цол, алба хаагчийн эрх зүйн байдлын талаарх судалгааг хийж үзэхэд: Чех, Польш, Унгар, Болгар, Словак, Беларусь, Вьетнам, Украин зэрэг 34 улс нь Ром-Германы, Америк, Канад, Австрали, Сингапур, Бангладеш зэрэг 16 улс Англо-Саксоны эрх зүйн тогтолцоонд хамаарч байна.

Судалгаанд хамрагдсан 50 гаруй улс орны шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын цол, хувцас хэрэглэлийг харъяаллаар ангилан авч үзвэл, Чех, Украин, Словак, Беларусь, Польш, Молдав, Армен, Казакстан, Киргиз, Бангладеш, Вьетнам, Сенегал, Иордан зэрэг 40 гаруй улс ял эдлүүлэх буюу хорих байгууллагын алба хаагчид тухайн улсын цэргийн цол, хувцсыг хэрэглэж, эрх зүйн байдлын хувьд цэргийн алба хаагчийн статустай байх ба Австрали, Канад, Япон, Солонгос, Сингапур, Тайланд, Малайз, Австри, Серби, Латви, Хорват Дани зэрэг 10 гаруй улс орны хорих байгууллагын алба хаагчид тусгайлсан цол, ялгах тэмдгийг хэрэглэж байна.

Харин иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх чиг үүргийн хүрээнд явагддаг иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувьд АНУ, Канад, Серби, Армен, Герман, Франц, Израйл улсын шийдвэр гүйцэтгэгчид бие даасан байгууллагын цол, Беларусь, Узбекистан, Иран, Тажикстан улсын шийдвэр гүйцэтгэгчид цэргийн цол, хувцсыг хэрэглэдэг бол Итали, Швейцарь, Эстони, Латви, Литва зэрэг улсын иргэний шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагааг нь мэргэшсэн шийдвэр гүйцэтгэгчдийн холбооны алба хаагчид гүйцэтгэж байна.

Зураг 41. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо чиг үүрэгт өгсөн үнэлгээ



Судалгааны түүврийн 290 буюу 28.9 хувь нь одоогийн тогтолцоо, чиг үүрэг хангалттай зохицуулагдсан, 176 буюу 17.5 хувь нь хуульд заасан тогтолцоо, чиг үүрэг нь ойлгомжгүй, давхардалтай тул шинэчлэх шаардлагатай, 539 буюу 53.6 хувь нь нарийвчлан зохицуулах шаардлагатай гэжээ. Нарийвчлан зохицуулах шаардлагатай гэж үзсэн алба хаагчийн ажилласан жилээр нь ангилан үзвэл 11-ээс дээш жил ажилласан алба хаагчийн 27.8 хувь, 7-10 жил ажилласан алба хаагчийн 22.4 хувь, 4-7 жил ажилласан алба хаагчийн 27.8 хувь, 1-3 жил ажилласан алба хаагчийн 30.3 хувь, 1 жил хүртэл ажилласан алба хаагчийн 39.3 хувь нь дэмжсэн байна.

ШШГТХ-ийн 257 дугаар зүйлийн 257.3-т “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага, иргэний, захиргааны, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх алба /цаашид "шийдвэр гүйцэтгэх алба" гэх/, цагдан хорих шүүхийн шийдвэр, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх алба /цаашид "хорих ял эдлүүлэх алба" гэх/, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг гүйцэтгэх алба /цаашид "хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба" гэх/, хорих байгууллага, аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс /цаашид "шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс" гэх/-ээс бүрдэнэ” гэж заажээ.

Хуульд хорих байгууллага, аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр газар, хэлтсийг “цаашид шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс гэх” гэсэн нь хорих байгууллагууд тухайн газар, хэлтэст хамаарах эсвэл нэг ойлголт байхаар зохицуулагдсан байна. Түүнчлэн Нэгдсэн эмнэлэг, Цагдан хорих 461 дүгээр анги, Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага болон Улаанбаатар хотод байрлах бүхий л хорих ангиуд Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт харьяалагдахаар байна.

Түүнчлэн хуулийн 257.1-т “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага мөн” гэж заасан нь Монгол Улсад шүүхээс гаргасан бүхий л төрлийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын хүрээнд гүйцэтгэх чиг үүрэг бүхий төрийн байгууллага байхаар тодорхойлогдсон байна.

ШШГЕГ-ын харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн нийт 250 шийдвэр гүйцэтгэгчээс 211 буюу 84.4%-иас нь иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэж буй байгууллагын харьяалалын талаар судалгаа авахад 70 буюу 33.1% нь ШШГЕГ-ын харьяанд байлгах, 35 буюу 16.5% нь хувийн хэвшлээр гүйцэтгүүлдэг тогтолцоонд шилжих, 54 буюу 25.5% нь тусдаа бие даасан агентлаг болох, 52 буюу 24.6% шүүхийн харьяанд шилжүүлэх гэсэн хариултыг өгсөн байна.

Олон улсын жишгийг судлан үзэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэдэг дараах үндсэн хэлбэртэй байна. Үүнд:

1. Шүүхийн харьяаны байгууллага гүйцэтгэх;

Шүүхийн байгууллагын тогтолцоонд байж, шүүгч өөрийн гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавин, гүйцэтгэлийг нь зарим тохиолдолд өөрчлөх, эсхүл албадлага хэрэглэхэд биечлэн оролцдог байна.

2. Төрийн хуулиар эрх олгогдсон байгууллага гүйцэтгэх;

Хуулиар тусгайлан эрх олгосон цэрэгжүүлсэн байгууллага төрийн албадлагын арга хэмжээгээр дамжуулан хэрэгжүүлдэг.

2. Төрийн болон хувийн байгууллага байх холимог тогтолцоо:

- хувийн шийдвэр гүйцэтгэл нь иргэд болон хуулийн этгээдийн хоорондын эд хөрөнгийн шинжтэй шийдвэрийг хэрэгжүүлдэг;

- хүүхдийн тэтгэлэг, эрүүгийн хэргийн хохирол, төрийн нэхэмжлэл зэрэг шийдвэрийг төрийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлдэг.

3. Хувийн шийдвэр гүйцэтгэлийн тогтолцоо;

- эрх зүйн системээсээ хамаарч өөр өөр байх ба иргэдийн өр төлбөр, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг хоорондын зуучлалын системээр хэрэгжүүлдэг.

ШШГБ-ын алба хаагч нь төрийг төлөөлж, хууль сахиулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг явуулдгийн хувьд үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хүний эрхийг хүндэтгэн хамгаалах зарчмыг ямагт мөрдөн ажилладаг. Нөгөө талаас тус байгууллагын ажилтны үйл ажиллагаагаа хараат бус, үр дүнтэй явуулах эрх зүйн болон нийгмийн баталгааг төр бүрдүүлж өгөх үүрэгтэй боловч нийгмийн хөгжлийг даган цаг үетэйгээ уялдаж улам боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг нэмэгдүүлэхэд хамгийн тулгамдсан асуудал бол тухайн ажиллагааг гүйцэтгэж буй байгууллагын тогтолцооны асуудал билээ. Харьцуулсан судалгаанаас авч үзэхэд гадаадын зарим улс орнуудын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь тогтолцооны хувьд өөр өөр байгаа бөгөөд төрийн буюу засгийн газар болон шүүхэд харьяалагддаг, ашгийн төлөө байгууллага буюу хувийн хэвшилд харьяалагддаг, холимог тогтолцоотой буюу засгийн газрын болон хувийн хэвшилд харьяалагддаг бүтэцтэй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг Шүүхийн удирдлага дор гүйцэтгэх засаглалаас хараат бусаар шүүхийн шийдвэр гүйцэтгэгч хэрэгжүүлдэг тогтолцоог шүүхийн тогтолцоо гэх бол төрийн тогтолцоо гэдэг нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг Засгийн газрын агентлагийн харьяанд төрийн албан хаагч шүүхээс хараат бусаар хэрэгжүүлнэ. Дан шүүхийн эсхүл төрийн албан хаагчийн тогтолцооноос гадна хувийн аж ахуйн нэгж шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг давхар хэрэгжүүлдэг бол холимог тогтолцоотой гэж ойлгож болно. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь шүүх болон Засгийн газраас хараат бусаар зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулахыг хувийн тогтолцоо гэдэг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төрийн тогтолцоо нь шийдвэр гүйцэтгэгчийн цалинг төсвөөс олгодог, төлбөр авагчийн төлбөрөө гаргуулан авах баталгаа нь төр байдаг, шүүхийн ямар ч шийдвэрийг биелүүлэх гэсэн нэг л зорилготой, нэгдмэл удирдлагатай, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, хуулийг нэг мөр хэрэглэх боломжтой байна. Төрийн тогтолцоотой улс оронд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь бусад төрийн байгууллагын туслалцаа, оролцоотойгоор үйл ажиллагаагаа явуулах тохиолдол элбэг байдаг. Мөн төрийн албан хаагч шийдвэр гүйцэтгэгчийн хувьд шийдвэр гүйцэтгэгчийн ажлын байр, цалин орлого илүү баталгаатай, тогтвортой төрийн тогтолцоо хамгийн тааламжтай байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хувийн тогтолцоо нь шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэрийг биелүүлэх бүхий л арга замыг ашиглан төлбөр төлөгчөөр төлбөл зохих төлбөрийг гаргуулдаг. Шийдвэр гүйцэтгэгч нь ашиг олох зорилготой учраас төлбөр гаргуулах бүхий л арга хэмжээг авч ажиллана. Үйлчлүүлэгч нь шүүхийн шийдвэрийг хамгийн богино хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлж чадах байгууллагыг сонгох боломжийг олгодог. Гэхдээ хувийн тогтолцоог иргэд хүлээн зөвшөөрч, шаардлагыг нь биелүүлэхэд тодорхой хэмжээнд бэрхшээлтэй байдаг. Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь ажилчдаа олгох цалин хөлс, түрээс, тоног төхөөрөмжийг санхүүжүүлэхээс гадна хувийн хариуцлага хүлээж, төлбөрийн чадваргүй болох эрсдэл өндөр байдаг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төрийн, хувийн эсхүл холимог тогтолцоог сонгох эсэх нь эрх зүйн тогтолцооноос бус тухайн улсын эдийн засаг, улс төр, захиргааны болон бусад хүчин зүйлээс шалтгаална¹⁶⁰.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх үйл явц, тэдгээрийн төгсгөлийн үе шат болохын хувьд, салшгүй холбоотой төдийгүй шүүхийн үйл ажиллагааны үргэлжлэл болж байдаг. Тодруулбал, шүүхээс хүн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээн шийдвэрлэх бол уг эрхийг бодит байдлаар сэргээн эдлүүлэх үндэслэл, нөхцөл нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар дамжин хэрэгжилт хангагддаг. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл болох гүйцэтгэх хуудас олгох, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх захирамж гаргах, тэдгээрийг албадан гүйцэтгүүлэхээр хүргүүлэх үндэслэл ИХШХШТ хуулиар зохицуулагдаж, уг эрх зүйн харилцааны үргэлжилсэн үе шатыг ШШГТ хуулиар зохицуулж, эдгээр нь шүүх эрх мэдлийн хүрээнд хэрэгжих, харилцан хамааралтай зохицуулалт байна.

¹⁶⁰ Алтангэрэл, Б. Мөн тэнд. 11 дэх тал.

3.2. Алба хаагчийн эрх зүйн байдал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, тухайлан Хорих байгууллагын алба хаагчид тавигдах шаардлагыг олон улсын болон үндэсний хууль тогтоомжид дараах байдлаар тусгасан байдаг. Үүнд:

Нэг. Олон Улсын баримт бичиг:

1.1. “Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрмүүд”¹⁶¹:

Энэхүү дүрэм нь хорих байгууллагын загвар тогтолцоог дүрслэн бичихийг зорилгоо болголгүй, орчин үеийн сэтгэлгээний нийтээр хүлээн зөвшөөрсөн ололт, амжилтад үндэслэн, өнөө үед шаардлага хангахуйц гэж болох тогтолцооны үндсэн элементийг харгалзан үзэж хоригдолтой харьцах, хорих байгууллагыг удирдах салбарт зарчмын болоод практикийн үүднээс зөв гэж үзэж болох зүйлийг тайлбарлахад зориулагдсан.¹⁶² Дүрэмд хорих байгууллагын албан хаагчийн талаар дараах зүйл тусгагдсан. Үүнд:

1. Хорих байгууллагын алба хаагчид тавигдах шаардлага:

- а) хорих байгууллагын удирдах газар нь бүх төрлийн боловсон хүчнээ сонгоход анхаарч, тэдний мэдлэг, үүрэг хариуцлага, ёс зүй, хувийн чанарыг харгалзах нь зүйтэй;
- б) хорих байгууллагын захиргааны ажилтныг байнгын орон тоонд төрийн албан хаагчийн статустай, мэргэжлийн хүн сонгон томилж байвал зохино;
- в) албан хаагч нь хангалттай боловсролтой, оюун ухааны хөгжилтэй байвал зохино;
- г) алба хаагчийг ажилд авахын өмнө ерөнхий болон тодорхой үүрэг гүйцэтгэхэд бэлтгэн, онол, практикийн шалгалт авна;
- д) ажилд орсны дараа албан хаагч ажлаасаа хөндийрөхгүйгээр, зохих хугацаанд зохион байгуулагдаж буй бэлтгэл сургалтад хамрагдан, мэргэжлийн түвшингээ зохих түвшинд дээшлүүлж байх ёстой;
- е) хорих байгууллагын алба хаагч хоригдлуудад үлгэр жишээ болж, хүндэтгэл хүлээхээр биеэ авч явж, үүргээ гүйцэтгэж байх ёстой;
- ё) хорих байгууллагын албан хаагч түрэмгий ааш авир гаргасан хоригдлыг дарж чадахуйц биеийн хүчний онцгой бэлтгэлтэй байвал зохино.

2. Хорих байгууллагын албан хаагчийг томилох:

- а) хорих байгууллагын даргаар хувийн зан чанар, зохион байгуулах авьяас, мэргэжлийн бэлтгэл, туршлагын хувьд хангалттай мэргэшсэн хүнийг томилбол зохино. Дарга нь өөрийн бүх цагаа даалгасан үүргийг биелүүлэхэд зориулж, байнгын орон тоонд ажиллах ёстой;
- б) албан хаагчдын бүрэлдэхүүнд сэтгэл судлаач, эмгэг зүйч, нийгмийн ажилтан, багш болон гар урлалын сургалт явуулах чадвартай багшийг аль болох хангалттай тоогоор багтаавал зохино;
- в) нийгмийн ажилтан, багш, гар урлалын багшийг байнгын орон тоонд томилж байвал зохино;

¹⁶¹ Гэмт явдлаас урьчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгсдэд хандах асуудлаар 1955 онд Женевт хуралдсан НҮБ-ын нэгдүгээр хурлаар баталж, эдийн засгийн болон нийгмийн зөвлөлийн 1957 оны 7 дугаар сарын 31-ний 663 C/XXIY/, 1977 оны 05 дугаар сарын 1-ний 2076 /LXII/ тогтоолоор батлав.

¹⁶² Оюунчимэг, П. Эрүү шүүлтийн эсрэг Олон улсын эрх зүйн эх сурвалж ба үндэсний илтгэлүүд, Нэгдсэн Үндэсний Байгууллагаас өгсөн зөвлөмжүүд.-УБ., 2015. 62 дахь тал.

г) нэг буюу хэд хэдэн эмч байнгын орон тоонд ажиллах ба дор хаяж нэг эмч нь хорих байгууллагын нутаг дэвсгэрт эсхүл ойролцоо амьдардаг байвал зохино;

д) хорих байгууллагын алба хаагчийн ажлын хөлс нь чадварлаг хүн татагдахаар тооцон, ажлын онцгой хүнд нөхцөлийг харгалзан зохих хөнгөлөлт олгон, ажиллах орчин, нөхцөлийг хангавал зохино гэжээ.

Хоёр. Үндэсний хууль, тогтоомж:

2.1. Төрийн албаны тухай хууль:

Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д “зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын болон шүүх шинжилгээний байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч, шүүх шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн, гадаадын иргэн, харьяатын байгууллагын ажилтан”-г төрийн тусгай албан тушаалын төрөлд хамааруулахаар заажээ.

Төрийн жинхэнэ албан тушаалд дараах нийтлэг шаардлагыг хангасан иргэнийг томилдог. Үүнд:

1. Монгол Улсын иргэн байх;
2. Дээд боловсролтой байх (туслах албан тушаалд энэ шаардлага хамаарахгүй);
3. Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх;
4. Монгол хэлний ярианы болон бичгийн чадвартай байх;
5. Сэтгэцийн өвчин, эмгэггүй байх;
6. Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөөгүй байх;
7. Хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн байх.

2.2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль:

Төрийн албан хаагч Үндсэн хуульд заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмаас гадна ард түмэнд үйлчлэх, мэргэшсэн, тогтвортой байх, улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх, төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах, төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах, ил тод байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, захирах, захирагдах ёсыг баримтлах зарчмаас гадна дараах ёс зүйн зарчмыг баримтална:

1. Хүнлэг, энэрэнгүй байх;
2. Үнэнч, шударга байх;
3. Хариуцлагатай байх;
4. Манлайлах;
5. Хамтач байх.

2.3. Цэргийн албаны тухай хууль:

Цэргийн албаны тухай хуульд “цэргийн алба” гэж зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагад Монгол Улсын иргэн цэргийн алба хаах үндсэн үүргийг биеэр гүйцэтгэх, эсхүл цэргийн бүртгэлд байхыг ойлгоно гэжээ. Түүнчлэн офицерын алба хаагч нь боловсрол, мэргэжил, ур чадвар, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн зохих шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Офицерыг дунд, ахлах, дээд гэж ангилж, офицерын албыг дунд офицер 47 нас хүртэл, ахлах офицер 52 нас хүртэл, дээд офицер 57 нас хүртэл, эмэгтэйчүүд офицерын албыг цэргийн цол харгалзахгүйгээр 47 нас хүртэл хаахаар тусгажээ.

Офицер, ахлагч нь дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байна:

1. Дипломын болон түүнээс дээш боловсролтой байх;
2. Мэргэжил, мэргэшил, ур чадварын түвшин нь томилогдох албан тушаалын ажлын байрны шаардлагыг хангасан байх;
3. Биеийн эрүүл мэндээр цэргийн жинхэнэ албанд тэнцэх тухай цэргийн эмч нарын комиссын дүгнэлт гарсан байх;
4. Бие бялдрын ерөнхий шалгуур үзүүлэлтийг хангасан байх;
5. Цэргийн алба хаагчийн ёс зүйн шаардлага хангасан байх.

Ажлын зайлшгүй шаардлага, мэргэжлийн онцлогийг харгалзан офицер, ахлагчийн алба хаагчид тавигдах ерөнхий шаардлагыг хангасан 35 хүртэлх насны иргэнийг офицерын, 30 хүртэлх насны иргэнийг ахлагчийн албанд авч болох бөгөөд офицер, ахлагчийн албанд авах уг иргэнийг цэргийн бэлтгэл, сургалтад хамруулна.

2.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ШШГБ-ын алба хаагчаар Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан шаардлага, ШШГБ-аас тогтоосон журам, эрүүл мэнд, бие бялдар, боловсрол, мэргэжил, мэргэшил, ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, 18 насанд хүрсэн, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаагүй Монгол Улсын иргэнийг авч ажиллуулна гэж заасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч дараах эрх зүйн баталгаагаар хангагдаж байна. Үүнд:

1. Төрийн албан хаагчийн албан хаагчийн хувьд /Төрийн албаны тухай хуулийн 61, 61 дугаар зүйл/:

Төрийн албан хаагч дараах нийтлэг баталгаагаар хангагдана:

1. Албан тушаалын цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж авах;
2. Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах;
3. Гүйцэтгэж байгаа албан үүргийн шинж байдлаас хамааран зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах төрийн тээврийн хэрэгслийн зардлын зохих хэсгийг нөхөн авах;

4. Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг тухайн ажиллаж байгаа байгууллага, эсхүл цагдаагийн байгууллагаар хамгаалуулах;

5. Орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх;

6. Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралт эдлэх;

7. Төрийн хөрөнгөөр 6 хүртэлх сарын хугацаагаар давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдах, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалын цалинг авах;

8. Үүргээ зохих журмын дагуу биелүүлснээс албан хаагчид учирсан эд хөрөнгийн хохирлыг төр хариуцаж, гэм буруутай этгээдээр хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлэх;

9. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй төрийн захиргааны албан хаагчид түүний зөвшөөрснөөр 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгох;

10. Хууль тогтоомжоор тогтоосон бусад баталгаа.

Төрийн жинхэнэ албан хаагч дээрхээс гадна дараах нэмэгдэл баталгаагаар хангагдана:

а) хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөхгүй, халагдахгүй байх;

б) УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газар, УДШ-ийн Ерөнхий шүүгч, УЕП, аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ, бүх шатны Засаг даргын бүрэн эрх дуусгавар болох, мөн энэ хуульд заасан улс төрийн албан тушаалтан уг албан тушаалаас өөрчлөгдөх, төрийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч болон шууд захирагч өөрчлөгдөх нь төрийн албан хаагчийг өөрчлөх үндэслэл болохгүй байх;

в) төрийн байгууллага өөрчлөн байгуулагдсан, эсхүл зохион байгуулалтын бүтэц нь өөрчлөгдсөн боловч төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн бол түүнийг уг албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах, хэрэв тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаалын орон тоо цөөрсөн бол уг албан тушаалыг эрхэлж байсан албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, мэдлэг, ур чадвар, ажлын дадлага, туршлага зэргийг нь харгалзан тухайн албан тушаалд тавигдах нийтлэг болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа албан хаагчийг томилох эрх бүхий албан тушаалтан шалгаруулж авах;

г) төрийн байгууллага татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо нь хасагдсан тохиолдолд цалин хөлсөө бууруулахгүйгээр мэргэжил, мэргэшлийн дагуу өөр ажил, албан тушаалд шилжих буюу төрийн хөрөнгөөр 6 сар хүртэл хугацаагаар дахин мэргэшиж болох бөгөөд энэ хугацаанд урьд нь эрхэлж байсан албан тушаалынхаа цалин хөлсийг авч, хууль тогтоомжид заасан журмын дагуу ажлын байраар хангуулах, эсхүл 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэлгийг тухайн байгууллагаас олгох

2. ШШГБ-ын алба хаагчийн хувьд /ШШГТХ-ийн 283-288 дугаар зүйл/:

Хорих байгууллагын алба хаагч Төрийн албаны тухай хуульд заасан баталгаанаас гадна дараах улс төр, хууль зүй, нийгэм, эдийн засгийн баталгаагаар хангагдана.

Улс төрийн баталгаа:

1. Алба хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд хуульд заасан албан үүргээс нь гадуур дайчлах, оролцуулахыг хориглоно.

2. Алба хаагчийг улс төрийн үйл ажиллагаанд оролцохыг шаардсан бол татгалзана.

3. Алба хаагч үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ албандаа хүндэтгэлтэй хандана.

4. ШШГБ, алба хаагч үйл ажиллагаандаа улс төрийн намын бэлгэ тэмдэг агуулсан эд зүйл, техник хэрэгсэл ашиглахыг хориглоно.

5. Алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ аливаа улс төрийн нам, түүний үйл ажиллагааны талаар хувийн үзэл бодлоо илэрхийлэх, албаны эрх мэдлээ улс төрийн зорилгоор ашиглахыг хориглоно.

Хууль зүйн баталгаа:

1. Иргэн, албан тушаалтан алба хаагчийн хууль ёсны үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, хуулиар хүлээсэн үүрэгт үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгэхийг шаардахыг хориглоно.

2. Алба хаагч албан үүргээ хууль ёсоор гүйцэтгэснээс үүссэн хохирлыг хариуцахгүй.

3. Алба хаагч ажлын бус цагаар хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн, түүнчлэн ажилдаа ирэх, буцах замд явсныг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нэгэн адил тооцно.

4. Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан алба хаагч болон түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учирсан, эсхүл учирч болзошгүй тохиолдолд тэдгээрийн амь нас, аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг ШШГБ хариуцна.

5. Алба хаагч хуульд заасан үндэслэл, журмын дагуу нэг бүрийн тусгай хэрэгсэл, биеийн хүч, галт зэвсэг хэрэглэх эрхтэй.

Нийгмийн баталгаа:

1. Алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно.

2. ШШГБ-аас чөлөөлөгдсөн иргэнийг урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбогдуулан эрүүл мэнд, амь насанд нь хохирол учруулсан бол мөн адил 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно.

3. Алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу Засгийн газар дараах нөхөх олговор, тусламж олгоно.

- хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөх олговор;

- хиймэл эрхтэн хийлгэсэн бол түүний зардлыг;

- хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид авч байсан цалингийн зөрүү.

4. Алба хаагчийн авч байсан цалингийн хэмжээ нэмэгдэх бүрд хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид авч байсан цалингийн зөрүүг нэмэгдсэн цалингаас шинэчлэн тооцож олгоно.

5. Албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь хохирол учирснаас хөгжлийн бэрхшээлтэй болсон ШШГБ-ын алба хаагч, уг үндэслэлээр чөлөөлөгдсөн иргэнд амралт сувиллын болон нөхөн сэргээх эмнэлгийн байгууллагад эмчлүүлэхээр очих ба буцах замын зардлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу жилд нэг удаа олгоно.

6. ШШГБ-ын алба хаагчийн баривчлах байр, цагдан хорих төв, цагдан хорих байр, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, хаалттай хорих ангид 1 жил ажилласан хугацааг 1 жил 3 сар, нээлттэй хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад 1 жил ажилласан хугацааг 1 жил 2 сар ажилласанд тооцно.

7. Хорих ангийн алба хаагчийг эрүүл мэнд, амь насанд өндөр эрсдэлтэй онцгой нөхцөлд алба хаасантай нь холбоотойгоор шаардлагатай бол 1 сар хүртэл хугацаагаар сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд хамруулна.

Эдийн засгийн баталгаа:

1. Засгийн газар ШШГБ-ын алба хаагчийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

2. Алба хаагч өөр аймаг, хот суурин газарт шилжин ажиллах болсноос шалтгаалан түүний эхнэр /нөхөр/ хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүний гэр бүлийг тэргүүн ээлжид түүний мэргэжлийн болон түүнтэй дүйцэхүйц ажлаар хангах бөгөөд ажлаар хангаагүй тохиолдолд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож улсын төсвөөс олгоно.

3. Ээлжийн ажил, үүрэг гүйцэтгэдэг ШШГБ-ын алба хаагчийг онцгой тохиолдолд илүү цагаар ажиллуулсан бол ажилласан цаг тутамд ногдох албан тушаалын цалинг олгоно.

4. Алба хаагчийг өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед болон ажлын бус цагаар, шөнийн ээлжид, хээрийн сургууль, дадлагын үеэр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно.

5. Алба хаагчид олгох хүнсний болон эдийн хангалт, хоолны зардлын хэмжээг Засгийн газар тогтооно.

6. Аймаг, хот хооронд түүнчлэн аймаг, хот дотор ШШГБ-д шилжин ажиллахаар томилогдсон алба хаагчид уналга, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүнд уналга, ачаа тээшний зардлыг тухайн үед мөрдөж байгаа онгоц, автомашин, төмөр замын тээврийн үнэлгээгээр тооцож олгоно.

7. ШШГБ-ын захиалгаар гадаад улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын их, дээд сургуульд суралцагч алба хаагчийн суралцах хугацааны сургалтын тэтгэлэг, ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцна.

8. Алба хаагчийн цалин хөлс нь үндсэн цалин, цолны цалин болон доор дурдсан нэмэгдлээс бүрдэнэ.

- төрийн тусгай алба хаасан хугацааны;
- албан ажлын онцгой нөхцөлийн;
- хоригдолтой ажилласны;

- мэргэжлийн зэргийн;
- эрдмийн зэрэг, цолны;
- хуульд заасан бусад.

Бусад баталгаа:

1. Аймгийн төвөөс бусад суманд томилогдсон алба хаагчийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, албаны орон сууц, уналга, холбооны хэрэгслээр хангах үүргийг ШШГБ хүлээнэ.


2. Алба хаагч хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст ажилласан 5 жил тутамд Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралтын үндсэн болон нэмэгдэл амралт дээр ажлын гурван өдрийн нэмэгдэл амралт эдэлнэ.

3. Алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон зардлыг тогтоосон журмын дагуу байгууллагаас нөхөн авна.

4. ШШГБ-ын захиалгаар суралцсан, ШШГБ-ын алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад ажилласан, сонсогчоор суралцсан болон цэргийн жинхэнэ алба хаасан хугацааг ШШГБ-д ажилласан хугацаанд оруулан тооцно.

Судалгаанд иргэний шийдвэр гүйцэтгэгч 68, эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч 94, хорих байгууллагын 1005, нийт 1167 алба хаагч оролцсоны 98 буюу 8.4 хувь нь улс төрийн /улс төрийн нөлөөнөөс ангид байх/ баталгааг сайжруулах гэж үзсэн бол 224 буюу 19.2 хувь нь хууль зүйн /ажил үүргээ гүйцэтгэхэд хөндлөнгийн нөлөөнөөс ангид байх/ баталгааг сайжруулах, 242 буюу 20.7 хувь нь нийгмийн /тусламж, дэмжлэг, тэтгэмж/ баталгааг сайжруулах, 603 буюу 51.7 хувь нь эдийн засгийн /цалин хөлс/ баталгааг сайжруулах гэж хариулжээ.

Зураг 42. Алба хаагчийн эрх зүйн байдлыг дээшлүүлэхэд анхаарах асуудал



Алба хаагчийн гаргаж буй нээлттэй санал асуулгад эрх зүйн баталгааг дээшлүүлэхэд дараах асуудалд анхаарах шаардлагатай гэж үзжээ. Саналыг ангилан үзвэл дараах байдлаар саналаа илэрхийлж байсан. Үүнд:

- хүний нөөцийг тогтвортой ажиллуулах шаардлагатай байна ялангуяа эмнэлгийн салбарын цалинг нэмэх шаардлагатай

- ялгамжтай цалин. өдрийн алба хаагч хоногийн үүрэг гүйцэтгэдэг алба хаагчтай ижил цалинтай, хариуцлага өндөр байдаг нь ажлаас зугтах, залхах, төвөгшөөх асуудал тодорхой хэмжээнд байдаг

- алба хаагчдын сэтгэл зүйн байдлыг засах өрөө алба хаагчдад зориулагдсан сэтгэл зүйчтэй болох

- нэг алба хаагчид оногдож байгаа хоригдлын тоо их байна. орон тоог стандартын дагуу нөхөж хүний нөөцийн асуудлыг нэг мөр шийдвэрлэх

- алба хаагчдын амьдрах, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах

- ажлын ачаалал багасгах орон тоо нэмэх

- удирдлагын шударга биш байдал, ял эдлүүлэх ажиллагааг бүх чиглэлээр жигд ажиллуулах. тухайлбал гүйцэтгэх ажил, харуул хамгаалалт чухал гээд бусад чиглэлээ орхиж байна

- орон нутагт томилогдон ажиллаж байгаа алба хаагчид амьдрах орон байраар хангах

- хүнийг нөөцийн дутагдалтай байдалд онцгой анхаар дутуу орон тоог нөхөж харуул хамгаалалтын алба хаагчдын 4 ээлжээр үүрэг гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах тал дээр онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна

- шийдвэр гүйцэтгэгчийн зэрэг дэвийн нэмэгдэл олгож, бусад ижил төстэй байгууллага, хорих ангийн алба хаагчтай ижил цалин хангамж авах боломжоор хангах

- шийдвэр гүйцэтгэгчийн дүгнэдэг шалгуур үзүүлэлтийн зарим хэсэгтэй санал нийлэхгүй бүтэн жил хүнд хүчир ажил хийчхээд эцэс сүүлд нь дүгнэх болохоор шинжээчийн унасан үнэлгээг шийдвэр гүйцэтгэгч хариуцмааргүй байна өөрийн буруутай хариуцах зүйтэй гэж үзэж байна . ингэж буруу дүгнэснээс болж ажиллах эрч хүч урам зориг мохож байна. яаж сайн ажилласан ч ийм зүйл дээр оноо хасаад байвал бид бүхэн хурааж битүүмжлэх ажиллагаа хийхээс аль болох зайлж байна.

- 5 жилийн нэмэгдэл олгох

- цалин хөлс нэмэгдүүлэх гүйцэтгэх баримт бичгээс урамшуулал авдаг байх зэрэг болно.


3.3. Шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллын асуудал

Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал нь шийдвэр гүйцэтгэгчийн цалин хөлс, урамшууллын хэлбэрт чухал нөлөөтэй. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагч төрөөс цалин хангамж авах, хувийн хэвшлийнх бол өөрийн хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлээр хариу төлбөр авах нь үндсэн зарчим юм. Гэхдээ шийдвэр гүйцэтгэгчийн ажлын онцлогоос хамаарч энэхүү үндсэн зарчмыг тэр чигээр нь хэрэгжүүлэх зохимжгүй бөгөөд ямар нэгэн хэмжээгээр хослуулан хэрэглэдэг практик дэлхийн олон улс оронд тогтжээ. Бусад улсын практикаас харахад шийдвэр гүйцэтгэгч нь шүүх юм уу, гүйцэтгэх засаглалын байгууллагад харьяалагдах төрийн албан хаагч байсан тохиолдолд ч гүйцэтгэлийн дүнтэй уялдсан урамшуулал авдаг байна¹⁶³.

ШШГТ хуулийн 2017 оны шинэчлэн найруулгаар шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллыг хүчингүй болгож, шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллыг хязгаарласан нь олон улсын жишиг, чиг хандлагаас ухарсан алхам болсон гэж үздэг эрдэмтэн судлаачид цөөнгүй байдаг. Урамшууллын тогтолцоо хэрэгжихээ больсон 2018 оноос шийдвэр гүйцэтгэгч нарын ажлаас чөлөөлөгдөх үзэгдэл өмнөх онуудаас огцом өссөн байна. Тухайлбал: 2016 онд 1 шийдвэр гүйцэтгэгч халагдсан, 2017 онд 1 ахлах шийдвэр гүйцэтгэгч 2 шийдвэр гүйцэтгэгч өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж байсан бол хууль хэрэгжиж эхэлсэн 2018 онд 1 ахлах шийдвэр гүйцэтгэгч 26 шийдвэр гүйцэтгэгч өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж, 2 ахлах шийдвэр гүйцэтгэгч 1 шийдвэр гүйцэтгэгч халагдсан. Нийт 30 шийдвэр гүйцэтгэгч ажлаас гарч 10 дахин өссөн ба 2019 онд 10 шийдвэр гүйцэтгэгч мөн өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн байна¹⁶⁴.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан ХЗДХЯ болон ШШГЕГ-т гаргасан өргөдөл, гомдлын тоо шийдвэр гүйцэтгэгчийн урамшуулал олгохыг больсноос хойш тасралтгүй өсжээ.

Зураг 43. Шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллын талаар



Дээрх асуулгад 1 буюу 1.5 хувь нь урамшуулал шаардлагагүй гэж үзсэн бол 11 буюу 16.2 хувь нь цалин бусад нэмэгдлийг шинэчлэн тогтоох, 56 буюу 82.4 хувь нь урамшуулалтыг олгох нь зүйтэй гэжээ.

Шийдвэр гүйцэтгэгчийн урамшуулдаг тогтолцооны үед бага үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бага явуулж өндөр үнийн дүнтэй буюу өөрөөр хэлбэл урамшуулал ахиухан авах гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх

¹⁶³ Шагдарсүрэн, З. “Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийн эмхэтгэл. Уб., 2023. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны урамшууллын тогтолцоо олон улсын чиг хандлага илтгэл. 22 дахь тал.

¹⁶⁴ ШШГЕГ-ын тайлан, мэдээ. 2016-2019 он

ажиллагаа түлхүү явуулж байснаас бага үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичигт явуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор ШШГЕГ болон ШГА-аас албан даалгавар гаргах, болзолт уралдаан зарлах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байлаа. Болзолт уралдаан зарлаад, албан даалгавар гаргаад ч хүрдэггүй байсан үзүүлэлтдээ урамшуулалгүй болсноос хойш хүрсэн байгаа нь яах аргагүй анхаарах асуудал мөн гэж бидний зүгээс үзэж байна¹⁶⁵.

Судалгааны дүнгээс харахад гүйцэтгэх баримт бичигт явуулсан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт 2015 онд 46.3 хувь байсан бол 2022 онд 54.6 хувь болж 8.3 хувиар өссөн нь сайн хэрэг ч, бага үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичиг буюу 5 сая хүртэлх үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичигт явуулсан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт 9.2 хувиар өссөн бол 5 саяас дээш үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичигт явуулсан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт 3.3 хувиар өсжээ. Шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлтийг ахиулахаар бага үнийн дүнтэй хялбар гүйцэтгэж болох гүйцэтгэх баримт бичиг шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түлхүү явуулжээ.

Харин урамшууллын хувь хэмжээг зүй зохистой тогтоохгүй бол төлбөр төлөгч, төлбөр авагчийн хувьд санхүүгийн дарамт болох, улмаар шүүхийн шийдвэрийн биелэлтийн хувьд сөргөөр нөлөөлөх, гагцхүү том дүнтэй хэргүүд дээр шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа төвлөрөх зэрэг сөрөг үзэгдлүүд түгээмэл ажиглагддаг.

¹⁶⁵ Батгэрэл, Я. Шийдвэр гүйцэтгэгчийн урамшуулал хэрэгцээ шаардлага илтгэл. “Шүүхийн шийдвэрийн биелэлтэд нөлөөлөх хүчин зүйлс, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийн эмхэтгэл. Уб., 2023. дахь тал.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид, судлаачдын зүгээс тус байгууллагын бүтэц, тогтолцоог шинэчлэх зайлшгүй шаардлага байна гэж үздэг байна. Өөрөөр хэлбэл, чиг үүргийн давхардал, үйл ажиллагааны тогтолцооны ойлгомжгүй байдлыг цэгцлэх шаардлага байна. Төрийн эрх мэдлийг хуваарилах онолын хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн хэм хэмжээ нь хүний эрх, эрх чөлөө хуулийн хамгаалалтад байх баталгаа болохын хувьд шүүх эрх мэдлийн хүрээнд зөрчигдсөн эрхийг сэргээн хамгаалах ёстой атал иргэний, захиргааны хэрэг маргаанд гүйцэтгэх засаглал хяналтыг хэрэгжүүлэн оролцож байгаа нь ардчилсан нийгмийн суурь зарчимтай харшилж байгааг нэг мөр шийдвэрлэх саналтай байна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар дэргэдээ ШШГТХ-ийн 257 дугаар зүйлийн 257.7-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг нэгжтэй болох зайлшгүй шаардлага үүссэн байна. Түүнчлэн энэхүү нэгж, алба хаагч нь хорихоос өөр төрлийн ял эдлэхээс зайлсхийсэн этгээд, шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн Эрүүгийн хуулийн 21.7-д заасан гэмт хэрэг үйлдсэн төлбөр төлөгч болон түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан арга журмын дагуу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрхтэй байх нь зүйтэй.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хугацаатай болгох, заасан хугацаанд төлбөрийг төлөөгүй бол иргэний эрх зүйн хариуцлага буюу хүү, алданги тооцох эрх зүйн зохицуулалтыг тусгах боломжтой. Тухайлбал, ОХУ-ын Гүйцэтгэх ажиллагааны тухай Холбооны хуульд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд төлбөр төлөх хугацаа тогтоож өгснөөрөө онцлогтой юм. Тогтоосон хугацаанд төлбөрийг барагдуулаагүй бол нэхэмжлэлийн үнийн дүнгийн 7 хувиар мөнгөн торгууль оногдуулдаг ба торгуулийн нэхэмжлэлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэгч тогтоол үйлдэн ахлах гүйцэтгэгч нь баталдаг байна гэж дүгнэлээ.

4. ШШГЕГ-аас шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачааллыг багасгах, тэнцвэржүүлэх, орон тоог нэмэгдүүлэх, ажлын байрны болон ажиллах нөхцөл боломжийг сайжруулах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг сайжруулахад чиглэсэн цогц бодлого хэрэгжүүлэх, алба хаагчийн эрх зүйн байдлыг дээшлүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын шинэчлэлт нь цаг үеэ олсон, хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах шаардлага үүсчээ гэж үзэж байна.

5. Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг энгийн алба хаагчаар гүйцэтгүүлэх замаар эрх зүйн томоохон шинэчлэл хийж, иргэн хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг олон улсын жишигт нийцүүлж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүнгээс хамаарч шийдвэр гүйцэтгэгчийг урамшуулах, төвлөрүүлсэн урамшууллаас зардлаа нөхөх замаар төсөвт хэмнэлттэй, өөрийгөө санхүүжүүлдэг тогтолцоог бий болгох нь зүйтэй гэж дүгнэлээ.

ТАВ. ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль:

- Монгол Улсын Үндсэн хууль (1992)
- Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль (2004)
- Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль (2015)
- Монгол Улсын Шүүхийн тухай хууль (2021)
- Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай (2017)
- Монгол Улсын Төрийн албаны тухай хууль (2017)

Хоёр. Эрдэм шинжилгээний бүтээл, ном, сурах бичиг:

- Алтангэрэл, Б. Иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилт. УБ., 2020.
- Дашзэвэг, Б. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй (тусгай анги). УБ., 2004.
- Дашзэвэг, Б. Монгол Улсын Эрүү, иргэний хэрэгт холбогдох шүүхийн шийдвэр биелүүлэх хууль тогтоомжийн хөгжилт 1955-2005. УБ., 2005.
- Дамдинцэрэн, Д. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй зарим асуудал. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэл эрдэм шинжилгээний хурал. УБ., 2021.
- Дугармаа, А. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онол, практикийн асуудал.
- Лхагва, А. Монгол Улсын Эрүү, иргэний хэрэгт холбогдох шүүхийн шийдвэр биелүүлэх хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 2005, Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал. УБ., 2008, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. УБ., 2012, Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж. УБ., 2014.
- Лхагвасүрэн, Д., Эрдэнэтуяа, Д. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа. УБ., 2016.
- Цэрэнханд, Э., Мөнгөннахиа. Б. Захиргааны хэргийн талаарх шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ. УБ., 2023.
- Оюумаа, Ю., Хажидмаа. М. Шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачаалал судалгаа. УБ., 2020.
- Чимэд, Б. Захиргааны ерөнхий анги. УБ., 1973.
- Өнөрцэцэг, Ч. Иргэний, захиргааны, зөрчлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа. УБ., 2019.
- Өнөрцэцэг, Ч. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. УБ., 2020.
- Өнөрцэцэг, Ч. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, эрх зүйн зохицуулалт УБ., 2022.